### Барилга, тээвэр холбооны салбар

Аймгийн хэмжээгээр 2013 онд 48779.6 сая төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэснээс 2397.7 сая төгрөгийн их засвар, 46381.9 төгрөгийн шинэ барилгын ажил хийгдсэн байна. Барилга угсралт, их засварын ажил нь өмнөх оны мөн үеэс 25180.2 сая төгрөг буюу 2 дахин өссөн байна.

## Хүснэгт №1.14. Барилгын ажлын хөрөнгө оруулалтын хэмжээг онуудад харьцуулсан байдал

№	Ажлын төрөл	/сая.төг/			
		Жилийн эцэс			2012.12%
		2011	2012	2013	2011.12%
1	Нийт барилга угсралт, их засварын ажил	207889.6	23599.4	48779.6	206.7
2	Барилга угсралт	18071.7	21443.6	46381.9	216.3
3	Их засвар	2717.9	2155.8	2397.7	111.2

## Холбоо

Аймгийн холбооны газрууд 2013 онд 564.7 сая төгрөгийн орлоготой ажилласнаас 191.3 сая төгрөгийг хүн амд үйлчилснээс оруулжээ. Телефон цэгийн тоо өнгөрсөн оны мөн үеэс 28 буюу 2.4 хувиар өссөн байна.

## Хүснэгт №1.15. Холбооны салбарын сүүлийн 3 жилийн орлогын харьцуулсан байдал

№	Үзүүлэлт	Жилийн эцэст			2013/2012
		2011	2012	2013	
1	Тарифын орлого \мян.төг\	495714.9	405838.7	564663.7	139.1
2	Үүнээс: Хүн амаас	198433.0	184909.7	191283.7	103.4
3	Телефон цэгийн тоо	1416	1162	1190	102.4
4	КаТВ-ийн сувагт холбогдсон хэрэглэгч	488	576	879	152.6

## Хүснэгт №1.16. Авто машины тоо, сумдаар


№	Сумдын нэрс	2010		2011		2012		2013	
		Бүгд	Амины	Бүгд	Амины	Бүгд	Амины	Бүгд	Амины
1	Алаг-Эрдэнэ	223	221	636	630	350	346	413	409
2	Арбулаг	282	279	437	430	487	482	459	454
3	Баянзүрх	168	165	352	345	287	285	315	313
4	Бүрэнтогтох	436	434	548	542	571	567	537	533
5	Галт	355	350	474	473	453	448	465	461
6	Жаргал	356	354	527	523	405	401	369	365
7	Их-Уул	258	255	428	420	404	400	435	431
8	Рашаант	266	264	384	379	289	285	326	422
9	Ренчинлхүмбэ	182	179	310	303	253	249	256	252
10	Тариалан	426	421	511	507	612	608	710	706
11	Тосонцэнгэл	413	411	638	630	374	370	562	558
12	Төмөрбулаг	215	213	378	370	370	366	384	380
13	Түнэл	288	285	332	327	374	370	442	438
14	Улаан-Уул	264	262	354	350	240	237	231	228
15	Ханх	157	153	299	296	229	225	226	222
16	Цагаан-Уул	504	499	693	693	598	594	622	617
17	Цагаан-Үүр	100	97	117	115	112	108	105	101
18	Цэцэрлэг	386	381	465	460	481	477	440	436
19	Чандмань-Өндөр	153	150	153	150	156	152	205	201
20	Шинэ-Идэр	164	159	292	288	300	296	288	284
21	Хатгал	202	198	278	276	301	297	355	351
22	Цагааннуур	137	135	130	127	103	100	109	106
23	Эрдэнэбулган	175	170	253	249	279	275	348	344
24	Мөрөн	3642	3415	5206	4996	4707	4420	5684	5397
<b>Аймгийн дүн</b>		<b>5443</b>	<b>4203</b>	<b>14195</b>	<b>13879</b>	<b>12735</b>	<b>12358</b>	<b>14286</b>	<b>14009</b>

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ, ЦАГ УУРЫН ҮНДСЭН НӨХЦӨЛ


### 2.1. Ландшафт, газарзүйн онцлог

#### 2.1.1. Газрын гадарга

Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэр нь Хангайн уулархаг мужид оршдог. Уул нурууны гол хэсэг нь хангай нурууны салбар хэсэг Хөвсгөл Тагна, Саяны уулс багтана. Дэлгэрхаан уулын ноён оргил нь далайн түвшнээс дээш 3491 метр өндөрт орших ба аймгийн нийт нутаг дэвсгэр нь далайн түвшнээс 1650-2050 метр өргөгдсөн.



Зураг №2.1. Хөвсгөл аймгийн газрын дүрсийн зураг



Зураг №2.2. Хөвсгөл аймгийн газрын дүрсийн зураг

**Уулын тайгын цэвдэгт-ухаа шороон хөрс:** Уулын тайгын бүсийн дээд ба дунд хэсгээр 1500-1600 метрээс 2200-2400 метр хүртэлх өндөрт дан хушин, хушин шинэсэн болон шинэсэн ойд тархана. Энэ хөрс газрын гадаргад олон жилийн цэвдэг ойрхон орших нөхцөлд тогтворжих бөгөөд цэвдгийн улирлын гэсэлтийн гүн 1-1,2 метрээс хэтрэхгүй. Энэ хөрс нь чийгээр байнга хангалуун байдаг хэдий ч сайр чулуурхаг, нунтаг шороон үе нь нимгэвтэр учраас ус барьж тогтоох чадвар сайн биш байна.

Хөрсний гадарга дээр ногоон хөвд битүү ургахаас гадна алирс, сургар, тэрэлж, нэрс, унаган туруу, ямаан арц, улалж тэргүүтэн ургана. Уулын тайгын цэвдэгт хөрс ерөнхийдөө нимгэн, хөрсний нийт зузаан 60-80см-ээс хэтрэх нь цөөн.

**Уулын тайгын ширэгт төмрийн исэлтэй хөрс:** Уулт-тайгын бүсэд уулын ар хажуугийн дунд ба доод хэсгээр, мөн өвөр хажууд нь, уулт - ойт хээрийн бүсэд уулын ар хажуугаар 1300-1400 метрээс 1900-2000 метр хүртэлх үнэмлэхүй өндөрт дан шинэсэн, нар шинэсэн, заримдаа хус холилдож ургасан өвслөг бүрхэвч бүхий дэд тайгын ойд голчлон тархсан хөрс юм. Алирс, тав илгана, нохойн хошуу зэрэг сөөгөнцөр, ойн улалж, цахилдаг гүзээлзгэнэ, унаган туруу, яргуй, гиш, буржгар, шимтэглээ мэтийн алаг өвс, зарим зүйлийн үетэн бүхий өвслөг ургамлын бүрхэвч сайн хөгжиж, бүтэц нь 50-80% хүрнэ.

Олон жилийн цэвдэг үргэлжилсэн тархалттай боловч улирлын гэсэлтийн гүн их (1,5-2 метр) учраас цэвдэгт үзэгдэл хүчтэй илрэх нь ховор. Хөрсний чийгийн үндсэн эх үүсвэр нь агаарын хур тунадас (жилийн дундаж нь 300-350 мм). Хур бороо ихтэй чийгшил ихтэй жил хөрсний үе давхаргууд цэвдэгт тултлаа нэвт норж, заримдаа цэвдэгийн дээр хэт чийгшил нөхцөл түр хугацаагаар үргэлжилдэг. Хур багатай гандуувтар жил 40-60см-ийн

гүн хүртэл чийглэгдээд түүнээс доош зун намрын турш хуурай байх тохиолдол элбэг байна.

**Уулын ойн ширэгт бараан хөрс:** Энэ хэв шинжийн хөрс ойн бүсийн доод захаар хээрийн хар шороон, хүрэн шороон, нугын ялзмагт далд глейрхэг хөрсүүдтэй хиллэж орших тул экологийн хувьд өргөн хэлбэлзэлтэй, гарал үүслийн хувьд өөр өөр чиглэлтэй байна. Дунджаар өндөр уулын ар хажуугаар 850-900 метрээс, 1600-1700 метрийн үнэмлэхүй өндөрт, 1800-2000 метрийн өндөрт өвслөг ургамлын бүрхэвч сайн хөгжсөн ойн болон нугат ойн, нугат хээрт элбэг тохиолдоно.

Олон жилийн цэвдэг байхгүй тохиолдолд улирлын хөлдөлт нилээн зузаан үеийг (2-2,5 м хүртэлх ) хамарч, хөлдөлт гэсэлт удаан хугацаагаар үргэлжилдэг. Хөрсний чийгийн гол эх үүсвэр нь болох хур борооны ус хөрсөнд гол төлөв 50 -60 см гүн, хур ихтэй зарим жил 100 см хүртэл гүн нэвчиж чийглэнэ. Үүнээс гадна улирлын ба олон жилийн цэвдгийн гэсэлт гадаргын урсацын нөлөөгөөр хөрсөнд нэмэгдэл чийг хуримтлагдах, хөрсний гүнд түр хугацаагаар хэт чийглэг нөхцөл бүрдэх явдал заримдаа тохиолдоно.

**Уулын карбонатгүй хар шороон хөрс:** Энэ хөрсний гарал үүсэл нь уулын хажууд ажиглагдах хөрсөн дотуурх урсацтай цуг хөрсний уусмал газрын уруу шилжиж зөөгдөхдөө хөрсөн доторх карбонатын давсыг уусган авч хажуугийн угаагдал үүссэний улмаас бий болсон хөрс юм.

**Уулын нугын хөрс:** Уулын нугын хөрс өндөр уулын тагын бүсэд нугын өтгөн шигүү ургамшил дор тогтворждог. Уулын нугат хээрийн хөрс чийглэгдүү, хүйтэн нөхцөлд алаг өвс-жигжиг үетэнт, заримдаа бушилз-ботуульт ургамшил доор тогтворжих бөгөөд ургамал нь их намхан, тачир ургасан байдгаараа онцлогтой.

### 2.1.2. Ландшафт, байгалийн бүс, бүслүүр

Монгол орны нутагт ландшафтын тархалтын онцлогтой уялдан өндөр уулын бүслүүр, уулын тайгын бүслүүр, ойт хээрийн, хээрийн, говийн, цөлийн бүс дараалан оршино. Эдгээрээс өндөр уулын болон уулын тайгын бүслүүрүүд нь хамрах нутгийн хүрээгээр ихэвчлэн ойт хээрийн бүсийн ареалд багтана.

Хүснэгт №2.1. Байгалийн бүс, бүслүүрийн эзлэх талбай, хувь

№	Бүс, бүслүүрийн нэр	Талбай (км <sup>2</sup> )	Эзлэх хувь
1	Өндөр уулын бүслүүр	56394.0	3.6
2	Уулын тайгын бүслүүр	70492.5	4.5
3	Ойт хээрийн (хангайн) бүс	238108.0	15.2
4	Хээрийн бүс	535743.0	34.2
5	Говийн бүс	366561.0	23.4
6	Цөлийн бүс	299201.5	19.1
7	<b>Дүн</b>	<b>1566500.0</b>	<b>100.0</b>

Өндөр уулын бүслүүр нь Хөвсгөлийн уулсад нийт нутгийн 0.8 хувийг эзлэх ба эдгээр нь нийлээд бүгд 3.6 хувь буюу 56394.0 км<sup>2</sup> талбайг хамарна. Нөгөө талаар өндөр уулын бүслүүрт Хангайн нуруунд уулын нуга, Хөвсгөлийн уулсад уулын тундр, дотоод бүтэц нь нарийн нийлмэл болж ирнэ. Өндөр уулын бүслүүрт байнгын хүйтэн, сэрүүн, салхитай учир хүйтэнд тэсвэртэй харьцангуй цөөн зүйлийн амьтан, ургамалтай. Энд аргаль хонь (*Ovis ammon*), янгир ямаа (*Capra sibirica*), ирвэс мий (*Uncia uncia*), цэвдгийн

цагаан ятуу (*Lagopus mutus*), алтайн хойлог (*Tetraogallus altaicus*) зэрэг ховор амьтан, одой нарс (*Pinus pumila*), монгол шивэлз (*Ptilagrostis mongolica*), өлчир дэгд (*Gentiana algida*) зэрэг ховор ургамлууд тааралдана.

Уулт тайгын бүслүүрт Өвөр Байгалийн уулт тайгын их мужид хамрагдах Хэнтий, Хөвсгөлийн уулс багтах бөгөөд Хөвсгөлийн зүүн хэсэг болох Зэд-Бүтээлийн нуруу үнэмлэхүй өндрийн хувьд харьцангуй намсаж өргөрөг бүсийн шинжийг илүүтэй хадгална. Өөрөөр хэлбэл манай улсын хилийн гадна орших тайгын бүсийн өмнөд сэжүүр Зэд-Бүтээлийн нуруугаар дамжин орж ирдэг байна. Уулын тайгын бүслүүр нь нийт нутгийн 4.5 хувийг эзлэх ба түүний 3 хувь нь Хөвсгөл орчимд, 1.5 хувь нь Хэнтийн нуруунд ноогдоно. Уулын тайгын бүслүүр нь уур амьсгалын хувьд чийглэг хүйтэн, жилд унах хур тунадасны хэмжээ 400-500 мм буюу түүнээс ч ахиу боловч дулааны хангамж дутагдалтайгаас ургамлын ургах хугацаа харьцангуй богино байдаг. Энэ бүслүүрт сибирь хуш (*Pinus sibirica*), сибирь шинэсэн (*Larix sibirica*) ой зонхилно. Энд хүрэн хүдэр (*Moschus moschiferus*), шивэр хандгай (*Alces alces*), шилүүс мий (*Lynx lynx*), голын халиу (*Lutra lutra*) зэрэг монгол улсын улаан номонд орсон амьтад идээшлэнэ.

Уулт тайгын бүслүүрт Өвөр Байгалийн уулт тайгын их мужид хамрагдах Хэнтий, Хөвсгөлийн уулс багтах бөгөөд Хөвсгөлийн зүүн хэсэг болох Зэд-Бүтээлийн нуруу үнэмлэхүй өндрийн хувьд харьцангуй намсаж өргөрөг бүсийн шинжийг илүүтэй хадгалана. Өөрөөр хэлбэл манай улсын хилийн гадна орших тайгын бүсийн өмнөд сэжүүр Зэд-Бүтээлийн нуруугаар дамжин орж ирдэг байна. Уулын тайгын бүслүүр нь нийт нутгийн 4.5 хувийг эзлэх ба түүний 3 хувь нь Хөвсгөл орчимд, 1.5 хувь нь Хэнтийн нуруунд ноогдоно. Уулын тайгын бүслүүр нь уур амьсгалын хувьд чийглэг хүйтэн, жилд унах хур тунадасны хэмжээ 400-500 мм буюу түүнээс ч ахиу боловч дулааны хангамж дутагдалтайгаас ургамлын ургах хугацаа харьцангуй богино байдаг. Энэ бүслүүрт сибирь хуш (*Pinus sibirica*), сибирь шинэсэн (*Larix sibirica*) ой зонхилно. Энд хүрэн хүдэр (*Moschus moschiferus*), шивэр хандгай (*Alces alces*), шилүүс мий (*Lynx lynx*), голын халиу (*Lutra lutra*) зэрэг монгол улсын улаан номонд орсон амьтад идээшлэнэ.

## 2.2. Уур амьсгал


Дэлхийн бусад газар нутгуудаас ялгарах уур амьсгалын гол онцлог нь Монгол оронд агаарын температурын хэлбэлзэл их, хур тунадас бага ордог, өргөргийн дагуу агаарын температур, хур тунадасны өөрчлөлт асар их байдагтай холбоотой юм.

Тухайн газар орны уур амьсгалын ерөнхий төлөв буюу горимийг хамгийн багадаа 30 жил буюу түүнээс урт цуваатай цаг уурын мэдээний дунджаар илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл уур амьсгалын горим нь тухайн газар орны цаг агаарын ерөнхий шинж нь жилийн аль сард ямар байх вэ гэдгийг илэрхийлдэг. Уур амьсгал судлалаас гардаг бас нэг үзүүлэлт бол дээрх 30 жилийн дундаж үзүүлэлтүүдийг орон зайн тархацыг зураг хэлбэрээр харуулдаг. Уур амьсгалын мэдээлэлд агаарын температур, хур тунадас, чийгшил, салхины хурд зэрэг цаг уурын үзүүлэлтүүдийг оруулдаг. Тухайн газар орны уур амьсгалд газрын гадаргуугийн өндөршил, газарзүйн өргөрөг, түүнд ойрхон байгаа ус бүхий гадарга, ургамлан бүрхэвч, салхины зүг чиг чухал нөлөө үзүүлдэг.

### 2.2.1. Дулааны горим

Жилийн дундаж агаарын температур: Агаарын хоногийн дундаж температур 10 сарын 15-аас 0<sup>0</sup> градусаас доош орж хүйтрэх ба 4 сарын 10-аас дулаарч эхлэдэг буюу 200-220 хоног нь хүйтэн байдаг.

Жилийн дундаж агаарын температур нилээд ялгаатай 1.4<sup>0</sup>C –аас -7.9<sup>0</sup>C градусын хооронд хэлбэлздэг. Тухайлбал Хөвсгөл нуураас хойд талын сумдад илүү хүйтэн буюу Ренчинлхүмбэ суманд хамгийн хүйтэн байна. Жилийн дундаж температурын хувьд Мөрөн хот, Бүрэнтогтох суманд эерэг утгатай буюу хамгийн дулаан нь Бүрэнтогтох суманд 1.4<sup>0</sup>C, бусад сумуудад сөрөг утгатай ба хамгийн хүйтэн нь Ренчинлхүмбэ суманд -7.9<sup>0</sup>C байсан бол Мөрөн хотод -0.2<sup>0</sup>C байсан байна. Агаарын температурын жилийн явцыг харахад 1 дүгээр сард хамгийн хүйтэн, 7 дугаар сард хамгийн дулаан байдаг Монгол орны уур амьсгалын ерөнхий зүй тогтол давтагдаж байна.



Зураг №2.3. Сумдын жилийн дундаж агаарын температур

Манай орны мал сүрэг жилийн дөрвөн улиралд байгаль цаг уурын байнгын нөлөөлөл дор бэлчээрийн маллагаатай байдаг тул цаг агаарын огцом өөрчлөлт, эрс тэс уур амьсгал нь мал сүргийн тогтвортой өсөлтийг хангах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх, түүний эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд багагүй бэрхшээл учруулдаг. Өөрөөр хэлбэл эрс тэс уур амьсгал малын амьдрах чадамж цаг агаар, уур амьсгалын нөхцлөөс хамааралтай байдаг болохоор цаг агаарын үзүүлэлтийн хэлбэлзэл малын дулаан солилцоо, амьдралын үйл ажиллагаанд шууд нөлөөлж түүний үр дагавар нь ашиг шимийн өөрчлөлтөөр илэрнэ. Мал маллагааны уур амьсгалын өртөнгийн судалгаанд жил, сарын дундажаас илүү хамгийн их бага өөрөөр хэлбэл хэлбэлзлийн мэдээ чухал. Иймд энд агаарын температурын үнэмлэхүйн их, бага утгыг авч үзлээ.


## Хүснэгт №2.2. Сумдын агаарын температур

Үзүүлэлт	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
<b>Мөрөн</b>													
Дундаж	-23.5	-18	-8.8	1.7	9	15.7	16.8	14.7	7.9	-1.4	-12	-21.1	<b>-1.6</b>
Үнэмлэхүй их	4.5	9.2	16.5	27.1	30.6	35.4	33.9	33.7	28.5	23.6	10.7	5.4	<b>33.9</b>
Үнэмлэхүй бага	-45.7	-44	-35	-22	-12	-2.7	1.4	-3	-10.3	-27	-38	-42.9	<b>-45.7</b>
<b>Чандагат</b>													
Дундаж	-27.4	-26	-15	-2.5	7.4	14.7	15.2	12.4	7.1	-3	-16	-24.2	<b>-5.3</b>
Үнэмлэхүй их	-3.1	-1.5	6.5	21.2	29.4	32.1	29.7	29.2	27	21.6	16	-1.6	<b>32.1</b>
Үнэмлэхүй бага	-49.2	-49	-40	-28	-20	-8	-2.7	-6.2	-11.6	-29	-40	-45.9	<b>-49.2</b>
<b>Ренчинлхүмбэ</b>													
Дундаж	-32.3	-27.1	-16.7	-3.5	5.4	11.2	13.2	10.9	4.3	-5.1	-19.8	-29.2	<b>-7.4</b>
Үнэмлэхүй их	-6.8	1.9	13.5	22.1	28.3	30.3	32	30.8	24.8	21.6	5.1	2.2	<b>32</b>
Үнэмлэхүй бага	-50.4	-48.1	-42.3	-35.5	-17.5	-6.7	-3.1	-7.5	-14.1	-35.6	-43.1	-48.1	<b>-50.4</b>
<b>Тариалан</b>													
Дундаж	-20.2	-16.6	-7.3	2	10	15	16.3	14.2	8	0.1	-10.2	-17.6	<b>-0.5</b>
Үнэмлэхүй их	5.3	7	18	27.2	31	34.4	37.8	31.6	27.9	23.6	11.7	11.9	<b>37.8</b>
Үнэмлэхүй бага	-38.3	-39.1	-30.6	-22.5	-12	-4.1	-0.2	-3	-8.2	-20.8	-30.6	-39.9	<b>-39.9</b>
<b>Бүрэнтогтох</b>													
Дундаж	-19	-14	-5.8	3.3	11.3	18.4	18.6	16	10.9	2	-8.5	-14.6	<b>1.6</b>
Үнэмлэхүй их	4	7.2	15.2	25.2	30.7	32.5	33.9	30.4	25.2	21.1	14	5	<b>33.9</b>
Үнэмлэхүй бага	-41.5	-39	-32	-24	-12	-5.5	4.6	-3.2	-7.5	-16	-29	-40.2	<b>-41.5</b>
<b>Цагаан-Уул</b>													
Дундаж	-21.4	-19	-12	-1.4	6.5	13.4	14	12.9	6.4	-3	-11	-20.9	<b>-3</b>
Үнэмлэхүй их	-2.8	0.3	9.6	24.3	26.3	23.8	29.4	29	24.1	18.9	16.5	0.3	<b>29.4</b>
Үнэмлэхүй бага	-42.5	-41	-35	-28	-17	-8.8	-1.4	-6.1	-18.3	-28	-39	-41.7	<b>-42.5</b>
<b>Хатгал</b>													
Дундаж	-23.1	-20.4	-12.6	-3	4.9	9.9	11.9	10.4	4.3	-4	-13.3	-20.2	<b>-4.6</b>
Үнэмлэхүй их	-0.4	10.9	15.5	23.2	27.5	29.7	31.8	30.4	25.3	20.7	12.2	6.9	<b>31.8</b>
Үнэмлэхүй бага	-47.6	-44.5	-41.5	-29	-17.6	-8.6	-4.7	-6.7	-22.5	-37.6	-39.8	-44.2	<b>-47.6</b>



Дээр өгүүлсэнчлэн тухайн газар орны уур амьсгалын ерөнхий төлөв буюу горимийг хамгийн багадаа 30 жил буюу түүнээс урт цуваатай цаг уурын мэдээний дунджаар илэрхийлдэг. Уур амьсгал судлалаас гаргах шаардлагатай бас нэг үзүүлэлт бол орон зайн тархац юм. Хөвсгөл аймгийн хойд талын сумдын хувьд өндөрлөг газраа хүйтэн нам дор газраа илүү дулаан байдаг ерөнхий зүй тогтол хадгалагдаж байна.

Жилийн доторх хуваарилалтын хувьд Монгол орны нийт нутгийн цаг агаарын хуваарилалтын нэгэн адил 1 дүгээр сард хамгийн хүйтэн, 7 дүгээр сард хамгийн дулаан байна. Ерөнхийдөө Хөвсгөл аймаг манай орны нэлээн хүйтэн өвөл болдог газрын нэг бөгөөд 1 дүгээр сарын агаарын дундаж температур  $-20.2^{\circ}\text{C}$ -с  $-32.3^{\circ}\text{C}$ -ын хооронд хэлбэлзэнэ.




Зураг№2.4. 1 ба 7-р сарын агаарын температурын орон зайн тархац

Жилийн хамгийн дулаан буюу 7-р сард  $18.8-24.3^{\circ}\text{C}$  хооронд байгаа энд нутагт харьцангуй сэрүүн зун болдгийг илэрхийлж байгаагийн зэрэгцээ “0” градус хүрч сэрүүсэх тохиодол гардаг ба өвөл нь хамгийн хүйтэн байдаг Мөрөнд зундаа хамгийн халуун буюу  $24.3^{\circ}\text{C}$  хүрдэг байна. Хатгал, Ренчинлхүмбэ зэрэг сумдад харьцангуй сэрүүн зун болдог байна.

Агаарын үнэмлэхүйн бага температур хамгийн хүйтэндээ Ренчинлхүмбэд  $-50.4^{\circ}\text{C}$ , хамгийн дулаандаа Тариаланд  $-39.9^{\circ}\text{C}$ , харин Мөрөнд  $-48.9^{\circ}\text{C}$  хүрч хүйтэрч байсан байна (1-р хүснэгт). Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ суманд 2000 оны 1 дүгээр сарын 6-нд  $-50.4$  хэм хүрч хүйтэрч байсан байна.

Харин үнэмлэхүйн их температур Мөрөнд  $38.1^{\circ}\text{C}$ , хамгийн багадаа Хатгалд  $31.8^{\circ}\text{C}$  хүрч халж байжээ (1-р хүснэгт, 5-р зураг). 1 ба 7 сарын агаарын температурын орон зайн тархцын зургаас харахад уулын өндөрлөг хэсэгтээ сэрүүн, нам газраа сэрүүвтэр байдаг байна.




Зураг №2.5. Агаарын дундаж болон үнэмлэхүй температурын сарын явц

Зургаас харахад Мөрөн хотын агаарын дундаж болон үнэмлэхүйн бага температур хамгийн их байгаа нь нэг талаас Хөвсгөл нуур, Дархадын хотгор нь эргэн тойрон өндөр уулсаар хүрээлэгдсэн тул намраас эхлэн хүйтэн агаар хуралдан тогтдог, нөгөө талаас газрын гадарга туяарлын замаар дулаанаа их алддагтай холбоотой юм.

Ер нь тухайн газар орны уур амьсгалд газрын гадаргуугийн өндөршил, өргөрөг, усан орчин, ургамлан бүрхэвч, салхины зүг чиг чухал нөлөө үзүүлдэг буюу Увс нуур эргэн тойрныхоо сум, ялангуяа Мөрөн хотын уур амьсгал, цаг агаарт маш их нөлөөтэй байна. Өөрөөр хэлбэл Хөвсгөл нуур орчиндоо бичил уур амьсгалыг бий болгож байна.


Аливаа нэг үйл ажиллагааны төлөвлөлт хийхэд тухайн газар орны уур амьсгалын горимыг заавал тусгах шаардлагатай болдог. Ийм учраас уур амьсгалын өөрчлөлт дэлхий нийтийн байгаль орчны эн тэргүүний асуудал болж улс орон бүр одорхой ажил хийж байна. Өөрөөр хэлбэл ямарч үйл ажиллагаа орон зай, цаг хугацааны дотор явагдаж л байгаа бол тухайн газар орны уур амьсгалд зохицох шаардлагатай гэсэн үг.

Уур амьсгалын судалгаанаас гаргах шаардлагатай бас нэг үзүүлэлт олон жилийн явц юм. Цаг агаарын мэдээний хамгийн урт цуваа бүхий Мөрөн цаг уурын станц дээр 1960-2013 онуудад хэмжсэн мэдээгээр олон жилийн явцыг жил, сараар гаргалаа. Мөрөн орчимд сүүлийн 50 гаруй жилийн хугацаанд агаарын жилийн дундаж температур  $2.48^{\circ}\text{C}$  – р нэмэгдсэн байна (2.6.-р зураг). Энэ нь Монгол орны хэмжээн дэх өөрчлөлтөөс илүү нэмэгдсэн ойролцоо байна (Монголын Үндэсний Илтгэл, 2010).



Зураг№2.6. Мөрөн хот орчмын агаарын жилийн дундаж температурын олон жилийн явц

Судалгааны бүс нутгийг уур амьсгалыг өөр бусад газартай харьцуулж үзэх мөн цаг уурын станц байхгүй буюу уур амьсгалын төлөв байлыг олон жилийн явцыг харуулах хангалттай мэдээ байхгүй сумдын уур амьсгалд гарч байгаа өөрчлөлтийг гаргахын тулд Монгол орны 69 станцын 1961-2011 оны агаарын температурын олон жилийн өөрчлөлтийн хандлагын шугаман регрессийг тооцож, абсолют өөрчлөлтийн орон зайн тархалтыг гаргалаа. Үүнд цэгэн мэдээллийг интерполяцлахдаа Co-kriging аргаар тооцсон. Энэ тооцооны дүнг 8-р зурагт үзүүлээ. Эндээс харахад судалгаанд хамрагдсан Хөвсгөл аймагт нэлээд дулаарсан байна. Тухайбал Мөрөн орчимд  $2.5^{\circ}\text{C}$  Цагааннуур сум орчимд  $2^{\circ}\text{C}$ , Тариаланд хамгийн бага буюу  $1.3^{\circ}\text{C}$ -аар дулаарсан байна.



Зураг№2.7. Хөвсгөл аймгийн агаарын температурын өөрчлөлтийн орон зайн тархалт


### 2.2.2. Чийгийн горим

Жилийн нийлбэр хур тунадасны орон зайн тархалтын тооцооны үр дүнг харвал нам өргөргийн нутгаар буюу говь цөлийн бүсэд жилдээ арав хүрэхгүй см хур тунадас орох бөгөөд заримдаа энд хэдэн жил ч бороо орохгүй тохиолдол бий. Энэ нь агаарт агуулагдаж буй усны уурын тоо хэмжээ бага байдагтай шууд холбоотой юм. Оронзайн тархацын

хувьд Хангайн нуруу, Хөвсгөл, Хэнтийн уулсаар 300-400 мм, Монгол Алтайн болон ойт хээрийн бүсэд 250-300 мм, хээрийн бүсэд 150-250 мм, говь цөлийн бүсэд 150-50 мм орчим хур тунадас унана.

Монгол орны газарзүйн өргөргийн дагуух хур тунадасны тоо хэмжээ газарзүйн нам өргөргөөс өндөр өргөрөг рүү шилжих тусам эрс ихэсдэг байна. Энэ нь газарзүйн өндөршилтэй шууд холбоотой байдаг. Жишээлбэл, 7 сард хойд өргөргийн 42 градусын бүслүүр дээр 31 мм, өргөргийн 46 градусын бүслүүр дээр 52 мм, өргөргийн 50 градусын бүслүүр дээр 96 мм хур тунадас тус ордог байна. Энэ зүй тогтол жилийн хамгийн хүйтэн 1-р сард мөн жилийн нийлбэр үед ч гэсэн хадгалагдаж байна.

Хур тунадасны 80-85% орчим нь жилийн дулаан улиралд /VI-IX сард/ үүнээс зөвхөн 7, 8 дугаар сард 60-70% нь орно.



Зураг №2.8. Хөвсгөл аймгийн жилийн нийлбэр хур тунадасны оронзайн тархац


Намрын анхны цас 9 сарын 2-3 дугаар арав хоногт орж, сүүлийн цас 4 сарын 3 дугаар арав хоногийн дунд үеэр орж хайлдаг буюу жилийн 150-160 хоногт цасан бүрхүүлтэй байдаг. Цасан бүрхүүлийн зузаан 10-15 см хүрнэ.

Нэгэнт 10 сарын 2-3 дугаар арав хоногт цас орж эхлэн 4 сарын 3 дугаар арав хоногийн дунд үеэр сүүлийн цас ордог болохоор 20 хүрэхгүй хувийн тунадас өвөл цас хэлбэрээр унана.

## Хүснэгт №2.3. Сумдын сарын дундаж тунадас

Сумдын нэр	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Нийлбэр
Мөрөн	2.1	1	2	9.5	14.4	48.1	68.9	59.7	15.6	8.2	3.3	3.8	236.7
Чандагат	2.7	3.5	3	7.6	11.1	35	66.8	48	17	8.7	5.9	4.6	213.9
Баянзүрх	0.8	0.9	2.6	6.4	13.6	43.8	73.9	50.6	15	4.7	1.8	2.1	216.3
Арбулаг	2.3	1.1	2.4	5.6	11.2	42.4	57.7	54.4	16.5	3.7	2.4	2.9	202.6
Бүрэнтогтох	1.6	0.5	1.4	4.7	10.4	41	39.3	49.6	13.8	2.2	2.3	2	168.6
Цагаан-Уул	2.4	2.3	3.1	6.8	16.7	48.7	70.6	61.6	17.6	6	3.3	4.1	243.2
Рэнчинлхүмбэ	2.7	1.7	2.6	5.6	19.1	48.2	80.6	63.6	30.4	6.8	5.4	2.9	269.8
Хатгал	1.4	1.1	2.3	8	17.8	51.6	89.3	74.4	37.3	9.5	5.6	1.4	299.6
Тариалан	2.2	1.4	2.3	6.9	17.8	53.2	104.5	79	26.2	6.1	2.5	2.1	304.3


Мөн сумдаас Цагаан-Уул, Рэнчинлхүмбэ, Хатгал, Тариалан сумуудад унах хур тунадасны хэмжээгээр илүү чийглэг буюу жилд 240 мм-ээс их, харин Бүрэнтогтох суманд хамгийн бага буюу жилд 170 орчим мм хур тунадас унадаг, илүү гандуу байдаг байна.



Зураг №2.9. Сумдын сар, жилийн нийлбэр тунадас

Хөвсгөл аймгийн хэмжээгээр хур тунадасны хэмжээ сүүлийн 50 гаруй жилд хэрхэн өөрчлөгдөж буйг үзүүлэхийн тулд Хөвсгөл аймгийн Мөрөн цаг уурын станц дээр 1961-2013 онуудад хэмжсэн мэдээг ашиглаж тооцоо хийлээ. Тооцоог хийхдээ сар бүрийн хур тунадасны хэмжээг өөр хооронд нь нэмж өөрчлөлтийн явцыг жил жилээр бодуулсан. Тооцооны үр дүн буюу сүүлийн 50 гаруй жилийн нийлбэр хур тунадасны өөрчлөлтийн явцын графикийг шугаман трендийн аргаар илэрхийлэв. Мөрөн орчмын тунадас 1961 оноос 1980 он хүртэл буурч, 1980-д оны дунд хүртэлх богинохон хугацаанд эрчимтэй нэмэгдэж түүнээс хойш өдийг хүртэл буюу сүүлийн 25 жилийн хугацаанд буурах хандлага ажиглагдаж байна.

Харин нийт 50 гаруй жилийн хугацаанд бүхэлд авч үзвэл 12.8 мм-ээр буурч байгаа өөрчлөлт харагдаж байна. Мөн явцаас Хөвсгөл нуур орчмын тунадасны өөрчлөлт агаарын температурын өөрчлөлттэй ямар нэг хэмжээгээр уялдаатай байна. Тухайлбал температур нэмэгдэхэд тунадас буурч, буурахад нэмэгдэж байна.



Зураг №2.10. Жилийн нийлбэр тунадасны өөрчлөлт, орон зайн тархац

Өвөл зуны болон байгаль, цаг уурын хамгийн тохиромжтой нөхцөлд мал амьдрах хэвийн нөхцөл бүрдэж ашиг шим, удамшлын чадамж дээд зэргээр илэрдэг. Тэгэхээр байгаль, цаг уурын тохиромжтой нөхцөл өөрчлөгдөх нь малын бие мах бодид сөргөөр нөлөөлж дарамт болсноос тарга хүч, ашиг шим нь муудах ялангуяа энэ нөлөө малын бие мах бодийн зохицон дасах чадварын хэмжээнээс хэтэрвэл үхэж хорогддог байна. (Төмөржав, 2004, Туваансүрэн нар, 1996).

Агаарын температурын халуун хүйтнээс цасан бүрхүүл жилийн туршид бэлчээрийн маллагаанд байгаа монгол малын бэлчээрлэх нөхцөл болдог. Монгол орны газарзүйн өргөргийн дагуух хур тунадасны тоо хэмжээ газарзүйн нам өргөргөөс өндөр өргөрөг рүү шилжих тусам эрс ихэсдэг. Энэ нь газарзүйн өндөршилтэй шууд холбоотой. Хөвсгөл аймгийн тунадасны өөрчлөлтийн хэмжээг Монгол орны өөр бусад хэсэгт өөрчлөгдсөн байдалтай харьцуулж үзэхэд Хөвсгөл аймгийн нутгийн баруун хэсэгтээ хур тунадас 4-40 мм-ээр нэмэгдсэн, зүүн өмнөд хэсэгтээ 2-25 мм-ээр буурсан бөгөөд станцаар нь авч үзвэл Мөрөнд 21 мм, Тариаланд 2,4 мм-ээр буурсан, Ренчинлхүмбэд 7 мм, Цагааннуурт 26 м-ээр нэмэгдсэн хандлагатай өөрчлөгдсөн байна.


### 2.2.3. Салхины горим

Салхины горим нь агаар мандлын орчил урсгал, агаарын даралт, тухайн нутгийн физик газарзүйн нөхцлөөс ихээхэн шалтгаалдаг.

Монгол орны тал хээр, говь, цөлийн бүс нь салхи ихтэй байдаг. Жилийн дундаж салхины хурд энэ бүс нутагт 4-6 м/с. Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгийн уулс хоорондын хөндийд 1-2 м/с, бусад нутгаар 2-3 м/с орчим байдаг. Тус орны 250 хот суурин орчимд хийсэн цаг уурын хэмжилтийн мэдээгээр нутгийн дөрөвний нэг орчимд нь жилийн дундаж салхины хурд 4.0 м/с-ээс их. Ихэнхидээ баруун, баруун хойд, хойд зүгийн салхи зонхилох боловч газрын хотгор гүдгэрийн нөлөөгөөр орон нутгийн ялангуяа уул-хөндийн салхи элбэг тохиолдоно. Монгол орны нийт нутгийн 41.3%-ийг эзлэх говь-цөлийн бүсэд сул шороо элбэг, салхи ихтэй тул шороон шуурга олонтаа тохиолдоно. Энэ

бүс нутагт жилдээ 30-100 өдөр, Монгол элсний өмнөд захад жилдээ 120 өдөр шороо хийснэ.

Энэхүү судалгааны үр дүн Хөвсгөл аймгийн нутгаар жилд 10-аас цөөн өдөр шороо хийсдэг болохыг тогтоосон байна (Natsagdorj нар 2002, 2003).




Зураг №2.11. Салхины дундаж болон хамгийн их хурд, м/с

Хөвсгөл аймгийн нутгаар салхины жилийн дундаж хурд 1,1-6,4 м/с-ийн хооронд хэлбэлзэх ба дунджаар 3 орчим м/с, салхины хамгийн их хурд ихэнх сумдад 20 м/с буюу түүнээс доош байх ба хамгийн ихдээ 28-40 м/с хүрдэг бол 15 м/с-ээс их салхитай өдөр дунджаар 12 өдөр тохиолддог байна (3-р хүснэгт). Мөрөн станцад 3 ба 4-р сард салхины хамгийн их хурд хааяа 30 м/с хүрдэг бол хүчтэй салхитай өдрийн тоо харьцангуй цөөн буюу 2-4 хоног ажиглагддаг байна. Салхи намуун байх давтагдал өвлийн улиралд хамгийн их /45.1-52.7%/ байдаг нь энэ бүс нутагт хүйтэн улиралд эсрэг циклон тогтвортой байрладагтай холбоотой.

**Салхины чиглэл:** Салхины чиглэл нь тухайн газар орны хотгор гүдгэрийн онцлогоор голчлон тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл уулархаг орон нутагт жилийн хүйтэн улиралд хүйтэн агаар өндөрлөг газраасаа нам газар луугаа чиглэн урсах хүндийн хүчний салхи зонхилох ба жилийн дулаан улиралд шатлуур багатай нам даралтын оронд салхины чиглэл тогтворгүй болох хандлага ажиглагдана.

Хөвсгөл аймгийн нутагт газрын хотгор гүдгэрийн онцлогоос шалтгаалан баруун зүгийн салхи зонхилон ажиглагддаг байна. Салхины чиглэлийн тухайд барууны салхины давтагдал жилийн турш бусад чиглэлийн давтагдлаас давуу байдаг онцлогтой. Баруун болон зүүн зүгийн салхины давтагдал өвөл хамгийн их 40 гаруй хувь хавар, намар адилхан 22-28 орчим хувь, харин зун хамгийн бага буюу 15 орчим хувь байна.



Зураг№2.12. Мөрөн станцын салхины зүгийн давтамж

Хүснэгт№2.4. Салхины хурд

Үзүүлэлт	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
<b>Мөрөн</b>													
Салхины дундаж хурд	1.1	1.5	2.6	3	3.4	2.5	1.8	1.8	1.9	1.8	2	1.4	<b>2.1</b>
Хүчтэй салхитай өдөр (15 м/с-эсс дээш)	3	2	3	4	5	3	2	2	2	2	2	1	<b>33</b>
Салхины хамгийн их хурд	30	18	24	28	25	25	25	22	20	24	18	16	<b>30</b>
<b>Чандагат</b>													
Салхины дундаж хурд	3.3	3.5	5.2	9.7	10.6	6.8	5.3	5.5	6.1	6.2	4.8	3.2	<b>6.4</b>
Хүчтэй салхитай өдөр (15 м/с-эсс дээш)	0	0	1	2	1	1	1	1	1	1	0	0	<b>9</b>
Салхины хамгийн их хурд	14	14	17	18	14	16	17	12	17	17	17	12	<b>18</b>
<b>Ренчинлхүмбэ</b>													
Салхины дундаж хурд	0.5	0.9	1.4	2.5	2.8	2	1.4	1.6	1.6	1.4	0.8	0.5	<b>1.4</b>
Хүчтэй салхитай өдөр (15 м/с-эсс дээш)	2	1	0	1	2	1	1	0	1	2	1	1	<b>13</b>
Салхины хамгийн их хурд	18	16	14	20	28	20	18	14	15	18	16	18	<b>28</b>
<b>Тариалан</b>													
Салхины дундаж хурд	2	2.3	2.9	3.2	3.2	2.7	2.3	2.3	2.6	2.5	2.5	2.2	<b>2.6</b>
Хүчтэй салхитай өдөр (15 м/с-эсс дээш)	1	1	3	2	3	1	0	0	0	1	1	0	<b>13</b>
Салхины хамгийн их хурд	16	17	20	18	18	18	18	18	14	14	14	17	<b>20</b>
<b>Хатгал</b>													
Салхины дундаж хурд	2.6	2.8	3.1	3.7	3.7	2.7	2.2	2.2	2.4	3.1	3.3	2.8	<b>2.9</b>
Хүчтэй салхитай өдөр (15 м/с-эсс дээш)	3	1	2	2	2	0	1	1	1	1	0	0	<b>14</b>
Салхины хамгийн их хурд	20	16	20	20	18	14	14	20	16	16	14	14	<b>28</b>
<b>Бүрэнгогтох</b>													
Салхины дундаж хурд	2.9	3.3	3.7	3.6	4	2.6	2.2	2	2	2.7	3.8	3.4	<b>3</b>
Хүчтэй салхитай өдөр (15 м/с-эсс дээш)	0	0	1	1	1	0	0	0	0	0	1	1	<b>5</b>



Салхины хамгийн их хурд	14	14	20	20	17	14	12	12	17	14	17	12	<b>20</b>
<b>Цагаан-Уул</b>													
Салхины дундаж хурд	2.1	2.7	4	4.6	4.6	3.6	3.1	2.8	2.9	3.3	3.2	2.7	<b>3.1</b>
Хүчтэй салхитай өдөр (15 м/с-эсс дээш)	0	2	1	2	2	1	0	0	0	1	0	0	<b>9</b>
Салхины хамгийн их хурд	12	18	20	20	17	17	14	12	14	15	12	16	<b>20</b>

#### 2.2.4 Ургамлын чийг, дулааны хангамж

Хөрсний дулааны гол эх үүсвэр нь нарны энерги юм. Энэ нь  $1\text{см}^2$  талбайд босоогоор минут бүрд буух цацрагийн хэмжээгээр илрэх бөгөөд ойролцоогоор 1,946 калори дулаан юм. Хөрсний дулааны горим нь түүний дулааны шинж чанараас шалтгаална.

Ургамлын ургах энергийн эх булаг дулаан нь навчин дахь шим бодисын нийлэгжилт, үрийн ургах, жигд цухуйх, ногоон масс үүсэх, үндэс, цэцэглэлт, үр жимс тогтох, ургац боловсроход шийдвэрлэх нөлөөтэй.

Үр ургах үеэс эхлээд ургац боловсрох хүртэл нийлбэр дулааны хэмжээгээр таримлууд адилгүй. Жишээ нь: буудай  $1600-2200^{\circ}\text{C}$ ; хөх тариа  $1700-2100^{\circ}\text{C}$ ; хошуу будаа  $1900-2300^{\circ}\text{C}$ ; төмс  $1300-3000^{\circ}\text{C}$ ; чихрийн манжин  $2400-3700^{\circ}\text{C}$ ; цагаан будаа  $3000-4500^{\circ}\text{C}$ ; хөвөн  $3500-5000^{\circ}\text{C}$  дулаанд сайн ургана. Тэжээлийн горим, цаг уурын нөхцөл, ургалтын хугацаа, газар нутгийн резьефийг хамааруулан шинжиж байх хэрэгтэй.

Температурын хэлбэлзэл ихтэй байх нь ургамлын өсөлт хөгжилд муу нөлөөтэй. Тохиромжтой дулаан нь бусад хүчин зүйлүүдийг тааламжтай болгоно. Дулаан дутагдалтай байх нь өсөлт, хөгжилтгйг удаашруулдаг. Хэт их дулаан ба халалт ургамлын ферментийн үйл ажиллагаа, фотосинтезийг зогсоож, ургалт зогсох төдийгүй үхэхэд хүргэнэ.

Агаарын болон хөрсний температурын нөхцлөөр ихээхэн өвөрмөц, жилийн агаарын температур  $-1-2^{\circ}\text{C}$  байдаг ба хамгийн дулаан нь болох  $7,8^{\circ}\text{C}$ -р сард хангайд агаарын температур  $15-20^{\circ}\text{C}$ , Говьд  $22-28^{\circ}\text{C}$ , Хөвсгөл орчимд  $9,6, -9,7^{\circ}\text{C}$  байдаг. Агаарын температур маш их хэлбэлзэлтэй бөгөөд жилийн хамгийн их хэлбэлзэл  $86-90^{\circ}\text{C}$ , хоногийн агаарын температурын хэлбэлзэл мөн их бөгөөд хавар  $3,4^{\circ}\text{C}$ -р сар, намар  $9^{\circ}\text{C}$ -р сард хамгийн их нь  $20-27^{\circ}\text{C}$  хүрдэг.

Агаарын температурын  $+5^{\circ}\text{C}$  –аас дээш үргэлжлэх хугацааг ургамал ургалтын бүрэн хугацаа гэж үздэг. Энэ хугацаанд өвөлжих ба үр тариа, олон наст өвс тариалах боломж илүүтэй юм.

$+10^{\circ}\text{C}$ -аар дээш дулаантай хоногийн тоог ургамал ургалтын тохиромжтой дундаж хугацаа гэнэ. Энэ хугацаанд наранцэцэг, чихрийн манжин, хүнсний ногоо, буурцагт үр тарианы тарималууд сайн ургана.

$+15^{\circ}\text{C}$  дээш хоногийн тоог дулаанд дуртай ургамлын ургалтын хугацаа гэнэ. Энд эрдэнэ шиш, хөвөн, усан үзэм зэрэг ургамлууд сайн ургана.

Ургамал ургалтын хугацаанд үргэлжлэл манай орны бүс бүрд харилцан адилгүй байдаг бөгөөд Их нууруудын хотгорт буюу Хөвсгөл аймгийн нутагт  $+5^{\circ}\text{C}$ -ээс дээш дулаан байх хугацаа 5-р сарын 7-нд эхэлж, 10-р сарын 7-нд дуусч, 153 хоног үргэлжилдэг байна.

Харин +10с-ээс дээш дулаан байх хугацаа 5-р сарын 25-нд эхэлж, 9-р сарын 20-нд дуусч, 118 хоног үргэлжилдэг байна.

Хаврын эцсийн хүйтрэлт орой, намрын эхний хүйтрэлт эрт болдог учир таримлыг зөв сонгон тариалах, эсвэл цочир хүйтрэлтээс хамгаалах, хүлэмжийн тариалан эрхлэх, хучлага +6 хэрэглэх аргыг өргөн нэвтрүүлэх нь чухал байдаг.

Доктор Ph.D Б.Жамбаажамц “Хөдөө аж ахуйн уур амьсгалын нөөц” (1983) номондоо Монгол орны газар нутгийг +10С-ээс дээшхи идэвхитэй температурын 80%-ийн хангамжтай нийлбэрээр нь:

<1250с бол хүйтэн бүс  
1250-1750с бол сэрүүн бүс  
1750-2250с бол сэрүүвтэр бүс  
2250-2750с бол дулаавтар бүс  
>2750с бол дулаан бүс  
гэж ангилсан байна.

Түүнчлэн ургамлын чийг хангамжийн бүсийг ургамлын чийгийн 80%-ийн хангамжаар тооцоолсон хуурайн зэргийг гаргахдаа:

<1.0 бол чийглэг  
1.1-2.5 бол чийглэгдүү  
2.6-4.0 бол хуурайдуу  
4.1-5.5 бол хуурай  
> 5.5 бол нэн хуурай  
гэж тус тус хязгаарлан ангилсан байна.

Дээрх үзүүлэлтүүдийг 7-р сарын агаарын дундаж температур, хур тунадас, ууршилт, дутагдал чийгийн мэдээтэй хам боловсруулан Монгол орны хэмжээгээр ургамлын дулааны болон чийгийн хангамжийн зургийг боловсруулж, бүс бүслүүр бүрийн уур амьсгалын статистик үзүүлэлтүүдийг тодорхойлсон байна. (Монгол улсын Үндэсний атлас)

Хүснэгт №2.5. Монгол орны ургамлын дулаан хангамжийн нөхцөл

Код	Дулааны бүслүүр	Дэд бүслүүр	Тухайн нөхцөлд тариалах боломжтой бүлэг таримал	+10с-аас дээш темп-н нийлбэр, °С	+5с-аас дээш темп-н нийлбэр, °С	7-р сарын дундаж темп, оС	Цочир хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа/өдөр/	Таримал ургамал ургах хугацаа /өдөр/	Ургамал ургах хугацаа /өдөр/
1	Хүйтэн	Нэн хүйтэн	Дулаалгатай ба хагас дулаалга-тай таримал	< 400	< 720	< 8	< 45	< 20	< 90
2		Хүйтэн	Ургах хугацаа богино, эрт болцтой хүнсний ногоо	400-1000	720-1325	8 – 13	45 – 70	20 – 55	90 – 115
3		Хүйтэвтэр	Эрт болцтой таримал	1000-1400	1325-1730	13 – 15	70 – 90	55 – 80	115 – 135
4		Хүйтэвтэр	Эртэвтэр болцтой таримал	1400-2000	1730-2230	15 – 19	90 – 110	80 – 115	135 – 160


5	Сэрүүн	Сэрүүн	Дунд болцтой таримал	2000-2600	2230-2940	19 – 22	110 – 140	115 – 150	160 – 190
6			Хожуувтар болцтой таримал	2600-3000	2940-3345	22 – 23	140 – 160	150 – 175	190 – 200
7			Хожуу болцтой таримал	> 3000	> 3345	> 23	> 160	> 175	> 200

Хүснэгт №2.6. Монгол орны ургамлын чийг хангамжийн нөхцөл


Код	Чийгшлийн бүс	Чийг хангамжийн дэд бүс	Агаарын чийгшлийн үзүүлэлт				Ургамлын чийг хангамж, %
			P/d	P/f	f/P	P	
1	Чийг хүрэлцээтэй	Илүүдэл чийгтэй, чийгтэй	>0.45	>1.00	<1.00	>580	>100
2	Чийг хүрэлцээгүй	Чийгтэйвтэр	0.35-0.45	0.77-1.00	1.00-1.28	460-580	80 – 100
3		Гандуувтар	0.25-0.35	0.55-0.77	1.28-1.80	340-460	55 – 80
4		Гандуу, нэн гандуу	0.15-0.25	0.33-0.55	1.80-3.00	220-340	30 – 55
5	Чийг багатай	Хуурайвтар, хуурай	0.05-0.15	0.12-0.33	3.00-4.50	105-220	10 – 30
6		Нэн хуурай	<0.05	<0.12	-	<105	< 10

Энэхүү статистик мэдээнд тулгуурлан боловсруулсан зургаас Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрээр таслан дүн шинжилгээ хийх ажлыг гүйцэтгэж ургамлын дулааны болон чийгийн хангамжийн бүс, дэд бүслүүрийн Хөвсгөл аймгийн нутгаар эзлэх хувийг 6 ба 7-р хүснэгтүүдээр харууллаа.

Ургамлын дулаан хангамжийн хувьд Хөвсгөл аймагт хүйтэвтэрээс нэн хүйтэн бүслүүр дайрах ба аймгийн нийт нутгийн 50 орчим хувийг эзэлж байгаа хүйтэвтэр дэд бүслүүрт хүйтрэлгүй үргэлжлэх хугацаа 70-110 хоног ба дулаан хангамж таримал болоод байгалийн ургамал ургахад арай илүү тохиромжтой буюу таримал ургамал 55-115, байгалийн ургамал 115-135 хоног ургах боломжийг бүрдүүлж байна.




Зураг№2.13. Ургамлын дулаан хангамжийн нөхцөл




Зураг№2.14. Хөвсгөл аймгийн ургамлын дулаан хангамжийн нөхцөлийн эзлэх талбай

Хүснэгт№2.7. Хөвсгөл аймгийн ургамлын дулаан хангамжийн байдал

Код	Дулааны бүс	Дэд бүслүүр	Тухайн нөхцөлд тариалах боломжтой бүлэг таримал	Талбай, км.кв	Эзлэх хувь, %
1	Хүйтэн	Нэн хүйтэн	Дулаалгатай ба хагас дулаалгатай таримал	22365.57	22
2		Хүйтэн	Ургах хугацаа богино, эрт болцтой хүнсний ногоо	30902.78	31
3		Хүйтэвтэр	Эрт болцтой таримал	38066.76	38
4			Эртэвтэр болцтой таримал	9414.66	9



Зураг№2.15. Ургамалын чийг хангамжийн нөхцөл



Зураг№2.16. Хөвсгөл аймгийн ургамлын чийг хангамжийн байдал

Ургамлын чийг хангамжийн бүс, дэд бүслүүрийн хувьд Хөвсгөл аймгийн нутгийн 50 орчим хувьд илүүдэл чийгтэйгээс чийгтэйвтэр дэд бүс дайран өнгөрч байгаа хэдий ч

орон зайн тархалтын хувьд чийг хүрэлцээтэй нутагт дулааны хувьд нэн хүйтэн, хүйтэн дэд бүслүүр давхцаж байгаа учраас байгалийн ургамал ургах нөхцөлийг бүрэлдүүлж байна.

Хүснэгт№2.8. Хөвсгөл аймгийн ургамлын чийг хангамжийн байдал

Код	Чийгшлийн бүс	Чийг хангамжийн дэд бүс	Талбай, км.кв	Эзлэх хувь, %
1	Чийг хүрэлцээтэй	Илүүдэл чийгтэй, чийгтэй	21956.98	22
2	Чийг хүрэлцээгүй	Чийгтэйвтэр	25969.47	26
3		Гандуувтар	35321.34	35
4		Гандуу, нэн гандуу	17497.34	17

Хүснэгт№2.9. Мөрөн станцын агаарын дундаж температур, 1960-2013

Он	Сар бүрийн агаарын дундаж температур [deg C / 10]												Дундаж
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
1962	-237	-153	-63	8	101	148	165	143	82	-12	-126	-150	-0.78
1963	-200	-170	-45	-20	95	140	160	155	67	-12	-95	-170	-0.79
1964	-233	-282	-86	0	92	155	176	158	65	-17	-113	-177	-2.18
1965	-200	-155	-62	5	110	165	163	142	76	-7	-117	-193	-0.61
1966	-203	-141	-75	-5	93	156	145	147	100	-2	-106	-267	-1.32
1967	-232	-197	-70	6	120	145	170	131	66	-1	-135	-246	-2.03
1968	-261	-225	-68	16	88	165	178	136	53	-27	-102	-183	-1.92
1969	-285	-230	-93	20	92	168	182	128	71	0	-110	-177	-1.95
1970	-210	-167	-133	7	88	158	195	145	62	-20	-131	-261	-2.23
1971	-260	-262	-135	27	93	135	155	140	72	-1	-93	-215	-2.87
1972	-270	-247	-86	40	106	167	162	147	68	-8	-98	-190	-1.74
1973	-237	-190	-63	25	75	161	157	132	92	-31	-105	-172	-1.30
1974	-231	-196	-101	33	92	150	165	157	73	-35	-126	-217	-1.97
1975	-192	-153	-60	-13	93	155	156	146	83	-21	-105	-241	-1.27
1976	-217	-138	-100	-5	81	152	156	130	90	-37	-205	-227	-2.67
1977	-312	-195	-67	11	75	160	167	160	103	5	-80	-175	-1.23
1978	-177	-160	-66	28	87	176	170	150	90	-5	-98	-217	-0.18
1979	-204	-110	-72	-5	106	190	167	137	83	31	-93	-153	0.64
1980	-215	-161	-109	-10	99	154	175	160	85	-20	-104	-184	-1.08
1981	-286	-195	-57	52	117	165	183	132	83	-58	-150	-196	-1.75
1982	-200	-194	-79	47	97	147	158	143	90	19	-126	-190	-0.73
1983	-223	-198	-82	-11	99	121	152	151	74	12	-90	-195	-1.58
1984	-221	-199	-70	2	113	152	147	127	80	16	-135	-234	-1.85
1985	-188	-175	-120	27	90	139	161	140	70	-10	-119	-215	-1.67
1986	-193	-198	-73	-4	117	148	163	143	103	-11	-144	-219	-1.40
1987	-190	-139	-93	34	101	142	160	149	87	-17	-135	-173	-0.62
1988	-206	-191	-97	25	95	151	173	162	97	-3	-78	-181	-0.44
1989	-262	-220	-50	42	111	142	168	145	67	18	-144	-170	-1.28
1990	-238	-148	-45	10	108	129	171	139	80	37	-101	-158	-0.13
1991	-260	-166	-83	-1	96	155	179	163	85	18	-86	-211	-0.93
1992	-205	-157	-69	32	125	160	176	144	65	-20	-75	-198	-0.18
1993	-279	-161	-45	17	85	146	160	147	83	-7	-157	-191	-1.68
1994	-166	-176	-67	37	111	162	170	146	77	6	-67	-241	-0.07
1995	-212	-169	-53	17	77	148	178	157	90	14	-61	-178	0.07
1996	-215	-191	-93	18	111	150	193	161	91	-1	-105	-131	-0.10
1997	-233	-161	-11	69	124	172	174	153	85	26	-107	-180	0.93
1998	-205	-117	-64	41	108	152	182	165	103	23	-83	-144	1.34
1999	-168	-119	-129	41	122	156	194	165	81	7	-86	-158	0.88
2000	-278	-189	-52	43	128	194	189	174	99	-22	-135	-163	-0.10
2001	-255	-143	-42	35	115	182	186	172	103	14	-122	-226	0.16
2002	-174	-132	-44	20	119	190	208	193	105	-8	-111	-283	0.69
2003	-234	-161	-84	20	99	185	183	146	99	10	-106	-170	-0.11
2004	-168	-107	-71	62	123	178	187	154	93	13	-104	-183	1.48
2005	-261	-287	-86	46	97	168	194	165	89	25	-72	-195	-0.98
2006	-219	-150	-43	-2	85	158	178	155	101	11	-59	-154	0.51

2007	-195	-109	-57	53	127	173	207	173	115	-2	-81	-181	1.86
2008	-257	-175	-16	47	100	172	191	158	95	14	-53	-153	1.03
2009	-210	-156	-66	65	121	150	178	152	93	9	-112	-203	0.18
2010	-248	-215	-97	-9	103	179	192	152	111	17	-63	-173	-0.43
2011	-278	-178	-79	54	87	168	180	177	83	25	-152	-220	-1.11
2012	-234	-188	-80	36	107	161	183	161	106	5	-154	-240	-1.14
2013	-253	-191	-27	40	115	155	183	161	89	3	-59	-153	0.51

## Хүснэгт №2.10. Мөрөн станцын хур тунадасны нийлбэр, 1960-2013


Он	Сар бүрийн нийлбэр хур тунадас [мм /10]												Нийлбэр
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
1962	13	0	28	14	23	699	557	1230	41	29	0	6	264
1963	31	59	32	11	115	712	1625	438	303	52	11	1	339
1964	24	12	6	197	263	638	334	1633	234	126	39	0	350.6
1965	0	0	12	18	131	274	507	323	89	63	31	59	150.7
1966	16	12	35	56	160	522	1012	799	57	48	0	22	273.9
1967	4	30	0	116	174	868	998	995	247	28	24	0	348.4
1968	30	48	24	39	272	130	706	558	501	121	3	3	243.5
1969	27	0	11	21	381	112	308	883	111	13	14	0	188.1
1970	0	14	4	24	87	323	346	474	244	8	6	32	156.2
1971	41	11	0	2	82	749	1300	434	140	40	34	35	286.8
1972	60	0	8	65	17	321	802	243	80	93	0	44	173.3
1973	4	10	2	27	30	864	653	1210	470	94	31	2	339.7
1974	13	4	11	283	80	194	769	773	27	24	0	10	218.8
1975	13	0	3	208	31	549	976	458	117	267	17	8	264.7
1976	2	6	12	55	324	262	901	605	47	50	78	1	234.3
1977	25	1	10	64	86	187	828	149	72	10	4	4	144
1978	3	4	0	80	174	252	302	140	597	24	9	61	164.6
1979	7	0	2	47	54	105	807	328	232	69	7	5	166.3
1980	17	0	6	11	128	312	362	463	117	4	38	14	147.2
1981	28	7	19	66	123	201	248	1207	54	32	24	0	200.9
1982	2	0	0	0	48	492	719	564	200	10	51	27	211.3
1983	4	18	2	35	38	674	873	425	105	0	26	0	220
1984	2	6	0	0	22	604	1021	688	194	12	42	10	260.1
1985	0	11	7	85	445	277	348	698	66	40	1	19	199.7
1986	15	8	15	254	118	2366	1205	227	147	119	34	49	455.7
1987	2	5	4	53	79	246	642	963	110	118	30	7	225.9
1988	0	63	0	31	303	198	163	715	170	75	0	24	174.2
1989	40	2	0	44	565	533	453	604	365	5	54	9	267.4
1990	2	2	9	181	215	849	1097	420	130	23	13	13	295.4
1991	22	6	4	79	122	732	576	634	214	28	3	43	246.3
1992	7	10	24	19	200	222	386	494	626	40	31	78	213.7
1993	5	15	4	0	138	720	915	697	229	65	16	28	283.2
1994	9	13	4	57	119	911	766	287	532	119	50	26	289.3
1995	0	3	10	18	201	356	892	523	16	9	0	0	202.8
1996	0	44	6	20	55	235	613	335	113	0	5	75	150.1
1997	38	0	5	17	428	291	1204	216	100	1	14	6	232
1998	0	3	6	25	282	175	1705	698	482	98	27	3	350.4
1999	3	0	22	41	58	285	608	214	112	2	25	10	138
2000	48	22	45	33	440	320	492	482	322	76	26	107	241.3
2001	12	0	1	192	342	389	646	787	101	12	94	71	264.7
2002	5	0	0	98	172	239	764	94	51	183	23	80	170.9
2003	70	11	13	135	178	145	743	682	220	10	5	11	222.3
2004	7	3	14	24	49	304	711	551	26	0	32	54	177.5
2005	29	23	78	28	211	127	865	1192	200	89	0	0	284.2
2006	9	29	0	343	102	374	898	208	342	90	27	10	243.2
2007	28	0	6	108	139	466	666	496	222	37	12	25	220.5
2008	7	0	2	58	65	409	602	856	186	230	1	12	242.8
2009	10	27	70	5	62	697	501	601	183	28	13	41	223.8

2010	44	5	14	9	163	499	650	737	111	132	2	71	243.7
2011	53	11	18	43	200	870	351	283	87	38	89	15	205.8
2012	0	7	45	147	128	560	768	581	114	73	100	81	260.4
2013	0	11	0	39	63	1172	790	699	191	63	32	28	308.8

### 2.3. Уур амьсгалын өөрчлөлт


#### Агаарын дулаан, хүйтний өөрчлөлт.

Монгол улсын хэмжээнд агаарын жилийн дундаж температур сүүлийн 70 жилд 2.14°C хэмээр нэмэгдсэн. Энэхүү үр дүнг Монгол орны нийт нутаг дэвсгэрийг хамаран байрласан 48 станцын олон жилийн ажиглалт хэмжилтийн цувааны шугаман хамаарлаар тооцон гаргасан болно. Энэхүү өсөлт нь дэлхийн дундаж температурын өсөлтөөс давж гарсан үзүүлэлт юм.



Зураг№2.17. Жилийн дундаж температурын өөрчлөлт, 0C





Зураг №2.18. Жилийн дундаж температурын өөрчлөлт, 0C

Хөвсгөл нуур Эг голын сав газрын агаарын жилийн дундаж температур Хөвсгөл нуурын баруун хэсгээр -4-8.0C, зүүн эрэг болон Эг, Үүрийн голын эхээр -40C-аас хүйтэн голын дунд адаг хэсэгт -10C-аас дулаан байдаг байна. Нийт нутаг далайн түвшнээс дээш ихээхэн өргөгдсөн учир зун сэрүүн, өвөл хүйтэн. Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын жилд 180-220 орчим хоног агаарын температур хасах хэмтэй байна. Жилийн доторх хуваарилалтын хувьд монгол орны нийт нутгийн цаг агаарын хуваарилалтын нэгэн адил 1 дүгээр сард хамгийн хүйтэн 7 дүгээр сард хамгийн дулаан байна.

#### **Хөвсгөл-Эгийн голын сав газрын уур амьсгалын ерөнхий төлөв**

Эгийн голын сав газрын дээд хэсэг буюу Үүр, Уйлгана голын эх хэсэг уур амьсгалын чийглэг хүйтэн зунтай бүсийн хахир өвөлтэй 2 дахь мужид, бусад хэсэг чийглэг хүйтэвтэр зунтай хахир өвөлтэй 2 дахь мужид хамрагдана (*Үндэсний атлас, 2009*).


Агаарын дулаан хангамж буюу +10°C-с дээших агаарын хоногийн дундаж температурын нийлбэр 1500-2000 байна. 15 м/с -ээс дээш хүчтэй салхитай байдаг өдөр болон цасан шуургатай байдаг өдрийн тоо голын савын эхэн хэсэгт 10 бусад хэсэгт 5-10 өдөр байна. Өвөл агаарын температур нэн хүйтэн буюу -30°C ба түүнээс доош температуртай байдаг өдрийн тоо голын эхэн хэсэгт дунджаар 45 хоног, доод хэсэгт 35 хоног зун нэн халуун буюу +30°C ба түүнээс дээш температуртай байдаг өдрийн тоо Хөвсгөл нуурын эргэн тойронд дунджаар 15 хоног, сав газрын дунд хэсгээр 25 хоног, Сэлэнгэ мөрөнд цутгах орчимд 35 хоног байна (*Үндэсний атлас, 2009*).

#### **Хөвсгөл -Эг голын сав газрын агаарын температурын 1960-2010 оны явц**

Харин сар бүрийн агаарын температурын өөрчлөлтөөс харахад өвлийн 3 сарын температур сав газрын эхэнд 2-30C, дунд хэсэгт 1-20C, хаврын сарынх сав газрын дээд хэсэгт 1.5-2.50C, дунд хэсэгт 1.5-200C, зуных сав газрын дээд хэсэгт 0.6-1.20C, дунд хэсэгт 0,6-1.50C, намрынх сав газрын дээд болон дунд хэсэгт адилхан 2.0-2.50C-р

нэмэгдсэн байна. Гэхдээ зуны саруудын температур 1940 оноос 1980 он хүртэл бага зэрэг буурч байснаа түүнээс хойш нилээд эрчимтэй нэмэгдэж байна.

Хөвсгөл нуур - Эг голын сав газрын уур амьсгалыг өөр бусад газартай харьцуулж үзэх цаг уурын станц байхгүй буюу уур амьсгалын төлөв байдлын олон жилийн явцыг харуулах хангалттай мэдээ байхгүй газрын уур амьсгалд гарч байгаа өөрчлөлтийг гаргахын тулд Монгол орны 69 станцын агаарын температурын олон жилийн өөрчлөлтийн хандлагын шугаман регрессийг тооцож, абсолют өөрчлөлтийн орон зайн тархалтыг гаргалаа. Үүнд: цэгэн мэдээллийг өндрийн тоон загвартай хослуулан интерполяцлах Co-kriging аргаар тооцсон. Эндээс харахад Хөвсгөл нуур -Эг голын сав газрын эхэн хэсгээр 2.8 градус, дунд хэсгээр 2.0 градус, доод хэсгээр 1.8 хүртэл дулаарсан байна.




Зураг№2.19. Монгол орны агаарын температурын өөрчлөлтийн орон зайн тархалт

### 2.3.1. Хур тунадасны өөрчлөлт

Хур тунадасны орон зай ба цаг хугацааны хувьсал өөрчлөлт температурынхаас илүү их байдаг. Иймд температуртай харьцуулбал хур тунадасны хандлагыг тооцоход илүү хүндрэл учирна. Урт цуваагаар тооцсон хандлагын үнэмшлийн түвшин 90 хувь байна.

Өвлийн хур тунадас ерөнхийдөө нэмэгдэж, харин дулаан улирлын болон зуны хур тунадас буурч байгаа нь илэрхий харагдана.

Жилд унах хур тунадасны хэмжээ багассан хандлагатай байна. Жилийн хур тунадасны явц нь дулаан улирлын хур тунадасны, түүний дотор жилийн нийлбэрийн 70%-ийг эзлэдэг зуны хур тунадасны явцаар тодорхойлогддог. Доорхи зурагт жилийн нийлбэр хур тунадасны олон жилийн явцыг үзүүлэв.



Зураг№2.20. Жилийн нийлбэр хур тунадасны олон жилийн явц

Ургамал ургалтын хугацааны хур тунадасны горимд орж байгаа бас нэг өөрчлөлт бол нийт хур борооны хэмжээний дотор аадар хур борооны хэмжээ нэмэгдэж байгаа явдал юм. Харин зуны хур тунадасны өөрчлөлт нь олон жилийн дундажтайгаа харьцуулахад өвлийн улирлыг бодвол бага нэмэгдэх хандлага байна.


### Цэвдэг

Өргөрөг хойшлох тутам цэвдгийн тархалт нэмэгдэж, үргэлжилсэн цэвдэгтэй газар элбэг болно. Мөн сүүлийн 50-иад жилийн хугацаанд термокарст, солифлюкци, термоэрози, халиа зэрэг цэвдэгт үзэгдэл нилээд идэвхитэй явагдах болов. Олон жилийн бөөргийн орой гэсэж доош сууж хонхор үүсэх, бөөргийн мөс хайлж хонхорт нуур тогтох, мөсөрхөг цэвдэгтэй ул хөрс гэсэж термокарстын нуур үүсэх зэрэг үзэгдэл элбэг тохиолдох болов. Цэвдгийн тархалт, хэмжээг тодорхойлоход хүндрэлтэй байдаг. Цэвдэгийн тархалтыг агаарын температурыг ашиглан тооцох аргыг өргөн ашигладаг боловч хөрсний гүний температур, агаарын температур хоорондоо өөр байдаг. Цэвдэгийн тархалт, гүн зэргийг загварчлах ихэнх аргууд нь хөрсний дулаан дамжуулалт дээр тулгуурласан байдаг бөгөөд энэ нь хөрсний физик, ус дулааны тухай өргөн мэдээлэл шаарддаг.

Цэвдгийн бүс багасаж байгаа бүсүүдэд хөрсний чийг мэдээж нэмэгдэнэ. Хөрсний чийг нэмэгдэх нь магадгүй тохиолдлын цэвдэгтэй бүсэд бэлчээрийн гарц нэмэгдэх нөхцөл бүрдэх эерэг талтай байж болно. Харин бусад бүс нутгийн хувьд хөрс чийгээр хэт ханаж бэлчээр намагжих, хот суурин газрын барилга байшин суух, зам гүүр эвдрэх гэх мэт сөрөг нөлөө гарч болох юм. Мөн хөрсний чийг нэмэгдэх нь газрын дээрх болон газрын доорх усны харилцан уялдааг нэмэгдүүлж гадаргын усны тухайлбал гол мөрний урсац, нуурын усны түвшин цэвдгийн эхэн үеийн эрчимтэй хайлалтын үед нэмэгдэж цаашид ус намаг ширгэж хөрс хуурайших нөхцөлд гадаргын болон газрын доорх усны нөөц багасч улмаар хатаж ширгэх сөрөг үр дагаврыг авчирч болох юм.

Монгол орны хувьд мөнх цэвдэг хойд өргөргийн  $43^{\circ}$ -аас хойш нутагт орших ба нийт нутгийн 63 хувьд цэвдэгт хөрс тархсан байна.

Мөнх цэвдэг гэж 2 жил буюу түүнээс дээш жил хөрсний гүний температур нь  $0^{\circ}\text{C}$ -ээс бага байдаг газар нутгийг хэлдэг. Мөнх цэвдэг тархсан байдлаар нь үргэлжилсэн, тасалданги, элбэг, алаг цоог, ховор алаг цоог, тохиолдлын, өнжмөл, улирлын тархалттай гэж 7 бүсэд ангилж үздэг.




Зураг №2.21. Монгол орны цэвдгийн газарзүйн тархалт

Өргөрөг хойшлох тутам цэвдгийн тархалт нэмэгдэж, үргэлжилсэн цэвдэгтэй газар элбэг болно. Сүүлийн 30 гаруй жилд цэвдэгт-нутгийн ул хөрсний улирлын гэсэлтийн давхарга Хөвсгөлийн уулархаг нутагт 0.6-1.6 см-ээр нэмэгджээ Хөвсгөлийн Артаг уулын 29.5 м, байна. Харин цэвдэгт ул хөрсний жилийн дундаж температур сүүлийн 10-30 жилийн хугацаанд Хөвсгөл, Хангайн уулархаг нутагт  $0,10-0,15^{\circ}\text{C}$ -аар тус тус нэмэгджээ.

Хөвсгөл нуур -Эгийн голын сав газрын хэмжээнд олон жилийн цэвдэг, ан цавлаг шохойн чулуу, гадаргын ус харьцангуй элбэг байдаг онцлогтой. Монгол орны цэвдэг хөрс чулуулагийн мужлалаар Хөвсгөл нуур -Эг голын сав газрын эхэн хэсэг үргэлжилсэн, дунд хэсэг тасалданги, элбэг алаг цоог, доод хэсэгт ховор алаг цоог, тархсан цэвдэгт бүслүүрт хамаарна. Тус бүслүүрийн цэвдэг хөрсний 20 м-ийн гүн дэхь температур  $-1-5^{\circ}\text{C}$  ба улирлын цэвдэг чулуулаг  $0-+3^{\circ}\text{C}$ , улирлын хөлдөлтийн гүн 2.5-5.0 м хүрдэг (Д.Төмөрбаатар, 2000). Мөн Шархүү нарын (2005) судалгаагаар Хатгал орчимд улирлын гэсэлтийн гүн 1969 онд 3.6 м, 1983 онд 4.0 м, 2004 онд 4.7 м хүрсэн Хөвсгөл орчимын олон жилийн цэвдэг Хангай, нуруунхаас илүү эрчимтэй явагдаж байна гэжээ.

### **Өндөр уулын мөнх цас, мөс ба цасан бүрхүүл.**

Монгол оронд өвөлдөө маш бага хур тунадас унах тул цасан бүрхэвчинд агуулах усны хэмжээ мөн хязгаарлагдмал болно. Гэхдээ голын жилийн урсацын 10-30% нь хаврын улиралд хайлсан цас мөснөөс бүрдэнэ.



Зураг№2.22. Монгол орны нутаг дэвсгэр дээрхи цасан бүрхүүлийн байдал


**Өндөр уулын мөстөл.** Мөстөлийн өөрчлөлтийг дэлхий нийтээрээ уур амьсгалын өөрчлөлтийн хамгийн тод индикатор гэж үздэг. Мөстөл бүхий бүс нутагт мөстөлийн хэмжээ, талбай улам л хумигдсаар байна. 2002 оноос эхлэн мөстөлийн байнгын ажиглалт хэмжилтийг хийж байна.

### **Цөлжилт**

Монгол нутаг одоо цагт явагдаж байгаа цөлжилтийн уур амьсгалын хүчин зүйл нь ургамал ургалтын хугацааны агаарын температурын өсөлт, үүнээс уламжлан дэвсгэр гадаргын ууршиц эрс нэмэгдэж байхад түүнийг дагаад хур тунадасны хэмжээ зохих хэмжээгээр /ууршицын алдаглыг нөхөх хэмжээнд/ нэмэгдэж чадахгүй, харин ч ихэнх нутагт буурч байгаа, ургамлыг халууны дарамтанд оруулах хэт халуун өдрийн тоо нэмэгдэж байгаа, жилийн дулаан улиралд ордог хур борооны дотор аадар хур борооны эзлэх хувийн жин хориод хувиар нэмэгдсэн, хур борооны нийт үргэлжлэх хугацаа богиноссон, цасан бүрхүүл эрт арилж ургамал ургахаас өмнө хөрс нүцгэн байдаг хоногийн тоо ихэссэн, үүнээс үүдээд өнгөн хөрсний сул элс, шороо салхинд хийсэх буюу шороо шуурах потенциал боломж нэмэгдсэн зэрэг олон хүчин зүйлийг тоочиж болно.

Манай орны цөлжилт гамшгийн хэмжээнд хүрчихсэн талаар судлаачид аль эрт хэлсээр байхад дорвитой арга авахгүй байсаар элс гэж мэдэхгүй шахам байсан дархадын хотгорт өндөр өндөр элсэн манхнууд бий болжээ.

Хөвсгөл аймгийн төв Мөрөн, Дархадын хотгор элсжиж эхэлчихээд байгаа нь Монголын цөлжилт гамшгийн хэмжээнд очсоныг харуулана. Мэдээж үүний шалтгаан нь дэлхийн уур амьсгалын дулаарлаас гадна хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй юм. Дархадын хотгор 300 гаруй том, жижиг нууртай, араатан жигүүртэн элбэгтэй, хэн бүхний гэтэл өнөөдөр 20 орчим нуур ширгэж, цөлжилт явагдах гол үндэс болжээ. Эдгээр нуурын хамгийн томд тооцогдох Цойцон нуур ширгэсэнээр байгалийн тэнцвэрт байдал илүү хурдтай алдагдаж байгааг онцолж байна.



Зураг №2.23. Монгол орны цөлжилт, газрын доройтлын байдал, 2006 он

Монгол нутаг одоо цагт явагдаж байгаа цөлжилтийн уур амьсгалын хүчин зүйл нь ургамал ургалтын хугацааны агаарын температурын өсөлт, үүнээс уламжлан дэвсгэр гадаргын ууршиц эрс нэмэгдэж байхад түүнийг дагаад хур тунадасны хэмжээ зохих хэмжээгээр /ууршицын алдаглыг нөхөх хэмжээнд/ нэмэгдэж чадахгүй, харин ч ихэнх нутагт буурч байгаа, ургамлыг халууны дарамтанд оруулах хэт халуун өдрийн тоо нэмэгдэж байгаа, жилийн дулаан улиралд ордог хур борооны дотор аадар хур борооны эзлэх хувийн жин хориод хувиар нэмэгдсэн, хур борооны нийт үргэлжлэх хугацаа богиноссон, цасан бүрхүүл эрт арилж ургамал ургахаас өмнө хөрс нүцгэн байдаг хоногийн тоо ихэссэн, үүнээс үүдээд өнгөн хөрсний сул элс, шороо салхинд хийсэх буюу шороо шуурах потенциал боломж нэмэгдсэн зэрэг олон хүчин зүйлийг тоочиж болно.


## ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОР НӨХЦЛИЙН МУЖ, ТОЙРГУУДЫН ОНЦЛОГ

### Байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийн мужлал

Хөвсгөл аймаг нь Хангай, Хөвсгөл орчмын өндөр уул, тайга хосолсон муж, Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон муж, Орхон-Сэлэнгийн савын ойт хээрийн мужуудад харьяалагдан ландшафтын 5-н тойргийг хамарч байна. Үүнд:

- Хөвсгөлийн баруун хэсгийн тайгат өндөр уул, хотгорын тойрог
- Хөвсгөлийн зүүн хэсгийн тайгат дундаж уулсын тойрог
- Ханхөхийн нурууны ойт хээр бүхий тойрог
- Булнай-Тарвагатайн нурууны ой, тайга бүхий тойрог
- Орхон-Туулын савын бэсрэг уулс бүхий ойт хээрийн тойрог болно.

Эндээс тус аймгийн нутаг дэвсгэр, байгаль газарзүйн нөхцлөөрөө эрс ялгагдсан хэсгүүдээс бүрдэж байгааг харж болно. Өөрөөр хэлбэл тус аймгийн нутагт, өндөр уулс, ойт хээр зэрэгцэн хослон оршдог өвөрмөц онцлог бүхий газар нутаг юм.



Зураг № 3.1. Хөвсгөл аймгийн байгаль нутаг дэвсгэрийн мужлалын зураг

### 3.1. Хөвсгөл орчмын өндөр уул, тайга хосолсон муж

Хөвсгөл орчмын өндөр уул, тайга хосолсон муж нь байгалийн цогцолборын хувьд ихээхэн өвөрмөц юм. Тус мужид нэг талаас Азийн хэвшинжийн байгалийн цогцолборууд харилцан түрж нэвтрэлцсэнээс гадна өмнөд Сибирийн байгалийн нэг хэсэг байдгаараа онцлогтой. Хөвсгөлийн муж нь тус орны хойт хэсэгт улсын хилийн дагуу орших бөгөөд

өмнө талаараа Хангайн мужтай, зүүн өмнө талаараа Орхон-Сэлэнгийн савын дундаж, нам уулсын мужтай тус тус хиллэнэ.

Хөвсгөлийн муж нь монгол орны байгалийн мужийн нэг томоохон төлөөлөгч болох бөгөөд гадаргын хувьд ян сарьдаг бүхий өндөр уул нурууд, дундаж өндөр уулс, тэдгээрийн хооронд орших томоохон буурц хотгор, гол мөрдийн хөндий хосолсон өвөрмөц тогтоцтой юм. Иймд Хөвсгөл орчмын өндөр уул, тайга хосолсон муж нь хил залгаа мужуудаас морфоструктурын онцлог, ландшафтын хэвшинжийн хослолоор илт ялгагдах бөгөөд дотроо Хөвсгөлийн баруун хэсгийн тайгат өндөр уул, хотгорын тойрог /Х-1/, Хөвсгөлийн зүүн хэсгийн тайгат дундаж уулсын тойрог /Х-2/ гэсэн 2 тойрогт хуваагдана.

Тойргийг ялган тогтоох үндэслэл нь гадаргын онцлог, уул нуруудын чиглэл, ландшафтын нэгэн төрөл байдал давамгайлах шинж болно. Уулс нь гол төлөв уртрагийн дагуу чиглэлтэй бөгөөд гурван том тектоник хотгороор /Хөвсгөл нуурын, Дархадын хотгорын, Бүсийн голын/ Хөвсгөлийн баруун хэсгийн өндөр уулс, Шишхэд орчмын дундаж уулс, Хөвсгөлийн зүүн хэсгийн тэгш өндөрлөг гэсэн гадаргын өөр өөр хэлбэр, бүтэц бүхий хэсэгт хуваагдана.

*Хөвсгөлийн баруун хэсгийн тайгат өндөр уул, хотгорын тойрог /Х-1/-т* Хөвсгөл нуураас баруун тийш орших хурц шовх оргил, хэрчигдсэн хянга хяртай ба хүн амьтан гарч боломгүй эгц цавчим хажуутай өндөр сүрлэг уулс хамрагдах бөгөөд эндэхийн уулсын хамгийн өндөр оргил нь далайн түвшнээс дээш 3491 м өндөрт өргөгдсөн Мөнх сарьдаг уул юм. Мөн Хорьдол Сарьдаг /3130.0 /, Улаан тайга /3357.0/, Баян /3093.0/, Дээд , Доод Саалигийн нуруу зэрэг 3000 метрээс дээш өргөгдсөн өндөр уул нилээд бий. Эдгээр уулс нь залуу шинэхэн хотгор гүдгэр юм. Энд Монгол орны өөр хаана ч байдаггүй жинхэнэ “ альп “ хэв шинжийн гадарга орших бөгөөд нуруудын хяраар арзгар хадан оргилууд шовойж үзэгдэх ба хавцлууд нь эгц гүн, нарийхан давчуу, хажуунууд нь асга чулуу элбэгтэй байдаг. Хөвсгөл нуураас баруун тийш орших уулс нь хотгор гүдгэрийн хувьд зүүнээ бодвол ихээхэн өвөрмөц онцлогтой. Уулс нь өндрийн агууриг ихтэй, хажуу нь маш их эгц учраас өндрийн ялгаа богино зайд өөрчлөгдөнө. Ян сарьдаг бүхий зарим уулсад уулын тагийн дэнж үүсч хэд хэд үелж тогтсон нь цөөнгүй ажиглагдана. Уулын тагийн дэнж үүсэх үзэгдэл нь үнэмлэхүй өндөр болон хүйтний өгөршил , гулсалт зэрэг үйл явцтай ихээхэн холбоотой. Ян сарьдагийн оройн өргөн харилцан адилгүй боловч дунджаар 400-600м, хамгийн өргөн хэсэгтээ 1.5-2.0 км хүрнэ. Уулсын хажуу нь тектоник хагарлын ан цавыг дагаж тогтсон гүн нарийн хавцал, хөндийгөөр ихээхэн хэрчигдсэн байна. Хөвсгөл хавийн уулс нь монгол орны эртний мөсдөл их тархсан нутгийн нэгд орох бөгөөд мөсдлийн ул мөр болох хунх, кар, хөндий, морены толгод, нуур гадаргад тод хадгалагдан үлдсэн төдийгүй орчин үеийн хур цас, мөсөн гол, мөнх сарьдагийн нуруунд бий. Тухайлбал мөсдлийн хун Хорьдол сарьдаг, Мөнх сарьдагт тохиолдох бөгөөд эцсийн морены толгод Тэнгис голын хөндийд 1600-1700 метрт тааралдана.

Хөвсгөлийн уулст эртний мөсдөл болж байсан газрын талбайг Ч.Дүвжир /1970/ тооцоолсныг үзвэл Улаан тайгын нуруунд 4200 км<sup>2</sup>, зүүн Соёны Шишхэдийн савд 4200



км<sup>2</sup>, Хорьдол сарьдагийн нуруунд 3000 км<sup>2</sup> орчим гэж тооцоод нийтдээ Хөвсгөлийн уулст 16.5 мянган хавтгай дөрвөлжин км талбай мөсөөр хучигдмал байсан гэжээ. Эндэхийн уулс каледоны ариат бүсэд хамрагдах бөгөөд дунд болоод шинэ төрмөлийн эриний зохицлын хөдөлгөөнд өртөж улмаар шинэ төрмөлийн эриний сүүл үеийн шинэхэн тектоник хөдөлгөөнд хүчтэй автагдаж гадаргын байдал нь альпийн хэв шинжийн уулсын төрхийг олжээ.

Дээр дурьдсан хоёр нуруунаас баруун тийш эргэн тойрон уулсаар хүрээлэгдсэн Дархадын хотгор гэдэг уудам хотгор оршино. Дархадын хотгор зүүн хойноос баруун урагшаа 150 орчим км үргэлжлэх зууван хэлбэртэй байна Энэ хотгорын зүүн хойт хэсэг 30- 40 км өргөн, харин баруун өмнөд өнцөг нь 10- 15 км хүртэл нарийсч Өлийн даваанд тулна. Хотгорын гадарга зүүн, зүүн өмнөөс баруун, баруун хойш нийтдээ налуу бөгөөд хамгийн нам хэсэг нь баруун хойт өнцөг буюу Доод нуурын хавьд байна. Хотгорын ёроолд эртний мөстлийн гаралтай хэдэн арван нуур байгаагаас хамгийн том нь Доод нуур / үнэмлэхүй өндөр нь 1560 м / юм. Доод нуураас Енисей мөрний нэг цуггал болох Шишхэд гол гардаг. Дархадын хотгорын зүүн, зүүн өмнөд хэсэгт Хордил сарьдагийн нурууны баруун хажуугаас бууж Шишхэд голд цутгах Шүлүүст, Алхан, Баян, Жаргалант зэрэг олон жижиг голын усан гаралтай хурдас тунаж налуу хэлбэрийг гадарга үүсгэжээ. Мөн хотгорын зүүн хойт хэсэгт Жиглэг, Мөнх сарьдагийн салбар уулсаас эх авсан Арсай, Хотон, Шарга зэрэг голын хурдаснаас үүссэн тал газар байна. Шишхэд, Арсай, Шарга мэтийн томоохон голын хөндийн адагууд эртний нуурын тунамал хурдсыг эвдэлж, гадаргыг хэрчиж, зарим голд 2-3 дэнж үүсгэснээс гадна хөндийг нилээн өргөн болгож, адагт нь их хэмжээний хурдас хуримтлуулжээ. Дархадын хотгорын ёроол нь ухаа гүвээ бүхий талархаг гадаргатай болсон байх ба түүн дээр хүрмэн хад ба толгодын бүлгүүд үзэгдэнэ. Дархадын хотгор нь их төлөв сүүлийн үеийн голын ба нуурын хурдсаар бүрэлдсэн байдаг онцлогтой.

Энэхүү тойргын гадаргын ерөнхий онцлог бол бараг уртрагийн дагуу суналттай буурц хотгор, өндөр нурууд голлох бөгөөд гадаргын байдал хэрчигдэж ихээхэн бартаатай болжээ. Гадаргын бартаа их, хэрчигдлийн шигүү 0,5 км, 0,5-1 км бөгөөд гадаргын налуу 20 градусаас их байна. Энэ нь аж ахуй эрхлэхэд ихээхэн тохиромжгүй байдаг.

Хөвсгөлийн зүүн хэсгийн тайгат дундаж уулсын тойрог /Х-2/-т хамрагдах уулс нь хотгор гүдгэрийн хувьд баруун хэсгийнхээс эрс ялгаатай буюу мэдэгдэхүйц нам, тэгш өндөрлөгийн шинжтэй болно. Эндэхийн уулс нь 1700-2000 м дундаж өндөртэй, ихэвчлэн мөлгөр бөөрөнхийдүү хэлбэртэй ба орой хяр нь ойн захаас дээш цухуйж гарах нь нэн ховор. Зөвхөн Үүр голын эх хавьд 2500-2600 м өндөр өргөгдсөн Хэвэн залуу үүрийн сарьдаг хэмээх нүцгэн оргил бүхий уулстай. Үүнээс урагшаа уулс нь тэгш оройтой болж ой модоор битүү хучигдсан байна. Энд гол мөрний сүлжээ нягт, голуудын хөндий өргөн буюу Хангайн голуудын хөндийн морфологитой ойролцоо байна.

Энэ тойрог нь уул зүйн хувьд Хөвсгөл нуурын хотгор, Цагаан уулын район, Эг - Үүрийн хотгор зэргээс бүрдэнэ.

Хөвсгөл нуурын хотгор нь техтоник гаралтай буурц хотгор бөгөөд гарал үүслийн хувьд Байгаль нууртай нэг ижил гэж үздэг. Хөвсгөл нуур эрт төрмөлийн эриний үеийн хагарал дагаж тогтсон. Нуурын эргээр голчлон элэгдлийн чулуут эгц дэнж, хадан хясаа голлоно. Нуур руу түрж орсон сэвсгэр хурдсан хушуу мөн цутгал голын садраа адаг зарим хэсэгт нь бий .

Цагаан уулын район. Энэ нь уулт өндөрлөг бөгөөд үнэмлэхүй өндөр нь 2000 метрээс дээш юм. Хөвсгөл нуураас зүүн тийш түүний зүүн хойд өнцөгт галт уулын залуу чулуулгуудаас бүрэлдэн тогтсон байдаг. Энэхүү тэгш өндөрлөг талархаг шинжтэй ба нилээд чийг бүхий уур амьсгалтай учир нам газартаа ихээхэн намагтай байдаг. Зүүн тийш гадарга намсаж бэсрэг уулс голлох бөгөөд тэдгээрийн хооронд Эг, Үүр голын буурц хотгор уртрагын дагуу сунаж оршино.

Эг, Үүрийн хотгор. Энэ мөн тектоник буурц хотгор юм. Уг хотгорын баруун хажуу , уулсын хажуу бэлээр тектоник мөрөгцөг тодорхой илэрсэн байх бөгөөд зүүн хажуугийн уулс бусдаасаа харьцангуй налуувтар олон цуваа уулсаас тогтжээ. Иймээс энд уулс хоорондын бага шиг хөндий зэрэгцэн оршино. Хотгорын ёроолд намаг тархсан байх ба цэвдгийн гаралтай бичил гадарга нилээд түгээмэл тархалттай байна. Ус зүйн сүлжээ сайн хөгжсөн бөгөөд бөөрөнхийдүү хэлбэртэй өргөн хөндийнүүд бүхий Хангайн уулсын дүрс хэлбэртэй ойролцоо болж ирнэ.

Хөвсгөлийн уулс нь Монгол орны хамгийн өвөрмөц уулын байгууламж бөгөөд Байгалийн рифтийн баруун - өмнөд төгсгөл болдогооро онцлогтой. Хөвсгөл орчмын нутагт кембрийн өмнөх эриний занар , талст шохойн чулуулаг , нэвтэрмэл эх чулуулаг, боржин түүнчлэн эрт төрмөлийн эриний эхэн үеийн элсэн чулуулаг, хөрсөн чулуу, занар болон нэвтэрмэл боржин ихээхэн тархсан байдаг. Энэ нь ашигт малтмалын нөөцөөр арвин баялаг болохыг харуулдаг.

**Уур амьсгалын хувьд** энэ муж нь нэлээд өвөрмөц юм. Тухайлбал, зундаа сэрүүвтэр уур амьсгалтай, өвөлдөө хөндий хотгор газар их хүйтэн, хур тунадас бусад нутгаас харьцангуй их унадаг байна.

*Температур:* Хөвсгөлийн баруун хэсгийн тайгат өндөр уул, хотгорын тойрог нь Монгол орны хамгийн хүйтэн нутгийн нэг юм. Энд жилийн дундаж агаарын температур - 4° орчим буюу түүнээс хүйтэн байдаг. 1 дүгээр сард Идэр, Тэсийн голын хөндий, Дархадын хотгорт -31°С , -32°С орчим, 7-р сард мөн нутагт дунджаар +14°С байна.

Хамгийн хүйтэн нь өвлийн улиралд -45°С-аас доош ордог аж. Ургамал ургахад нэн их шаардлагатай идэвхитэй температурын нийлбэр бусад нутгаас харьцангуй бага. Тухайлбал хоногийн дундаж агаарын температурын +5 градусаас дээших температурын нийлбэр 1400-1600 градус буюу ургамлын дулааны хангамж дутагдалтай нутагт ордог.

Харин Хөвсгөлийн зүүн хэсгийн тайгат дундаж уулсын тойрог нь дээрхийг бодвол харьцангуй дулаавтар, жилийн дундаж агаарын температур - 1-ээс -3 градус орчим байна. Өвлийн улирлын (XII-II) сарын дундаж агаарын температур Хөвсгөлийн Тариалан сумын орчим -17.5°С-аас -20°С, зуны саруудад (VI- VIII) 14-16°С орчим байдаг, өөрөөр хэлбэл энэ тойрогт Хөвсгөлийн баруун хэсгийн тайгат өндөр уул хосолсон тойргоос өвөл нь

дулаавтар, харин дулаан улирлын агаарын температурын горим нь үндсэндээ адил байна. 7-р сард агаарын хамгийн их температур  $+32^{\circ}\text{C}$  хүрдэг. Гэвч зарим жил 7 дугаар сард ч шөнө  $-2^{\circ}\text{C}$  –аас  $-5^{\circ}\text{C}$  хүртэл цочир хүйтрэх явдал тохиолдоно. Хоногийн дундаж агаарын температур  $10^{\circ}\text{C}$ -ын заагаар хавар 6 дугаар сарын эхээр, намар 8 дугаар сарын сүүлчээр тус тус тогтвортой дайрч өнгөрдөг.  $10^{\circ}\text{C}$ -аас дулаан байх өдрийн тоо 70-80 хоног, энэ үед  $1250-1750^{\circ}\text{C}$  дулаан хуримтлагдана. Энэ мужид таримал ургамлын дулааны хангамж дутагдалтай боловч эрт болцын арвай, хошуу будаа, вандуй г.м үр тарианы ургамал, түүнчлэн төмс тариалах боломжтой.

**Ургамлан нөмрөг.** Ургамалжилтын хувьд зонхилох хэв шинж нь уулын шинэсэн ба шинэс-хушин тайга юм. Хөвсгөл нуурын зүүн тал нь хавьгүй өтгөн ой байх бөгөөд тэнд тайгатай холилдон хус, нарс оролцсон холимог ойн хэсэг бий.

Дархадын хотгорын зүүн зах, ялангуяа Арсайн голын дагууд хэсэгхэн гацууран ойтой, Шишхэд голын зүүн гар дагууд жодоо хэсэг хэсгээр тааралдана. Уулын таг, ян сарьдаг нь хэрчигдэл ихтэй, эгц, цавчим хад асга, нураг чулуу ихтэй тул нүцгэн, зарим хэсэгтээ хаг хөвдөн царамтай. Уулсын дээд хэсгээр бушилз, өлөн, тагийн өвслөг ургамал, намгархаг ба уулын нугатай юмуу сөөгөн торлогтой байна. Уулын хормой, хөндий ёроол дагуудаа ихэд намагжсан, бас навтгар хус (*Betula humilis*) зонхилсон сөөгөн торлогтой байдаг. Энэ мужийн нутагт ялангуяа баруун хэсэг болон дорнод хэсгийн өмнөд захын зарим уулсын нарлаг энгэр дагаж уулын хээрийн ургамалжилт тайгын гүн рүү нэвтэрч орсон байдаг. Дархадын хотгорт нэлээд их хэмжээний талбайг хамарсан хээрийн ургамалжилтын хэвшинжүүд ажиглагддаг нь хотгорын уур амьсгалын нөлөөтэй холбоотой юм.

Тус муж нь монгол улсын нутаг дэвсгэрийн 4.96%-ийг эзэлдэг. Одоогийн байдлаар энд 886 зүйл гуурст ургамал бүртгэгдсэний дотор 768 зүйлийн өвслөг ургамал (86.68%), 118 зүйл модлог сөөглөг ургамал (13.32%) байна. Хөвсгөл орчмын ургамлыг экологийн үндсэн бүлгүүдэд хувааж үзвэл:

- чийгсэг ургамал, чийгсүү-хуурайсаг ургамал 121 зүйл (13.66%),
- Усны ургамал 25 зүйл (2.82%),
- Бүх бүлгийн хүйтсэг ургамал 242 зүйл (27.32%),
- Бүх чулуусаг бүлгийн ургамал 205 зүйл (23.25%) байна.

Энэ нь энд тайга, өндөр уулын хэвшинж зонхилдгийг нотолж байна. Тайгын зах болон заримдаа түүний гүн рүү нэвтрэн орсон хуурайсаг ургамал 33 зүйл (3.73%), элссэг 5 зүйл (0.56%), нуурын эрэг, хотгор дагууд тохиолдох давссаг бүлгийн ургамал 30 зүйл (3.36%) байгаа нь мужийн ургамлын аймгийн бүрэлдэхүүний дотор бага хувийг эзэлж байна.

Энэ мужид Соёны ба Алтай-Соёны ургамлын аймгийн төлөөлөгчид гол байр эзэлдэг бөгөөд тэдгээрийн зарим нь бие даасан бүлгэмдэл үүсгэхэд чухал үүрэгтэй байдаг. Хөвсгөлийн баруун хэсгийн тайгат өндөр уул, хотгорын тойрогт хамрагдах Хөвсгөл нуурын баруун эргийн дагуу, Шишхидын голын баруун биеэр уул- тайгын ойтой хэсгээр тэжээлийн холбогдолгүй. Харин Шишхид голын баруун, зүүн биеэр уулс хоорондын

хөндий, хотгорын бушилз-ботуулыг уул-тайгын бэлчээртэй, үхэр, сарлаг, адуунд тохиромжтой, 9-12 ц/га тэжээлийн нөөцтэй, 600-800 кг/га тэжээлийн нэгжтэй. Тайгын бүсээс дээш өндөр уулын тундрын бэлчээртэй (хөвд, хаг бүхий торлогтой) зөвхөн зуны улиралд цаа буга, сарлагт тохиромжтой, 2.0 ц/га тэжээлийн нөөцтэй, 100-150 кг/га тэжээлийн нэгжтэй. Шишхэд гол, түүний цутгалуудын дагуу, мөн Дэлгэр мөрний савын дагуу татмын нугын бэлчээртэй, зун, намрын үед бүх төрлийн малд тохиромжтой 20- 24 ц/га тэжээлийн нөөцтэй, 1400-1600 кг/га тэжээлийн нэгжтэй. Тэсийн голын эх, тойргийн хойт хэсгээр алаг өвс-үетэн бүхий навчит ойтой уул-ойт хээрийн бэлчээртэй, үхэр, адуунд тохиромжтой, 10-11.5 ц/га тэжээлийн нөөцтэй, 800-900 кг/га тэжээлийн нэгжтэй. Тэсийн голын дагуу алаг өвс-үетэн бүхий бургасан ойтой, бүх төрлийн малд тохиромжтой 20.0 ц/га тэжээлийн нөөцтэй, 1500-1600 кг/га тэжээлийн нэгжтэй. Хөвсгөлийн зүүн хэсгийн тайгат дундаж уулсын тойрогт хамрагдах Хөвсгөлийн зүүн хэсгээр үлэмж их талбайг тэжээлийн ач холбогдол багатай уулын тайгын ой эзлэнэ. Ойн бүсээс дээш хөвд, хөвд-үетэн, хөвд-бургаст өндөр уулын тундрын бэлчээртэй, цаа буга, сарлагт тохиромжтой, 2.0 ц/га тэжээлийн нөөцтэй, 100-1200 кг/га тэжээлийн нэгжтэй.

Эг, Үүр голуудын саваар намгийн хүлэрлэг цэвдэгт хөрстэй тармаг шинэс, бургасан төгөл бүхий алаг өвс-улалжит, алаг өвст намгархаг нугын бэлчээртэй, зун-намарт үхэр, адуунд тохиромжтой. 9-12 ц/га тэжээлийн нөөцтэй, 500-600 кг/га тэжээлийн нэгжтэй.

Тойргийн хойт хэсэг болох улсын хилийн дагуу цэвдэгт тайгын (заримдаа хүлэрлэг) хөрстэй шинэсэн, гацууран, хуш-шинэсэн, тайга ба сарьдаг орчмын тармаг ойг бэлчээрт дагавар байдлаар ашиглах боломжтой.

Дэлгэрмөрөн, Сэлэнгэ мөрний хойт хэсгээр сайргархаг хар шороон ба нунтаг карбонатлаг хар хүрэн хөрстэй алаг өвс - ботуулыг хээрийн бэлчээртэй, зун - намар бог мал, адуунд тохиромжтой 10-15 га тэжээлийн нөөцтэй.

**Хөрсөн бүрхэвч.** Энэхүү тойргийн хөрс нь аядуу зөөлөн хүйтэн чийглэг уур амьсгалын дор уулын чулуулгийн элювийн ба делювийн шавранцар ба шаварлаг хурдас дээр үүсэн тогтворжсон, үржил шимээр харьцангуй сайн боловч үе давхаргын хөгжил султай, чийгийн хангамж сайтай, дулаан дутагдалтай, цэвдэгшлийн нөлөө ихтэй байдаг онцлогтой. Энэ бүсийн уулархаг хэсгээр өндөр уулын, уулын тайгын ба ойн хар шороон хөрс, уулс хоорондын нарийн ам, голуудын хөндийгөөр нугын ба нугат намгийн хар хүрэн хөрс, аллювийн нугын хар хүрэн хөрс, уулын бэл хормойгоор хар хүрэн ба хүрэн хөрс, зарим тохиолдолд цайвар хүрэн хөрс бага хэмжээтэйгээр хөрсний дэд хэв шинжүүд болон тархсан байдаг. Тус мужид уулын тайгын ширэгт хар шороон хөрс 28%, уулын тундрын ширэгт хөрс 12%-д, уулын тайгын цэвдэгт хөрс 16%-ийг эзлэнэ.

*Хүснэгт № 3.1. Хөвсгөл орчмын өндөр уул, тайга хосолсон мужийн хөрсний нөөц*

№	Хөрсний нэр	Х-1		Х-2		Мужийн дүн	
		га	%	га	%	га	%
1	Нуур	14626.12	0.34	280893.13	5.73	<b>295519.24</b>	3.22
2	Уулын тундрын ширэгт	908965.27	21.23	237744.56	4.85	<b>1146709.83</b>	12.48
3	Уулын тундрын хүлэрлэг глейт/намгийн цэвдэгт	162610.36	3.80	55601.67	1.13	<b>218212.03</b>	2.38

4	Уулын нугын/уулын тайгын ширэгт	253242.06	5.92	7366.87	0.15	<b>260608.93</b>	2.84
5	Уулын нугат хээрийн болон уулын нугын	293715.67	6.86	-	0.00	<b>293715.67</b>	3.20
6	Уулын тайгын цэвдэгт/уулын тайгын ширэгт	800514.93	18.70	685915.35	13.98	<b>1486430.28</b>	16.18
7	Уулын тайгын ширэгт/уулын чандруулаг	-	0.00	244764.82	4.99	<b>244764.82</b>	2.66
8	Уулын тайгын ширэгт/уулын карбонаттай хар шороон	641622.40	14.99	1993633.20	40.64	<b>2635255.60</b>	28.69
9	Уулын ойн ширэгт бараан/уулын хар шороон	-	0.00	399342.40	8.14	<b>399342.40</b>	4.35
10	Уулын карбонаттай хар шороон/уулын карбонатгүй хар хүрэн	26.60	0.00	15336.35	0.31	<b>15362.95</b>	0.17
11	Уулын хар шороон/уулын хар хүрэн	120304.41	2.81	211932.11	4.32	<b>332236.52</b>	3.62
12	Уулын хар хүрэн/уулын нимгэн хар шороон	38019.56	0.89	-	0.00	<b>38019.56</b>	0.41
13	Уулын хүрэн/уулын хар хүрэн	20739.00	0.48	-	0.00	<b>20739.00</b>	0.23
14	Толгодын хар шороон/нугат хар шороон	10166.06	0.24	113512.17	2.31	<b>123678.23</b>	1.35
15	Толгодын хар хүрэн/нимгэн сайр чулуурхаг хар хүрэн	38133.05	0.89	27862.87	0.57	<b>65995.93</b>	0.72
16	Толгодын хүрэн/нимгэн сайр чулуурхаг хүрэн	951.35	0.02	-	0.00	<b>951.35</b>	0.01
17	Ердийн хар шороон/нугат хар шороон	43346.61	1.01	139524.17	2.84	<b>182870.78</b>	1.99
18	Нугат хар шороон/нугат намгийн мараалаг	-	0.00	34341.94	0.70	<b>34341.94</b>	0.37
19	ердийн хар хүрэн/сайр чулуурхаг хар хүрэн	88251.33	2.06	-	0.00	<b>88251.33</b>	0.96
20	Ердийн хар хүрэн/мараалаг хар хүрэн	-	0.00	-	0.00	<b>0.00</b>	0.00
21	Ердийн хар хүрэн/далд глейрхэг хар хүрэн	38800.68	0.91	42294.80	0.86	<b>81095.48</b>	0.88
22	Давсархаг хар хүрэн/хужир мараалаг хар хүрэн	9179.68	0.21	2244.23	0.05	<b>11423.91</b>	0.12
23	Ердийн хүрэн/сайр чулуурхаг хүрэн	37917.51	0.89	-	0.00	<b>37917.51</b>	0.41
24	Сийрэг элсэн хүрэн	28934.24	0.68	-	0.00	<b>28934.24</b>	0.31
25	Намгийн цэвдэгт/нугат намгийн цэвдэгт	-	0.00	5056.21	0.10	<b>5056.21</b>	0.06
26	Нугат намгийн цэвдэгт/намгийн цэвдэгт	412993.60	9.65	148804.81	3.03	<b>561798.41</b>	6.12
27	Нугат намгийн цэвдэгт хужирлаг/нугын цэвдэгт хужирлаг	-	0.00	-	0.00	<b>0.00</b>	0.00
28	Нугын цэвдэгт/нугат хар шороон	76700.00	1.79	100097.23	2.04	<b>176797.23</b>	1.92
29	Нугын хужир/хужирлаг нуга	-	0.00	4615.30	0.09	<b>4615.30</b>	0.05
30	Аллювийн намгийн	-	0.00	23448.25	0.48	<b>23448.25</b>	0.26
31	Аллювийн нугат намгийн/Аллювийн нугын хужирлаг	72984.92	1.70	9781.05	0.20	<b>82765.97</b>	0.90
32	Аллювийн нугын/Аллювийн нугын давсархаг	40944.02	0.96	121134.02	2.47	<b>162078.04</b>	1.76
33	Аллювийн үелсэн тогтоцтой ба Аллювийн нугын	7974.25	0.19	-	0.00	<b>7974.25</b>	0.09
34	Шалархуу хагас бэхэжсэн элс	1924.83	0.04	-	0.00	<b>1924.83</b>	0.02
35	Хөдөлгөөнт элс	5797.05	0.14	-	0.00	<b>5797.05</b>	0.06

36	Хад асга	111309.27	2.60	-	0.00	<b>111309.27</b>	1.21
	<b>Дүн</b>	<b>4280694.81</b>	<b>100.00</b>	<b>4905247.50</b>	<b>100.00</b>	<b>9185942.31</b>	<b>100.00</b>

**Ан амьтан.** Монгол орны говийн бүсээс бусад байгалийн бүх бүс бүслүүрийг багтаасан хад, нуур, намаг мэт бүсийн бус бичил орчингоор баян энэ мужийн амьтны аймаг бол палеарктикийн элементүүдийн зүүн ба өрнөд тархцын уулзуур дээр бүрдэн тогтсоноор сонирхолтой бөгөөд ихэнхи зүйл амьтад нь амьтны газарзүйн хувьд Енисей мөрний сав нутгийнх, цөөнхи нь Монголын хээр талын зүйлүүдээс бүрдсэн ажээ.

Энэ мужид нийтдээ 5 ангийн 264 зүйл буюу манай орны сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 40.5 % нь оршин амьдардаг байна.

*Хүснэгт № 3.2. Хөвсгөл орчмын өндөр уул, тайга хосолсон мужийн сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүн*

Нэгж	Дэлэнтэн	Шувуу	Мөлхөгчид	Хоёр нутагтан	Загас	Дугариг амьтан	Бүгд
Баг	5	16	1	2	5	-	29
Овог	17	34	4	2	8	-	65
Зүйл	54 (38.8%)	188 (45.3%)	5 (23.8%)	2 (33.3%)	15 (21.7%)	-	264 (40.5%)

*Тайлбар: Монгол оронд бүртгэгдсэн тухайн ангийн амьтдын зүйлийн бүрэлдэхүүний хэдэн хувийг эзэлж буйг хаалтанд бичив.*

**Дэлэнтэн.** Энэ мужид 5 багт хамаарах 54 зүйл дэлэнтэн амьтан тэмдэглэгдсэн нь манай орны дэлэнтний зүйлийн 38.8 % болж байна. Эдгээрийн дотор шавжичтан 5, далавчтан 4, туулайтан 4, мэрэгчтэн 20, махчтан 13, туурайтан 8 зүйл тус тус байна. Дэлэнтэн дотор зүйлийн тоогоор махчтан /эндэхийн хөхтөний 24.0%/, мэрэгчтэн /37.0%/ зонхилно.

Энэ мужид хамаарах нутгийн байгаль, ландшафтын онцлог нь өндөр уулс /тагийн бүслүүртэй/, тайга, ойт хээр, хээржүү уудам хотгор, уулын хөндий ээлжлэн алагласан газар юм.

Газар нутгийн ийм олон янз байдал, онцлогтой уялдан хойноос умрын ой тайгын зүйлүүд /хүрэн баавгай, ойн булга, нохой зээх, баданга хүдэр, халиун буга, бор гөрөөс, молцог хандгай, зэрлэг гахай, алтайн чацуулин, чандага туулай, асганы огодой, бараан хэрэм/, өмнөөс Төв азийн хээрийн зүйлүүд /Монгол тарвага, шивэр алагдаага, хярс үнэг, шар үнэг, мануул мий, дагуур огодой, боролзон туулай, хэргэлзий оготно гэх мэт/, мөн өндөр уулын амьтан /аргаль хонь, янгир ямаа, цөөвөр чоно, суусар булга, цоохор ирвэс, буган цаа, тагийн огодой гэх мэт/ харилцан нэвтрэлцэж “холилдсон” шатрын хөлөг шиг цоохор бүрдэлтэй нутаг юм. Байгалийн нөхцөл ландшафт дагасан хөхтөн амьтны бүрэлдэхүүн, байршлын алаг цоохор нь хэвтээ, босоо, хөндлөн гурван чиглэлдээ ялгардаг онцлог шинжтэй. Гол мөрөн, нуур усны сүлжээ, тогтолцоо сайтай учраас газар усны болон чийглэг орчны хөхтөн амьтны хэдэн зүйл /голын халиу, усны үен, усч бөрөм, усч гэрэлзгэнэ гэх мэт/ бас бий. Сүүлийн 30 гаруй жилд эндэхийн амьтны аймагт шинээр 1 зүйл байгалийн аясаар өөрөө ОХУ-ын нутгаас нэвтрэн ирж нутагшсан нь усны үен юм.

Энд дэлэнтэн амьтны зонхилох цөм нь Умрын ойн болон Сибирийн тайгын зүйлүүд юм. Гэхдээ Төв Азийн хээрийн болон өндөр уулын зүйлүүд ч бас байна.

Энэ тойрогт оршин амьдрах дэлэнтнээс голдуу агнуурын чухал ач холбогдолтой уламжлалт ангийн 19 зүйл амьтан тархац нутаг, тоо толгойн хувьд аль нэг хэмжээгээр багасан цөөрч ховордсоны дотор 2 зүйл /цөөвөр чоно, цоохор ирвэс/ бараг устаж, 5 зүйл /голын халиу, алтайн чацуулин, буган цаа, аргаль хонь, янгир ямаа/ нэн ховорджээ. Харин агнуурын аж ахуйн шууд холбогдол багатай буюу огт үгүй шавж, жижиг мэрэгчтэний тоо толгой хэвийн юмуу элбэг, тархац нутаг нь мэдэгдэхүйц багасаагүй нь хүний шууд нөлөөтэй холбоотой юм.

Энд дэлэнтэнээс Монголын улаан номонд 9 зүйл /янгир ямаа, аргаль хонь, буган цаа, бараан хандгай, баданга хүдэр, цоохор ирвэс, голын халиу, цөөвөр чоно, алтайн чацуулин/, олон улсын улаан номонд 5 зүйл /голын халиу, цоохор ирвэс, нохой зээх, саарал чоно, цөөвөр чоно./, Монголын ховор амьтны жагсаалтанд 4 зүйл /аргаль хонь, янгир ямаа, бараан хандгай, халиун буга/ оржээ. Ховордсон зэрлэг ургамал, амьтны худалдааны тухай олон улсын конвенцийн I, II хавсралтанд орсон 9 зүйл /1 хавсралтанд: цоохор ирвэс, голын халиу, цөөвөр чоно, II хавсралтанд: аргаль хонь, баданга хүдэр, шилүүс мий, мануул мий, хүрэн баавгай, саарал чоно/ бий.

*Хөвсгөл орчмын өндөр уул, тайга хосолсон мужийн ховордсон болон улс, олон улсын ач холбогдолтой зарим хөхтөний тархац, тоо толгойн байдал:*

*Буган цаа.* Улаан тайгын нурууны Жамас, баруун зүүн Жолог, мөн Бяранга, Тэнгис, Шарга голуудын эхний улсын хилийн ойролцоох тайгат уулсаар нутаглана. Одоо ихээхэн ховордсон. 1994 оны зуны ажиглалтаар Жамас, Жолог хавьд 2, 3, 5 толгой бүхий гуравхан сүрэг үзсэн нь үнэхээр ховордож цөөрч буйн гэрч юм. Сүүлийн 30-аад жилд Монгол орон дахь нутаг, тоо толгой нь 50 хувь багасчээ. Бяранга, Тэнгис голын эхний буган цаа улсын хилээр гарч улирлаар нүүдэг байна. Наяад оны дунд үеийн мэдээгээр 750 орчим толгой бодьгал байсан бол ерээд оны дундуур монголд 200-400 толгойгоос хэтрэхгүй бодьгал үлдсэн гэж үзэж байна. Үүний тал буюу 100-200 нь Баруун Хөвсгөлийн популяцид ногдоно. Эдгээр цөөн баримтаас үзвэл энэ зүйлийн тоо толгой үнэхээр цөөрсөн бөгөөд тусгайлан судалж хамгаалах арга хэмжээ авууштай болсон нь илэрхий юм.

*Аргаль хонь.* Урьд Хөвсгөл орчмын нутгаар одоогийнхоос нилээд өргөн тархацтай байсан. Одоо зөвхөн Хордилын нуруунд Арсай, Нарийн, Бэлтэс голуудын эх, Хорон тал, Улаан хад, Айраг уул хавиар 42 мянга орчим га талбай бүхий хэсэгхэн нутагт байна.

Энэ тасархай популяци далаад оны үед 200 орчим толгой байсан бол одоо 40-50 толгойгоос хэтрэхгүй болж улам бүр цөөрсөөр байна. Улаан тайгын өмнө салбар уулс, Дэлгэр мөрний эх, Тэс голын эхний хойд уулсаар аргаль хонь устаад олон жил боллоо.

*Янгир ямаа.* Хөвсгөл орчмын нутагт янгир ямаа хоорондоо нэлээд зайтай тасархай хоёр хэсэг газар нутагладаг. Эхнийх нь Улаан тайгын популяци. Улаан уул сумын нутгийн баруун хэсэг, Баянзүрх сумын нутгийн хойд, баруун хойд хэсэг, Улаан тайгын нурууны салбар уулсаар нутагладаг. Гол байршил газар нь Хөг голын эх, Хосдог, Сул, Жалайлаг, Соосогног, Буурал гол, Ямаатын гозгор, Хавтгайн даваа, Мунгаргийн эх, Барзан, Мараат, Урт нуурын эх, Салбадаг, Дэлгэр мөрний эх хавь нутаг болно. Нөгөө нь Хордил, Баяны популяци бөгөөд Улаан уул сумын нутгийн зүүн хэсэгт Арсай, Бэлтэс голуудын эхээр

Янгир, Нарт, Ямаат, Зост зэрэг газар, Дэлгэрхааны уулсаар тохиолдоно. Бас Ринчинлхүмбэ сумын нутаг Жар, Шарга, Ходон голуудын эхний уулсад бий. Тоо толгойн одоогийн байдал тодорхойгүй. Наяад оны сүүлч, ерээд оны эхээр 1000 гаруй толгой гэж байв. Орчны хязгаарлагдмал хүнд нөхцөлд байдаг.

*Бараан хандгай.* Дархадын хотгорыг тойрсон уулархаг нутагт хааяагүй тархмал ч тоо толгой нь газар сайгүй цээн. Шарга, Тэнгис, Жамас, Жолог, Бяран, Хөг голуудын сав, Баян, Хордил, Дэлгэрхааны зарим хэсгээр бий. Наяад оны дундуур нийтдээ 500-600 бодгаль байжээ. Сүүлийн арваад жил хууль бус агнуурт онцгой өртөж байгаа мэдээтэй. Тоо толгой нь өсөөгүй нь лавтай байна.

*Цоохор ирвэс.* Аргаль хонь, янгир ямаа бүхий хад чулуу, бартаат өндөр уулсаар дээр үед цөөвтөр үзэгддэг байжээ. Сүүлийн үед үзэгдэхээ больсон. Хааяа гүйдлээр үзэгддэг.

*Цөөвөр чоно.* Хөвсгөлийн өндөр уулсын таг царам дагаж дээр үед байсан гэдэг. Сүүлийн 40-50 жилд баригдсан тохиолдол гараагүй. Наяад онд Жолог, Тэнгис, Шарга, Хөг голуудын эхний уулсаар нутгийнхан үзлээ гэсэн яриа байдаг ч үнэмшилтэй мэдээ алга. Ер нь Хөвсгөл орчимд цөөвөр чоно устаж үгүй болсон бололтой.

*Халиун буга.* Бүх ойт нутагт тархмал. Тоо толгойг тусгайлан судалж байгаагүй. Наяад оны эхээр элбэг газраа 1000 га-д 4-7 хүрч, ховор газраа 1000 га-д 1-2 толгой ноогдож байсан. Сүүлийн арваад жил зах зээлийн нөхцөлтэй уялдан хууль бус агнах явдал их эрчимжсэнээс тоо толгой нь ихээхэн хорогдсон нь тодорхой.

*Голын халиу.* Монголын нэн ховор амьтны нэг. Доод Шишгэд буюу Шишгэд, Тэнгисийн бэлчирээс доош улсын хил хүртэлх Шишгэд гол дагуу нутагладаг. Хааяа Бяран, Жолог голд үзэгддэг. Тоо толгойг нарийвчлан тогтоогоогүй. Цөөхөн бодгаль бий нь илэрхий. Хууль бусаар агнах тохиолдол бий. Тархац нутгийг нь одоо болтол тусгай хамгаалалалтад аваагүй байна.

**Шувуу.** Судалгааны дүнд тухайн мужийн жигүүртний аймгийн зүйлийн жагсаалтанд 16 баг, 34 овог, 188 зүйлийг багтаасан нь монгол орны бүх шувуудын зүйлийн бүрдлийн 45.3% нь энд тохиолддог гэсэн үг юм. Оршин амьдрах байдлын хувьд эдгээрийн 35 зүйл нь суурин, 153 зүйл нүүдэллэн ирдэг ажээ. Эдгээрээс 30 зүйл тус нутгийг нүүдлийн хугацаандаа дайрч өнгөрдөг, өвөл ирээд хавар умард зүгт буцдаг 13 зүйл, тохиолдлын буюу төөрч ирдэг 6 зүйл байгаа юм.

Энэ мужийн ой, бут бургас, голын төгөл маягийн хэв шинжит нутгаар 105 зүйл, хээр талд 17, ус намгуудаар 100, өндөр уулсын тагаар 13, хад буттай орчноор 28 зүйл шувуу тус тус оршин амьдардаг байна.

Эдгээр зүйл шувуудаас Монгол улсын улаан номонд (1997) орсон *Platalea leucorodia* (халбаган хошуут), *Cygnus cygnus* (гангар хун), *Anser indica* (хээрийн галуу), *Anser cygnoides* (хошуу галуу), *Pandion haliaetus* (явлаг сар), *Haliaeetus albicilla* (усны цагаан сүүлт бүргэд), *Limnodromus semipalmatus* (Азийн цууцаль) зэрэг 7 зүйл өндөглөн зусах, дайрч өнгөрөх буюу нүүдлийн хугацаандаа үзэгдэнэ. Олон улсын улаан номонд (1988) дээрхи зүйл ховор шувуудаас усны цагаан сүүлт бүргэд, Азийн цууцаль оржээ.



Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалахыг хориглосон тухай конвенцийн (CITES) 1-р хавсралтанд усны цагаан сүүлт бүргэд, 2-р хавсралтанд халбаган хошуут, хар өрөвтас, байгалийн нугас, явлаг сар орсон болно.

**Мөлхөгчид.** Хөвсгөлийн баруун хэсгийн тайгат өндөр уул, хотгорын тойрогт хамаарах Улаан тайгын Мэнгэ булгын даваа орчимд зулзагалагч гүрвэл оршин амьдарна. Ерөнхий зүй тогтлын хувьд авч үзвэл энэ зүйл гүрвэл Бүсийн голын сав газар болон Баруун тайгын хад чулуут уулсаар тархсан байх боломжтой. Оршин байгаа нутагтаа тоо толгойн хувьд элбэг. Энэ мужийн Хангайтай хиллэх өмнө талын зурвас нутгаар монгол гүрвэл, рашааны могой, бамбай хоншоорт могой алаг цоог тархжээ. Харин Хөвсгөл нуурын зүүн эрэг орчмоос өнгөрсөн зууны эхээр эгэл загалмайт могойг тэмдэглэснээс өөр ямар нэг мэдээ байхгүй.

**Хоёр нутагтан.** Энэ мужид шивэр гүлмэр, монгол бах хэмээх 2 зүйлийн хоёр нутагтан тэмдэглэсэн байна. Шивэр гүлмэр одоогоор Хөвсгөлийн баруун хэсгийн тайгат өндөр уул, хотгорын тойрогт хамаарах Мөнх Сарьдаг, Дархадын хотгор, Хөг ба Шишхэд голын саваас олджээ. Монгол улсын Улаан номонд орсон ховор амьтан. Сэлэнгэ, Дэлгэр мөрний голын сав нутгаар монгол бах тархан амьдарна.

**Загас.** Энэ мужид харьцангуй олон зүйлийн загас идээшин амьдрах бөгөөд тоо, толгой, нөөцийн хувьд манай орны хэмжээнд дээгүүр ордог, загас агнуурын үндсэн бүс нутгийн нэг мөн.

Хөвсгөлийн баруун хэсгийн тайгат өндөр уул, хотгорын тойрогт багтах Тэнгис Шишхэдын сав газрын нуур, голуудад 6 овгийн нийт 11 зүйлийн загас амьдардаг. Цагаан загасны *ICoregonidae*/ овгийн 3 зүйл байгаагаас Дархадын цагаан загас *ICoregonus lavaretus pidschianl* нь нутгийн унаган амьтан бөгөөд шинээр нутагшуулсан байгалийн оморь *ICoregonus autumnalis migratoriusl*, жарга *ICoregonus peledl* гэсэн 2 зүйл бий. Эдгээр нь бүгд агнуурын өндөр ач холбогдолтой загаснууд юм. Харин *Cyprinidae* овгийн эгэл варлан *Phoxinus phoxinusl*, сахалт эрээлж *Nemachilus barbatulusl*, чимхүүр загас *Cobitis taenia*/ хэмээх 3 зүйл нь агнуурын бус загас боловч бусад загасны идэш тэжээлийн чухал объект болдог. Харин булуусгай *Prosopium cylindraceum*/ зүйлийн загасыг Оросын Газарзүйн нийгэмлэгээс зохион байгуулсан Г.Н. Потанины удирдсан экспедицийн судлаачид Шишхэдийн голоос 1899 онд олж тэмдэглэснээс өөр ямар нэг мэдээ байхгүй.

Энэ тойргийн нуур, голуудад 1995 оноос Монгол орны улаан номонд бүртгэгдсэн тул загас түгээмэл тархсан байдаг. Харин Монгол орны нэн ховор амьтны жагсаалтанд орсон дархан цаазат хилэм загас Дархадын хотгорын голд тохиолдсон болохыг А. Дулмаа, Я. Цэнд-Аюуш нар 1973 тэмдэглэсэн байдаг боловч түүнээс хойш өнөөг хүртэл уг зүйлийг барьсан мэдээ баримт, түүний биологи экологийн холбогдолтой судалгааны материал алга байна.

1986 онд ЗХУ-ын /хуучин нэрээр/ Улаан-Үд хотын загас үржүүлгийн заводаас байгалийн оморь *ICoregonus autumnalis migratoriusl*, жарга *ICoregonus peledl* загасны 3 сая жараахайг зөөвөрлөн авчирч Доод цагаан нууртай холбоо бүхий Хармайн болон Төгрөг

нууруудад шилжүүлэн тавьсан нь орчин нөхцөлдөө дасан зохицож улмаар агнуурын хэмжээнд хүрсний дотор жарга загас нь агнуурын 3-4 хувийг эзлэх болжээ.

Хөвсгөлийн зүүн хэсгийн тайгат дундаж уулсын тойрогт Хөвсгөл нуур, түүнээс эх авсан Эгийн гол, тэдгээрийн цутгалууд бүхэлдээ хамрагдаж байгаа билээ. Энэ тойрогт 7 овгийн 11 зүйл загас оршин амьдарна. Эдгээрээс тул /*Hucho taimen*/, шивэр хадран / *Th. Arcticus*/, Хөвсгөлийн хадран /*Th.nigriscens*/, ердийн цурхай /*E.reichertii*/, улаан нүдэн /*R. rutilus*/, гутаарь /*L. lota*/, алгана /*P.flubiatilis*/ зэрэг нь агнуурын ач холбогдолтой. Харин эгэл варлан /*Phoxinus phoxinus*l, сахалт эрээлж /*Nemachilus barbatulus*l, чимхүүр загас /*Cobitis taenia*/ нь агнуурын бус загас юм.

**Ландшафтын онцлог.** Хөмбөн-цулдам уул, тэгш өндөрлөг, рифтийн хотгор бүхий Хөвсгөл орчмын мужид өндөр уулын ян сарьдгийн /хаг-хөвдөт тундрын болон чулуурхаг / ландшафт түгээмэл байна.Тэр нь дундаж өндөр уулст уулын тагийн /тармаг ойн/ ландшафт болон цэвдэгт тайгын, ширэгт тайгын хөрстэй шинэс, хуш-шинэсэн ой бүхий дундад ба өмнөд тайгын ландшафтаар солигдоно. Хотгор газраар тайгын, ойн, торлогийн буюу нугат хээрийн, нугын ландшафт тархана.


Хөвсгөл орчмын баруун талын өндөр уул нуруунд өндөр уулын ян сарьдаг, уулын нуга, уулын тайгын ландшафт голлоно. Уулсын хамгийн дээд давхаргад ялгардаг ландшафтын хэв шинж болох хур цас, мөс зөвхөн Мөнх сарьдагт тархана. Ян сарьдагийн ландшафт нь 2900-3000 метрээс дээш өргөгдсөн хэсэгт тохиолдоно. Уулын тайгын ландшафтын дээд хил нь 2100- 2200 метрийн өндрөөр зааглагдана. Хөвсгөлийн уулсын тайга нь Хэнтийн нурууны тайгыг бодвол харьцангуй өндөр түвшинд үүсч тогтворжсон ажээ. Энд Хачимын тайга, Хүрэн тайга, Шаргын тайга, Жүгнэгийн тайга, Цагаан чулуутын тайга, Утрагийн тайга, Улаан тайга, Хөх тайга, Хүнхэр тайга, Лам тайга зэрэг ой хөвч бүхий уулс олонтой.

Монгол орны уулын ой Сибирийн байнгын нөлөөн дор бүрэлдэн тогтсон тул Евразийн шилмүүст ойн их мужид хамаарах уулсын хажуу бүхэнд жигд сайн илэрсэн ойн бүслүүр хөгжсөн байдаг. Хөвсгөлийн зүүн талын нутаг бүхэлдээ ой-ургамалшлын мужлалаар Өвөр Байгалийн их мужийн Зэдийн мужид багтах бөгөөд өмнөд сибирь- умард монголын хэвшинжид хамаарах уулын тайгын ойн бүслүүрт хамрагдах нутаг юм. Энд шинэс, хуш хоёр нэлээд өтгөн, өндөр ургахын хамт зарим газраар гацуур, нарс, хус холилдон ургана.


Ургамлын бүлгэмдлийн хувьд дурьдсан нутагт хөвдлөг, өвслөг, сөөгт ургамал бүхий шинэсэн ой зонхилно. Эдгээрээс сургар-алирс-ногоон хөвдөт, алирс-бадаант хуш бүхий шинэсэн ой Эрэн, Азрагын голын сав болон улсын хилийн дагуу өргөн тархана. Мөн Хантайн нуруу ялангуяа түүний өвөр хажуу дагууд алирс-хөвдөт шинэсэн, хуш-шинэсэн ойгоор бүрхмэл юм. Зэд, Хантайн нурууны өндөрлөг хэсгүүд тухайлбал Сөртгийн магнай, Харагдах магнай, Оросын нуруу, Онгоны нуруу, Будлан пүүсгэр уулын 1800 м-ээс дээш өндөртэй хэсэгт сургар-ногоон хөвдөт, алирс-бадаант шинэс бүхий хушин ой элбэг тархдаг байна.

Эндхийн ойд хусан ой түрж ургах явдал хааяагүй тохиолдоно. Ялангуяа ойн түймрийн дараа шинэс, нарсан ойд хус ихээр түрж ургадаг байна. Иймд дурьдсан нутагт алаг өвс-улалжит шинэсэн ой, түүний оронд ургасан хусан ой нэлээд том талбай эзэлнэ. Энэ нь Эрэн голын сав дагуу Хавчиранга, Салмын Эрээнээс дээш Хойгын даваа, Эвэрт, Нуурын булаг гол хүртэлх хэсэгт мөн Азарга, Зэлтэр голын бэлчрээс доош Ар Шүрэнгийн гол хүртэл болон Хантайн нурууны хойт талын Балинхай, Ангархайн нурууны дагуух нутагт элбэг тархана.


Эг, Үүр, Эрэн, Илэнх, Тарвагатай, Азрага, Зэлтэрийн голын татам дагуу бургас, сөөг бүхий торлогт намгархаг нуга, үетэн-алаг өвст нуга ээлжлэн тархана. Эндхийн ихэнх цутгал уулын жижиг голуудын татам дагууд сөөгөн ширэнгэ бүхий намгархаг нуга давамгайлна.



Зураг № 3.2. Хөвсгөл орчмын өндөр уул, тайга хосолсон мужийн хөрс



Зураг№ 3.3. Хөвсгөл орчмын өндөр уул, тайга хосолсон мужийн ургамалжилт



Зураг№ 3.4. Хөвсгөл орчмын өндөр уул, тайга хосолсон мужийн газар ашиглалт

### **3.2. Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон муж**

Хангайн нуруу нь тус орны бараг төв хэсэгт ерөнхийдөө баруун хойноос зүүн урагшаа чиглэн 750 гаруй км урт үргэлжлэх бөгөөд энэ тогтолцоонд Хангайн нурууны ноён оргил Отгонтэнгэр түүний салбар уулс болон Хан Хөхийн нуруу, Тарвагатай, Булнайн нуруу багтана. Эндхийн уулсын үнэмлэх өндөр дунджаар 3000 м орчим боловч зарим оргил далайн төвшнөөс дээш 3500-4000 м хүрнэ. Хамгийн өндөр оргил Отгонтэнгэр уул 4021 м хүрнэ. Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон муж нь Хан Хөхийн нурууны ойт хээр бүхий тойрог (Х-3), Булнайн-Тарвагатайн нурууны ой, тайга бүхий тойрог (Х-4), Хангайн тэгш өндөрлөгийн тойрог (Х-5) гэсэн 3 тойрогт хуваагдана. Эдгээр тойргууд нь байрлал, өндөр намын ялгаа, ландшафтын бүтэц, ашиглалтын түвшин зэрэг олон үзүүлэлтээр өөр хоорондоо ялгарна.

#### **1. Хан Хөхийн нурууны ойт хээр бүхий тойрог: (Х-3)**

Хангайн гол нурууны хамгийн баруун талын томоохон салбар болох Хан Хөхийн нуруу, түүний зүүн талын салбар уулс хамрагдана. Хан Хөхийн нуруу Их Нууруудын хотгор руу гүн түрж орсон тул Увс, Хяргас нуурын хонхорыг бие биеэс нь зааглан оршино. Хан Хөхийн нуруу Хангайн гол нурууг бодвол намхан, хамгийн өндөр нь зүүн хэсэгт байгаа Хан Хөхий ууланд 2928 м хүрнэ. Эндээс баруун тийшээ болоход гадаргын үнэмлэхүй өндөр намсан Тогтохын шилтэй залгах бөгөөд түүний оргил Хүрмэн овоо 2356 м өндөр юм. Эндэхийн уулс голчлон эрт төрмөлийн эриний эхэн үеийн боржин, талст занар зэрэг чулуулгаас бүтсэн байна.

Хан Хөхийн нурууны ар хажуу нь налуу, оройгоосоо бэл рүүгээ алгуур намсаж Увс нуурын хотгорт шилждэг бол өвөр хажуу нь хана шиг эгц байдалтай, Хяргас нуурын хотгор руу огцом бууж нийлсэн байна. Хан Хөхийн нуруу зүүнээс баруун тийш бараг өргөргийн дагуу сунаж байрласан учраас түүний ар, өвөр хажуугийн хөрс, ландшафтын байдал хоорондоо эрс тэс ялгаатай ажээ. Үүнд: Хан Хөхийн нурууны ар хажууд нуга, ой мод, хээр бүх уулыг бүрхэж байхад өвөр хажуу нь ой модгүй болж хаяагүй хуурай хээрүүд үзэгдэх ба хуурай сайраар сүрхий хэрчигдсэн байдаг ажээ.

Хан Хөхийн нуруунаас богино голууд эх авч уулын тэгш өргөн хөндийгөөр урсана. Эдгээр хөндий нь дээд бүсдээ бага налуу ба доод бүсдээ эрс гүн болж ирэх бөгөөд энд чулуурхаг хавцал олонтоо тохиолдоно. Мөстлийн ул мөр Хан Хөхийн төв хэсэгт үлджээ. Нурууны оройн хэсгээр тэгшрэлийн гадаргын үлдэц сайн хадгалагдаж үлдсэн тул уулсын орой хавтгай хэлбэртэй байна. Хан Хөхийн уулсын ар хормой дагуу эртний тетоник гүний хагарал байрласнаас үзэхэд энэ тойрог нь газар хөдлөлтийн идэвхтэй мужид багтана.

#### **2. Булнайн-Тарвагатайн нурууны ой, тайга бүхий тойрог: (Х-4)**

Хангайн гол нурууны томоохон салбар болох Идэрийн гол, Тэрхийн гол хоёрын хооронд орших Тарвагатайн нуруу, түүнээс хойш Тэс, Дэлгэр мөрний савыг тусгаарлан баруунаас зүүн тийш чиглэж тогтсон Булнайн нуруу тус тус багтана. Булнайн нурууны оргил 2596 м бөгөөд нийтдээ Тарвагатайн нуруунаас нам юм. Тарвагатайн нурууны гол оргил Совдон уул д.т.д. 3240 м, Загастай уул 3161 м тус тус өргөгджээ. Орой нь ихэнхээ тэгш хавтгай буюу бага зэрэг бөмбөгөр хэлбэртэй ажээ. Булнайн нуруу нь Ханхөхийн

нурууны зүүн үзүүрээс олон голын бэлчир хүртэлх газрыг хамрана. Хангайн гол нуруун дээр өргөрөгийн дагуу сунаж тогтсон энэхүү нуруу нь хойд хэсэгтээ Тэс ба Дэлгэр мөрний хөндийнүүд, өмнө хэсэгтээ Идэр голын хөндийг тусгаарлана. Булнайн нуруу тетоникийн тогтоцын хувьд тууш хөндийнүүдээр тусгаарлагдсан гүний чулуулгуудын зөрөгт шилжээсүүдээр бүрэлдэн бий болжээ. Тэдгээр урт, нарийхан зөрөгт шилжээсүүд нь мегаблокуыг үүсгэн өргөрөгийн чиглэлд орших бөгөөд бүгд ижил чиглэлтэй байдгаараа онцлогтой. Мегаблокуын зүүн хэсэг нь баруун хойд чиглэлийн хагарлуудаар тусгаарлагдах бөгөөд уул нуруудын хэмжээ эрс буурч байдгаараа ялгаатай. Булнайн нуруунаас хойш Тэсийн голын хөндий, Дэлгэр мөрөн хүртэл нам уулс, цав толгод голлох бөгөөд тэдгээрийн хоорондох хотос хонхорт эртний усан сангийн үлдэц нуур, намаг, цэвдэгт ул хөрс өргөн тархсан байна.

Тарвагтайн нуруу нь Идэр голоос урагш түүний баруун гарын цутгалууд ба Тэрхийн гол хоёрын хооронд оршино. Тарвагтайн нуруу нь нилээд өндөр бөгөөд түүний хажуунуудыг Булнайн нурууны хажуутай харьцуулан үзвэл эсрэг байдалтай юм. Үүнд Тарвагатайн нурууны ар хажуу нь урт бөгөөд Идэр голын хөндий рүү налуу унана. Харин өвөр хажуу нь эгц бөгөөд Тэрхийн хөндий ба нуур руу эрэг адил оршино. Тарвагатайн нурууны дундаж өндөр нь 3000 - 3200 метр байна. Хангайн гол нурууны салбар энэхүү уулс нь Хангайн уулт өндөрлөгт багтана. Эндэх уулсын орой хавтгайвтар, хажуу нь эгц, гадарга нь ихээхэн хэрчигдэж бартаатай болсон байна. Эртний тэгшрэлийн гадарга төв хэсгээсээ аваад салбар уулс хүртлээ өргөн тархана. Тарвагатайн нурууны ар хажуугийн дагуу цэвдгийн нөлөөгөөр үүссэн орчин үеийн бичил хотгор гүдгэр түгээмэл байна.

### **3. Хангайн тэгш өндөрлөгийн тойрог: (Х-5)**

Хангайн гол нуруу, Хангайн өмнөд тэгш өндөрлөг, Хангайн уулт өндөрлөгийн баруун хэсгийн салбар уулс бүрэлдүүлнэ. Хангайн гол нуруу нь ерөнхийдөө Монгол - Алтайн гол нуруутай зэрэгцэн баруун хойноос зүүн урагш сунаж түүний урт нь баруун талдаа Цэцэн хайрхан уулнаас зүүн талдаа Дэлгэрхаан уул хүртэл 500 км, өргөн нь буюу хойноосоо урагшаа 350- 400 км юм. Хангай нь өндөр нуруу бөгөөд түүний ноён оргил нь Улиастай хотоос зүүн тийш, далайн түвшинээс дээш 4021 метрт орших мөнх цастай Отгонтэнгэр уул юм. Хангайн бусад ноён оргилууд нь 3200- 3500 метр өндөрт оршино. Хангайн гол нурууны хяр нь дунджаар 3000 метрт орших бөгөөд бэгэлцгийн үлдэж хоцорсон өргөн тэгш хэсэг болно. Түүний гадарга дээр намгууд онцгойрон харагдах ба зарим оройнууд дээр жижиг жижиг нуурууд тогтсон байдаг. Хангайн уулсад одоо үед мөсөн голууд бараг байхгүй юм. Мөнх цас ба бага хэмжээний жижиг мөсөн гол зөвхөн Отгонтэнгэр уулын оройд байна. Зуны улиралд хангайн уулсын орой болон хажуу бэлээр цас орох нь ховор биш байдаг. Эрт цагт Хангайн уулс нь мөсөн голуудаар ихээхэн хучигдсан байжээ. Эгийн давааны орчимд мөсөн голын хөндийнүүд ба нурууны эгц ханан хажуу дор цөрүүд тод үзэгдэх бөгөөд энд эрт цагт мөсөн голын эх нь байжээ. Мөсөн голын үйлчлэлийн ул мөрүүд Хангайн гол нурууны бусад хэсэгт ч олонтоо тохиолдоно. Хангайн өвөр хажууд Завхан голын сав газар орших Хөх нуурын гарал үүсэл өвөрмөц онцлогтой. 15 км урт, 0,5- 1,5 км өргөн энэхүү нуур нь хотгор газар хэрхэн морены

хурдсаар боогдсоноор нуур болж үлдсэнийг гэрчилнэ. Галт уулын чулуулагууд тодруулбал ихэвчлэн хүрмэн чулуулгаас тогтсон гадаргын хэлбэр дүрсүүд Хангайн төв хэсгээр нилээд тархсан байдаг. Энэ талаар шинэ төрмөлийн эриний гуравдагчийн сүүлч, дөрөвдөгчийн галавын эхээр оргилж байсан галт уул олон бөгөөд тэдгээрээс бялхан гарсан хүрмэн урсгал Тэрхийн голын хөндийг боож Тэрхийн Цагаан нуурын хотгорыг үүсгэсэн болохын гэрчилдэг. Энэ хотгорт орших Чулуут гол нь зарим газраа бачуу, гүн хавцлыг бүрэлдүүлэгч хүрмэн чулуун эргийн дотуур урсана. Тэрхийн Цагаан нуураас зүүн тийш “ Хоргын тогоо “ гэж нэрлэгдэх хэвээрээ үлдэж хоцорсон хэд хэдэн галт уулын шовгор оршино. Түүнчлэн зөв хэлбэртэй галт уулын үлдэгдэл уулс Улаанбаатараас Мөрөн орох замын дагуу тохиолддог.

Гол нурууны дагуу эртний тэгшрэлийн гадаргын хамгийн өндөр хэсэг хадгалагдаж үлдсэн тул уулсын цөм хавтгай буюу бөмбөгөрдүү байна. Гол нуруу, том голуудын эхээр / Чулуут, Байдраг, Тамир/ эртний мөстлийн сийлээ хотгор гүдгэрийн бүх хэлбэрүүд тухайлбал хунх, цөр, тэвшин хөндий зэрэг элэгдлийн хэлбэрүүд, түүнээс доош эцсийн , ёроолын хажуугийн морены толгодууд байхын зэрэгцээ гадаргын байдал ихээхэн хэрчигдсэн тул уулсын хажуу нь эгц, хад асга ихтэй бөгөөд хормойн хурдас, хушуу туугдас нилээд түгээмэл тархсан байна.

Хангайн гол нуруунаас Сэлэнгэ мөрөн, Орхон, Тамир, Байдраг, Түй, Онгийн гол, түүнчлэн Тэс , Завхан голууд эх авна.

**Уур амьсгал:** Тус мужийн тойргууд нь өөр хоорондоо нэлээд ялгаатай. Ялангуяа Хан Хөхийн нурууны ойт хээрийн тойрог нь ихээхэн ялгаатай болно. Учир нь Хан Хөхийн уулс Алтайн ар говийн цөлөрхөг муж дотор нэлээд баруун зүг түрж тогтсон байгалийн сонин үзэгдэл (феномен) юм. Орчноосоо харьцангуй өндөр Хан Хөхийн нуруу нь зундаа сэрүүвтэр, өвөлдөө дулаавтар, хур чийг харьцангуй их тул ойт хээрийн шинжийг агуулсан байдаг. Энэ тойрогт мэдээний урт цуваатай цаг уурын станц байхгүй бөгөөд гол төлөв бүрэн бус мэдээтэй, цөөн жил ажилласан цаг уурын харуулууд ажилладаг тул уур амьсгалын нөхцлийн талаар нарийвчлан тодруулах үндэслэл муутай байгаа болно. Энд жилийн дундаж агаарын температур  $-2^{\circ}\text{C}$ , хамгийн хүйтэн 1 дүгээр сард  $-25^{\circ}\text{C}$ , хамгийн дулаан 7 дугаар сард  $+20^{\circ}\text{C}$  орчим байдаг нь дурдсан мужийн бусад тойрогтой харьцуулахад хүйтний улиралд илүү хүйтэн, зундаа арай дулаан байгаа нь цөлөрхөг газрын хүрээлэлд оршдогийн илрэл юм.

Эндхийн цөлөрхөг нутагт жилдээ 100 орчим мм тунадас ордог бол Хан Хөхийн нуруу орчим үүнээс 2 дахин их буюу жилийн нийлбэр хур тунадас 200 орчим мм байдаг. Гэхдээ энэ нь Хангайн бусад тойргоос 20-50 мм-ээр бага байна. Уур амьсгалын нөхцлийн нэг онцлог нь Тэс, Идэр голын хөндий, уулс хоорондын хөндий хотгор газартаа өвөл нэн хүйтэн байдаг. Баян-уул (Завхан) суманд 1-р сард үнэмлэхүй хамгийн бага температур 1981 онд  $-52^{\circ}\text{C}$  хүрч хүйтэрсэн бөгөөд үнэмлэхүй бага температурын дундаж нь  $-45^{\circ}\text{C}$  байдаг. Түүнчлэн ийм байдал Баянтэс, Сонгино, Түдэвтэй, Идэр, Яруу зэрэг сумын цаг уурын станц, харуулд тэмдэглэгдсэн байна.

Зундаа сэрүүвтэр, дулаан улирлын дундаж агаарын температур  $+13 - +15^{\circ}\text{C}$  орчим байдаг боловч заримдаа их халах явдал тохиолддог. Тухайлбал, дээр дурдсан Баян-уул суманд 1974 оны 6-р сард үнэмлэхүй хамгийн их температур  $+37^{\circ}\text{C}$  хүрч байсан байна. Энд 7 дугаар сарын 2-р арав хоногт хамгийн их температур бараг жил бүр  $30^{\circ}\text{C}$  хүрч болох (90%-ийн хангамжтай) бөгөөд 10 жилийн 5-д нь  $+27^{\circ}\text{C}$ , 10 жилд 1 удаа  $+24^{\circ}\text{C}$  хүрч байсан байна. Иймд энэ тойрогт эх газрын эрс тэс уур амьсгалын нөхцөл хүчтэй илэрдэг байна.

Булнай-Тарвагатай нурууны ой тайга бүхий тойрогт Хөвсгөл, Завхан, Архангай аймгийн хангайн сумууд хамрагддаг. Энэ нь Монгол орны хамгийн их хур тунадастай, усзүйн сүлжээ ихтэй ой тайга бүхий газрын нэг юм. Хамгийн дулаан 7 дугаар сарын дундаж агаарын температур  $+15^{\circ}\text{C}$ -аас үл хэтрэх бөгөөд зуны турш цочир хүйтрэл олон тохиолдоно. Ургамалд нэн халгаатай цочир хүйтрэлтэй өдрийн тоо дулааны улиралд дунджаар 31-ээс дээш байхын хамт эцсийн цочир хүйтрэл 6 дугаар сарын сүүлчээр, анхны цочир хүйтрэл 7 дугаар сарын сүүлч, 8 дугаар сарын эхээр болдог. Хүйтрэлгүй хугацаа 80 хоног орчим байна. Ургамлын ургалтын хугацаан дахь температурын нийлбэр  $+1250^{\circ}\text{C}$ -аас бага (80%-ийн хангамжтай) байдаг. Жилдээ 350 мм орчим хур тунадас ордог. Өөрөөр хэлбэл ургамал ургах хугацаанд чийгийн хангамж ихэнх тохиолдолд хүрэлцээтэй боловч ургамал ургах хугацааны дулаан хангалтгүй байдаг.

Хангайн нурууны тэгш өндөрлөгийн тойрогт Завхан, Архангай, Өвөрхангай аймгийн хангайн сумын нутаг хамрагдана. Жилийн дундаж агаарын температурын хувьд нөгөө 2 тойргоо бодвол харьцангуй дулаавтар, ихэнх нутгаар нь хур тунадасны хэмжээ нь ойролцоо болно. Харин уг тойрогт багтах Завхан, Баянхонгор, Өвөрхангайн өмнөд хэсэг нь жилдээ 200-290 мм тунадас ордог буюу арай хуурайвтар байдаг онцлогтой. 1 дүгээр сарын дундаж агаарын температур Баянхонгорт  $-18.3^{\circ}\text{C}$ , Хужиртад  $-21.1^{\circ}\text{C}$ , Арвайхээрт  $-14.7^{\circ}\text{C}$  байдаг байна. 7 дугаар сард дунджаар  $14.6-16.2^{\circ}\text{C}$  байна. Дулааны улирлын цочир хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 80-100 хоног бөгөөд энэ нь хавар 5 дугаар сарын сүүлч 6 дугаар сарын эхнээс 9 дүгээр сарын эх хүртэл үргэлжилнэ. Агаарт  $0.. - 2^{\circ}\text{C}$  цочир хүйтрэл болох нь дунджаар 10 удаа,  $-3...- 4^{\circ}\text{C}$  хүрч хүйтрэх нь 4-5 удаа,  $-5^{\circ}\text{C}$ -аас доош хүчтэй цочир хүйтрэх нь дулааны улиралд дунджаар 2 удаа тохиолддог байна. Энэ нутагт их халуун болох үед цочир хүйтрэх, мөндөрт цохиулах зэргээр эрсдэлтэй боловч ерөнхийдөө газар тариалан эрхлэхэд харьцангуй тохиромжтой нутаг юм.

**Ургамлан нөмрөг.** Ургамалжилтын хувьд нэг талаас Сибирийн тайгын элементүүд, нөгөө талаас Монголын хээрийн төлөөлөгчид мөн Дагуурын элементүүд нэвтэрч байршсан учир уулын хээр, уулын ойт бүслүүр ээлжлэн солигддог. Хангайн нурууны тагд Алтай-Соёны өндөр уулын элементүүд нилээд бий. Залуу унаган ургамлуудаас гадна Төвд бягзаа, их бушилз зэрэг Гималайн өндөр уулсын үлдвэр ч энд бий. Тагдаа бушилз, өлөн-бушилзат, алаг өвст намгархаг нугатай, хаг, хөвдөт царамтай тагийн сөөгөн ширэнгэтэй. Уулсынхаа арыг дагаж саруул шинэсэн ой зонхилох боловч Тарвагатай болон Булнайн уулсын ой нь тайгажуу шинжийг үзүүлдэг.



Хангайн нурууны олонхи уулсын хажуугаар ботууль-алаг өвст, үетэн-алаг өвст, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст уулын хээр өргөн тархсан байх ба тэнд Ленийн ботууль, саман дурваа, сунагар биелэг, сибирь ботууль, сибирь ба байгаль хялгана Шеллийн бутнуур зэрэг үетэн, зогдор, өлөн, хигмэл бивлэнцэр, одой далантүрүү, дагуур тайр, нарийн навчит тарна, цомогт баавар цэцэг зэрэг ургамлууд голлох байр эзлэнэ.

Өргөн хөндийнүүддээ хуурай шивээт хялгана, шивээт хялгана-агьт хээртэй. Харин хангайн нурууны баруун болон өвөр хэсгээр их хээржсэн тул түүгээр дамжин цөлөрхөг хээрийн ургамал энэ мужид нэвтэрсэн байдаг.

Одоогийн байдлаар 1214 зүйл ургамал бүртгэгдээд байгаа бөгөөд үүний дотор 151 зүйл өвслөг ургамал (тойргийн ургамлын 12.44%), 1063 зүйл модлог болон сөөглөг ургамал (87.51%) байна. Зүйлийн бүрдлээрээ хамгийн баялаг мужид орж байгаа бөгөөд модлог болон сөөглөг ургамлын тоо хамгийн олон. Энэ мужид байгаа ургамлыг экологийн бүлгээр нь ялгаж үзвэл:

- Чийгсэг, чийгсүү-хуурайсуу ургамал 336 зүйл (мужийн бүх ургамлын 27.68%)
- Намагсаг бүлгийн бүх ургамал 175 зүйл (14.41%)
- Усны ургамал 37 зүйл (3.05%)
- Хүйтсэг бүлгийн бүх ургамал 210 зүйл (17.3%)
- Чулуусаг бүлгийн ургамал 271 зүйл (22.32%)
- Элссэг ургамал 21 зүйл (1.73%)

- Давссаг ургамал 74 зүйл (6.1%) байгаа нь уулын хээр, тайгын ойн шинжийн аль алиныг нь харуулж, өндөр уул элбэгтэй тул тагийн ургамал ихтэйг, тойргийн захаар том том элсэн манхан шургаж орсон, нуур голын давс хужиртай эрэг, марз мараатай голууд байдгийг илтгэж байна.

Хан Хөхийн нурууны ойт хээрийн тойрог. Тойргийн төв хэсэг Хан Хөхийн нурууны өндөрлөг хэсгээр цэвдэгт тайгын (заримдаа хүлэрлэг) хөрстэй шинэсэн, гацууран, хуш-шинэсэн, тайга ба сарьдаг орчмын тайрмал ойтой дайвар байдлаар ашиглах бэлчээр, уулын нугын, уулын нугат-хээрийн хөрстэй бушилзат хээршсэн бэлчээртэй. Зун-намарт сарлагт тохиромжтой.

Хан Хөхийн нурууны дунд бие, бэл орчмоор хар шороон, нугат-хар шороон хөрстэй боролзгоно бүхий алаг өвс-улалж-алтайн бутнуурт нугат-хээрийн бэлчээртэй, зун-намарт үхэр, адуунд тохиромжтой. 15-20 ц/га тэжээлийн нөөц бүхий, 800-850 кг/га тэжээлийн нэгжтэй (дундаж өндөр ба нам уулын орчмоор).

Сонгино хайрхан, Түдэвтэй уул, Хан Жаргалант уулсын хяраар зожир өвст, боролжит болон бусад сөөг, сөөгөнцөрт тундр бүхий уулын тундрын ба уулын нугын ялзмагт хөрстэй бушилзат бэлчээр, зун-намарт сарлагт тохиромжтой. Тэдгээрийн дунд бие, бэлээр нунтаг карбонатлаг хар хүрэн ба хар шороон хөрстэй алаг өвс-дааган сүүлт нугат-хээрийн ба хээрийн, нунтаг карбонатлаг сайргархаг хар хүрэн хөрстэй алаг өвс-хялганат, зүр өвс-хялганат, алаг өвс- хиаг-хялганат хээрийн бэлчээртэй зун-намарт бог мал.үхэр адуунд тохиромжтой. 8.0 ц/га тэжээлийн нөөцтэй, 400-440 кг/га тэжээлийн нэгжтэй.

Булнай-Тарвагатайн нурууны ой, тайга бүхий тойрог. Булнай нурууны ар хэсгээр цэвдэгт тайгын хөрстэй шинэсэн, гацууран, хуш-шинэсэн, тайга ба сарьдаг орчмын торлог ойтой бэлчээрт дайвар байдлаар ашиглагдана. Харин Булнай нурууны урд энгэр нь зожир өвст, боролжит болон бусад сөөг, сөөгөнцөрт тундр бүхий уулын тундрын ба уулын ялмагт хөрстэй өндөр уулын бэлчээр нь зун-намарт сарлагт тохиромжтой. Мөн ширэгт-тайгын ба нугат-ойн гүндээ цэвдэгтэй хөрс бүхий сахлаг өвст шинэсэн, хус-шинэсэн, хус-нарсан ойтой дундаж өндөр ба нам уулын бэлээр зун намарт үхэрт тохиромжтой. 10-11.5 ц/га тэжээлийн нөөцтэй, 800-840 кг/га тэжээлийн нэгжтэй.

Тарвагатайн нурууны өндөр хэсгээр өндөр уулын бүслүүрийн хад, асга бүхий бэлчээрт тохиромжгүй. Түүнээс доошлоод дундаж өндөрлөг уул, нам уулсаар сайргархаг хар шороон ба нунтаг карбонатлаг хар хүрэн хөрстэй алаг өвс-бортуульт хээрийн бэлчээртэй. Зун-намарт бог мал адуунд тохиромжтой, 8.0 ц/га тэжээлийн нөөцтэй, 400-440 кг/га нэгжтэй.

Идэр, Тэрхийн голын сав дагуу тайгын нугын хөрстэй. Улиасан төгөл бүхий нугын алаг өвст, намгийн хүлэрлэг цэвдэгт хөрстэй бургас бүхий хөвөн оройт- улалжит нугын бэлчээртэй. Үхэрт тохиромжтой. 20-25 ц/га нөөцтэй, 1400-1600 кг/га тэжээлийн нэгжтэй.

*Хангайн тэгш өндөрлөгийн тойрог.* Тойргийн төв хэсэг болох Хангайн нурууны дундаж өндөр уулын хэсгээр зожир өвст, боролжит болон бусад сөөг, сөөгөнцөрт тундр бүхий уулын тундрын ба уулын нугын ялмагт хөрстэй, бушилзат бэлчээртэй. Энэ уулын цармын бэлчээр нь зун-намарт сарлагт тохиромжтой. 5.5-6 ц/га тэжээлийн нөөц бүхий 350-400 кг/га тэжээлийн нэгжтэй.

Сайргархаг хар шороон ба нунтаг карбонатлаг хар хүрэн хөрстэй алаг өвс-ботуульт нугат-хээрийн, чулуурхаг хар хүрэн ба хүрэн хөрстэй чулуусаг алаг өвс-ерхөг-хялганат, ерхөгт хуурай хээрийн бэлчээр зун-намарт бог мал, үхэр, адуунд тохиромжтой, 8-10 ц/га тэжээлийн нөөцтэй, 400-550 кг/га тэжээлийн нэгжтэй.

Завхан, Байдраг, Өлзий, Түй, Таацын голын сав дагуу нунтаг карбонатлаг хүрэн, хар хүрэн хөрстэй жижиг бутлаг үетэн-хялганат, хазаар өвс-хялганат дов толгод ба талархаг хуурай хээрийн бэлчээртэй, 7-10 ц/га тэжээлийн нөөцтэй, 250-350 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун-намарт үхэр, адуунд тохиромжтой.

**Хөрсөн бүрхэвч.** Энэ муж нь аядуу зөөлөн сэрүүн чийглэг уур амьсгалтай, ургамлын баялаг нөмрөгтэй, дулаан ба хүйтний ялгарал жигд бус байдаг нь хөрсөн бүрхэвч бүрэлдэн тогтоход чухал нөлөө үзүүлдэг. Хөрсөн бүрхэвчид уулын хөрс зонхилох ба эдгээрээс хамгийн их тархалттай нь уулын ойн хөрс юм. Уулын ойн хөрс Х-3 тойрогт хамгийн их тархсан ба Х-4, Х-5 тойрогт 20 гаруй хувьтай байна. Тал хөндийн хөрсний тархалт мужийн хэмжээнд 6.7 хувиас хэтрэхгүй байна. Бүс дундын хөрс 5-8 хувийг эзэлж байгаа элювийн элсэн хөрс Х-3 тойрогт бага хэмжээтэй тархжээ. Хөрс үүсгэгч эх чулуулгийн хурдас нь элюви, делюви, аллювийн хурдас бөгөөд голдуу шавранцар ба шаварлаг механикийн бүрэлдэхүүнтэй байх боловч сайргархаг ба элсэрхэг хурдас нилээд тааралддаг. Үржил шимээр харьцангуй сайн боловч үе давхаргын хөгжил жигд бус, чийг ба дулааны горим нь өмнөх тойргийн хөрснөөс дээр боловч дулаан нь

таримал ургамлын өсөлт хөгжилтөнд хангалтгүй. Голын хөндий ба нуга-намгийн хөрсөнд цэвдэгшлийн нөлөө их. Хархираагийн уулс Хангайн тэгш өндөрлөгийн тойргийн баруун захаар цөлөрхөг хээрийн бор хөрс бага хэмжээгээр тааралдана. Хөрс нь голдуу шавранцар ба шаварлаг механикийн бүрэлдэхүүнтэй боловч Х-3, Х-5 тойргуудад элсэнцэр ба элсэрхэг хөрс нилээд тархжээ.

Хүснэгт № 3.3. Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон мужийн хөрсний нөөц

Д/д	Хөрсний нэр	Х-3		Х-4		Х-5		Мужийн дүн	
		га	%	га	%			га	%
1	Нуур	40517.47	1.13	34251.58	0.72	5953.88	0.06	<b>80722.93</b>	<b>0.42</b>
2	Уулын тундрын ширэгт	6214.69	0.17	-	0.00	-	0.00	<b>6214.69</b>	<b>0.03</b>
3	Уулын нугын/ уулын тайгын ширэгт	22533.07	0.63	325728.05	6.84	941739.64	8.85	<b>1290000.76</b>	<b>6.79</b>
4	Уулын нугат хээрийн болон уулын нугын	125564.87	3.49	301890.41	6.34	1634421.6	15.36	<b>2061876.88</b>	<b>10.85</b>
5	Уулын тайгын цэвдэгт/уулын тайгын ширэгт	30882.01	0.86	326759.87	6.86	3284.50	0.03	<b>360926.39</b>	<b>1.90</b>
6	Уулын тайгын ширэгт/ уулын карбонаттай хар шороон	213736.82	5.93	1187091.2	24.92	1024649.3	9.63	<b>2425477.40</b>	<b>12.76</b>
7	Уулын ойн ширэгт бараан/уулын хар шороон	26420.89	0.73	83181.53	1.75	25049.68	0.24	<b>134652.10</b>	<b>0.71</b>
8	Уулын карбонаттай хар шороон/уулын карбонатгүй хар хүрэн	70832.44	1.97	141150.88	2.96	36209.73	0.34	<b>248193.06</b>	<b>1.31</b>
9	Уулын хар шороон/ уулын хар хүрэн	669922.45	18.60	1086573.3	22.81	1237814.8	11.63	<b>2994310.68</b>	<b>15.76</b>
10	Уулын хар хүрэн/ уулын нимгэн хар шороон	990070.50	27.49	356293.33	7.48	2344444.1	22.04	<b>3690807.94</b>	<b>19.42</b>
11	Уулын хүрэн/ уулын хар хүрэн	142343.36	3.95	-	0.00	262709.47	2.47	<b>405052.83</b>	<b>2.13</b>
12	Уулын карбонаттай цавар хүрэн/ уулын нимгэн цавар хүрэн	7260.63	0.20	-	0.00	165180.69	1.55	<b>172441.32</b>	<b>0.91</b>
13	Толгодын карбонатгүй хар шороон/ нимгэн сайр чулуурхаг хар хүрэн	21323.23	0.59	-	0.00	-	0.00	<b>21323.23</b>	<b>0.11</b>
14	Толгодын хар шороон/ нугат хар шороон	8391.71	0.23	89059.84	1.87	47443.91	0.45	<b>144895.47</b>	<b>0.76</b>

15	Толгодын карбонатгүй хар хүрэн/ нимгэн сайр чулуурхаг хар хүрэн	-	0.00		0.00	6790.71	0.06	<b>6790.71</b>	<b>0.04</b>
16	Толгодын хар хүрэн/ нимгэн сайр чулуурхаг хар хүрэн	120171.13	3.34	99088.68	2.08	64206.45	0.60	<b>283466.26</b>	<b>1.49</b>
17	Толгодын хүрэн/ нимгэн сайр чулуурхаг хүрэн	68031.20	1.89	-	0.00	448683.66	4.22	<b>516714.86</b>	<b>2.72</b>
18	Сайр чулуурхаг цайвар хүрэн	1801.53	0.05	-	0.00	307107.87	2.89	<b>308909.40</b>	<b>1.63</b>
19	Толгодын цөлөрхөг хээрийн бор	-	0.00	-	0.00	4142.53	0.04	<b>4142.53</b>	<b>0.02</b>
20	Ердийн хар шороон/ нугат хар шороон	40969.82	1.14	65816.21	1.38	85263.39	0.80	<b>192049.43</b>	<b>1.01</b>
21	Нугат хар шороон/ нугат намгийн мараалаг	-	0.00	-	0.00	1637.44	0.02	<b>1637.44</b>	<b>0.01</b>
22	ердийн хар хүрэн/ сайр чулуурхаг хар хүрэн	203121.84	5.64	94091.81	1.98	19322.31	0.18	<b>316535.97</b>	<b>1.67</b>
23	Ердийн хар хүрэн/ мараалаг хар хүрэн	-	0.00	-	0.00	32718.28	0.31	<b>32718.28</b>	<b>0.17</b>
24	Ердийн хар хүрэн/ далд глейрхэг хар хүрэн	47085.63	1.31	75990.74	1.60	140625.83	1.32	<b>263702.20</b>	<b>1.39</b>
25	Үлдмэл нугат хар хүрэн/нугын мараалаг хар хүрэн	-	0.00	-	0.00	4625.10	0.04	<b>4625.10</b>	<b>0.02</b>
26	Давсархаг хар хүрэн/ хужир мараалаг хар хүрэн	143365.95	3.98	40904.78	0.86	9315.62	0.09	<b>193586.36</b>	<b>1.02</b>
27	Ердийн хүрэн/ сайр чулуурхаг хүрэн	233221.47	6.48	-	0.00	270068.28	2.54	<b>503289.75</b>	<b>2.65</b>
28	Ердийн хүрэн/сайр чулуурхаг болон хужир мараалаг хүрэн	-	0.00	-	0.00	8566.51	0.08	<b>8566.51</b>	<b>0.05</b>
29	Ердийн болон нугат хүрэн/ үлдмэл нугат хүрэн		0.00	-	0.00	116130.89	1.09	<b>116130.89</b>	<b>0.61</b>
30	Ердийн цайвар хүрэн/ сайр чулуурхаг цайвар хүрэн	61764.87	1.71	-	0.00	429429.40	4.04	<b>491194.26</b>	<b>2.58</b>
31	Ердийн цайвар хүрэн/ нугат цайвар хүрэн	-	0.00	-	0.00	7015.50	0.07	<b>7015.50</b>	<b>0.04</b>
32	Ердийн цайвар хүрэн/	-	0.00	-	0.00	3573.49	0.03	<b>3573.49</b>	<b>0.02</b>

	хужир марааны бүрдэл								
33	Мараалаг цайвар хүрэн/сайр чулуурхаг цайвар хүрэн	-	0.00	-	0.00	5653.70	0.05	<b>5653.70</b>	<b>0.03</b>
34	Сийрэг элсэн хүрэн	42431.99	1.18	-	0.00	41978.96	0.39	<b>84410.95</b>	<b>0.44</b>
35	Мараалаг нугат хүрэн /үлдмэл нугат хүрэн / хужир марааны бүрдэл	-	0.00	-	0.00	836.89	0.01	<b>836.89</b>	<b>0.00</b>
36	Цөлөрхөг хээрийн бор	-	0.00	-	0.00	7105.06	0.07	<b>7105.06</b>	<b>0.04</b>
37	Цөлөрхөг хээрийн бор/ сайрын болон элсэн хучаастай бор	20.78	0.00	-	0.00	4173.34	0.04	<b>4194.12</b>	<b>0.02</b>
38	Цөлөрхөг хээрийн сайр чулуурхаг бор	-	0.00	-	0.00	8050.35	0.08	<b>8050.35</b>	<b>0.04</b>
39	Цөлөрхөг хээрийн мараалаг бор /хужирлаг нугат бор	-	0.00	-	0.00	5344.66	0.05	<b>5344.66</b>	<b>0.03</b>
40	Элсэн хучаастай бор /элсэн хучаастай сийрэг бор	-	0.00	-	0.00	47972.71	0.45	<b>47972.71</b>	<b>0.25</b>
41	Намгийн цэвдэгт/ нугат намгийн цэвдэгт	-	0.00	-	0.00	4342.07	0.04	<b>4342.07</b>	<b>0.02</b>
42	Нугат намгийн цэвдэгт/намгийн цэвдэгт	-	0.00	52462.13	1.10	126724.72	1.19	<b>179186.85</b>	<b>0.94</b>
43	Нугат намгийн цэвдэгт хужирлаг /нугын цэвдэгт хужирлаг	4276.28	0.12	2690.42	0.06	11793.81	0.11	<b>18760.51</b>	<b>0.10</b>
44	Нугын цэвдэгт/нугат хар шороон	17411.82	0.48	245151.06	5.15	356230.63	3.35	<b>618793.51</b>	<b>3.26</b>
45	Нугын хужир/ хужирлаг нуга	9649.79	0.27	-	0.00	17250.51	0.16	<b>26900.30</b>	<b>0.14</b>
46	Аллювийн нугат намгийн/Аллювийн нугын хужирлаг	25760.37	0.72	63065.83	1.32	49702.70	0.47	<b>138528.89</b>	<b>0.73</b>
47	Аллювийн нугын/ Аллювийн нугын давсархаг	8008.10	0.22	92076.31	1.93	86031.60	0.81	<b>186116.01</b>	<b>0.98</b>
48	Аллювийн нугын хужирлаг ба Аллювийн нүелсэн тогтоцтой	8426.66	0.23	-	0.00	105120.36	0.99	<b>113547.02</b>	<b>0.60</b>

49	Аллювийн үелсэн тогтоцтой ба Аллювийн нугын	-	0.00	-	0.00	43629.01	0.41	<b>43629.01</b>	<b>0.23</b>
50	Хужир марааны бүрдэл	1380.33	0.04	-	0.00	1446.93	0.01	<b>2827.27</b>	<b>0.01</b>
51	Хужир болон хужирлаг нугат бор	5388.86	0.15	-	0.00	3559.10	0.03	<b>8947.96</b>	<b>0.05</b>
52	Хагас бэхэжсэн элс	106265.91	2.95		0.00	-	0.00	<b>106265.91</b>	<b>0.56</b>
53	Хөдөлгөөнт элс	55959.16	1.55	-	0.00	2405.30	0.02	<b>58364.46</b>	<b>0.31</b>
54	Хад асга	21005.31	0.58	-	0.00	21936.60	0.21	<b>42941.91</b>	<b>0.23</b>
	<b>Дүн</b>	<b>3601532.9</b>	<b>100</b>	<b>4763318.1</b>	<b>100.0</b>	<b>10639413</b>	<b>100</b>	<b>19004264.7</b>	<b>100.0</b>

**Ан амьтан.** Энэ мужид нийтдээ 5 ангийн 338 зүйл буюу манай орны сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 51.9 % нь оршин амьдардаг байна /3.4-р хүснэгт/.

*Хүснэгт № 3.4. Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон мужийн сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүн*

Нэгж	Дэлэнтэн	Шувуу	Мөлхөгчид	Хоёр нутагтан	Загас	Дугариг амтан	Бүгд
Баг	5	17	1	1	5	-	29
Овог	15	42	4	2	8	-	71
Зүйл	64 (46.0%)	251 (60.5%)	4 (19.0%)	2 (33.3%)	17 (10.0%)	-	338 (51.9%)

*Тайлбар: Монгол оронд бүртгэгдсэн тухайн ангийн амьтдын зүйлийн бүрэлдэхүүний хэдэн хувийг эзэлж буйг хаалтанд бичив.*

**Дэлэнтэн.** Энэ мужид 5 багт хамаарах 64 зүйл дэлэнтэн амьтан тэмдэглэгдсэн нь манай орны дэлэнтний зүйлийн 46.0 % болж байна. Эдгээрийн дотор шавжтан, далавчтан тус бүр 5, туулайтан 6, мэрэгчтэн 26, махчин 14, туурайтан 8 зүйл тус тус байна. Дэлэнтэн дотор зүйлийн тоогоор мөн л мэрэгчтэн /эндэхийн хөхтөний 40.6%/, махчтан / 21.8%/ зонхилно.

Энэ мужийн нутаг дэвсгэрт хойноос умрын ой тайгын зүйлүүд /нохой зээх, баданга хүдэр, халиун буга, бор гөрөөс, зэрлэг гахай, чандага туулай, асганы огодой, бараа хэрэм/, өмнөөс Төв азийн хээрийн зүйлүүд /Монгол тарвага, шивэр алагдаага, хярс үнэг, шар үнэг, мануул мий, дагуур огодой, боролзон туулай, хэргэлзий оготно гэх мэт/, мөн өндөр уулын амьтан /аргаль хонь, янгир ямаа, суусар булга, цоохор ирвэс, тагийн огодой гэх мэт/ харилцан нэвтрэлцэж сууршсанаар онцлог. Энэ тойрогт агнуурын чухал ач холбогдолтой уламжлалт ангийн 24 зүйл амьтан тэмдэглэгдсэнээс 15 зүйлийн тархац нутаг, тоо толгой аль нэг хэмжээгээр багасан цөөрч ховордсоны дотор зүйл /цоохор ирвэс, голын халиу/ бараг устаж, 5 зүйл /суусар булга, мануул мий, баданга хүдэр, аргаль хонь, янгир ямаа/ ихээхэн ховорджээ.

Эндхийн дэлэнтэнээс монголын улаан номонд 5 зүйл /янгир ямаа, аргаль хонь, баданга хүдэр, цоохор ирвэс, голын халиу/, олон улсын улаан номонд 4 зүйл /голын халиу, цоохор ирвэс, нохой зээх, саарал чоно/, Монголын ховор амьтны жагсаалтанд 4 зүйл, /аргаль хонь, янгир ямаа, халиун буга/ оржээ. Ховордсон зэрлэг ургамал, амьтны худалдааны тухай олон улсын конвенцийн I, II хавсралтанд орсон 7 зүйл /I хавсралтанд:

цоохор ирвэс, голын халиу, II хавсралтанд: аргаль хонь, баданга хүдэр, шилүүс мий, мануул мий, саарал чоно/ бий.

**Шувуу.** Энэ мужид 17 баг, 42 овгийн 251 зүйл шувуу тэмдэглэсэн нь манай орны шувуудын зүйлийн бүрэлдэхүүний 60.5 % болно. Шувуудын дотор зүйлийн тоогоор бор шувууны багийн амьтад тэргүүлэх /122 зүйл буюу энэ мужийн шувуудын зүйлийн бүрэлдэхүүний 48.6 %/ бөгөөд дараа нь хөгчүү хэлбэртэн /34 зүйл буюу 13.5 %/, шонхор хэлбэртэн /26 зүйл буюу 10.3 %/, галуу хэлбэртэн /21 зүйл буюу 8.3 %/ тус тус ордог. Ийнхүү Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон мужийн нутаг дэвсгэрт оршин амьдрах дээрх 4 багийн 203 зүйл шувуу нь уг мужийн шувууны нийт зүйлийн бүрэлдэхүүний 80.8 %-ийг эзэлдэг ажээ.

Ан агнуурын тухай Монгол улсын хууль, тогтоомж, Зэрлэг амьтан, ургамлын зүйлийг Олон улсад худалдаалах тухай конвенцийн 1.2-р хавсралт, Монгол улсын ба Байгаль хамгаалах Олон улсын холбооны Улаан номонд орох зэргээр эрх зүйн хувьд ямар нэг хэмжээгээр хамгаалалтад авсан 43 зүйл шувуу /Усны үхэр, халбаган хошуут, хар өрөвтас, хээрийн галуу, хошуу галуу, гангар хун, явлаг сар, согсоот зөгийч сар, сохор элээ, цагаан элэгт, морин харцгай, үлэг харцгай, шунгаач харцгай, шилийн сар, талын сар, бахим бүргэд, тарважи бүргэд, цармын бүргэд, усны нөмрөг бүргэд, усны цагаан сүүлт бүргэд, ёл, цасны хажир бүргэд, тас, идлэг шонхор, эгэл шонхор, шууман шонхор, хайргууна шонхор, амарын турамдай шонхор, зээрд шонхор, начин шонхор, алтайн хойлог, хархираа тогоруу, хар тогоруу, өвөгт тогоруу, тоодог, азийн цууцаль, гуйвангуу ууль, шар шувуу, явлиг ууль, савагт ууль, дорнодын бүгээхэй, харсуун ууль, хув бэгбаатар, өгөөлэй шулганаа/ тус мужийн нутаг дэвсгэрт оршин амьдардаг. Энэ бол тухайн мужийн шувуудын аймгийн генофондын үнэт чанарыг илэрхийлэх нэг үндсэн үзүүлэлт болно.

Ус намгийн амьдралтай, спорт агнуурын өндөр ач холбогдол бүхий 21 зүйл, хөлдүү түүхий эдийн холбогдолтой 8 зүйл шувуу энэ мужид оршин амьдардаг. Мөн байгаль, экологийн тэргүүлэх зэргийн үүрэгтэй хэмээн тооцдог 26 зүйл өдрийн махчин шувуу, шар шувууны багийн 7 зүйлийг энд тэмдэглэсэн байна. Эдгээр нь тухайн мужийн мэрэгч амьтдын тоо толгойг зохицуулах, мал, элдэв амьтны сэг зэмийг устгахад тун чухал үүрэг гүйцэтгэдэг нь ойлгомжтой.

**Мөлхөгчид.** Энэ мужид хайрстны баг, гүрвэлийн салбар багт хамаарах замба гүрвэлийн овгийн цоохор хонин гүрвэл /*Phrynoscephalus versicolor*/, жинхэнэ гүрвэлийн овгийн монгол гүрвэл /*Eremias argus*/, могойн салбар багт хамаарах хар могойн овгийн рашааны могой /*Elaphe dione*/, хорчигнуурт могойн овгийн бамбай хоншоорт могой /*Aqkistrodon halys*/ гэсэн 4 зүйл тэмдэглэжээ. Цоохор хонин гүрвэл нь гол төлөв Их нууруудын хотгор, Нууруудын хөндийд усаа нийлүүлдэг голуудын хөндийг дагаж Хангайн нурууны өмнө ба баруун өмнүүр нэвтрэн орж ирсэн байна. Харин Монгол гүрвэлийн хувьд Орхон, Туулын сав дагуу Хануйн голын дунд хэсэг хүртэл оочин цоочин тархалттай юм. Нөгөө хоёр зүйл могойн хувьд Хангайн мужийн ойт хээр, хээр, уулын

хээр, нуга, намаг гэх мэт бараг бүх хэв шинжийн биотопд оршин амьдарна. Ялангуяа булаг, шандын эх, халуун, хүйтэн рашааны орчмоор элбэг.


**Хоёр нутагтан.** Хангайн мужид сүүлгүй хоёр нутагтны багт хамаарах бахын овгийн монгол бах /*Bufo raddei*/, мэлхийн овгийн шивэр мэлхий /*Rana amurensis*/ гэсэн 2 зүйл амьтан тэмдэглэжээ. Гол төлөв Хойд мөсөн далайн ай савын усан сангуудаар тархсан, элбэг тохиолдох зүйлүүд юм. Хангайн нурууны өврөөс эх авч Нууруудын хөндийд усаа нийлүүлдэг Байдраг, Түй, Онгийн голын эх орчмын нутаг, тэдгээрийн ай савд багтах булаг, шандаар монгол бах нилээд элбэг.

**Загас.** Энэ мужийн усан сангуудаар Хойд мөсөн далайн болон Тав Азийн ай савын гаралтай 5 баг, 8 овгийн 17 зүйл загас тархжээ. Агнуурын өндөр ач холбогдолтой тул, зэвэг, жарга, шивэр хадран, ердийн цурхай, улаан нүдэн, шивэр сугас, бух сугас, гутаарь, алгана зэрэг загас Хойд мөсөн далайн ай савын Идэр, Дэлгэр мөрөн, Хойд, Урд Тамир, Орхон, Хануй, Чулуут, Суман гол, тэдгээрийн цутгалууд, Тэрхийн цагаан нуурт элбэг. Хангайн нуруунаас эх авч Их нууруудын хотгорын Увс, Айраг, Нууруудын хөндийн Бөөн цагаан, Орог, Таацын цагаан, Улаан нуурт цутгадаг Тэс, Завхан, Байдраг, Түй, Онгийн голын ай савд дан ганц уулархаг Азийн цэнгэг усны *Oreoleuciscus* төрлийн 3 зүйлээс гадна *Rhoxinus* ба *Nemachilus* төрлийн агнуурын холбогдолгүй жижиг загаснууд бий.


Тарвагатайн нуруу түүний орчмын нутаг бол жинхэнэ уулт ой хээрийн район мөн. Энд ой, хээр хоёр талбайн хувьд бараг тэнцүү ажээ. Уулсын дээд хэсгээр хуш-шинэсэн тайга, түүнээс доош шинэсэн ой тархсан. Уулын өмнөд хажуу, энгэр нь уулын хээрээс бүрдэх ба хөндийн төв хэсэг чийг ихтэй намагжуу нугатай. Булнайн нурууны ар хажуу ойтой. Уулсын тэгш зоо модлог ургамалгүй, зөвхөн өндөр уулын нуга, нураг асга, намгаар хучигдсан байдаг.

Хангайн гол нуруунд өндөр уулын нуга түүнийг дагасан бут сөөгөн ширэнгэ ян оргилын намаг, хад чулуун нураг даган ноёрхдог. Өндөр уулын нугууд нь нэгэн жигд хэв шинжтэй бөгөөд энэ нь харьцангуй цөөн зүйл алаг өвс бүхий бушилз, бушилз -улалжит бүлгэмдлээс бүрдэнэ. Дээшлэхэд бушилзат нуга дундуур нураг асга бий болж түүнийг хэсэгхэн хувааж талбайг нь багасгана. Үүнээс бүр дээшлэхэд нүцгэн хад асга, нураг болж хувирах ба тэдгээрийн зайд тагийн цөөн зүйл ургамал ургана. Хангайн нурууны өндөрлөг хэсгээр ой багавтар тохиолдоно.






Зураг № 3.5. Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон мужийн хөрс



Зураг № 3.6. Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон мужийн ургамалжилт



Зураг № 3.7. Хангайн нурууны өндөр уул, ойт хээр хосолсон мужийн газар ашиглалт

### 3.3. Орхон - Сэлэнгийн савын ойт хээрийн муж

Орхон-Сэлэнгийн савын ойт хээрийн муж нь Орхон-Туулын савын бэсрэг уулс бүхий ойт хээрийн тойрог (Х-6), Сэлэнгэ-Орхоны хөндийн хээр бүхий тойрог (Х-7) гэсэн 2 тойрогт хуваагдана.

#### 1.Орхон-Туулын савын бэсрэг уулс бүхий ойт хээрийн тойрог: (Х-6)

Бүрэнгийн нуруу, Хан Жаргалант, Заамарын нуруу болон бусад салбар дундаж, нам уулс хамрагдана. Эдгээрээс томоохон нь Бүрэнгийн нуруу юм. Бүрэнгийн нуруу бол хотгор гүдгэрийн хувьд Хангайн нурууны зүүн хойт дундаж уулсын үргэлжлэл, ландшафтын хувьд Сибирийн хөвч тайгын хээржүү хувилбар, өмнөд төгсгөл болох байгалийн өвөрмөц тогтоцтой нутаг билээ.

Бүрэнгийн нуруу нь бүхэлдээ Сэлэнгэ мөрний дагуу зүүн хойт чигт байрлах нэгэн нэгдмэл уулзүйн тогтолцоог бүрдүүлэх бөгөөд өмнөд хэсэг нь харьцангуй өндөр өргөгдсөн тул хойшоогоо намсах байдалтай гэж болно. Хотгор гүдгэрийн шинж байдал нь Хангайн нуруунаас эрс ялгаатай. Энд хурц шовх оргилууд байхгүй төдийгүй үнэмлэхүй өндрийн хувьд илүү нам юм. Иймд уг уулсын системийн гол цөм болсон Бүрэнгийн нуруу нь эртний тэгшивтэр гадарга бүхий хавтгай орой, хяртай, 1400-1600 м-ийн үнэмлэхүй өндөртэй дундаж уулсаас голлон тогтоно. Эндэхийн уул нурууд нь харьцангуй намхан, бэсрэг уулын шинжтэй бөгөөд морфоструктурын онцлогийн хувьд гадарга нь нилээд хэсэгчлэгдсэн, уул нурууд нь ихэвчлэн гүний хагарлуудын чиглэл дагуу тогтсон байна> Энд Сэлэнгэ мөрний цутгал Зад, Барт, Уул, Алтаад, Өлзийбүрэн, Баруун Нарийн зэрэг голууд эх авах Хан Жаргалант( 2069,0), Дунд Зад ( 1548,7), Зад Барт ( 1802,8), Бодонт ( 1604,7), Өлзий бүрэн ( 1244,5), Хушт, булуу ( 1982,9) зэрэг далайн түвшнээс дээш 1400-2000м өндөр өргөгдсөн бэсрэг, нам уулс зонхилно. Хамгийн өндөр цэг нь 2069,0 өргөгдсөн Хан Жаргалантын нурууны оргил Дүндгэр уул юм. Эндэхийн нам уулс, цав толгод ихээхэн элэгдсэн төрх байдалтай байх ба тэдгээрийн хооронд суурь чулуу ил гарсан суурь тал болон хужир- марцаг- нуур тал элбэг байна. Дээрх уулсаас гадна гадаргын үндсэн хэв шинжийг Орхон болон Туул голын хөндий бүрдүүлнэ. Орхон гол бол Сэлэнгэ мөрний хамгийн том цутгал бөгөөд хангайн өндөр уул Суврагахайрхан / 3200 м / - аас эх авч, Хангайн уулсаас гадна харин өөрийн баруун гарын том цутгалууд болох Туул, Хараа ба Ерөөгөөр дамжин Хэнтийн уулархаг орноос усжина. Орхон гол нь Хархориноос доош 40 км хүртэл өргөн бөгөөд бас нэг зэрэгцээ гол болох хөгшин Орхоноор усжиж хээрийн хөндийгөөр урсана.

Орхон голын зүүн гарын цутгалуудаас томоохон нь Тамирын гол юм. Тамирын хөндий нь дунд ба адаг хэсэгтээ өргөн тавиу /дунджаар 4-5 км / байх ба голын гольдролын өргөн нь 15 - 30 метрийн хооронд байна. Орхон голын дагуух ухаа гүвээрхэг гадаргатай нутагт ихээхэн хэрчигдсэн элэгдлийн гадарга зонхилох бөгөөд тэдгээрийн хооронд намаг, багахан нуурт хотгорууд түгээмэл тархжээ. Гадаргын байдал ихээхэн намагжсан явдал тус орны хойт хэсэгт тархсан мөнх цэвдэгт ул хөрстэй шууд холбоотой байдаг.

Туул голын хөндий нь Улаанбаатараас доош 185 км-т олон салаалсан байх ба зарим үед салаануудын тоо 8-10 болсон байна. Туулын их тохойн хуримтлалын тал нь Туул

голын дагуу Баян Эрхэтийн нуруунаас Заамар хүртэлх газрыг хамрах бөгөөд зарим газраа цав толгодтой хослон оршино. Неоген, дөрөвдөгчийн хурдас түгээмэл бөгөөд бага шиг хотгорын ёроолд хужир, марц, жижиг нуур тогтжээ. Туул голын дагуух цав толгодын үнэмлэхүй өндөр 900 - 1200 метр, харьцангуй өндөр 200 - 400 метр байна. Эндэхийн гадарга түр зуурын урсацаар ихээхэн хэрчигдэж бартаатай болсон буюу их, бага гуу, сайр зэрэг элэгдлийн хэлбэртэй байна. Толгодын оройгоор үлдэц хад, цохио үргэлжлэн тохиолдохоос гадна толгодын хажуугаар ч суурь чулуулаг ил гарсан байна.

## **2. Сэлэнгэ - Орхоны хөндийн хээрийн тойрог: / X - 7/**

Хангай ба Хэнтийн уулт мужийн завсар орших бөгөөд гадаргын байдал нь жигд биш, бэсрэг болон нам уулс, цав толгод, ухаа гүвээт тал, уулс хоорондын хотгор хослон оршино. Өөрөөр хэлбэл, энэхүү тойрог нь Сэлэнгэ - Орхон голуудын дунд, адаг орчмыг хамрана. Дэлгэр Мөрөн болон Идэрийн гол нийлснээс хойш Байгаль нуурын гол цутгал болох Сэлэнгэ мөрөн бүрэлдэнэ. Сэлэнгэ мөрний хөндий нь өргөн, нарийн хэсгүүдтэй бөгөөд өргөн нь 25-30 км хүртэл байна. Сэлэнгэ мөрний хөндий нь хээр боловч голыг хүрээлж орших уулс нь зарим газар хар модтой байдаг. Сэлэнгэ мөрөн өөрийн хөндийн өргөн газруудад олон салаалах бөгөөд энэ нь тус голын өвөрмөц шинж үзэгдэл болох бөгөөд шугуйтай олон арлыг бүрэлдүүлнэ.

Орхон - Сэлэнгийн элэгдлийн уулс нь нийтдээ баруунаас зүүн тийш 1000 орчим км, өргөн нь 300 - 350 км үргэлжилнэ. Эндэхийн уулс бөмбөгөр оройтой, налуу хажуутай, хад чулуу багатай байдаг. Энэ тойргийн үнэмлэхүй өндөр нь 1500 - 2000 орчим метр байх буюу хөндийнүүдийнх нь өргөн 800 - 1200 метр байна. Голын өргөн хөндийнүүдээр голдуу хээр /голын шугуйнаас бусад нь/ байх бөгөөд тийм хөндийгөөр дэрс бүхий давслаг хөрстэй газрууд хааяа тохиолдоно.

Орхон - Сэлэнгийн савын ойт хээрийн муж нь гүний болоод гадаргын усны нөөц их манай улсын хамгийн их устай Сэлэнгэ мөрөн түүний цутгал Орхон, Туул, Идэр, Эг зэрэг голууд урсах тул голын сүлжээ нягт хөгжсөнөөс гадна байран болон хормойн хурдаст уулсын хажуу, уулс хоорондын хотгорт гүний усны нөөц их байдаг. Иймээс хотгор гүдгэрийн хувьд нэн тааламжтай нөхцөлтэй тул манай орны агро үйлдвэрлэлийн гол бүс болон хөгжиж ирсэн. Түүнчлэн инженер хайгуулын ажил, зам тавих, усжуулалт зэрэг ажилд байгалийн аятай нөхцөл бүхий нутаг болно.

Уур амьсгалын хувьд энэ муж нь Хангай, Хэнтийн нурууны хоорондох өргөн уудам харьцангуй нам газраар хээрийн бүс нэлээд хойш түрж орсон, тухайн өргөрөгтөө харьцангуй дулаавтар байдаг гол онцлогтой.

Орхон-Туулын савын бэсрэг уулс бүхий ойт хээрийн тойрогийн хойд хэсэг нь Монгол орны газар тариалангийн гол бүс нутаг юм. Энд 7 дугаар сарын дундаж агаарын температур нь 17-20°C, хоногийн дундаж агаарын температур 10°C-ийн заагийг хавар 5 дугаар сарын сүүлчээр, намар 9 дүгээр сарын дунд үеэр тус тус дайрч, энэ үеийн үргэлжлэх хугацаа нь 117-120 хоног, уулархаг хэсэгтээ 105-110 хоног байдаг. Энэ хугацаанд 1750-2250°C-ийн дулаан хуримтлагддаг.

Хавар эцсийн цочир хүйтрэл олон жилийн дунджаар 5 дугаар сарын 25- наас 6 дугаар сарын эхээр шувтарч намар анхны цочир хүйтрэл 8 дугаар сарын сүүлч, 9 дүгээр сарын эхээр тохиолддог. Булган аймгийн төв орчим энэ хугацаанд агаарт 0°C-аас -2°C хүрч цочир хүйтэрсэн өдрийн тоо олон жилийн дунджаар 19 орчим, -3-аас -4 хүрч цочир хүйтрэх нь 9 удаа тохиолддог. Цочир хүйтрэлгүй байх хугацаа 80-100 хоногт хүрэх бөгөөд 90 хоног байх магадлал 75% байдаг. Дулаан хангамжийн хувьд энэ мужид буудайн эрт болцын сорт, арвай, хошуу будааны эрт ба дунд болцын сорт, вандуй, төмс зэрэг ургамлыг тариалах бололцоотой. Дулааны улиралд 250-300 мм хур тунадас ордог. Харин Сэлэнгэ Орхоны хөндийн хээрийн тойрог нь хээрийн бүсийн шинж арай илүү, томоохон гол мөрний хөндий (Туул, Орхон, Хараа, Ерөө)-гөөр өвөлдөө илүү хүйтэн, зундаа дулаан байдаг. Энэ нутагт жилдээ 250-300 мм хур тунадас ордог.

Энэ мужид ургамлын ургалтын эхний хагас нь хур тунадасаар муу хангагддаг. Хавар гандуу байх магадлал 50% байдаг. Иймээс энд ургацыг бууруулж болох гандуу нөхцөл 10 жилийн 2-5-д нь тохиолдож болох магадлалтай. Энэ бүсэд тогтвортой сайн ургац авахын тулд гантай тэмцэх, ургамлын чийг хангамжийг сайжруулахад (услах) түлхүү анхаарах шаардлагатай юм.

**Ургамлан нөмрөг.** Ургамалжилтын үндсэн хэлбэр нь уулын хээр, түүний хээржсэн хувилбарууд болно. Өндөр уулсаар нь ой зонхилох бөгөөд хус, улиангар заримдаа бага зэрэг холилдон ургасан өвслөг ургамалт шинэсэн ой тохиолдоно. Орхоны голын хажуугийн цутгал намагжсан, татам нь шугуй торлог ихтэй. Хээржсэн нугаас гадна өлөнгө, цахилдаг бүхий марцлаг нуга, дэрс тохиолдоно. Харин Сэлэнгийн саваар хэсэг хэсэг газар элс даган навчит ойн төгөл тохиолддог. Уулсын дээд бие болон нуруудын хавтгай хяраар тохиолдох ой нь тайгын шинжтэй бөгөөд тодорхой хэмжээний хуш үзэгдэх болсон. Уулын хээр нь уулсын өмнөд хэсэг, хөндийгөөр байх ба зүйлийн бүрдэл нь алаг цоог бөгөөд ботууль, туужууны өвс, саман ерхөг зэрэг үетнээс гадна алаг өвс нилээд элбэг. Харин уулсын нөгөө талаар хуурай хээрийн бүлгэмдэл болох хазаар өвс-хялганат, зүр өвс-хялганат, хялгана-навтуулт хээр тааралдана. Уулс хоорондын хөндий нь намагжсан бөгөөд энд үетэн, үетэн- улалжит нуга нам бургаснаас бүрдсэн багавтар шугуй бий.

Орхон-Туулын савын бэсрэг уулс бүхий ойт хээрийн тойргийн өндөрлөг уулсаар дундаж өндөр уулын ширэгт-тайгын ба нугат-ойн гүндээ цэвдэгтэй хөрс бүхий сахлаг өвст шинэсэн, хус-шинэсэн, хус-нарсан ойн бэлчээртэй. 13- 15 ц/га тэжээлийн нөөцтэй, 700-800 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун-намарт үхэрт тохиромжтой.

Тойргийн хойт уулархаг хэсгээр нунтаг карбонатлаг сайргархаг хар хүрэн хөрстэй алаг өвс-хялганат, зүр өвс-хялганат, алаг өвс-хиаг-хялганат, нугат- хээрийн бэлчээртэй. 9- 11 ц/га тэжээлийн нөөцтэй, 650-700 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун-намарт үхэр, адуунд тохиромжтой.

Тойргийн зүүн, зүүн өмнөд хэсгээр нунтаг карбонатлаг сайргархаг хүрэн хөрстэй чулуусаг алаг өвс-хялганат, хазаар өвс-хялганат, харгана-хялганат хээрийн бэлчээртэй, 5-8

ц/га тэжээлийн нөөцтэй, 250-350 кг/га тэжээлийн нэгжтэй. Өвөл-хавар бог мал, адуунд тохиромжтой

Сэлэнгэ, Орхон, Туул голын сав дагуу намгийн хүлэрлэг цэвдэгт хөрстэй бургас бүхий хөвөн оройт-улалжит, татмын нугын хөрстэй улиасан төгөл бүхий нугын алаг өвст нугын бэлчээртэй. 26-29 ц/га тэжээлийн нөөцтэй, 1900-2100 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун-намарт үхэрт тохиромжтой.

Туул голын зарим хэсэг, Өгий нуур, түүний орчмын хонхор хотгор хэсгээр марзлаг нугын хөрстэй улалжит, цахилдагт, зурман сүүлт нугын бэлчээртэй. 18-20 ц/га тэжээлийн нөөцтэй, 850-900 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун-намарт бог мал, тэмээнд тохиромжтой.

Сэлэнгэ-Орхоны хөндийн хээрийн тойргийн хойт хэсэг-Дэлгэрхан уул, Бүтээлийн нурууны зүүн сэжүүр хэсгээр ойн бараан ба нугат-ойн гүндээ цэвдэгтэй хөрс бүхий сахлаг өвст хус, улиангаран дундаж өндөр уулын ойн бэлчээртэй. 12-15ц/га тэжээлийн нөөц, 800-850 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун- намарт үхэрт тохиромжтой.

Нам уулсын бэлээр хар шороон, нугат-хар шороон хөрстэй боролзгоно бүхий улалж-үетэнт, сайргархаг хар шороон ба нунтаг карбонатлаг хар хүрэн хөрстэй алаг өвс-ботуульт нугат хээрийн бэлчээртэй. 8-10 ц/га тэжээлийн нөөцтэй, 400-500 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун-намарт бог мал, адуунд тохиромжтой.

Тойргийн төв хэсгийн тал хөндийгөөр нунтаг карбонатлаг сайргархаг хүрэн хөрстэй чулуусаг алаг өвс-хялганат, харгана-хялганат, хазаар өвс-хялганат хуурай хээрийн бэлчээртэй. 20-22 ц/га тэжээлийн нөөцтэй, 1400-1500 кг/га тэжээлийн нэгжтэй. Өвөл-хаварт бог мал, адуунд тохиромжтой.

Сэлэнгэ, Орхон бусад голын татмын нугын хөрстэй улиасан төгөл бүхий хөвөн оройт-улалжит нугын бэлчээртэй. 24-30 ц/га тэжээлийн нөөцтэй, 1700- 1800 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун намарт үхэр, адуунд тохиромжтой.

**Хөрсөн бүрхэвч.** Энэ мужийн хөрсөн бүрхэвчид уулын хөрс зонхилох ба уулын хар шороон болон хар хүрэн хөрс тус мужийн 30 хувийг эзлэх бөгөөд мужийн өмнөд хэсгийн уулархаг нутгаар тархана. Мөн ердийн болон сайр чулуурхаг хар хүрэн хөрс 20 орчим хувийг эзэлж байна. Бүс дундын хөрс 9 гаруй хувийг эзэлж байгаа ба элсэн хөрс Х-6 тойргийн урд хэсгээр бага зэрэг тархана. Хөрс үүсгэгч эх чулуулгийн хурдас нь элюви, делюви, аллювийн хурдас бөгөөд голдуу хүнд болон дунд шавранцар ба шаварлаг механикийн бүрэлдэхүүнтэй байх боловч сайргархаг ба элсэрхэг хурдас нилээд тааралддаг онцлогтой.Ерөнхийдөө манай орны газар тариалангийн төв бүсийг хамран байрлах тул хөрсний ялзмагт үеийн зузаан их, үржил шим харьцангуй тогтвортой өндөр үзүүлэлттэй байдаг.

Хүснэгт№ 3.5. Орхон-Сэлэнгийн савын ойт хээрийн мужийн хөрсний нөөц

Д/д	Хөрсний нэр	Х-6		Х-7		Мужийн дүн	
		га	%	га	%	га	%
1	Нуур	7186.64	0.08	201.86	0.01	<b>7388.50</b>	<b>0.06</b>
2	Уулын тайгын ширэгт/уулын карбонаттай хар шороон	1036433.62	12.00	33005.76	0.86	<b>1069439.38</b>	<b>8.58</b>
3	Уулын ойн сул чандруулаг элсэн	-	0.00	36589.38	0.96	<b>36589.38</b>	<b>0.29</b>
4	Уулын ойн ширэгт бараан/уулын хар	392925.41	4.55	441925.96	11.56	<b>834851.37</b>	<b>6.70</b>

	шороон						
5	Уулын карбонаттай хар шороон/уулын карбонатгүй хар хүрэн	62302.05	0.72	-	0.00	<b>62302.05</b>	<b>0.50</b>
6	Уулын хар шороон/уулын хар хүрэн	922924.23	10.69	243077.32	6.36	<b>1166001.55</b>	<b>9.36</b>
7	Уулын хар хүрэн/уулын нимгэн хар шороон	2508108.13	29.05	1308568.41	34.23	<b>3816676.54</b>	<b>30.64</b>
8	Уулын хүрэн/уулын хар хүрэн	44645.91	0.52	-	0.00	<b>44645.91</b>	<b>0.36</b>
9	Толгодын хар шороон/нугат хар шороон	257423.79	2.98	82082.92	2.15	<b>339506.71</b>	<b>2.73</b>
10	Толгодын карбонатгүй хар хүрэн/нимгэн сайр чулуурхаг хар хүрэн	31572.08	0.37	47189.52	1.23	<b>78761.60</b>	<b>0.63</b>
11	Толгодын хар хүрэн/нимгэн сайр чулуурхаг хар хүрэн	413301.95	4.79	152181.90	3.98	<b>565483.84</b>	<b>4.54</b>
12	Толгодын хүрэн/нимгэн сайр чулуурхаг хүрэн	113927.82	1.32	-	0.00	<b>113927.82</b>	<b>0.91</b>
13	Сул чандруулаг элсэн	4054.27	0.05	66534.08	1.74	<b>70588.35</b>	<b>0.57</b>
14	Ердийн хар шороон/нугат хар шороон	61428.09	0.71	2158.75	0.06	<b>63586.84</b>	<b>0.51</b>
15	Нугат хар шороон/нугат намгийн мараалаг	10674.16	0.12	9525.76	0.25	<b>20199.91</b>	<b>0.16</b>
16	ердийн хар хүрэн/сайр чулуурхаг хар хүрэн	368054.38	4.26	121484.70	3.18	<b>489539.08</b>	<b>3.93</b>
17	Ердийн хар хүрэн/мараалаг хар хүрэн	19415.10	0.22	75580.82	1.98	<b>94995.92</b>	<b>0.76</b>
18	Ердийн хар хүрэн/далд глейрхэг хар хүрэн	918100.19	10.63	847472.87	22.17	<b>1765573.06</b>	<b>14.17</b>
19	Үлдмэл нугат хар хүрэн/нугын мараалаг хар хүрэн	126848.78	1.47	20329.13	0.53	<b>147177.91</b>	<b>1.18</b>
20	Давсархаг хар хүрэн/хужир мараалаг хар хүрэн	8012.29	0.09	15816.56	0.41	<b>23828.86</b>	<b>0.19</b>
21	Ердийн хүрэн/сайр чулуурхаг хүрэн	55099.17	0.64	-	0.00	<b>55099.17</b>	<b>0.44</b>
22	Ердийн хүрэн/сайр чулуурхаг болон хужир мараалаг хүрэн	26299.82	0.30	-	0.00	<b>26299.82</b>	<b>0.21</b>
23	Ердийн болон нугат хүрэн/үлдмэл нугат хүрэн	124558.37	1.44	-	0.00	<b>124558.37</b>	<b>1.00</b>
24	Сийрэг элсэн хүрэн	96336.69	1.12	42038.36	1.10	<b>138375.04</b>	<b>1.11</b>
25	Мараалаг нугат хүрэн/үлдмэл нугат хүрэн/хужир марааны бүрдэл	90750.07	1.05	5212.14	0.14	<b>95962.22</b>	<b>0.77</b>
26	Нугат намгийн цэвдэгт/намгийн цэвдэгт	14812.40	0.17	1785.80	0.05	<b>16598.21</b>	<b>0.13</b>
27	Нугат намгийн цэвдэгт хужирлаг/нугын цэвдэгт хужирлаг	16371.35	0.19	2436.47	0.06	<b>18807.82</b>	<b>0.15</b>
28	Нугын цэвдэгт/нугат хар шороон	173292.30	2.01	23595.89	0.62	<b>196888.18</b>	<b>1.58</b>
29	Нугын хужир/хужирлаг нуга	60500.55	0.70	7492.74	0.20	<b>67993.29</b>	<b>0.55</b>
30	Аллювийн нугат намгийн/Аллювийн нугын хужирлаг	27547.11	0.32	6562.03	0.17	<b>34109.14</b>	<b>0.27</b>
31	Аллювийн нугын/Аллювийн нугын давсархаг	474188.49	5.49	208794.13	5.46	<b>682982.61</b>	<b>5.48</b>
32	Аллювийн үелсэн тогтоцтой ба Аллювийн нугын	5833.09	0.07	-	0.00	<b>5833.09</b>	<b>0.05</b>
33	Хужир марааны бүрдэл	27874.64	0.32	21088.01	0.55	<b>48962.65</b>	<b>0.39</b>
34	Хужир болон хужирлаг нугат бор	53674.21	0.62	-	0.00	<b>53674.21</b>	<b>0.43</b>
35	Хагас бэхэжсэн элс	70949.83	0.82	-	0.00	<b>70949.83</b>	<b>0.57</b>
36	Мөнх цас мөсөн гол, эх чулуулгийн илэрц	9521.18	0.11	-	0.00	<b>9521.18</b>	<b>0.08</b>
	<b>Дүн</b>	<b>8634948.17</b>	<b>100.00</b>	<b>3822731.24</b>	<b>100.00</b>	<b>12457679.42</b>	<b>100.00</b>

**Ан амьтан.** Энэ мужид нийтдээ 5 ангийн 310 зүйл буюу манай орны сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 47.6 % нь оршин амьдардаг байна.

Хүснэгт № 3.6. Орхон-Сэлэнгийн савын ойт хээрийн мужийн сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүн

Нэгж	Дэлэнтэн	Шувуу	Мөлхөгчид	Хоёр нутагтан	Загас	Дугариг амтан	Бүгд
Баг	6	18	1	2	6	-	33
Овог	16	45	3	4	11	-	79
Зүйл	58 (41.7%)	219 (52.7%)	5 (23.8%)	4 (66.6%)	24 (14.2%)	-	310 (47.6%)

Тайлбар: Монгол оронд бүртгэгдсэн тухайн ангийн амьтдын зүйлийн бүрэлдэхүүний хэдэн хувийг эзэлж буйг хаалтанд бичив.

**Дэлэнтэн.** Энэ мужид 6 багт хамаарах 58 зүйл (монгол орны дэлэнтний зүйлийн 41.7%) одоогоор тэмдэглэсний дотор шавжичтан 5, далавчтан 5, туулайтан 6, мэрэгчтэн 28, махчтан 12, туурайтан 5 зүйл байна. Дэлэнтний дотор зүйлийн тоогоор манай аль ч нутагт тохиолддогийн адил мэрэгчтэн (эндэх хөхтний 48.2%) тэргүүлж, дараа нь махчтан (20.6%) орж байна.

Орхон-Туулын савын бэсрэг уулс бүхий ойт хээрийн тойргийн дэлэнтэн амьтны зүйлийн зонхилох хэсгийг умрын ой, сибирийн тайгын (бор гөрөөс, нохой зээх, модны үен, усчин гэрэлзгэнэ, асганы огдой, улаан ойго, халиун буга г.м) амьтан эзэлж байна. Гэтэл Сэлэнгэ-Орхоны хөндийн хээрийн тойрогт гол мөрний хээржсэн өргөн хөндий бэл, дэнж дагаж Төв азийн хээр талын нэлээд зүйл нэвтэрсэн (монгол тарвага, хярс үнэг, шар үнэг, шивэр алагдаага, мануул мий, дагуур огдой, бор туулай) байна. Ийнхүү энэ муж ой, хээрийн дэлэнтэн амьтны холимог бүрдэлтэй. Том, бага голуудын хээржсэн, нугажсан өргөн, нарийн хөндийнүүдээр хэрчигдсэн дундаж, өндөр өвс бүхий ойт нам уулс нь ан амьтан, ялангуяа ойн амьтан (халиун буга, бор гөрөөс, зэрлэг гахай, зүйл бүрийн мах идэштэн, мэрэгч) байрших тохиромжтой өгөөмөр газар болно. Эртнээс хүн харьцангуй шигүү нутаглаж байсан энэ нутгийн зарим агнуурын үнэт амьтан (голын минж, голын халиу, өмнөөс нүүдлээр нэвтэрдэг цагаан зээр г.м) одоо нэгэнт устаж үгүйрчээ.

Сүүлийн 50-аад жилд эндхийн гол мөрөнд зэргэлдээх ОХУ-ын нутгаас заарт ондоотор, усны үен гэх агнуурын чухал холбогдолтой хоёр зүйл амьтан өөрөө байгалийн аясаараа нэвтрэн ирж нутагшиж байна. Эдгээр ирмэлүүд нутгийн ан амьтан, биоценозод ямар нөлөө холбогдолтойг өнөө хэр судлаагүй байна.

Эндэхийн дэлэнтнээс Монголын улаан номонд 2 зүйл /дагуур зараа, баданга хүдэр/, олон улсын улаан номонд 2 зүйл /нохой зээх, саарал чоно/, Монголын ховор амьтны жагсаалтанд 1 зүйл /халиун буга/ оржээ. Ховордсон зэрлэг ургамал, амьтны худалдааны тухай Олон улсын конвенцийн II хавсралтанд 4 зүйл /баданга хүдэр, шилүүс мий, мануул мий, саарал чоно/ орсон бий.

**Шувуу.** Орхон-Сэлэнгийн савын ойт хээрийн мужийн нутаг дэвсгэрт нийт 17 баг, 45 овгийн 251 зүйл шувуу бүртгэгдсэн байна. Шувуудын дотор зүйлийн тоогоор бор шувууны багийн амьтад тэргүүлэх /85 зүйл буюу энэ мужийн шувуудын зүйлийн бүрэлдэхүүний 33.8 %/ бөгөөд дараа нь хөгчүү хэлбэртэн /27 зүйл буюу 10.7 %/, шонхор хэлбэртэн /25 зүйл буюу 9.9 %/, галуу хэлбэртэн /26 зүйл буюу 10.3 %/ тус тус ордог. Ийнхүү Орхон- Сэлэнгийн савын бэсрэг уул, ойт хээр хосолсон мужийн нутаг дэвсгэрт



оршин амьдрах дээрх 4 багийн 163 зүйл шувуу нь уг мужийн шувууны нийт зүйлийн бүрэлдэхүүний 64.9 %-ийг эзэлдэг байна. Орших хэлбэрийн хувьд суурин 44 зүйл, нүүдэллэн өндөглөдөг 157, өндөглөдөг эсэх нь бүрэн тогтоогдоогүй 15, дайрч өнгөрдөг 27, өвөл орж ирдэг 8 зүйл байдаг ажээ.

Үндсэн биотоп, байршлын хувьд : Гол, нуур, намагтай орчинд 95 зүйл, Ой шугуй , төгөлд 111, хээр талд 23, хад чулуугаар 14, антропоген орчинд 5, ямар ч орчинд түгээмэл тархсан 3 зүйл энд оршино.

Монгол улсын Улаан номонд орсон шувуудаас энэ мужийн нутаг дэвсгэрт *Egretta alba* (цасч дэглий), *Platalea leucorodia*, (халбаган хошуут), *Ciconia nigra* (хар өрөвтас), *Cygnus cygnus* гангар хун), *Anser indicus* (хээрийн галуу), *Anser cygnoides* (хошуу галуу), *Anas formosa* (байгалийн нугас), *Pandion haliaetus* (явлаг сар), *Haliaeetus albicilla* (усны цагаан сүүлт бүргэд ), *Grus vipio* (цэн тогоруу), *Otis tarda* (тоодог), *Remiz pendulinus* (уран шувуу) тааралдана. Мөн Монгол болон Олон улсын бусад хууль тогтоомжийн дагуу хамгаалагдсан 36 зүйл /усны бух, цагаан элэгт, үлэг харцгай, шунгаач харцгай, тарлан сар, шалийн сар, талын сар, бахим бүргэд, тарважи бүргэд, цармын бүргэд, усны нөмрөг бүргэд, тас, идлэг шонхор, шууман шонхор, хайргууна шонхор, амарын турамдай шонхор, зээрд шонхор, начин шонхор, хархираа тогоруу, цэн тогоруу, өвөгт тогоруу, хилэн жигүүрт, азийн цууцаль, цэвдгийн ууль, шар шувуу, явлиг ууль, савагт ууль, дорнодын бүгээхэй, харсуун ууль, хув бэгбаатар, уран шувуу, хилэн жигүүрт г.м./ энэ мужид оршин амьдарна.

Тус муж агнуурын ач холбогдолтой зүйл шувуудаар баян юм. Зөвхөн хөлдүү түүхий эдийн бэлтгэлийн агнуурын нөөц ихтэй хур, сойр, хөтүү, дагуурын ятуунаас гадна ус, намгийн спорт агнуурын шувууд цуглардаг газар энд олон бий. Спорт агнуур хөгжүүлэх ирээдүй ихтэй боломжийг анхааралдаа авахын хамт энэ нутагт өндөглөдөг хар өрөвтас, гангар хун, хээрийн галуу, хошуу галуу, явлаг сар, усны цагаан сүүлт бүргэд, тоодог, уран шувуу зэргийг хамгаалах, мөн ус намгийн агнуурын шувуудыг үржлийн хугацаанд тайван байлгах талаар тодорхой арга хэмжээ авах шаардлагатай.

**Мөлхөгчид.** Энэ мужид 4 овгийн 6 зүйл мөлхөгч амьтан бий. Энэ нь манай орны мөлхөгчдийн зүйлийн бүрэлдэхүүний 28.5 % болно. Замба гүрвэлийн овгийн цоохор хонин гүрвэл тус мужийн зөвхөн Орхон- Туулын савын бэсрэг уулс бүхий ойт хээрийн тойрогт хамаарах Хөгнө-Тарны элс орчимд тохиолдоно. Харин жинхэнэ гүрвэлийн овгийн монгол гүрвэл Орхон-Сэлэнгийн савын хээрийн хэв шинжит нутгаар нилээд түгээмэл тархалттай юм. Рашааны могой, бамбай хоншоорт могой гэсэн 2 зүйл амьтан энэ мужид өргөн тархсан, элбэг зүйлүүд болно. Харин Сэлэнгэ-Орхоны хөндийн тойрогт хамаарах Шаамар орчимд усны могой, Цагаан толгой орчимд нарийн могой тус тус оршин амьдарна. Энэ 2 зүйл бол хязгаарлагдмал тархалттай ховор зүйлүүд бөгөөд нарийн могой нь Монгол улсын Улаан номонд орсон ажээ.


**Хоёр нутагтан.** Орхон-Сэлэнгийн савын ойт хээрийн мужид 4 зүйл хоёр нутагтан тэмдэглэгдсэн нь тус орны энэ бүлэг амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 66.6 % болж байгаа нь манай орны хувьд нилээд өндөр үзүүлэлт юм. Сүүлтэй хоёр нутагтны багийн шивэр

гүлмэр, сүүлгүй хоёр нутагтны багийн модны мэлхий зэрэг амьтад Сэлэнгийн савын Шаамар орчимд бий. Энэ хоёр зүйл Монгол улсын Улаан номонд орсон ховор зүйлүүд билээ. Харин шивэр мэлхий, монгол бах хэмээх 2 зүйл сүүлгүй хоёрнутагтан нь энэ мужийн ус намаг бүхий бараг бүх нутгаар өргөн тохиолдох, элбэг зүйлд орно.


**Загас.** Энэ мужид 6 баг, 11 овгийн 24 зүйл загас тэмдэглэжээ. Эдгээрээс спорт агнуурын ач холбогдолтой 14 зүйл /тул, зэвэг, байгалийн омоль, шивэр хадран, ердийн цурхай, улаан нүдэн, шивэр сугас, бух сугас, алтайн сугас, мөнгөлөг хэлтэг, булуу цагаан, ердийн цулбуурт, гутаарь, алгана/ загас бий. Тус мужид Монгол улсын Улаан номонд орсон шивэр хилэм, тул зэрэг нэн ховор, ховор загас оршин амьдарна.

**Ландшафтын онцлог.** Эндхийн ландшафтад уулын тайгын ширэгт хөрстэй үетэн бүхий нарс-шинэс болон уулын тайгын цэвдэгт хөрстэй давжаа бут-ногоон хөвд бүхий шинэсэн ойгоос бүрдэх тайга, татмын нуга, ойт хээр, нугат хээр зонхилох рольтой. Эндхийн ойд хусан ой түрж ургах явдал хааяагүй тохиолдоно. Ялангуяа ойн түймрийн дараа шинэс, нарсан ойд хус ихээр түрж ургадаг байна. Иймд дурьдсан нутагт алаг өвс-улалжит шинэсэн ой, түүний оронд ургасан хусан ой нэлээд том талбай эзэлнэ.


Сэлэнгэ мөрний татам дагуу бургас, сөөг бүхий торлогт намгархаг нуга, үетэн-алаг өвст нуга ээлжлэн тархана. Эндхийн ихэнх цутгал уулын жижиг голуудын татам дагууд сөөгөн ширэнгэ бүхий намгархаг нуга давамгайлна.



Зураг № 3.8. Орхон-Сэлэнгийн савын ойт хээрийн мужийн хөрс



Зураг№ 3.9. Орхон-Сэлэнгийн савын ойт хээрийн мужийн ургамалжилт



Зураг№ 3.10. Орхон-Сэлэнгийн савын ойт хээрийн мужийн газар ашиглалт

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХОТ ТОСГОН БУСАД СУУРИНЫ ГАЗАР АШИГЛАЛТЫН ОДООГИЙН БАЙДАЛ

### 4.1. Хот тосгон бусад суурин газрын ангилал


Тус аймгийн хот тосгон бусад суурины ангиллын газарт аймгийн төв Мөрөн хот, 23 сум болон алт, нүүрсний уурхайн газрууд тэдгээрийг түшиглэсэн суурингууд, улсын болон орон нутгийн чанартай амралт, рашаан сувиллын газрууд хамрагдаж байна.

*Хүснэгт № 4.1. Хот, тосгон бусад суурины ангиллын газрын харьцуулсан судалгаа (га-аар)*

№	Ангиллын нэр	2003 оны ГНС-н бүртгэлээр /га/	2013 оны ГНС-н бүртгэлээр /га/	Өөрчлөлт /га/	
				+	-
1	Хот тосгон бусад суурины газар- бүгд (га)	18584.0	18783.6	199.6	
2	Барилга байгууламжийн доорхи газар (иргэд, аж ахуйн нэгжүүдийн эзэмшилд)	1593.3	1748.28	154.9	
3	Амралт, рашаан сувиллын газар	56.3	173.14	116.8	
4	Нийтийн эдэлбэрийн газар	15398.3	14046.2		1352.1
5	Үйлдвэр, уурхайн газар-бүгд	239.1	1100.3	861.2	
6	Гэр хорооллын газар-бүгд	1343.3	1866.1	522.8	
7	Бусад	-	-	-	

Хөвсгөл аймгийн хот тосгон бусад суурины ангиллын газрын бүтцийг тодорхойлохын зэрэгцээ уг ангиллын газарт 2013 оны судалгаагаар орсон өөрчлөлтүүдийг тайлбарлах нь зүйтэй юм. Хот тосгон бусад суурины ангиллын хэмжээ 2013 оны судалгаагаар өмнөх 2003 оны газрын бүртгэлээс 199.6 га-аар нэмэгдлээ. Барилга байгууламжийн доорхи газар 154.8 га газраар нэмэгдэж гарсан. Амралт, рашаан сувиллын дэд ангиллын газар зүйн 116.8 га газраар нэмэгдсэн байна. Ийнхүү өсөн нэмэгдэж байгаа хот сууринд хот төлөвлөлтийг газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан хийх шаардлагатай байна.

4.2. Бүлэг суурингийн тогтолцоо



Зураг № 4.1. Бүлэг суурингийн тогтолцоо

Хүснэгт № 4.2. Бүлэг суурингийн төвүүдийн тогтолцоо

Аймгийн нэр	Бүлэг суурингийн тогтолцоо бүгд	Үүнээс		
		Хот аймгийн төвийн	Сум дундын төвийн	
Хөвсгөл	6	Мөрөн	1	Ренчинлхүмбэ
			2	Хатгал
			3	Цагаан уул
			4	Шинэ идэр
			5	Тариалан

Одоогоор бараг бүх сумд зарим сум дундын эмнэлэг, сургуулийг эс тооцвол бусад төрлийн үйлчилгээг аймгийн төвөөс авч байгааг өөрчилж эдийн засаг, аж ахуйн үйл ажиллагааны үр ашигтай шаталсан хэлбэрт оруулах шаардлага нийгмийн шинэчлэлт өөрчлөлтийн өнөөгийн амьдралаас урган гарч байна.

Ийм ч учраас сумдыг бүсчлэн хөгжүүлэх талаар аймаг, орон нутаг санаачлага гаргаж зарим сумдыг нэгтгэж бүсчилсэн хөгжлийн бодлогын зарчмын шийдлийг хүлээсээр байгаа юм.

Бүсчилсэн хөгжлийн бодлогыг төгс хэрэгжүүлэх үүднээс үйлчилгээний зохистой хүрээнд эдийн засаг, аж ахуйн уялдаа холбооны үр ашгийг дээшлүүлэх, засаг захиргааны давхардлыг багасгах шаардлагатай байна.

### 4.3. Хот, тосгон, бусад суурин газрын инженер-геологийн нөхцөл, хот байгуулалтын үнэлгээ

#### 4.3.1. Инженер-геологийн нөхцөл

##### Газрын гадарга.

Газрын гадаргын налуу нь суурьшлын бүс газрын барилга, байгууламж барьж байгуулахад ихээхэн нөлөөтэй болохыг зураг төсөл боловсруулах, барилга байгууламж барих талбайн бэлтгэл, газар шорооны ажилтай шууд холбож үздэг. Газрын гадаргын налуу ихсэх тутам газар шорооны ажлын хэмжээ мөн төдий чинээ нэмэгддэгтэй холбоотой.

Иймд газрын гадаргын налуугийн олон төрөл байдал нь хот төлөвлөлтийн үүднээс эзлэхүүн, орон зайн төлөвлөлтөд өвөрмөц үүрэг гүйцэтгэх нь маргаангүй бөгөөд хот, суурингийн янз бүрийн үүрэг зориулалтын бүсүүдийг гадаргын налуугийн хүчин зүйл, тухайн суурингийн онцлог байдалтай уялдуулан төлөвлөж барьж байгуулах нь зүйтэй юм.

Хүснэгт № 4.3. Газрын гадаргын хот байгуулалтын үнэлгээ

№	Аймгийн нэр	Нийт талбай /км <sup>2</sup> /	Үүнээс тохиромж муутай талбай	
			/км <sup>2</sup> -аар/	/хувиар/
1	Хөвсгөл	100662.0	49012.0	49.0

##### Өндөржилт.

Хот, суурингийн байрлаж буй газрын өндөржилт ихсэх тутам агаарын хүчилтөрөгчийн агуулга болон температур буурч, өдөр шөнийн температурын зөрүү огцом өсч, салхины хүч ширүүсэн, агаарын хуурайшил нэмэгдэн, цаг уурын бусад өөрчлөлтүүдээс шалтгаалж, оршин суугчдын ая тухтай байдал алдагдан, эрүүл мэндэд нөлөөлөхөөс гадна барилга байгууламжийн ашиглалтад сөрөг үр дүн үзүүлдэг байна.

Эмнэлэг-биологийн шаардлагаас үндэслэн, хот байгуулалтын хувьд далайн түвшнээс дээш 1500 м хүртэл өндөжилттэй бол тохиромжтой, 1500-2500 м хүртэл хязгаарлагдмал тохиромжтой, 2500 м-ээс дээш тохиромж муутай нөхцөлд үнэлэгдэж байна.

##### Ус зүй, усан хангамж.

Нутаг дэвсгэрийн хот байгуулалтын үнэлгээний үндсэн үзүүлэлтийн нэг нь хот, суурин газрын усан хангамжийн асуудал юм. Хөрсний усны түвшин 3.0 м-ээс доош бол нэн тохиромжтой, 1.0-3.0 м бол хязгаарлагдмал тохиромжтой, 1.0 м-ээс дээш бол тохиромж муутай ангилалд тооцогдоно.

Газрын доорхи усны нөөцийн ашиглалтын модуль нь 2.0, 6.0, 30.0, 100,0 мянган хүнтэй хот сууринд харгалзан 0,1л/сек.км 2-оос дээш, 0.3 л/сек.км 2-оос дээш, 0,6 л/сек. км 2-оос дээш, 1,0 л/сек.км 2-оос дээш бол тохиромжтой гэж тооцдог.

##### Ул хөрсний ус.

Хот, суурин газрын байршил, барилга байгууламжид нөлөөлөх нэлээд өвөрмөц хүчин зүйлийн нэг нь ул хөрсний ус юм. Хот байгуулалтын хувьд ул хөрсний усны түвшин 3.0 м-ээс дээш гүнд орших бол нэн тохиромжтой, 1.0-3.0 м-ийн гүнд

хязгаарлагдмал тохиромжтой, 1.0 м хүртэл буюу өндөр даралттай уст давхарга байрласан нөхцөлд тохиромж муутай гэсэн үнэлгээнд хамрагдана.

Ул хөрсний усны түвшин өндөр байгаа нөхцөлд хот, суурин барилга байгууламж барьж байгуулахад инженерийн нэмэлт арга хэмжээ зайлшгүй авах шаардлагатай ба үүний улмаас уг барилга багууламжийн төсөвт өртөг нэмэгддэг жамтай юм.

***Ул хөрс.***

Инженер-геологийн хамгийн төвөгтэй нөхцөл нь олон жилийн цэвдэг чулуулаг хөрс бөгөөд энэ хөрсний тархалтад газар орны хотгор, гүдгэрийн байдал, налуужилтын зүг зовхис, агаарын темпратур, хөрсний ус, түүний түвшин, хөдөлгөөний идэвх болон хурдсын төрөл зүйл, шинж байдал нөлөөлнө.

Инженер-геологийн төвөгтэй нөхцөл, улирлын хөлдөлт гэсэлтээс хамаарч ул хөрсний хэв гажилт /овойлт, суулт, хөөлт гэх мэт / үүсэх үзэгдэл манай оронд нилээд элбэг тохиолддог. Ул хөрсний энэ хэв гажилтад цэвдэг чулуулаг хөрс, хөрсний усны түвшин голлон нөлөөлөх бөгөөд овойлт, суулт, хөөлт үүсгэдэг хөрсийг хот байгуулалтын хувьд хүчтэй, дунд, сул гэж ангилан үздэг.

***Инженер-геологийн үйл явц***

Монгол орны нийт нутаг дэвсгэрт намаг, хужир, мараа, хуурай сайр, нуранги асга, хөндийлж болон олон жилийн цэвдэг чулуулаг, улирлын хөлдөлт, гэсэлтээс шалтгаалан үүсэх орчин үеийн геологийн үзэгдэлүүд нэлээд хэмжээгээр тархсан нь хот, суурингийн байршил, түүний цаашдын хөгжилд тодорхой хэмжээгээр нөлөөлдгийг харгалзан инженерийн нарийвчилсан тооцоог хийх нь чухал шаардлагатай болно.

## ТАВДУГААР БҮЛЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР, АШИГЛАЛТЫН ОДООГИЙН БАЙДАЛ

Хөвсгөл аймаг нийт 10062882 га газар нутагтайгаас Хөдөө аж ахуйн газар газрын нэгдмэл сангийн ангилалд одоогийн байдлаар 3749056,8 га / ГНС-ийн тоо бүргэлээр/ байна.

*Хүснэгт №5.1. Хөдөө аж ахуйн газрын ангилал*

№	Хөдөө аж ахуйн зориулалттай газрын ангилал	Хэмжээ/га/
1	Бэлчээр	3649948,5
2	Хадлан	48218
3	Тариалан	33266,68
4	Атаршсан газар	10685,92
5	ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газар	6847,84
6	ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар	89,8
7	<b>НИЙТ</b>	<b>3749056,74</b>

### 5.1. Малын тоо, толгойн өсөлт

Хөвсгөл аймгийн хэмжээнд 3664602 толгой малтайгаас үүний дотор адуу 169854, үхэр 330309, хонь 1741631, ямаа 1420893, тэмээ 1915 байна.

*Хүснэгт №5.2. Нийт малын тоо /сумдаар/*

№	Сумын нэр	Бүгд	Малын төрөл				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
1	Мөрөн	154502	9	5495	10028	76075	62895
2	Алаг-Эрдэнэ	120380	6	4221	10875	51287	53991
3	Арбулаг	221434	176	9689	11797	113788	85984
4	Баянзүрх	179504	89	6060	14859	96031	62465
5	Бүрэнтогтох	247094	116	8330	13134	132201	93313
6	Галт	276414	37	13028	15573	130422	117354
7	Жаргалант	183893	26	8849	13073	100771	61174
8	Их-Уул	217880	42	7620	15663	96504	98051
9	Рашаант	178232	-	6769	13416	88520	69527
10	Рэнчинлхүмбэ	123073	128	9141	23988	50213	39603
11	Тариалан	149543	-	7864	16586	64687	60406
12	Тосонцэнгэл	228554	13	6908	14830	113617	93186
13	Төмөрбулаг	219901	17	5589	12041	82455	119799
14	Түнэл	141462	98	5512	13267	61763	60822
15	Улаан-Уул	114535	130	7561	18769	46760	41315
16	Ханх	29932	-	3259	11865	7312	7496
17	Хатгал	27291	-	2558	6933	6317	11483
18	Цагааннуур	11085	-	1251	3078	3418	3338
19	Цагаан-Уул	279699	611	14133	14069	150369	100517
20	Цагаан-Үүр	24070	-	3439	12064	4933	3634
21	Цэцэрлэг	200022	341	13237	12915	103518	70011
22	Чандмань-Өндөр	40765	-	3218	13678	9372	14497
23	Шинэ-Идэр	184491	76	7485	10860	113544	52526
24	Эрдэнэбулган	55423	-	4319	13474	18877	18753
	<b>Нийт</b>	<b>3664602</b>	<b>1915</b>	<b>169854</b>	<b>330309</b>	<b>1741631</b>	<b>1420893</b>

*Хүснэгт №5.3. Нийт малын тоо, өсөлт харьцуулсан байдал /төрлөөр/*


№	Малын төрөл	Малын тоо			
		2004	2014	Зөрүү	Өсөлтийн хувь
1	Адуу	156073	169854	9462	+6,0
2	Үхэр	238346	330309	78489	+32,9
3	Тэмээ	2729	1915	-814	-30,1
4	Хонь	930886	1741631	791868	+85,0



5	Ямаа	965365	1420893	436775	+45,2
6	Бүгд	2293399	3664602	1371203	+59.7

Малын нийт тоо 2004 оныхоос 1,4 сая буюу 59.7 хувиар өссөн байна. Малын тоо толгойн өсөлтөнд хонь, ямаан сүргийн өсөлт хамгийн их байна. Харин тэмээн сүргийн тоо толгой буурчээ.

Цаашид бэлчээрийн газрыг доройтлоос хамгаалахын тулд улсын хэмжээнд малын тоог бэлчээрийн даацад тааруулан барих, эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлэх зорилгоор жижиг, дунд фермерийн аж ахуйг хөгжүүлэх, доройтсон газрыг нөхөн сэргээх бодлого боловсруулах шаардлагатай.



Зураг № 5.1. Малын өсөлт /мян.толгой/

## 5.2. Эрчимжсэн мал аж ахуй

Хөдөө аж ахуйд бэлчээрийн мал аж ахуй түлхүү хөгжиж, газар тариалан дагалдах үүрэг гүйцэтгэсээр өнөөг хүрчээ. Гэвч сүүлийн жилүүдэд нийгэм-эдийн засгийн хөгжилд уул уурхайн салбар илүү давамгайлах шинжтэй болж, түүнийг дагалдан хүнд, хөнгөн үйлдвэрүүд болон бусад салбарууд эрчимтэй хөгжих хандлага бий болж, хүн амын шилжилт хөдөлгөөн, суурьшил, ажиллах хүчний хуваарилалт мэдэгдэхүйц өөрчлөгдлөө.

Байгалийн тэжээлийн нөөцийн хомсдлыг багасгахын тулд бэлчээрийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх, хүний буруутай үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалтын алдаатай бодлогын үр дүнд үүссэн бэлчээрийн талхлагдал, ургамлан нөмрөгийн өөрчлөлт, элсжилт, цөлжилт, байгалийн давтагдашгүй хүчин зүйлийн /байгаль-экологи, уур амьсгалын өөрчлөлт, ус, салхины сөрөг нөлөө, цөлжилт, хортон мэрэгчдийн тархалт гэх мэт/ сөрөг нөлөөллийн сааруулахад чиглэсэн байгаль-экологидоо суурилсан бодлого-төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага бидэнд тулгарч байна. Үүний тулд Эрчимжсэн Мал Аж ахуйг түлхүү хөгжүүлэх шаардлагатай байна.

Энэ нь Газар тариалан, Эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослуулан хөгжүүлэх, хот, төв суурин газрын хүн амын хүнсний хангамжийг нийлүүлэх, импортыг бууруулах зорилготой. Үүнтэй холбоотойгоор сүүлийн жилүүдэд эрчимжсэн фермерийн аж ахуйн тоо нэлээд нэмэгдэж, энэ чиглэлийн бизнес эрхлэгчдийн тоо өссөөр байна.

## Хүснэгт№5.4. Тахианы аж ахуй эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжийн судалгаа

Д/д	Сумын нэр	Аж ахуйн нэгж иргэдийн нэр	Тахианы тоо /толгой /	Хаяг/байршил/
1	Мөрөн	"Улаан залаат" ХХК	1100	"Чимэд"-ийн толгойд
2		Нямаа	8	1-14-5
3		Д.Батэрдэнэ	4	1-29-6
4		Л.Батмөнх	7	1-32-13А
5		Баасансүрэн	100	4-12-18
6		Ж.Болдбаатар	15	6-18-12
7		Б.Жавхлантуяа	210	9-29-3
8		Энхтайван	20	12-1-11
9		Дүүрэнбаяр	1000	Цагаан бургас-ны ам
10		Пүрэвсүрэн	20	12-9-8
ДҮН			<b>2484</b>	

## Хүснэгт№5.5. Хөвсгөл аймгийн үхрийн эрчимжсэн аж ахуйн судалгаа одоогийн байдлаар

№	Сумын нэр	Багын нэр	Аж ахуйн тоо бүгд	Нийт	Сүүний үхэр			Тугал	Нийт үнээний дундаж нас	Сүүний дундаж гарц /л/
					Үнээ	Бух	Бусад			
1	Бүрэнтогтох	Их-уул	1	24	13	1	10	10	5	4
2		Туяа	1	41	30	2	9	26	4.5	5.5
3		Бүрэнхаан	1	64	23	1	40	23	4.5	6
4		Бүрэнхаан	1	60	24	2	34	22	6	5
5		Бүрэнхаан	1	41	15	1	25	14	5	7.1
6		Баянхошуу	1	10	10			10		
7	Мөрөн	1/12/2012	1	28	16	1	11	13	5	5
8		13-р баг	1	43	16	1	26	6	6	5.5
9		6-14-5	1	75	41	1	33	41	4.5	6.5
10		5-7-11	1	63	35	1	27	35	4.5	5
11		УБ	1	42	10		16			
12			1	18	9		3			
13		10-1-14	1	25	13		12			
14		1-20-07	1	21	17		1			
			1	18	13	1	4	9		
			1	22	20	1	1	20		
Нийт			15	555	Нас гүйцсэн		Тугал			

## Хүснэгт №5.6. Сумдын бэлчээрийн нөөц, хэрэгцээ, хүрэлцээ, даац

№	Сум	2002-2009 оны эхний малын дундаж тоо, бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Хонин толгойд шилжүүлбэл	Бэлчээрийн тэжээлийн хэрэгцээ, мянган тонн тэжээлийн нэгж (D)	100 га бэлчээрг оногдох хонин толгой	Бэлчээрийн нөөц, мянган тонн тэжээлийн нэгж (S)	Дутагдаж, илүү гарч буй бэлчээрийн нөөц, мянган тонн тэжээлийн нэгж	Бэлчээрийн даац %	Бэлчээрийн га-гийн ургац, ц/га
1	Алаг-Эрдэнэ	115460	37	8807	19191	35858	51567	270273	88.7	94.1	93.4	1.5	101.6	5.24
2	Арбулаг	155368	195	9050	10905	68227	66991	269883	88.7	82.9	94.9	3.2	103.5	4.70
3	Баянзүрх	128769	267	5951	13765	66597	42189	238374	78.1	78.8	82.8	1.7	102.1	4.41
4	Бүрэнтогтох+Мөрөн	234527	198	9945	13855	102342	108186	365269	119.8	125.5	134.5	10.3	108.3	7.45
5	Галт	209921	63	11392	11620	96764	90082	341360	112.2	125.2	127.0	10.9	109.4	7.51
6	Жаргалант	103696	18	5502	7606	49042	41527	177294	58.2	108.1	65.6	5.3	108.8	6.45
7	Их-Уул	168559	38	8655	12038	60094	87733	281984	92.6	201.8	102.4	6.6	106.8	11.82
8	Рашаант	142709	0	7874	10569	60736	63530	245741	80.7	172.5	91.2	7.7	109.2	10.33
9	Ренчинлхүмбэ	110568	159	9413	24239	41460	35298	298100	97.8	72.0	99.7	-1.6	98.4	3.89
10	Тариалан	129504	23	9204	14818	50401	55058	264843	87.0	124.2	94.0	4.0	104.4	7.11
11	Тосонцэнгэл	166707	28	7352	11055	69885	78386	266683	87.4	152.4	98.9	8.3	109.1	9.12
12	Төмөрбулаг	163316	38	6154	8005	53434	95684	237114	77.7	116.0	88.7	8.0	110.0	7.00
13	Түнэл + Мөрөн 50	175890	87	8722	15980	62427	88675	309781	101.6	112.7	108.1	2.8	102.7	6.35
14	Улаан уул	85260	209	7086	19456	29795	28714	232922	76.4	46.2	76.6	-2.6	96.7	2.45
15	Ханх	30668	7	2787	10236	8289	9349	101308	33.1	37.9	33.4	-1.0	97.1	2.02
16	Цагаан уул	190037	626	9342	9486	96850	73733	302191	99.3	60.8	107.3	4.6	104.5	3.48
17	Цагаан үүр	24483	0	3403	12099	4620	4361	109554	35.9	34.9	36.6	-0.7	98.2	1.88
18	Цэцэрлэг	135066	573	8706	9978	60607	55202	246885	81.3	50.1	89.2	5.3	106.3	2.92
19	Чандмана-Өндөр	44869	0	3828	14720	11068	15193	145132	47.5	71.9	49.0	-0.3	99.3	3.92
20	Шинэ идэр	132600	64	5938	8729	74682	43187	215194	70.6	127.0	79.9	6.7	109.2	7.60
21	Эрдэнэбулган	53009	3	5052	12180	17980	17794	149005	48.9	95.7	51.2	0.5	101.1	5.31
22	Цагааннуур	9785	5	1213	2914	2636	3017	32972	10.8	15.1	11.0	-0.2	98.5	0.82
23	<b>НИЙТ</b>	<b>2710771</b>	<b>2638</b>	<b>155376</b>	<b>273444</b>	<b>1123794</b>	<b>1155456</b>	<b>5101862</b>	<b>1674.3</b>	<b>2105.8</b>	<b>1815.4</b>	<b>81</b>	<b>2285.2</b>	<b>121.78</b>

Хүснэгт №5.7. Сумдын жилд дунджаар үйлдвэрлэсэн мал аж ахуйн бүтээгдэхүүн

№	Сум	Үйлдвэрлэсэн мах, бүгд, амьдын жингээр, тонн	Тэмээний мах	Адууны мах	Үхрийн мах	Хонины мах	Ямааны мах	Үйлдвэрлэсэн махыг 2009 оны зах зээлийн үнээр үнэлбэл, сая төг	Үйлдвэрлэсэн тэмээний ноос, тонн	Адууны хөөвөр, хялгас, тонн	Үхрийн хөөвөр, хялгас, тонн	Хонины ноос, тонн
1	Алаг-Эрдэнэ	2619.0	1.1	359.4	994.5	585.6	678.4	4493.2	0.2	1.8	3.8	51.0
2	Арбулаг	2935.8	5.8	369.3	565.1	1114.2	881.3	4908.0	0.8	1.8	2.2	97.1
3	Баянзүрх	2606.8	8.0	242.9	713.3	1087.6	555.0	4517.8	1.1	1.2	2.8	94.8
4	Бүрэнтогтох+Мөрөн	4224.3	5.9	405.9	717.9	1671.4	1423.2	7073.4	0.8	2.0	2.8	145.7
5	Галт	3834.3	1.9	464.9	602.1	1580.3	1185.1	6386.5	0.3	2.3	2.3	137.7
6	Жаргалант	1966.5	0.5	224.5	394.2	800.9	546.3	3319.5	0.1	1.1	1.5	69.8
7	Их-Уул	3113.8	1.1	353.2	623.8	981.4	1154.2	5170.7	0.2	1.7	2.4	85.5
8	Рашаант	2696.7	0.0	321.3	547.7	991.9	835.8	4520.0	0.0	1.6	2.1	86.5
9	Ренчинлхүмбэ	2786.4	4.7	384.1	1256.1	677.1	464.4	4894.1	0.7	1.9	4.8	59.0
10	Тариалан	2691.6	0.7	375.6	767.9	823.1	724.3	4555.4	0.1	1.8	3.0	71.7
11	Тосонцэнгэл	3046	0.8	300.0	572.9	1141.3	1031.2	5107.9	0.1	1.5	2.2	99.5
12	Төмөрбулаг	2798.5	1.1	251.2	414.8	872.7	1258.8	4591.3	0.2	1.2	1.6	76.1
13	Түнэл + Мөрөн 50	3372.7	2.6	355.9	828.1	1019.5	1166.5	5671.3	0.4	1.7	3.2	88.9
14	Улаан уул	2168.0	6.2	289.2	1008.2	486.6	377.7	3813.4	0.9	1.4	3.9	42.4
15	Ханх	902.7	0.2	113.7	530.4	135.4	123.0	1625.7	0.0	0.6	2.0	11.8
16	Цагаан уул	3443.2	18.7	381.3	491.6	1581.7	970.0	5765.1	2.6	1.9	1.9	137.9
17	Цагаан үүр	898.7	0.0	138.9	626.9	75.5	57.4	1642.4	0.0	0.7	2.4	6.6
18	Цэцэрлэг	2605.5	17.1	355.3	517.1	989.8	726.2	4352.0	2.4	1.7	2.0	86.3
19	Чандмана-Өндөр	1302.7	0.0	156.2	765.9	180.7	199.9	2344.4	0.0	0.8	3.0	15.8
20	Шинэ идэр	2484.4	1.9	242.3	452.3	1219.7	568.1	4245.4	0.3	1.2	1.7	106.3
21	Эрдэнэбулган	1365.2	0.1	206.2	631.2	293.6	234.1	2389.5	0.0	1.0	2.4	25.6
22	Цагааннуур	283.4	0.2	49.5	151.0	43.1	39.7	498.6	0.0	0.2	0.6	3.8
23	<b>НИЙТ</b>	<b>54146.2</b>	<b>78.6</b>	<b>6340.8</b>	<b>14173</b>	<b>18353.1</b>	<b>15200.6</b>	<b>91885.6</b>	<b>11.2</b>	<b>31.1</b>	<b>54.6</b>	<b>1599.8</b>

## Хүснэгт № 5.8 Сумдын жилд дунджаар үйлдвэрлэсэн мал аж ахуйн бүтээгдэхүүн /ноолуур, сүү, шир/

№	Сум	Ноолуур тонн	Үйлдвэрлэсэн ноос, ноолуурыг 2009оны зах зээлийн үнээр үнэлбэл, сая төг	Үйлдвэрлэсэн сүү, мян...литр	Үүнээс: ингэний сүү	Гүүний айраг	Үнээний сүү	Хонины сүү	Ямааны сүү	Үйлдвэрлэсэн сүүг 2009онб зах зээлийн үнээр үнэлбэл, сая төг	Үйлдвэрлэсэн тэмээний шир, ш	Адууны шир, ш
1	Алаг-Эрдэнэ	20.0	758.7	2177.7	0.1	80.2	1793.0	80.5	224.0	2055.9	2	1165
2	Арбулаг	25.9	1014.6	1545.8	0.5	82.4	1018.8	153.1	290.9	1368.5	13	1197
3	Баянзүрх	16.3	677.8	1673.6	0.7	54.2	1286.0	149.4	183.2	1540.9	18	787
4	Бүрэнтогтох+Мөрөн50	41.9	1622.4	2085.0	0.6	90.5	1294.4	229.7	469.9	1805.5	14	1315
5	Галт	34.9	1366.1	1797.8	0.2	103.7	1085.6	217.1	391.2	1554.6	4	1507
6	Жаргалант	16.1	636.6	1051.2	0.1	50.1	710.6	110.1	180.4	935.0	1	728
7	Их-Уул	34.0	1280.9	1719.4	0.1	78.8	1124.7	134.9	381.0	1513.1	3	1145
8	Рашаант	24.6	952.5	1471.3	0.0	71.7	987.5	136.3	275.9	1306.5	0	1041
9	Ренчинлхүмбэ	13.7	550.6	2597.1	0.4	85.7	2264.6	93.0	153.3	2498.7	11	1245
10	Тариалан	21.3	825.2	1820.5	0.1	83.8	1384.4	113.1	239.1	1679.6	2	1217
11	Тосонцэнгэл	30.3	1167.3	1597.1	0.1	66.9	1032.8	156.8	340.4	1398.2	2	972
12	Төмөрбулаг	37.0	1377.1	1339.5	0.1	56.0	747.9	119.9	415.6	1125.4	3	814
13	Түнэл + Мөрөн 50	34.3	1299.2	2097.8	0.2	79.4	1492.9	140.1	385.1	1887.8	6	1153
14	Улаан уул	11.1	443.7	2074.3	0.6	64.5	1817.7	66.9	124.7	1998.0	14	937
15	Ханх	3.6	142.5	1040.9	0.0	25.4	956.3	18.6	40.6	1017.2	0	369
16	Цагаан уул	28.5	1155.4	1510.6	1.8	85.1	886.2	217.3	320.2	1296.5	43	1235
17	Цагаан үүр	1.7	70.3	1190.6	0.0	31.0	1130.3	10.4	18.9	1178.9	0	450
18	Цэцэрлэг	21.4	851.7	1388.8	1.6	79.3	932.2	136.0	239.7	1239.3	39	1151
19	Чандмана-Өндөр	5.9	227.1	1506.5	0.0	34.9	1380.8	24.8	66.0	1470.2	0	506
20	Шинэ идэр	16.7	697.0	1224.9	0.2	54.1	815.5	167.6	187.6	1082.9	4	785
21	Эрдэнэбулган	6.9	271.8	1301.6	0.0	46.0	1138.0	40.3	77.3	1254.5	0	668
22	Цагааннуур	1.2	46.0	302.3	0.0	11.0	272.2	5.9	13.1	294.7	0	16038
<b>23</b>	<b>НИЙТ</b>	<b>447.3</b>	<b>17434.5</b>	<b>34514.3</b>	<b>7.4</b>	<b>1414.7</b>	<b>25552.4</b>	<b>2521.8</b>	<b>5018.1</b>	<b>31501.9</b>	<b>179</b>	<b>36425</b>

## Хүснэгт № 5.9 Сумдын жилд дунджаар үйлдвэрлэсэн мал аж ахуйн бүтээгдэхүүн, /шир, арьс/

№	Сум	Үхрийн шир, ш	Хонины арьс, мян.ш	Ямааны арьс, мян.ш	Үйлдвэрлэсэн арьс ширийг 2009оны зах зээлийн үнээр үнэлбэл, сая төг	Мал аж ахуйн нийт бүтээгдэхүүн, 2009оны үнээр сая төг	Нэг хонины толгойгоос үйлдвэрлэсэн мал аж ахуйн нийт бүтээгдэхүүн, төг	Нэг га бэлчээрээс үйлдвэрлэсэн мал аж ахуйн нийт бүтээгдэхүүн
1	Алаг-Эрдэнэ	3810	13.2	17.9	225.6	7533.5	27874	26221
2	Арбулаг	2165	25.1	23.3	2743	7565.3	28032	23225
3	Баянзүрх	2733	24.5	14.7	244.1	6980.6	29284	23086
4	Бүрэнтогтох+Мөрөн50	2750	37.7	37.6	407.3	10908.5	29864	37478
5	Галт	2307	35.7	31.3	364.8	9672.0	28334	35481
6	Жаргалант	1510	18.1	14.4	185.6	5076.7	28634	30950
7	Их-Уул	2390	22.1	30.5	292.0	8256.7	29281	59084
8	Рашаант	2098	22.4	22.1	252.6	7031.6	28614	49360
9	Ренчинлхүмбэ	4812	15.3	12.3	234.3	8177.7	27433	19758
10	Тариалан	2942	18.6	19.1	240.4	7300.7	27566	34231
11	Тосонцэнгэл	2195	25.8	27.2	291.4	7964.9	29866	45513
12	Төмөрбулаг	1589	19.7	33.3	271.4	7365.3	31062	36036
13	Түнэл + Мөрөн 50	3172	23.0	30.8	313.4	9171.7	29607	33367
14	Улаан уул	3862	11.0	10.0	181.6	6436.7	27635	12766
15	Ханх	2032	3.1	3.2	72.6	2858.0	28211	10706
16	Цагаан уул	1883	35.7	25.6	331.4	8548.4	28288	17186
17	Цагаан үүр	2402	1.7	1.5	67.1	2958.7	27007	9422
18	Цэцэрлэг	1981	22.3	19.2	239.9	6682.9	27069	13549
19	Чандмана-Өндөр	2934	4.1	5.3	105.3	4147.0	28574	20542
20	Шинэ идэр	1733	27.5	15.0	240.2	6265.5	29116	36970
21	Эрдэнэбулган	2418	6.6	6.2	112.9	4028.8	27038	25882
22	Цагааннуур	578	1.0	1.0	22.2	861.5	26128	3951
<b>23</b>	<b>НИЙТ</b>	<b>54296</b>	<b>414.2</b>	<b>401.5</b>	<b>7439.1</b>	<b>145792.7</b>	<b>624517</b>	<b>604764</b>

### **5.3. Бэлчээр, бэлчээр ашиглалтын өнөөгийн байдал, нөөцөд гарсан өөрчлөлт**

#### **5.3.1. Бэлчээрийн газрын ашиглалтын байдал**

Хөвсгөл аймгийн нийт нутгийн 37,5 хувийг хөдөө аж ахуйн эдэлбэр газар эзэлнэ. Хөвсгөл аймаг нийт мал сүргийнхээ тоогоор улсдаа тэргүүлж тус аймгийн байгаль цаг уурын нөхцөлд тохирсон нутгийн шилмэл омгийн дархад омгийн хонь, хогорын улаан монгол, эрчимын хар ямаа, тэсийн голын адуу зэргийг үржүүлэн ашиглаж байна. Бэлчээрийн хэв шинжээр өндөр уул, уулын ойт хээрийн бэлчээрт багтдаг нь уламжлалт, хөрсний бүтцийн хувьд эмзэг, нилээд онцлогтой. 3.5-4.0 сая хонь бэлчээх багтаамжтай, бэлчээрийн даацыг 5 жилийн давтамжтай тооцож үзэхэд 1 хонин толгойд ногдох бэлчээр байнга буурч 0.9 га бэлчээр оногдож байгаа нь мал хэт ихээр олноор өсөж бэлчээрийн даац багассаныг харуулж байна.

#### **5.3.2. Бэлчээрийн талхлагдал ба талхлагдлын зэрэглэл**

Мал аж ахуйн үйлдвэрлэл олигтой эрчимжээгүй байгаа одоогийн нөхцөлд байгалийн бэлчээрийн талбай багассан нь мал болон зэрлэг ан амьтад тэжээлээр хомсдох, амьдрах нөхцөл, орчин хязгаарлагдах зэрэг сөрөг үүсэхэд нөлөөлж байна.

Үүнтэй зэрэгцээд, зориулалтаараа үлдсэн бэлчээрт байгалийн болон хүний ямар үйл ажиллагаа сөрөг нөлөөлж байна вэ гэдгийг зөв олж харан, түүнийг засч, залруулах арга хэмжээг зөв төлөвлөж хэрэгжүүлэх учиртай. Иймээс, бэлчээрийн хомсдлыг бий болгож байгаа байгалийн болон хүний хүчин зүйлүүдийг харгалзан үзэх нь зүйтэй юм.

Бэлчээрийн талхлагдал нь хөрсний бүтэц, шимт чанарыг доройтуулж, цөлжилт үүсгэн, байгалийн унаган төрхийг алдагдуулахын зэрэгцээ экологийн онц ноцтой өөрчлөлт рүү чиглүүлэгч анхдагч хүчин зүйл болохын хувьд нийгэм-эдийн засагт асар их хор хохирол дагуулдаг онцлогтой үйл явц юм.

Малаа дагаж амьдардаг байсан монгол малчдын амьдралд суурьшил, зах зээлийн харилцааны нөлөөгөөр малаа дагуулж амьдрах хэв маяг голлох болсноор мал маллагааны уламжлалт арга ухаан гээгдэж, бий болсон шинэ нөхцөлд таарах бэлчээрийн менежментийн оновчтой арга барил үгүйлэгдэж, бэлчээрийн доройтол эрчимжихэд хүргэж байна. Бэлчээр, хадлангийн газрыг малчдын бүлэг, хоршоонд эзэмшүүлэх нь газарт өөриймсөг хандах, сайжруулах, хашиж хуваарьтай ашиглах зорилгоор хөрөнгө оруулалт хийх сонирхол төрүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Нөгөө талаас:

- Уламжлалт 5 төрлийн малын хоорондын зохистой харьцаа алдагдсан
- Бэлчээр нийтийн эзэмшилд байгаа
- Бэлчээр ашиглах, эзэмших эрх зүйн зохицуулалтгүй
- Нүүдлийн тоо цөөрч, нүүх зай богиносон зөвхөн зун- намар, өвөл-хавар гэсэн нутагтай болсон
- Бэлчээрийн даацыг зохицуулах талаар малчид ч, төрийн захиргааны байгууллагууд нь ямар нэг арга хэмжээ авахгүй байгаа
- Бэлчээр талхласан, доройтуулсны төлөө хэн ч хариуцлага хүлээдэггүй, хүлээлгэх механизм нь тогтоогүй


- Нэгэнт доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх ажил хийхгүй байгаа
- Бэлчээрийн усан хангамж дутагдалтай
- Хотжилт, үйлдвэржит (уул уурхай) эрчимтэй явагдаж байгаа зэрэг объектив, субъектив олон хүчин зүйлтэй холбоотой.

Бэлчээрийн талхлагдлыг харилцан хамааралтай хоёр бүлэг хүчин зүйлд хамааруулан авч үзэх үндэслэлтэй. Үүнд:

**Нэгдүгээрт:** Байгалийн давтагдашгүй хүчин зүйлийн нөлөө буюу дэлхийн уур амьсгалын дулааралт, өөрчлөлт

**Хоёрдугаарт:** Хүний буруутай үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл зэрэг болно.

Энэ хоёр бүлэг хүчин зүйл нь өөр хоорондоо харилцан хамааралтай боловч байгалийн бэлчээрийн хувьд, хоёр дахь хүчин зүйл нь эхний хүчин зүйлийнхээ анхдагч нөхцлийг нь бүрдүүлж өгдгөөрөө онцлог юм. Үүний нэг хэлбэр нь байгалийн бэлчээрийн талхлагдал бөгөөд мал аж ахуйн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, түүний үр шимийг хүртэж байгаа хүний хүчин зүйлээс үүдэлтэй билээ.



Зураг № 5.3. Бэлчээрийн талхлагдлын зураг



## Хүснэгт №5.10. Сумдын бэлчээрийн талхлагдлын байдал

№	Сум	Бэлчээрийн, талбай га	Үүнээс их талхлагдсан	Дунд зэрэг талхлагдсан	Бага зэрэг талхлагдсан	Талхагдаагүй	Их талхлагдсан %	Дунд зэрэг талхлагдсан %	Бага зэрэг талхлагдсан %	Талхагдаагүй %	Худаг усны хүрэлцээгүйгээс ашигдалгүй, га	Алслагдсан га	Хад, асга, ян, сарьдаг, га	Бусад шалтгаанаар бэлчээр ашиглах боломжгүй, га
1	Алаг-Эрдэнэ	287313	407	44988	27237	214681	0.1	15.7	9.5	74.7		482		
2	Арбулаг	325745	0	0	84659	241086	0.0	0.0	26.0	74.0			137	
3	Баянзүрх	302379	2394	62764	26063	211158	0.8	20.8	8.6	69.8			3778	
4	Бүрэнтогтох+Мөрөн	291066			93098	197968	0.0	0.0	32.0	68.0				
5	Галт	272596			42267	230329	0.0	0.0	15.5	84.5				
6	Жаргалант	164032			17381	146651	0.0	0.0	10.6	89.4				
7	Их-Уул	139744	25462	35567	3051	75664	18.2	25.5	2.2	54.1				
8	Рашаант	142456			16411	126045	0.0	0.0	11.5	88.5				
9	Ренчинлхүмбэ	413890	0	46435	37148	330307	0.0	11.2	9.0	79.8			141721	8260
10	Тариалан	213275			39597	173677	0.0	0.0	18.6	81.4				
11	Тосонцэнгэл	175002	24647	30855	11100	108400	14.1	17.6	6.3	61.9				
12	Төмөрбулаг	204389			37154	167235	0.0	0.0	18.2	81.8				
13	Түнэл + Мөрөн 50	274870	29836	53498	16667	174869	10.9	19.5	6.1	63.6				
14	Улаан уул	504200	805	677	26608	476109	0.2	0.1	5.3	94.4			75388	603
15	Ханх	266962		12310	13541	241111	0.0	4.6	5.1	90.3		29108		
16	Цагаан уул	497405	104021	77635	18166	297584	20.9	15.6	3.7	59.8				
17	Цагаан үүр	314013		15461	17007	281545	0.0	4.9	5.4	89.7		134657		
18	Цэцэрлэг	493258	41563	146734	18830	286132	8.4	29.7	3.8	58.0		27073		
19	Чандмань-Өндөр	201876		9767	10744	181365	0.0	4.8	5.3	89.8				
20	Шинэ идэр	169478			35932	133546	0.0	0.0	21.2	78.8				
21	Эрдэнэбулган	155660		13338	13338	128984	0.0	8.6	8.6	82.9		10542		
22	Цагааннуур	218051	3590	1761	25886	186815	1.6	0.8	11.9	85.7			79934	
23	<b>НИЙТ</b>	<b>6027660</b>	<b>232725</b>	<b>551790</b>	<b>631885</b>	<b>4611261</b>	<b>75.2</b>	<b>179.4</b>	<b>244.4</b>	<b>1700.9</b>	<b>0</b>	<b>201862</b>	<b>300958</b>	<b>8863</b>

## Хүснэгт № 5.11. Бэлчээрийн талхлагдлын зэрэглэл /сумдаар/

Аймаг	10-20%	20-30%	30-40%	≥40%
Хөвсгөл	Галт	Алаг-Эрдэнэ	Баянзүрх	Их-Уул
	Жаргалант	Арбулаг	Бүрэнтогтох-М50	Цагаан-Уул
	Рашаант	Рэнчинлхүмбэ	Тосонцэнгэл	Цэцэрлэг
	Төмөрбулаг	Тариалан	Түнэл-М50	-
	Цагаан-үүр	Шинэ-идэр	-	-
	Чандмань -Өндөр	-	-	-
	Эрдэнэбулган	-	-	-
	Цагааннуур	-	-	-

Бэлчээрийн газрын талхлагдал нь хүн ам шигүү суурьшилтай хот суурин болон тал хээрийн бүс, хангайн болон баруун бүсийн голын хөндий, татам нуга газарт илүү эрчимтэй явагдаж байна

Бэлчээрийг талхагдалд хүргэж байгаа хүчин зүйл нь хот суурин газрын орчимд малын бөөгнөрөл ихэссэн, автогений болон техногений нөлөөлөл их, ойт хээрийн бүсэд улирлын бэлчээрийн хувиар алдагдаж нүүж нутаг сэлгэх, отор хийхээ больсон, өндөр уулын бүсэд царцааны гаралт ихэссэн, мал өссөн, тал хээр, говийн бүсэд огтоно, хулганы хөнөөл, уст цэг тойрсон малын хэт төвлөрөл бий болсноос голлон шалтгаалж байна.

### 5.3.3. Бэлчээрийн хортон мэрэгч устгах арга хэмжээ

Аймгийн хэмжээнд 2013 онд 5 суманд үлийн цагаан оготно болон бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх зорилгоор 40000 га талбайд 57,68 сая төгрөгийн устгалын ажил хийсэн байна. Тухайн сумдад бэлчээрийн хортон мэрэгчид устгах ажлыг багийн засаг дарга, сумын хөдөө аж ахуйн мэргэжилтэн, сумын газрын даамал нарт хамтран малчдын хүчээр хийсэн бөгөөд өлийн цагаан оготны нүхэнд ус цутгах, шувуу суух шон босгох, оготны хөөг ухах, утах зэрэг ажил хийснээс гадна бэлчээрийн хортон мэрэгчдийг биологийн аргаар хор цацаж устгах зэрэг ажилууд хийгдсэн байна.

### 5.4. Бэлчээрийн усан хангамж

Хөвсгөл аймгийн хэмжээнд 2012 онд иргэдийг ундны усаар хангах усгүйн улмаас ашиглагдахгүй байгаа бэлчээрийг усжуулж ашиглахаар нийтдээ 15 сумаанд 24 худгийг тендер зарлаж шинээр барьсан байна. Тус худгийн ажлыг Хөвсгөл аймгийн “Хөвсгөл геологи” ХХК, Идэр чандмань ХХК нар улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн байна.

#### Хүснэгт №5.12. Шинээр баригдсан худаг

№	Сумын нэр	Байршил	Шинээр баригдсан худаг	
			Худгийн тоо /инженерийн хийцтэй/	Санхүүжилтийн эх үүсвэр
1	Арбулаг	2-р баг Баян үзүүрийн ар	1	Улсын төсвийн хөрөнгөөр
2	Алаг-эрдэнэ	2-р баг улаан толгой	1	Улсын төсвийн хөрөнгөөр
3	Бүрэнтогтох	Туяа баг дааган толгой, бүрэн хаан баг Хөх хөтөлийн өвөр	2	Улсын төсвийн хөрөнгөөр
4	Галт	Рашаант баг Хөшөөт, Зүрх баг хайлантай	1	Улсын төсвийн хөрөнгө гишүүдийн багцаас
5	Мөрөн сум	10-р баг талын хонхор	4	Улсын төсөв, гишүүдийн багц, чехийн төслөөр
6	Их-уул	Асгат баг, олон жалга	1	Улсын төсөв
7	Рашаант	5-р баг их-ац, сумын төв	2	Улсын төсөв гишүүдийн багц
8	Тариалан	Ар тархи баг Тасархайн ам	1	Улсын төсөв

9	Тосонцэнгэл	4-р баг Олон булаг	2	Улсын төсөв гишүүдийн багц
10	Төмөрбулаг	Жаргалант баг Хойт цагааны гол	1	Улсын төсөв гишүүдийн багц
11	Түнэл	2-р баг нарийн хөндий	1	Улсын төсвийн хөрөнгөөр
12	Цагаан-үүр	Сумын төвд Булган хороололд	1	Улсын төсөв гишүүдийн багц
13	Чандмань-өндөр	2-р баг Цахиурт	1	Улсын төсвийн хөрөнгө
14	Эрдэнэбулган	4-р баг Нарангийн энгэр	1	Улсын төсвийн хөрөнгө
15	Шинэ-Идэр	3-р баг Хошой цэцэрлэг, Холбоогийн дөрөлж, 2-р баг Сүүлт, нум толгой	4	Улсын төсвийн хөрөнгөөр
<b>Нийт дүн</b>			<b>24</b>	

### 5.5. Хадлангийн газрын ашиглалт, нөхцлийн өнөөгийн байдал

2013 оны газрын нэгдмэл сангийн тайлангаар 48218 га хадлангийн газартай байгаа нь сүүлийн 10 жилд 2686.4 мян га-аар өссөн байна. Хөвсгөл аймгийн хөдөө аж ахуйн газар дахь хадлангийн нийт хэмжээ 48218 га байна. Хадлангийн голлох нутаг бүхий сум Рашаант, Тариалан, Цагааннуур сум юм. Ус чийг хэт ихтэй газар байрласан хадлангийн газруудын ургамлын бүтэц төдий л сайн биш суан, шагшуурга, шимт тэжээлээр тааруу идэмж муутай ургамал голлодог. Мөн хадлангийн талбайн ашиглалт жигд сайн биш, услахаас өөр тордолт сайжруулалтын арга хэмжээ авдаггүй, хадлангийн газар багатай сумууд талбайгаа жил өнжөөхгүй хаддаг, хадах хугацааг жил жилд өөрчилдөггүй өөрөөр хэлбэл хадланг ургамлын вегетацын өөр өөр хөгжлийн шатанд хадах замаар олон наст ургамалд үр унагах бололцоо олгодоггүй зэрэг нийтлэг дутагдал байна.

2013 онд аймгийн дүнгээр 158344.5 тн өвс, 220.7 тн гар тэжээл бэлтгэжээ. Өвс бэлтгэх албан даалгавараас 8.5 хувь буюу 14771.5 тн, гар тэжээлийн 39.7 хувь буюу 145.3 тн, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7672.7 тн-оор тус тус бага өвс бэлтгэжээ.

#### Хүснэгт №5.13. Хадлангийн талбай, бэлтгэсэн өвсний хэмжээ

№	Сумдын нэрс	2012	Өвс			2012 оноос зөрүү	Гар тэжээл		
			Даалгавар	Гүйцэтгэл	Хувь		Даалгавар	Гүйцэтгэл	Хувь
1	Алаг-Эрдэнэ	4700.0	6381.0	4111.2	64.4	-588.8	20.0	12.9	64.5
2	Арбулаг	7317.0	9732.0	1400.0	14.4	-5917.0	20.0		0.0
3	Баянзүрх	4150.0	8722.0	793.0	9.1	-3357.0	20.0	3.3	16.5
4	Бүрэнтогтох	4987.0	10343.0	6252.6	60.5	1265.6	20.0	12.1	60.5
5	Галт	5102.0	10927.0	2294.9	21.0	-2807.1	20.0	10.0	50.0
6	Жаргалант	4275.2	7818.0	6304.0	80.6	2028.8	20.0	13.4	67.0
7	Их-Уул	7180.0	10337.0	8133.0	78.7	953.0	20.0		0.0
8	Рашаант	5836.0	7861.0	5168.4	65.7	-667.6	15.0		0.0
9	Рэнчинлхүмбэ	5981.0	8381.0	4740.0	56.6	-1241.0	20.0	19.9	99.5
10	Тариалан	22767.0	7366.0	25189.0	342.0	2422.0	10.0	32.2	322.0
11	Тосонцэнгэл	7585.0	10297.0	5660.0	55.0	-1925.0	20.0	20.0	100.0
12	Төмөрбулаг	6261.0	9594.0	8860.9	92.4	2599.9	15.0		0.0
13	Түнэл	5110.0	7536.0	8060.0	107.0	2950.0	15.0		0.0
14	Улаан-Уул	2043.0	6867.0	1116.0	16.3	-927.0	15.0	8.4	56.0
15	Ханх	1549.0	3259.0	1100.0	33.8	-449.0	4.0	0.5	12.5
16	Хатгал	1680.0	2106.0	739.0	35.1	-941.0	4.0		0.0
17	Цагааннуур	216.0	896.0	898.5	100.3	682.5	3.0		0.0
18	Цагаан-Уул	8809.0	11451.0	13406.0	117.1	4597.0	20.0	50.0	250.0
19	Цагаан-Үүр	28750.0	2689.0	24000.0	892.5	-4750.0	10.0	10.0	100.0
20	Цэцэрлэг	6000.0	8067.0	8000.0	99.2	2000.0	15.0	21.0	140.0
21	Чандмань-Өндөр	5000.0	3934.0	4100.0	104.2	-900.0	15.0		0.0
22	Шинэ-Идэр	5454.0	7261.0	6000.0	82.6	546.0	15.0		0.0
23	Эрдэнэбулган	9500.0	3802.0	9712.9	255.5	212.9	10.0		0.0
24	Мөрөн	5765.0	7489.0	2305.1	30.8	-3459.9	20.0	7.0	35.0
<b>ДҮН</b>		<b>166017.2</b>	<b>173116.0</b>	<b>158344.5</b>	<b>91.5</b>	<b>-7672.7</b>	<b>366.0</b>	<b>220.7</b>	<b>60.3</b>

Хадлангийн талбайг хамгаалах, сайжруулах арга хэмжээ

1. Үлийн цагаан оготоно, бусад мэрэгчид, царцаатай тэмцэх ажлыг тусгах.
2. Жил бүрийн 5 дугаар сарын 15–наас эхлэн хадлан авч дуустал хадлангийн талбайг малын хөлөөс хамгаалах ажлыг зохион байгуулж, хяналт тавихаар төлөвлөсөн байна.


**5.6. Тариалангийн газрын ашиглалт, төлөв байдал**

Хөвсгөл аймаг 2013 оны байдлаар 33266.6 га тариалангийн газартай гэж бүртгэгдсэнээс үүний ихэнх хэсэг нь Тариалан, Эрдэнэбулган, Рашаант, Бүрэнтогтох, Түнэл зэрэг суманд газар тариалан эрхэлдэг.

Цэцэрлэг, Цагаан-уул, Шинэ-Идэр, Бүрэнтогтох, Жаргалант, Галт, Төмөрбулаг сумдын нутаг үлийн цагаан оготны тархалттай. Ренчинлхүмбэ, Их-Уул, Төмөрбулаг, Бүрэнтогтох, Цэцэрлэг, Рашаант суманд элсний нүүдэл ажиглагдаж байна.

Хүснэгт №5.14. Аймгийн тариалангийн газрын ашиглалтын байдал (га)

Үзүүлэлт		Хөвсгөл
Тариалангийн газар, бүгд /га/		33266.68
1	Тариалсан талбай	19304.42
Үүнд	Үр тариа	17707
	Төмс, хүнсний ногоо	756.72
	Тэжээлийн ургамал	709
	Таримал ургамал, жимс жимсгэнэ	131.7
	Усалгаатай тариалан	-
2	Уриншилсан газар	2503
3	Өнжөөсөн талбай	2053.26
4	Атаршсан газар	10685.9



Зураг № 5.4. Тариалангийн газар ашиглалтын зураг /Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнөөс/

Тариалангийн талбай салхины эвдрэлд орох, үржил шим нь буурах, мэрэгчид, хортон шавжид нэрвэгдэх зэргээр нийт хөрсний ялмагийн агууламж буурч, ургамалд ашигтай тэжээлийн химийн элементүүд багасаж байна.

Тариалангийн газрын хохирол доройтлыг салхи, усны элэгдэл эвдрэлд орсон, үржил шимийн бууралттай, хортон шавжид нэрвэгдсэн, хөрс бохирдсон, онц аюултай хог ургамалд нэрвэгдсэн гэсэн тодорхой үзүүлэлтээр, өөр төрлийн хохирлыг бусад гэсэн ангилалд хамааруулан гаргахад тариалангийн 1561.5 га талбай хохиролд өртсөн байна. Үүнээс 48 орчим хувь буюу 760 га талбай үржил шимийн бууралттай, 51.2 хувь буюу 800 га талбай мэрэгчид, хортон шавьжинд идэгдсэн нь хамгийн их талбайг хамарч байна. 1.5 га тариан талбай салхины нөлөөгөөр хохиролд өртсөн байна.

Хүснэгт №5.15.Тариалангийн газрын төлөв байдал

Аймаг	Судлагдсан газрын Хэмжээ(га)	Түүнээс		Эвдрэлийн зэрэг		
		Эвдрээгүй тариан талбай	Эвдэрсэн тариан талбай	Сул	Дунд	Хүчтэй
Хөвсгөл	46852,7	27923,2	18929,5	3921,0	5749,5	9259,0

### 5.5.2. Тариалалт, ургац хураалтын байдал

Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэхгүйгээр найдвартай өндөр ургац авч эдийн засгийн хувьд үр ашигтай ажиллах боломжгүй юм. Хөвсгөл аймгийн хувьд газар тариаланг эрчимжүүлэх гол эх сурвалж нь байгаль цаг уурынхаа нөхцөлд нийцүүлэн усалгаатай газар тариалан эрхлэх явдал юм.

Хүснэгт №5.16. Тариалалт хийгдсэн талбайн хэмжээ


№	Сумдын нэрс	Үр тариа			Улаан буудай			Төмс			Хүнсний ногоо		
		2012	2013	Зөрүү	2012	2013	Зөрүү	2012	2013	Зөрүү	2012	2013	Зөрүү
1	Алаг-Эрдэнэ			0.0			0.0	0.1	5	4.9	0.008	1	1.0
2	Арбулаг			0.0			0.0	6	2	-4.0		1	1.0
3	Баянзүрх			0.0			0.0	1.2	3	1.8	0.3	1.5	1.2
4	Бүрэнтогтох			0.0			0.0	10.1	11	0.9	6	6.3	0.3
5	Галт			0.0			0.0	7.0	3.0	-4.0	0.8	1.5	0.7
6	Жаргалант			0.0			0.0	9.9	10.2	0.3	2.6	2.8	0.2
7	Их-Уул			0.0			0.0	18.9	17.9	-1.0	4.9	3.0	-1.9
8	Рашаант	1860.0	1703.0	-157.0	1790.0	1673.0	-117.0	10.5	4.5	-6.0	2.5	1.2	-1.3
9	Рэнчинлхүмбэ			0.0			0.0	5.0	3.5	-1.5	1.5	2.0	0.5
10	Тариалан	10723.0	10650.0	-73.0	10685.0	10565.0	-120.0	35.0	38.1	3.1	45.5	47.2	1.7
11	Тосонцэнгэл			0.0			0.0	140.0	56.0	-84.0	17.2	19.0	1.8
12	Төмөрбулаг			0.0			0.0	3.0	8.1	5.1	1.7	0.9	-0.8
13	Түнэл			0.0			0.0	15.0	10.0	-5.0	8.0	8.7	0.7
14	Улаан-Уул			0.0			0.0	2.0	2.0	0.0	0.5	0.8	0.3
15	Ханх			0.0			0.0		1.2	1.2		0.3	0.3
16	Хатгал			0.0			0.0	0.5		-0.5	0.5		-0.5
17	Цагааннуур			0.0			0.0	6.5	1.2	-5.3	3.5	0.2	-3.3
18	Цагаан-Уул			0.0			0.0	17.0	1.0	-16.0	0.5		-0.5
19	Цагаан-Үүр			0.0			0.0	11.5	6.5	-5.0	4.0	2.6	-1.4
20	Цэцэрлэг			0.0			0.0	2.0	6.0	4.0	1.0		-1.0
21	Чандмань-Өндөр			0.0			0.0	0.1	10.5	10.4	0.03	4.7	4.7
22	Шинэ-Идэр			0.0			0.0	81.0	1.0	-80.0	54.0	1.0	-53.0
23	Эрдэнэбулган	2291.0	2577.0	286.0	2256.0	2567.0	311.0	12.1	12.4	0.3	5.9	7.3	1.4
24	Мөрөн			0.0			0.0	1.5	58.6	57.1	0.2	50.5	50.3
	<b>ДҮН</b>	<b>14874.0</b>	<b>14930.0</b>	56.0	<b>14731.0</b>	<b>14805.0</b>	74.0	<b>395.9</b>	<b>272.7</b>	-123.2	<b>161.1</b>	<b>163.5</b>	2.4

2013 онд аймгийн дүнгээр үр тариа 24193.9 тн, төмс 2747.7 тн, хүнсний ногоо 1232.3 тн-ийг хураан авав. Өнгөрсөн оны мөн үеэс үр тариа 6135.9 тн-оор их, төмс 523.0 тн, хүнсний ногоо 129.6 тус тус бага ургац хураажээ.


Хүснэгт №5.17. Ургац хураалт

№	Сумдын нэрс	Үр тариа			Улаан буудай			Төмс			Хүнсний ногоо		
		2012	2013	Зөрүү	2012	2013	Зөрүү +, -	2012	2013	Зөрүү	2012	2013	Зөрүү
1	Алаг-Эрдэнэ							1.5	4.2	2.7	0.001	0.5	0.5
2	Арбулаг							12	1.5	-10.5		2.5	2.5
3	Баянзурх							1.6	2.3	0.7	0.7	1	0.3
4	Бүрэнтогтох							70.1	75.3	5.2	43.9	45.4	1.5
5	Галт							58.6	35.0	-23.6	4.4	3.8	-0.6
6	Жаргалант							69.7	71.5	1.8	4.1	4.5	0.4
7	Их-Уул							170.0	208.0	38.0	81.7	44.5	-37.2
8	Рашаант	3142.0	3322.0	180.0	3068.0	3290.0	222.0	89.0	78.0	-11.0	33.6	18.0	-15.6
9	Рэнчинлхүмбэ							3.5	2.6	-0.9	0.5	0.6	0.1
10	Тариалан	13530.0	17927.9	4397.9	13501.5	17821.1	4319.6	337.4	364.3	26.9	473.2	458.6	-14.6
11	Тосонцэнгэл							1440.0	650.0	-790.0	96.0	146.0	50.0
12	Төмөрбулаг							7.6	40.0	32.4	39.5	5.8	-33.7
13	Түнэл							42.0	38.0	-4.0	14.8	22.5	7.7
14	Улаан-Уул							6.0	5.9	-0.1	0.8	0.7	-0.1
15	Ханх								1.2	1.2		0.1	0.1
16	Хатгал							0.6		-0.6	0.4		-0.4
17	Цагааннуур							0.7	0.3	-0.4	0.06	0.21	0.2
18	Цагаан-Уул							1.0	3.5	2.5	0.5		-0.5
19	Цагаан-Үүр							35.0	35.0	0.0	16.4	16.4	0.0
20	Цэцэрлэг							78.0	21.0	-57.0	0.85		-0.9
21	Чандмань-Өндөр							23.4	48.2	24.8	4.2	6.8	2.6
22	Шинэ-Идэр							18.9	10.0	-8.9	5.3	8.2	2.9
23	Эрдэнэбулган	1386.0	2944.0	1558.0	1355.0	2934.0	1579.0	74.1	115.0	40.9	23.0	38.0	15.0
24	Мөрөн							730.0	936.9	206.9	518.0	408.2	-109.8
<b>ДҮН</b>		<b>18058.0</b>	<b>24193.9</b>	<b>6135.9</b>	<b>17924.5</b>	<b>24045.1</b>	<b>6120.6</b>	<b>3270.7</b>	<b>2747.7</b>	<b>-523.0</b>	<b>1361.9</b>	<b>1232.3</b>	<b>-129.6</b>

Тарималуудын нэг га-ийн ургацын усалгаатай үр тарианы ургац нилээд доогуур байна. Энэ нь тус нутагт энгийн усалгаатай тариалан зонхилж, инженерийн хийцтэй усалтын систем ашиглаж эхэлж байгаа боловч түүний ашиглалтын түвшин, агротехнологийн арга ажиллагаа хоцрогдонгуй байгааг харуулж байна.



Зураг № 5.5. Тариалсан талбай, 2011-2013 оны байдлаар, га



Зураг № 5.6. Хураасан ургац 2011-2013 оны байдлаар, тн

Хүснэгт № 5.18. Хөвсгөл аймгийн голлох тарималуудын нэг га-ийн ургац (сүүлийн 4 жилийн дунджаар цн)

Үр тариа	Малын гэжээл	Төмс	Хүсний ногоо	Жимс жимсгэнэ
15.2	308	2985.2	1206	-

Тарималуудын нэг га-ийн ургацын усалгаатай үр тарианы ургац нилээд доогуур байна. Энэ нь тус нутагт энгийн усалгаатай тариалан зонхилж, инженерийн хийцтэй усалтын систем ашиглаж эхэлж байгаа боловч түүний ашиглалтын түвшин, агротехнологийн арга ажиллагаа хоцрогдонгүй байгааг харуулж байна.



## ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ЗАМ ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗРЫН ОДООГИЙН БАЙДАЛ

Хөвсгөл аймгийн газрын нэгдмэл сангийн ангиллаар 2013 онд нийт зам шугам сүлжээний газрын хэмжээ 7784,90 га талбай байна. 2013 оны байдлаар авто замын газар 3199,76 га, агаарын тээврийн газар 151,05 га, шугам сүлжээний газар 4432,29 га байна. Нийтдээ зам шугам сүлжээний газрын хэмжээ 2003 онтой харьцуулхад 44 %-иар буюу 3396.2 га талбайгаар өссөн байна.

*Хүснэгт №6.1. Зам шугам сүлжээний газрын талбай*

№	Дэд ангилал	2013 он, /га-аар/
1	Авто замын газар бүгд	3199.76
2	Төмөр замын газар бүгд	-
3	Агаарын тээврийн газар бүгд	151.05
4	Шугам сүлжээний газар бүгд	4432.29
5	Усан тээврийн газар бүгд	1
<b>6</b>	<b>Бүгд</b>	<b>7784.90</b>

### 6.1. Авто зам

Хөвсгөл аймгийн хувьд авто замын газрын талбайн өөрчлөлтийг 2003-2013 онтой харьцуулахад 34,06 га-аар буурсан байна. Энэ нь энгийн шороон зам болон, сайжруулсан шороон замын хэмжэээ буурсантай холбоотой юм.

*Хүснэгт №6.2. Автозамын газар ашиглалтын байдал (га)*

Д/д	Аймаг	Автозамын газар, бүгд	Үүнээс			
			Улсын чанартай	Орон нутгийн чанартай	Аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын зориулалттай	Авто тээврийн барилга, байгууламж, зогсоолын талбай
1	Хөвсгөл	3199,76	642,9	2343,46	211,7	1,7

Хөвсгөл аймаг нь Монгол улсын төвийн хойт хэсэг оршдог бөгөөд уул нуруу, гол мөрөн нутгийн бусад хэсэгтэй харьцуулахад ихтэй бөгөөд зам барьж байгуулахад нилээд хүнд нөхцөлтэй юм. Түүнээс гадна зам барьж байгуулахад Сэлэнгэ, Дэлгэрмөрөн, Эг, Тэс, Үүрийн гол зэрэг олон тооны том жижиг олон гол горхитой тул зам тавихад тэр бүгд дээр найдвартай төмөр бетон гүүр байгуулах шаардлага гардаг.

Хөвсгөл аймгийн нутгаар улсын болон орон нутгийн чанартай 5547 км авто зам дамжин өнгөрч байгаагаас улсын чанартай зам 1065 км, орон нутгийн чанартай зам 1848 км, сумаас баг хүртлэх 2834 км ердийн хөрсөн зам байна.

Аймгийн төвөөс 50 км дотор алслагдсан 2 сумтай, 100-150 км-д алслагдсан 1 тосгон 13 сумтай, 150 км-с цааш алслагдсан 8 сумтай байгаа юм.

Хөвсгөл аймгийн улсын чанартай замын Мөрөн-Хатгалын А1101 чиглэлийн 89,9 км хатуу хучилттай зам ашиглалтанд орсон.

Мөрөн - Булганы 180 км /253.3/ хатуу хучилттай автозам 2014 онд ашиглалтанд бүрэн орж, Улаанбаатар хот, Булган, Эрдэнэт, Дархан хотуудтай хатуу хучилттай замаар холбогдоно. Энэ чиглэлийн замтай давхцаж байгаа Их-Уул, Тосонцэнгэл сумууд хатуу хучилттай замаар аймгийнхаа төвтэй холбогдоно. Хатуу хучилттай зам Тариалан сумаас 9

км зайтай өнгөрөнө. Мөн Мөрөн–Хатгалын хатуу хучилттай авто замаас Алаг-Эрдэнэ сумын төв 7 км зайтай байна.

Ханх-Мондын замын 20.63, Мөрөнгийн төвийн Хилэнтийн 180.0, Түнэл сумын Эгийн голын 162.5, Галт сумын Идэрийн голын 162.9, Жаргалант сумын Идэрийн голын 163.1, Цагаан-Үүр сумын Үүрийн голын 350 у/м төмөр бетон, Шишгэд, Хогоргын голын 150 у/м хөвдөг гүүрүүд баригдан ашиглалтанд оржээ.

Тус аймагт авто замыг хариуцан өвөл зуны аль ч улиралд тээврийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлж, зорчигч тээвэрчдэд, авто замаар саадгүй үйлчлэх үүрэгтэй зам засвар арчлалтын компани ажиллаж байна.

Мөрөн–Булган, Мөрөн–Улиастай, Мөрөн–Тэрхийн Цагааннуур улсын чанартай авто замын хөдөлгөөний эрчим жилд дунджаар 4-5 хувиар өсөж байна.

*Хүснэгт №6.3. Хот хоорондын авто замын одоогийн байдал*

Замын чиглэлийн дугаар	Авто замын чиглэл, нэр	Замын төрөл	Хүчин чадал /км/
A0902	Мөрөн – Булган чиглэл	Хатуу хучилттай	180.0
A1101	Мөрөн – Хатгал*	Хатуу хучилттай	103.0
A1101	Хатгал – Ханх*	Ердийн хөрсөн	180.0
A1101	Ханх – Монд /Улсын хил/	Ердийн хөрсөн	23.0
A1101	Мөрөн – Улиастай *	Ердийн хөрсөн	226.0
A18	Мөрөн / Тунамал нуурын ар – Баруун туруун – Улаангом/	Ердийн хөрсөн	139.0
	Мөрөн-Тэрхийн Цагаан нуур	Ердийн хөрсөн	214.0
Дүн	Улсын чанартай замын нийт урт		1065.0
	Үүнээс хатуу хучилттай		283.0

\*УИХ-ын 2001 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан Мянганы замын босоо тэнхлэгийн авто зам Улсын чанартай замын 26.5 хувь буюу 283 км нь хатуу хучилттай зам байна.

*Хүснэгт №6.4. Сумуудын авто замын одоогийн байдал*

№	Авто замын чиглэл	Нийт зай /км/	Хучилтын одоогийн байдал
1	Мөрөн-Бүрэнтогтох	45	Ердийн хөрсөн
2	Бүрэн тогтох-Цагаан- Уул	88	Ердийн хөрсөн
3	Цагаан-Уул –Цэцэрлэг сум	80	Ердийн хөрсөн
4	Цэцэрлэг сумаас-Залаагийн дөрөлж	60	Ердийн хөрсөн
5	Цагаан-Уул сумаас- Халзан согоот	93	Ердийн хөрсөн
6	Мөрөн-Төмөрбулаг	65	Ердийн хөрсөн
1-рт хүний зүй бус үйл ажиллагаанаас болж удаа дараа гарч байсан ойн түймрийн учруулсан хохирол их байна.

2-рт ойн ариун цэвэр муу байгаагаас ойн хөнөөлт шавжийн голомт арилахгүй, залуу дунд насны болон болц гүйцэж яваа ойд учруулсан хохирол их байна.

3-рт мод, модон материалын хэрэгцээ эрс нэмэгдэн, зах зээлд мод үнэтэй болсон нь хууль бусаар мод бэлтгэх сонирхолыг төрүүлж байгалийн ойд ихээхэн хохирол учруулж байна.

4-рт уур амьсгалын өөрчлөлт, хуурайшилтын нөлөөгөөр гацуур болон навчит үүлдэрийн модод хатаж хуурайших явдал ажиглагдаж байна. Мөн байгалийн аясаараа сэргэн ургалт муу байгаагаас ойн сан тэлж ургах явц удаан, бага байна.

5-рт хүн, малын хүчин зүйлийн сөрөг нөлөө, байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр хээржих үйл явц явагдаж байна.

Дээрх хүчин зүйлсийн нөлөөгөөр байгалийн ой их хэмжээгээр хорогдож ойгоор бүрхэгдээгүй талбайн ангилалд шилжсэн байна. Хүснэгтээс харахад бургасан ойн талбай, нөөц өсч гарсан байна. Энэ нь өмнөх оны ой зохион байгуулалтаар ойн санд бүртгэгдээгүй голын дагуух бургасыг шинэ зохион байгуулалтаар ойн санд бүртгэж авсан явдал юм.

### ***В.Ойн сангийн таксацын дундаж үзүүлэлтийн өөрчлөлт.***

Ойн сангийн таксацын дундаж үзүүлэлтүүдийн өөрчлөлтөөс үзэхэд бүх дундаж өсөлт 249.1 мян.шоо.метрээр, байгалийн ойн 1 га-н нөөц 8 шоо.метрээр, 1 га-н өсөлт 0.01 шоо метрээр тус тус багасаж, дундаж бонитет 0.01, дундаж өтгөрөл 0.05-аар, нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Ойн таксацын гол гол үзүүлэлтүүд бүгд буурч гарсан нь түймэр, ойн хөнөөлт шавжийн тархалт, хууль бус мод бэлтгэлээс учирч буюу хор уршиг төдийгүй ойд хэрэгжүүлэх шаардлагатай ойн аж ахуйн арга хэмжээнүүд хийгдэхгүй байгаагаас шалтгаалж байна. Нөгөө талаар сүүлийн жилүүдэд тохиолдож байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс болж ойн ургах орчин ихээхэн өөрчлөгдөж байгаатай холбоотой.

### **7.3. Ой хамгаалах, нөхөн сэргээх талаар хийгдсэн ажлын судалгаа**

#### ***1.Ойг хамгаалах талаар.***

Ойг хамгаалах арга хэмжээнд ойг түймэр, хөнөөлт шавьж, өвчнөөс хамгаалах, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх ажлууд багтдаг.

#### ***А.Ой, хээрийн түймрээс хамгаалах талаар***

Жил бүр Аймгийн Засаг даргын захирамжаар түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын хэсэг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулан ажиллаж иржээ. Гэвч сүүлийн 5 жилд давхардсан тоогоор 56 суманд 98 удаа ой хээрийн түймэр гарч, байгаль экологид 694.9 тэрбум төгрөгийн хохирол учруулжээ.

*Хүснэгт №7.12. Хөвсгөл аймагт 2008-2012 онд гарсан ой, хээрийн түймрийн судалгаа*

№	Үзүүлэлт	2008он	2009он	2010он	2011 он	2012 он	Дүн
1	Түймэр гарсан сумын тоо	15	7	7	11	16	56
2	Гарсан түймрийн тоо	30	10	9	15	34	98
3	Бүгд шатсан талбай сая га	5379	3318.2	333.5	634		
4	Экологийн хохирол сая.төг	148188900	481838390	27403950	132210806	694175464654	694965106700
5	Нийт хохирол сая.төг	169365054	486633280	31226160	142363180	694175464654	695005052328

#### ***Б.Ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх талаар***

Сүүлийн жилүүдэд ойн хөнөөлт шавьж, өвчний тархалтын судалгаа явуулах ажлыг 810.9 мянган га талбайд явуулж, түүнтэй тэмцэх ажлыг 105.8 мянган га талбайд тус тус зохион байгуулж, зохих үр дүнд хүрсэн хэдий ч одоо 2014 оны судалгаагаар аймгийн хэмжээгээр зайлшгүй тэмцэл явуулах шаардлагатай 102002 га ойн талбай байгаа юм. Ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх шаардлагатай талбайг сумдаар *хүснэгт №7.12.-д* харуулав.

## Хүснэгт №7.13. 2008-2012 онуудад хортонтой тэмцэх ажил хийгдсэн байдал

Он	Тэмцэл хийсэн сумын нэр	Судалгаа /мян.га/-р	Тэмцэл явуулсан талбай /мян.га/-р				Нийт дүн
			Ан-2 онгоцоор	Газрын техникээр	Дельта план	Механик аргаар	
2009	Шинэ-Идэр, Галт, Тариалан	-	9000	1800	-	1500	12300
2010	Рашаант, Их-уул, Тосон цэнгэл, Түнэл, Бүрэнтогтох, Жаргалант	175950	29100	1700	-	-	30842
2011	Рашаант, Цагаан-Үүр, Эрдэнэ булган	250000	-	4500	-	4500	9000
2012	Цагаан-Үүр, Эрдэнэбулган, Тариалан, Бүрэнтогтох, Цэцэрлэг, Рашаант	385000	26100	2500	-	12050	40650
2013	Цагаан-Үүр, Эрдэнэбулган, Тариалан	-	-	-	-	13000	13000
<b>Нийт дүн</b>		<b>810950</b>	<b>64200</b>	<b>10500</b>	<b>-</b>	<b>31050</b>	<b>105792</b>

## Хүснэгт №7.14. Ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх шаардлагатай талбай

№	Сумын нэр	Зайлшгүй тэмцэл явуулах талбай		Зүйлийн нэр
		Талбайн хэмжээ	Хэсэглэлийн дугаар	
1	Рашаант	33938	33, 34, 61, 57- 59, 70-72, 79, 80, 67, 68, 93, 94, 98, 101, 86, 87, 92, 97, 100, 104,	Якобсоны төөлүүрч, Сибирийн хур, өрөөсгөл хур
2	Галт	13957	1-5, 57-61, 58, 74-76, 84, 86, 99, 100-102, 117-119, 121, 122, 125, 126, 138, 139, 140, 142, 163	Якобсоны төөлүүрч, Эгэл бийрэн сүүлт
3	Их-Уул	5642	117, 118, 120-124	Якобсоны төөлүүрч, Сибирийн хур
4	Жаргалант	8138	1-7, 14, 15, 18-26	Якобсоны төөлүүрч, Эгэл бийрэн сүүлт
5	Шинэ-Идэр	15304	41- 43, 56, 57, 59-62, 64,	Якобсоны төөлүүрч
6	Цэцэрлэг	16300	28, 29, 32, 64-69, 130, 142-144, 165-167, 173, 181, 185, 193	Сибирийн хур
7	Эрдэнэбулган	5070	227-229, 210, 211, 233, 204-206, 301, 303-305	Өрөөсгөл хур
9	Түнэл	3216	181-185	Якобсоны төөлүүрч, Сибирийн хур
10	Тосонцэнгэл	437	35	Якобсоны төөлүүрч, Сибирийн хур
	Дүн	102002		

**В.Хамтын эзэмшлийн ойн менежментийг хөгжүүлэх.**

Ойг хамгаалах арга хэмжээний чухал нэг хэсэг бол ойн сангийн тодорхой хэсгийг ойн нөхөрлөлд эзэмшүүлэх явдал юм. Сүлийн жилүүдэд ойн сангийн газрыг нөхөрлөлүүдэд эзэмшүүлснээр ойн түймрийг цаг алдалгүй унтраах, түймрийн тоог эрс багасгах сайхан боломж бүрдэж байгаагийн зэрэгцээ ойд хууль бусаар мод бэлтгэх явдлыг үндсэндээ зогсоож чадсан байна. Хөвсгөл аймгийн хувьд 2014 оны бүрэн бус мэдээгээр 3116 гишүүтэй 154 ойн нөхөрлөл үйл ажиллагаа явуулж, 441.5 га талбайг хариуцан ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр ажиллаж байгаа юм. Эдгээр ойн нөхөрлөлийн 71 нь гэрээгээр эзэмшиж байгаа ойн сангийн талбайдаа ой зохион байгуулалт хийлгэж, 58 ойн нөхөрлөл ойн менежментийн төлөвлөгөөг батлуулжээ. Аймгийн ойн нөхөрлөлийн судалгааг хүснэгт 7.15-д харуулав.

## Хүснэгт№7.15. Хөвсгөл аймгийн ойн санг гэрээгээр эзэмшиж буй нөхөрлөлийн судалгаа

№	Сумын нэр	Нөхөрлөлийн нэр	ИТХ-ын шийдвэр он сар	Эзэмшиж буй ойн сангийн талбайн хэмжээ	Гишүүд -ийн тоо	Нөхөрлөлийн тоо						
						Үүнээс						
						ОЗБ-хийгдсэн	ОЗБ хийгдээгүй	ОМТ-хийж батлуулсан	ОМТ-гүй	Гэрчилгээтэй	Гэрчилгээгүй	
1	Арбулаг	Баянбуурал	2009.07.28	2994	34	2009	(-)	2011	(-)	(-)	(-)	
2		Шимийн ундраа	2009.07.28	1224	24	2009	(-)	2011	(-)	(-)	(-)	
3		Чулуут	2009.07.28	1333	5	2009	(-)	(-)	(-)	(-)	(-)	
4		Сүмбэр	2009.07.28	1799	5	2009	(-)	(-)	(-)	(-)	(-)	
5	Баян зүрх	Хамрынхан	2012.12.19 2/03	-	25	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
6		Бэлхэс		-	10	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
7		Урт бүгт		-	15	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
8	Ренчинлхүмбэ	Мөнхчачир	2009.08.01	5380	57	2009	(-)	2010	(-)	(-)	(-)	
9		Баянхангай	2007	3800	97	(-)	(-)	2011	(-)	(-)	(-)	
10		Аргал	(-)	3820	-	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
11		Шарга	(-)	4100	-	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
12		Тэнгис	(-)	6000	-	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
13		Алтантал	2012.02.13 №11	-	-	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
14		Шишгэдийнхөгжил		-	-	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
15		Улаан-Уул	Тайж	2009.09.13	1976	22	2009	(-)	2012	(-)	(-)	(-)
16	Эрэн		429		13	2009	(-)	(-)	(-)	(-)	(-)	
17	Гурван тайга		342		16	2009	(-)	(-)	(-)	(-)	(-)	
18	Бөөштөг		1457		32	2009	(-)	2012	(-)	(-)	(-)	
19	Сэрх		5880		9	2009	(-)	(-)	(-)	(-)	(-)	
20	Ушигдай		5513		37	2009	(-)	2010	(-)	(-)	(-)	
21	Цагаанчулуут		2634		8	2009	(-)	(-)	(-)	(-)	(-)	
22	Хуулгат		2010		4430	17	(-)	(-)	2011	(-)	(-)	(-)
23	Алтгана		2011.01.12 №61		-	-	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
24	Гялаад				-	-	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
25	Мөнхийн ус				-	-	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
26	Астлаг				-	-	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
27	Булгийн-Ундраа	-		-	(-)	(-)	2010	(-)	(-)	(-)		
28	Номт	-		-	(-)	(-)	2011	(-)	(-)	(-)		
29	Цагаан-	Гурван сайхан	2009	2276	15	(-)	(-)	2010	(-)	(-)	(-)	

30	нуур	Цатга	2010	1638	22	(-)	(-)	2011	(-)	(-)	(-)
31	Цагаан-Үүр	Бадар	2009.10.15	2402	16	2009	(-)		(-)	(-)	(-)
32		Цахир	2010.04.27	2094	14	2009	(-)	2011	(-)	(-)	(-)
33		Бургалтай	2012.10.29	6171		2009	(-)	(-)	(-)	(-)	(-)
34		Шивээт	2012.10.29	7832		(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
35		Нуга хангай	2012.10.29	7182		(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
36		Ойдгон	2012.10.29	3794		(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
37		Арбулаг	2012.10.29	3476		(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
38		Дархинт	2012.10.29	9365		(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
39		Баян гол	2012.10.29	13494		(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
40		Булаг	2012.10.29	3998		(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
41		Онгон Уул	2009.05.20	5223	12	2009	(-)	(-)	(-)	(-)	(-)
42		Нарийн	2012.10.29	7260		(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
43		Эрдэнэ-булган	Баян бөөрөг	2009.04.20	2993	10	2009	(-)	2009	(-)	(-)
44	Хүрэн Уул			1105		2009	(-)	(-)	(-)	(-)	(-)
45	Чандмань-Өндөр	Буянт нутаг	2011.12.16	6328	32	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
46		Зуун цэцэг	2011.06.25	1115	25	(-)	(-)	2011	(-)	(-)	(-)
47		Далийн цэцэг	2012.03.01	7844	16	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
48		Баян Уул	2011.10.04	8276	24	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
49		Уран дөш	2010.10.04	4805		(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
50	Алаг-Эрдэнэ	Цахирын ам	2009	4020	23	2009	(-)	2010	(-)	(-)	(-)
51		Эрхэл	2009.07.13	4841		2010	(-)	2011	(-)	(-)	(-)
52		Ар гол	2009.07.13	3780	12	2009	(-)	2011	(-)	(-)	(-)
53		Живлэг	2009.07.13	5555	27	2009	(-)	2011	(-)	(-)	(-)
54		Хужирт	2009.07.13	6239	31	2009	(-)	2012	(-)	(-)	(-)
55	Их-Уул	Ар зуслан	2009.09.17	5446	11	2009	(-)	2011	(-)	2012	(-)
56		Чандмань	2009.09.17	3251	15	2009	(-)	2011	(-)	2012	(-)
57		Хонгор	2009.09.17	3708	7	2009	(-)	2011	(-)	2012	(-)
58		Сараалж	2009.09.17	3050	9	2009	(-)	2012	(-)	2012	(-)
59		Наран	2009.09.17	1788	8	2009	(-)	2012	(-)	(-)	(-)
60		Царам	2009.09.17	1671	16	2009	(-)	2012	(-)	(-)	(-)
61	Рагцаан	Тусгалт	2012.04.10 №23	2915	54	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
62		Өвөр бургаст		726	12	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
63		Их булаг		683	32	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)

64		Өгөөмөр		4282	50	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
65		Амга		1009	22	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
66		Улаан бургаст		716	32	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
67		Дулаан хаан		4541	12	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
68		Ар бургаст		1872	41	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
69		Дулаан хан	2008.11.28	5163	30	2009	(-)	(-)	2012	(-)	(-)	
70		Жаргалант	2008.11.28	4557	32	2009	(-)	(-)	2011	(-)	(-)	
71		Ирээдүй	2012			(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
72		Хан намнан	2012			(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
73		Хөх чулуу	2012			(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
74		Сайхан модот	2012			(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
75		Цагаан чулуут	2012			(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
76		Эв санаа	2012			(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
77		Тосонцор н-гэд	Баян тал	2010	4262	39	2010	(-)	2011	(-)	1	(-)
78			Улиастайн гол	2009.05.04 №20	1197	16	2009	(-)	2011	(-)	2	(-)
79			Улиастай эв санаа	(-)				(-)	2012	(-)	(-)	(-)
80	Түнэл	Талын толгой	2007	3181	42	2009	(-)	2010	(-)	(-)	(-)	
81		Ург булаг	2009.12.10		31	2009	(-)	2010	(-)	(-)	(-)	
82		Алтгана	2009	2711	50	2009	(-)	2011	(-)	(-)	(-)	
83		Хөндий	2008.03.06	1994	29	2009	(-)	(-)	(-)	(-)	(-)	
84		Хан-Уул	2008.01.21	2044	27	2009	(-)	2011	(-)	(-)	(-)	
85		Ундарга	2007.05.22	421	25	2009	(-)	(-)	(-)	(-)	(-)	
86		Ёлгос	2009.05.19	4191	30	2009	(-)	(-)	(-)	(-)	(-)	
87		Могойн гол		3000	32	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
88		Бийж	2011.03.24 №19	3000		(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
89		Ар булан		3000		(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
90		Хөх хайрхан	2011.03.24 №21	3000		(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
91		Цахир-Уул	2012.05.16 №40	3000		(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
92		Халуун ус	2012.05.25 №48	2500		(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
93		Төвгөр сайр	2012.05.25 №47	4000-		(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
94		Нуггийн хишиг	2012.05.10 №42	6000		(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
95		Баян-Улаан		3000		(-)	(-)	2011	(-)	(-)	(-)	
96	Хагга л	Өрхөт	2010	5276		2010	(-)	2011	(-)	(-)	(-)	
97		Хүйн холбоо	2009	9716	28	2010	(-)	2011	(-)	(-)	(-)	



98		Жанчивтолгой	2010	2843	54	2010	(-)	2010	(-)	(-)	(-)
99		Жинст-Оргил	2007	2619	21	2010	(-)	2011	(-)	(-)	(-)
100		Улаанбулаг	2010.10.08 №37	10730	31	2010	(-)	2011	(-)	(-)	(-)
101		Эвт-Оргил	2011.05.25	5589	31		(-)	(-)	(-)	(-)	(-)
102		Жанхай	2011.04.07 №33	6000	31		(-)	(-)	(-)	(-)	(-)
103		Их-Уул	2011.05.05 №40	9000	25		(-)	(-)	(-)	(-)	(-)
104		Балын гозгор	2012.05.11	5050	53		(-)	(-)	(-)	(-)	(-)
105		Галт	Сайхан хангай	2009.02.12	3824	43	2009	(-)	2011	(-)	(-)
106	Баян хангай		2009.02.12	2918	65	2009	(-)	2011	(-)	2011	(-)
107	Буянт хайрхан		2009.02.12	2522	25	2009	(-)	(-)	(-)	2011	(-)
108	Элгэн нутаг		2012.05.23 №144		45	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
109	Мандах харгана		2012.05.23 №144		39	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
110	Нарлаг		2012.05.23 №144		19	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
111	Нарийн хужирт		2012.05.23 №144		32	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
112	Их хүрээ		2012.05.23 №144		24	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
113	Өрнөх		2012.05.23 №144		14	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
114	3 яргайт		2012.05.23 №144		46	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
115	Баянзүрх		2012.05.23 №144		21	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
116	Жаргалант	Өндөр хайрхан	2008.04.18	1788	16	2009	(-)	2011	(-)	2012	(-)
117		Их саваг	2008.04.18	1671	24	2009	(-)	2011	(-)	2012	(-)
118		Цэцүүх бургаст	2008.04.18		17	2009	(-)	2011	(-)	2012	(-)
119		Хэц	2008.04.18	1099	16	2010	(-)	2011	(-)	2012	(-)
120		Шар жалга	2008.04.18	724	12	2010	(-)	2011	(-)	2012	(-)
121		Хангайн Хишиг	2008.04.18	2013	8	2010	(-)	2011	(-)	2012	(-)
122		Байц	2008.04.18	227	13	2010	(-)	2011	(-)	2012	(-)
123		Нарийн	2008.04.18	3099	10	2010	(-)	2011	(-)	2012	(-)
124		Дамбын мухар	2008.04.18	324	12	2010	(-)	2011	(-)	2012	(-)
125		Ташгай	2008.04.18		6	2010	(-)	2011	(-)	2012	(-)
126		Дарцаг	2008.04.18		19	2010	(-)	2011	(-)	2012	(-)
127	Шинэ-Идэр	Жаргалант	2012.06.27 №07	2677	133	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
128		Байц		2169	53	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
129		Цохиот		2950	120	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)
130		Дөрөлж		2373	155	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)

131		Нумт		4258	84	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
132	Төмөрбулаг	Таравц	2012.07.06 №43		31	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
133		Баянбулаг			31	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
134		Баянхангай			37	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
135		Дашдэрчин			63	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
136		Баянчулуут			44	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
137		Гурванхайрхан			11	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
138		Таван гол			25	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
139		Цагаан-Уул		Баянбулнай	2009.07.24 №32	10093	25	2010	(-)	2011	(-)	2011
140	Элээт		6282	27		2010	(-)	2011	(-)	(-)	(-)	
141	Байгалийн хишиг		3464	25		2010	(-)	(-)	(-)	2012	(-)	
142	Их элээт			15		(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
143	Халиун энгэр			16		(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
144	Булнайн хишиг			21		(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
145	Цэцэрлэг	Диданлхүмбэ	2011.10.13 №31	812	12	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
146		Тэсийн цуурай	2012.10.06 №65	3000	14	(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
147	Бүрэнгогтох	Төмөртий	2007.12.28 №07	2063		2010	(-)	2011	(-)	2011	(-)	
148		Тээл	2007.12.28 №07	2091		2010	(-)	2011	(-)	2011		
149		Хоёр могой	2007.12.28 №07	2142		2010	(-)	(-)	(-)		(-)	
150		Өндөр жаргалант	2007.12.28 №07	524		2010	(-)	(-)	(-)		(-)	
151		Миний нутаг	2007.12.28	4255		2009	(-)	2009	(-)	2011	(-)	
152		Дэлгэрмөрөн	2007.12.28	2821		2010	(-)	(-)	(-)	(-)	(-)	
153		Хөх сайг онгон хайрхан	2011.03.25	2864		2011	(-)	2012		(-)		
154		Сангийн далай		2083		(-)	(-)	(-)	(-)	(-)	(-)	
<b>411492</b>					<b>3116</b>	<b>71</b>		<b>88</b>	<b>58</b>	<b>101</b>	<b>24</b>	<b>135</b>

**2.Ойг зөв зохистой ашиглах талаар.**

Хөвсгөл аймгийн хувьд ойн нөөцөөр баялаг боловч үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэдэг томоохон аж ахуйн нэгж байхгүйгээс арчилгаа цэвэрлэгээний огтлолтоор ахуйн хэрэглээний мод болон иргэд, айл өрхийн түлээний хэрэгцээг хангадаг. Ахуйн зориулалтаар хэрэглээний модыг /сургууль, цэцэрлэг, эмнэлэг, конторын барилга болон айлын хашаа, байшин малын хашаа барих гүүр тавих гэх мэт/ түймэрт шатсан, ойн хөнөөлт шавжид нэрвэгдэн сэргэн ургах чадвараа бүрэн алдсан ойгоос цэвэрлэгээний журмаар авч ашиглаж байна. Айл өрх, албан байгууллага, аж ахуй нэгжүүдийн түлш, малчдын хашаа саравч, иргэдийн ахуйн болон орон сууцны хэрэгцээнд зориулж ойгоос ашиглаж болох хэрэглээний модыг ойн арчилгаа, цэвэрлэгээгээр төсөлд заасны дагуу зөв зохистой ашиглуулах нь зүйтэй юм.Иймээс орон нутгийн ард иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хэрэгцээг ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх замаар шийдвэрлэх нь зүйтэй юм.Мөн хамтлаг нөхөрлөлүүд эзэмшлийн ойгоосоо ойн цэвэрлэгээний журмаар түлшний мод бэлтгэх боломжтой юм.Хөвсгөл аймагт сүүлийн 5 жилд арчилгаа цэвэрлэгээний огтлолтоор бэлтгэсэн модны хэмжээг хүснэгт 7.16.-д харуулав.

*Хүснэгт №7.16. Хөвсгөл аймагт сүүлийн 5 жилд арчилгаа цэвэрлэгээний огтлолтоор бэлтгэсэн модны хэмжээ*

№	Сумын нэр	5 жилд арчилгаа цэвэрлэгээгээр бэлтгэсэн модны хэмжээ шоо.м	5 жилийн дундаж	2013 онд бэлтгэсэн модны хэмжээ
1	Арбулаг	17176	3435.20	6437.5
2	Алаг-Эрдэнэ	68884.61	13776.92	27187.5
3	Баянзүрх	21776.71	4355.4	9920
4	Бүрэнтогтох	153090.71	30618.14	14450
5	Галт	38008.6	7601.7	11737.5
6	Жаргалант	45531	9106.2	17987.5
7	Их-Уул	31215.1	6243.0	11031.3
8	Рашаант	31866	6373.2	12181.3
9	Ренчинлхүмбэ	36476.3	7295.3	15137.5
10	Тариалан	35055.35	7011.1	18400
11	Тосонцэнгэл	25898	5179.6	12000
12	Төмөрбулаг	20506	4101.2	17656.3
13	Түнэл	39143.5	7828.7	26775.5
14	Улаан-Уул	20424.1	4084.8	10262.5
15	Цагаан-Үүр	29426.9	5885.4	24393.8
16	Цагаан-Уул	27440.8	5488.2	16656.3
17	Цэцэрлэг	36678.11	7335.6	11746.9
18	Чандмань-Өндөр	27917.8	5583.6	27986.3
19	Шинэ-Идэр	30697.1	6139.4	5826.9
20	Ханх	22681.84	4536.4	9562.5
21	Эрдэнэбулган	36702.1	7340.4	29692.8
22	Цагааннуур	17464	3492.8	8937.5
<b>Нийт Дүн</b>		<b>814060.2</b>	<b>162812</b>	<b>345967.4</b>


**3.Ойг нөхөн сэргээх арга хэмжээний талаар**

Энэ арга хэмжээнд тарьц суулгац бойжуулах, ойг тарьж ургуулах, байгалийн сэргэн ургалтанд туслах ажлууд багтаж байна. Ойжуулалтын ажлыг гол усны эх, ай савыг ойжуулах, цөлжилтийг бууруулах, усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх, суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хамгаалалтын ойн зурвас байгуулахад чиглүүлэх зорилт


тавин ажиллажээ. Хүснэгт 10 болон график 2-д сүүлийн 5 жилд хийгдсэн ойжуулалтын ажил болон байгалийн сэргэн ургалтанд туслах арга хэмжээг сумдаар харуулав. Хөвсгөл аймгийн сүүлийн 5 жилийн ойг нөхөн сэргээх арга хэмжээг хүснэгт 7.17 болон , Зураг№ 4,5 -д тус тус үзүүлэв.

Хүснэгт№7.17. Хөвсгөл аймгийн сүүлийн 5 жилийн ойг нөхөн сэргээх арга хэмжээ

№	Сумын нэр	Ойжуулалт, га					Дүн	Байгалийн сэргэн ургалтанд туслах, га					Дүн
		2009	2010	2011	2012	2013		2009	2010	2011	2012	2013	
1	Алаг-Эрдэнэ			210		35	245			105		15	120
2	Арбулаг			20		5	25						
3	Баянзүрх						-						
4	Бүрэн тогтох					105	105						
5	Галт				170	47	217				50	60	110
6	Жаргалант				180		180				108		108
7	Их-Уул					10	10					100	100
8	Рашаант					18	18						80
9	Ренчинлхүмбэ						-						
10	Тариалан		140			18	158					19	19
11	Тосонцэнгэл					127	166					19	19
12	Төмөрбулаг					2	2					3	3
13	Түнэл		60			155	215					135	135
14	Улаан-Уул						-						
15	Ханх						-						
16	Цагаан-Уул	327			123	125	452	20			86,3		106.3
17	Цагаан-Үүр						-						
18	Цэцэрлэг						-						
19	ЧандманьӨндөр					36	36						
20	Шинэ-Идэр						-						
21	Эрдэнэбулган					1	1					8	8
22	Цагааннуур						-						
23	Аймгийн дүн	327	200	230	473	684	1914	20	-	105	244.3	359	728.3




Зураг№7.4. Ойжуулалт, га-аар




Зураг№7.5. Байгалийн сэргэн ургалтанд туслах арга хэмжээ

### Үр бэлтгэл, тарьц суулгацын талаар.

Ойжуулалтын ажлын хэмжээг нэмэгдүүлэхэд модны үр бэлтгэл, тарьц суулгац бойжуулах ажил чухал үүрэг гүйцэтгэнэ. Сүүлийн 5 жилд бэлтгэсэн үр, бойжуулсан тарьц суулгацын хэмжээг Зураг№ 7.6., 7.7.-д тус тус үзүүлэв.



Зураг№7.6. Бэлтгэсэн үр, кг-аар



Зураг№7.7 Бойжуулсан тарьц суулгацын тоо хэмжээ /сая.ширхэг/

**НАЙМДУГААР БҮЛЭГ. УСНЫ САН БҮХИЙ ГАЗАР****8.1. Усан сан бүхий газрын өнөөгийн байдал**

Монгол орны гадаргын усны нөөцийн 53%, гадаргын цэвэр усны нөөцийн 96% буюу 317,4 шоо дөрвөлжин км усыг Хөвсгөл аймгийн нуур голуудын ус бүрдүүлдэг бөгөөд түүний 96,6% -ийг Хөвсгөл нуурын ус бүрдүүлдэг. Дэлхийн 10 том мөрний нэг Енисей мөрөн Хөвсгөл аймгийн нутгаас эхэлдэг. Манай орны томоохон гол болох Эг, Сэлэнгэ голууд манай аймгийн нутгийн нуур, голуудаас усаа цуглуулан эх авч дэлхийн цэвэр усны нөөцийн 20%-ийг агуулдаг Байгаль нуурын усны нөөцийн 60%-ийг бүрдүүлэхээс гадна цэвэр тунгалагжилтын эх үүсвэр болдог.

Хөвсгөл нуур нь тунгалагжилтын зэргээрээ дэлхийд гуравдугаарт буюу Байгаль нуур, Саргасын тэнгисийн дараа ордог төдийгүй төв азийн хамгийн гүн нуур болох учир нийт монголчуудын хайрлан хамгаалдаг байгалийн хосгүй өв юм. Энэ ч утгаараа “Дэлхийн байгалийн өв”-д бүртгүүлэхээр ажиллаж байгаа юм.

Хөвсгөл нуур нь газар хөдлөл, хагарлын хүчин зүйлийн нөлөөгөөр үүссэн хойноосоо урагш сунаж тогтсон өндөр уулын бүсэд багтдаг, цэвэр тунгалаг устай Далайн түвшинээс дээш 1645 м өндөрт орших, 7-8 сая жилийн түүхтэй нуур юм.

Нуурын мандал нь 2760 хавтгай дөрвөлжин км бөгөөд ус хураах 4940 хавтгай дөрвөлжин км талбайд 383,7 шоо дөрвөлжин км ус агуулдаг байна. Хөвсгөл нуурын эргийн шугамын урт 414 км, урт нь 136 км, дундаж өргөн нь 26 км, хамгийн гүн цэг 262 м, нуурт 111 гол горхи цутган ганц Эгийн гол эх аван урсдаг.

Хөвсгөл нуур нь талбайн хэмжээгээрээ Азид 3 дугаарт, Монголдоо Увс нуурын дараа, гүнээрээ Ази тивд 4 дүгээрт, цэвэр усны нөөцөөрөө Монголд 1 дүгээрт ордог. Хөвсгөл аймгийн гадаргын усыг бүрдүүлэгч голууд Усны газраас тогтоосон сав газруудаас 6 савд багтах Хөвсгөл нуур-Эгийн гол, Дэлгэр мөрөн, Сэлэнгэ мөрөн, Идэрийн гол, Шишхэдийн гол, Увс нуур-Тэсийн гол зэрэг томоохон голуудаас гадна Сангийн далай, Гандан нуур, Цагаан нуур, Зүүн нуур, Эрхэл нуур, Жугнайн нуур, Тунамал нуур, Цэнгэл нуур, Тайжийн нуур зэрэг томоохон нуурууд, олон булаг шандаас бүрдэж байна.

Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэр дэх газрын доорхи усны нөөц харьцангуй бага судлагдсан бөгөөд одоогийн байдлаар Алаг-Эрдэнэ, Бүрэнтогтох сумын нутгийн заагт орших “Дэлгэр мөрний орд” -6559,0 м<sup>3</sup>/хоног, Ренчинлхүмбэ сумын Арсайн ам, Зөөлөн орчмын “Ренчинлхүмбийн орд”-488,0м<sup>3</sup>/хоног, Арбулаг сумын Ямаат, Сүмбэр орчмын “Хүрэн булагийн орд”-259,2 м<sup>3</sup>/хоног, Цагаан-Уул сумын Өвгөд багийн “Хүйтэн хошууны орд”- 242,0 м<sup>3</sup>/хоног, Ханх сумын “Хавцлын амны орд”-492,0 м<sup>3</sup>/хоног, Цагаан-Уул сумын “Шар голын орд”-244,0 м<sup>3</sup>/хоног буюу аймгийн хэмжээгээр 8284,2 м<sup>3</sup>/хоногийн нөөцтэй гэж тогтоогдсон байдаг.

Манай аймгийн хувьд урьдчилсан судалгаагаар газрын доорхи ус 2,49км<sup>3</sup> үүнээс ашиглах боломжтой нөөц 1,95 км<sup>3</sup>, гадаргын ус 6,59 км<sup>3</sup>, үүнээс ашиглах боломжтой нөөц 0,16 км<sup>3</sup> байгааг тогтоосон байна. Манай аймгийн хэмжээнд хоногт 3500 м<sup>3</sup>, хүн ам ихээр төвлөрсөн Мөрөн суманд хоногт 1500 м<sup>3</sup> ус хэргэлдэгээс 1000 орчим м<sup>3</sup> усыг бохир

хэлбэрээр хаягддаг байна. Одоогийн байдлаар аймгийн нийт хүн амын 80 гаруй хувь баталгаат ундны усны эх үүсвэрээс хэргэлж байна.

Хөвсгөл аймгийн нутаг ус зүйн сүлжээгээр Хойд мөсөн далайн ай савд хамрагддаг. Хорьдол–Сарьдаг, Мөнх Сарьдаг, Булнай зэрэг уулс нь усны ай савын хагалбар болдог төдийгүй Дархадын хотгорыг хүрээлэн орших уул, нуруудаас эх авах булаг шанд, гол, горхи нь бүгд Шишхэд голын савд усаа юүлэх учир Монгол улсдаа хамгийн их гадаргын усны нягтшилтай бүс нутаг юм. Энд 400 орчим гол горхи, булаг шанд эх авч 300 гаруй нуур тогтсоноор манай орны цэнгэг усны ундраа нөөц болж байна. 2003 онд хийсэн гадаргын усны тооллогоор Хөвсгөл аймгийн хэмжээнд 70 гол горхи, 193 булаг шанд, 30 нуур цөөрөм, 2007 оны усны тооллогоор 179 булаг шанд, 471 гол горхи, 49 нуур, цөөрөм, 2011 оны тооллогоор 132 гол горхи, 163 булаг шанд, 62 нуур тойром ширгэсэн байдаг. Харин 2013 оны гадаргын усны тооллогын дүнд 1212 гол горхи тоологдсоноос устай 1173, нуур тойромоос 578 бүгд устай, 929 булаг шанд тоологдсоноос 841 устай, Рашаан нийтдээ 61 устай тоологдсон байна

Түүнчлэн хүн малын усан хангамжийн эх үүсвэр болсон гол усны эх үүсвэр болох 18 цэгээс жилд 126 дээж авч усны бохирдолтыг MNS45:86:98 стандартаар авч үзэхэд: Дэлгэрмөрөн, Идэр, Сэлэнгэ мөрний усны чанар 2-р зэрэг буюу цэвэр, бусад уст цэгүүдийн усны чанар 1-р зэрэг буюу маш цэвэр ангилалд хамаарч байгааг тогтоосон байна. Усанд байдаг гол элементүүд зөвшөөрөгдсөн хэмжээнээс давсан үзүүлэлт үгүй бөгөөд PO<sub>4</sub> элемент хойд мөсөн далайн савд ордог, Хөвсгөлийн уулсад орших фосфоритийн орд газар, нэгж талбайд ноогдох малын тоо толгой харьцангуй их, газар тариалан энэ сав газарт төвлөрсөн зэргээс хамааралтайгаас арай ахиу гарч байгаа ч хүлцэх хэмжээнээс бага байна. Харин газрын гүний ус харьцангуй хатуулаг ихтэйг лабораторийн шинжилгээгээр тогтоосон юм.

Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт 2010 оны усны тоо бүртгэлээр гол горхи-838, нуур тойром-449, булаг шанд- 1077, эмчилгээний ач холбогдол бүхий рашаан-62, мөстөл-1, услалтын систем-2, цэвэрлэх байгууламж-1, худаг-993, хамгаалалтын далан-1 усан цахилгаан станц-1 тоологдсон байна. Аймгийн БОАЖГ-аас сүүлийн 50 жилд ширгэж усгүй болсон уст цэгийн судалгаагаар гол горхи-138, нуур тойром-32, булаг шанд- 214, рашаан-1 тус тус ширгэж усгүй болсон, усны хэрэглээ нэмэгдэж байгаа, усны үнэ цэнийг нэмэгдүүлэх хамгаалах зайлшгүй шаардлагыг харгалзан “Ус” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж байна. Нөгөө талаар байгалийн баялаг болсон усыг ариг гамгүй хэрэглэх, усны үнэ цэнийг иргэд ойлгоогүйгээс “Хар ус” хэмээх ойлголт иргэдийн дунд түгээмэл болсон нь усны талаар иргэдэд нэгдсэн ойлголт өгөх ажил дутмаг байгааг харуулж байгаа төдийгүй аймгийн хүн ам, малын тоо толгой тасралтгүй өсөн нэмэгдэж байгаа нь цаашид усны хэрэглээ нэмэгдэх хандлагатай байгаа юм.

## 8.1.1. Гадаргын усны горим, төлөв байдал

Хүснэгт№8.1. Хөвсгөл аймгийн усан сангийн газар 2013 оны байдлаар

№	Гадаргын ус	Га-аар
1	Мөрөн, гол	33298.3
2	Нуур,цөөрөм,тойром	51390.1
3	Цас мөсөн гол	194.5
4	Горхи, булаг шанд	1314.1
5	<b>НИЙТ</b>	<b>86197</b>


Дээрх хүснэгтээс харахад нуур цөөрөм тойрмын талбайн хэмжээ хамгийн их буюу 59.6 хувийг, гол мөрөн 38.6 хувийг, үлдсэн 1.8 хувийг горхи, булаг шанд, цас, мөсөн гол эзэлж байна.

Булаг шанд, нуга намгаас эх авсан жижиг голуудын булаг шандууд ямарч хамгаалалтгүй зуны цагт усны эхэн дээр адуу мал олноор тийрэглэн шавж усны эхийг их хэмжээгээр бохирдуулах явдал түгээмэл үзэгдэл болсон байна.


Хүснэгт№8.2. Хөвсгөл аймгийн усны тоолого

№	Сумдын нэрс	Гол горхи		Нуур, тойром		Булаг шанд		Рашаан	
		Тоологдсон	Устай	Тоологдсон	Устай	Тоологдсон	Устай	Тоологдсон	Устай
	<b>Бүгд</b>	<b>1212</b>	<b>1173</b>	<b>578</b>	<b>578</b>	<b>929</b>	<b>841</b>	<b>61</b>	<b>61</b>
1	Алаг-Эрдэнэ	29	29	3	3	53	53	1	1
2	Арбулаг	25	25	43	43	61	61	-	-
3	Баянзүрх	39	39	3	3	34	34	3	3
4	Бүрэнтогтох	42	42	8	8	84	84	3	3
5	Галт	45	45	-	-	29	29	5	5
6	Жаргалант	42	42	-	-	62	60	2	2
7	Их-Уул	18	13	-	-	36	22	2	2
8	Рашаант	9	8	28	28	35	12	5	5
9	Ренчинлхүмбэ	88	88	185	185	24	24	4	4
10	Тариалан	38	38	3	3	41	41	4	4
11	Тосонцэнгэл	24	12	3	3	42	42	-	--
12	Төмөрбулаг	22	14	-	-	93	46	2	2
13	Түнэл	42	42	4	4	42	42	2	2
14	Улаан-Уул	105	105	106	106	7	7	3	3
15	Ханх	44	44	11	11	10	10	2	2
16	Цагаан-Уул	38	37	25	26	45	45	-	-
17	Цагаан-Үүр	192	192	16	16	32	32	11	11
18	Цэцэрлэг	120	120	10	10	30	30	4	4
19	ЧандманьӨндөр	40	40	3	3	36	36	3	3
20	Шинэ-Идэр	21	9	3	3	53	51	-	-
21	Хатгал	2	2	2	2	14	14	-	-
22	Мөрөн	-	-	-	-	-	-	-	-
23	Эрдэнэбулган	77	77	7	7	57	57	3	3
24	Цагааннуур	110	110	115	115	9	9	2	2






Зураг№8.1. Хөвсгөл аймгийн гадаргын усны тооллого 2013 он



Зураг№8.2. Сумуудын усан сан бүхий газрын хэмжээ, га-аар

Гадаргын усан сан бүхий газар (гол нууруудын талбай) нь экобүсийн сумуудад ямар хэмжээтэй байгааг авч үзвэл: Баянзүрх сумын нийт нутгийн 0,06 хувь буюу 2,2 мянган га, Ренчинлхүмбэ сумын 1,5 хувь буюу 12,7 мянган га, Улаан-Уул сумын 0,85 хувь буюу 8,5 мянган га, Цагааннуур сумын 2,2 хувь буюу 11,7 мянган га, Цагаан-Үүр сумын 0,5 хувь буюу 4,0 мянган га талбайг тус тус эзэлнэ. Хөвсгөл далайн нийт талбай энд орж тооцогдоогүй, УТХГ-ын ангилалд багтаж Ханх сумын нутагт орж тооцогддог байна.



Зураг №8.3. Хөвсгөл аймгийн усны сав газрын зураг

Хүснэгт №8.3. Хөвсгөл аймгийн усны нөөц шоо км<sup>3</sup>

Аймаг	Гадаргын ус		Газрын доорх ус	
	Нийт	Ашиглах боломжтой	Ул хөрсний	Ашиглах боломжтой
Хөвсгөл	6.59	0.16	2.49	1.95

Гадаргын болоод газар доорхи усны нөөцийн нийт хэмжээ 9.1 км<sup>3</sup> байна. Үүнээс 72.4 хувийг гадаргын ус, үлдсэн 27.6 хувийг газрын доорх ус эзэлж байна. Эндээс харахад Хөвсгөл аймаг нь гадаргын усны нөөцөөр баялаг нутаг юм.

## 8.2. Хөвсгөл аймгийн усны сав газруудын усны нөөц, горим

Усны нөөцийг байгалийн бусад нөөцтэй харьцуулахад хэд хэдэн онцлог чанартай. Ус бол юугаарч сольж болшгүй амин чухал эрдэс бодис, засаг захиргааны хил заагт үл хамаарах хийгээд хатуу, шингэн, хийн төлөвийг дамжин хийн мандал, шим мандалд чөлөөтэй шилжих онцлогтой. Усны нөөц тоо чанарын хувьд цаг хугацаа, орон зайд байнга хувьсч байдаг. Байгалийн усны эргэлтээр сэлбэгдэж, тунгалагших явцдаа байгаль орчны бүрэлдэхүүний зайлшгүй нэгэн хэсэг болно. Хөвсгөл нутаг нь гадаргын усны ихээхэн нөөцтэй боловч уур амьсгалын дулаарал, ой модны огтлолт зэрэг байгалийн болон хүний үйл ажиллагааны нөлөөгөөр нөөц тодорхой хэмжээгээр багассан байна. Томоохон голуудын сүүлийн 15 жилийн түвшний цуваанаас үзэхэд Үүрийн голын түвшин 43 см, Шишхэд голын түвшин 34 см, Дэлгэр мөрөн, Эг голын (Эрдэнэбулган суманд) түвшин 27 см орчмоор тус тус буурсан байна. Мөсний зузааны сүүлийн 10 –аад жилийн хэмжилтээс харахад Шишхэд, Эг, Дэлгэрмөрөн голын 2004 оны ус судлалын харуул дээр хэмжигдсэн мөсний зузаан нь олон жилийн дундаж зузаанаасаа багассан байна. Эдгээр нь цаашид

усны нөөцийг тооцоо судалгааны үндсэн дээр зөв зохистой ашиглах шаардлагатайг харуулж байна. Ялангуяа цэнгэг усны ихээхэн нөөцтэй Хөвсгөл нуурын усыг бохирдуулахгүй байх нь хамгийн чухал байна. Манай орны гадаргын усны нөөцийн 85 хувийг цэнгэг ус, түүний 93.6 хувийг Хөвсгөл нуурын ус эзэлдэг.

Уур амьсгалын өөрчлөлт, усны зохисгүй ашиглалт, гол мөрний эх авдаг уулсын ойг хавтгайруулан огтлох нь усны нөөцийг хомсдуулах гол шалтгаан болж байна. Усыг цэвэр ариун байлгах, усны нөөцийг хамгаалахын тулд усны нөөцийн менежментийг хэрэгжүүлэх шаардлагатай.

Хөвсгөл аймгийн томоохон голууд, тэдгээрийн сав газрын ус хурах талбайн хэмжээ, голын сүлжээний нягтшил, голын урт зэрэг усны сав газрын үзүүлэлтүүдийг 2.1-р хүснэгтээр, сав газрууд дахь голуудын тоо болон томоохон цутгал голуудыг хүснэгт 2.3, хүнэгт 2.4-т тус тус үзүүлэв.

Хүснэгт №8.4 Хөвсгөл аймгийн усны сав газрын үзүүлэлт

№	Гол, горхи	Талбай, ам км	Үндсэн голын урт, км	Голын дундаж уналт, %	Сав газрын дундаж өндөр, м	Нийт голын урт, км	Голын сүлжээний нягтшил км/ км <sup>2</sup>	Голын зэрэг
<b>Хойт мөсөн далайн ай сав</b>								
1	Сэлэнгэ	282154.1	1095	0.0019	1500	107692,8	0.38	9
2	Идэр	22419.9	465	0.0047	1780	22230.3	0.99	7
3	Дэлгэрмөрөн	18670.6	439.7	0.0035	1921	8002.3	0.43	6
4	Эг	38354.1	509.5	0.0016	1624	13551.3	0.35	7
5	Тэс	21027	426	0.0029	1682	5083.64	0.24	5

Дээрх хүснэгтээс үзэхэд Хөвсгөл аймагт орших Сэлэнгэ, Идэр, Дэлгэрмөрөн, Эг, Тэс, голуудын нийт талбайн хэмжээ 156560,34 ам км байна. Энэ нь тус аймгийн нийт газар нутагтай харьцуулахад харьцангуй их үзүүлэлт юм.

Хүснэгт №8.5. Аймгийн хил дэх усны томоохон сав газар ба голуудын тоо

№	Сав газрын нэр	Хөвсгөл аймаг (ширхэг)
1	Сэлэнгэ	73
2	Хөвсгөл-Эг	304
3	Дэлгэрмөрөн	129
4	Идэр	90
5	Увс нуур-Тэс	39

Хүснэгт №8.6. Усны сав газрын томоохон хэмжээний цутгал голууд

Сав газрын нэр	Томоохон цутгал голууд
Сэлэнгэ	Асгатын гол
	Шивэртийн гол
	Харганатын гол
	Бухын гол
	Галтайн гол
	Зоохын гол
	Оргихын гол
Хөвсгөл-Эг	Үүр гол
	Цагаан бургас гол
	Бургалтайн гол
	Эрингийн гол

	Тарвагатайн гол
Дэлгэр мөрөн	Агарын гол
	Бэлтэс гол
	Шаргын гол
	Бах гол
Идэр	Жаргалант гол
	Ямаатын гол
	Өвөр хожуулын гол
	Зартын гол
	Хөнжлийн гол
	Бүгдгээний гол
Увс-Тэс	Жарантайн гол
	Шавартайн гол
	Түргэний гол
	Боршоо гол
	Тээлийн гол
	Хөндлөн гол
	Хархираа гол

### 8.2.1. Усны сав газрын үндсэн гол горхи, нууруудын тодорхойлолт:

**Гол горхи:** Хөвсгөл аймагт гол горхи, булаг шанд эх авч 300 гаруй нуур тогтсоноор манай орны цэнгэг усны ундраа нөөц болж байна. 2013 онд хийгдсэн усны тооллогоор 1212 гол горхи бүртгэгдсэн ба үүнээс 1173 устай 39 ширгэсэн байна.

Төв Азид томоохонд тооцогддог Хөвсгөл нуурын баруун, зүүн бүс нутгаас Шарга, Тэнгис, Шишхэд, Хөг, Гуна, Бэлтэс, Арсай, Залуу-Үүр, Эг, Дэлгэрмөрөн, Хэвэн, Рашаант, Хөх, Дархинт, Халхан, Ариг, Уйлган зэрэг голууд эх авна. Харин нутгийн өмнөт хэсгээр Сэлэнгэ мөрөн, Тэс, Идэр, Чулуут голууд урсана.

**Эгийн гол:** Эг гол бол 7 дугаар эрэмбийн гол юм. Хөвсгөл нуураас эх авах боловч хаврын шар усны болон зуны хур борооны үерийн хэв шинжийн горимтой учир Үүр голыг Эг голын эх хэмээн үзнэ. Ус хурах талбай нь 38354.1 ам км, 509.5 км урт, 0.0016 хэвгий юм. Голдрилын дундаж өндөр 1140 м, ус хагалбарын шугамын урт 2545 км, түүний дундаж өндөр 1622.5 м, голуудын нийлбэр урт 13551.3 км, усан сүлжээний нягтшил 0.35 км/ам км, ус хурах талбайн дундаж өндөр 1624.0 м, хөндийн гүн дунджаар 482.5 м, түүний өргөн 75.3 км, сав газрын суналтын зэрэг 6.8, ус хагалбарын шугамын хөгжлийн зэрэг 3.6, хажуугийн хэрчигдэл 1.5, Хортоны хуулийн голын тоо, урт, ус хурах талбайн харьцаа 3.78, 2.42, 4.529 тус тус байна.

Эг голын усны жилийн дундаж өнгөрөлт Хатгал хотын орчим 23.8 шоо м/с байснаа Алаг-Эрдэнэд 9.13 шоо м/с, Эрдэнэбулганд 18.5 шоо м/с хүртэл буурч алдагдаж байхад Сантын нуруунаас эх авах Үүр голын жилийн дундаж өнгөрөлт Цагаан-Үүр сумын орчимд 21.5 шоо м/с байгаа нь түүнийг Эг голын эх гэж үзэх үндэс болно. Голын сав газарт навчит болон шилмүүст, холимог ой ихтэй. Голын ёроол хайрга чулуун хурдастай, зарим огцом уналттай хэсэгт харгиа боргио бий. Эг голын сав газрын хаврын шар усны үерийн хамгийн их хэмжээ, зуны хур борооныхоос бага бөгөөд хамгийн их хур борооны үер 1986 онд 2100 шоо м/с хүрчээ.

**Үүр гол нь:** Эгийн голын хамгийн том цутгалан. Монгол улсын хойт хязгаарт Хөвсгөл аймгийн Дорнод Саяаны нурууны салбар уулсаас эх авч урсах Залуу үүр, Хөгшин үүр голуудын уулзвараас эхлэн Үүр гол гэж нэрлэгдэх бөгөөд Хөвсгөл нуурын зүүн талын тэгш өндөрлөгийг дайран Цагаан-Үүр, Эрдэнэбулган сумын нутгаар урсах замдаа Хэвэн, Ялар, Цагаан, Хөх, Баян, Хойт Бургалтай, Ариг, Уйлган голуудыг өөртөө нийлүүлэн ой тайгын дундуур 331 км урт замыг туулж Эгийн голд цутгана. Ус хурах нийт талбай 12,300 км квадрат, үүр голын жилийн дундаж өнгөрөлт Цагаан-Үүр сумын орчимд 21.5 шоо м/с байгаа нь түүнийг Эг голын эх гэж үзэх үндэс болно. Голын өргөн дунджаар 70м, голын дундаж гүн 1.5-2м,

**Дэлгэрмөрөн гол нь** бол 6 дугаар эрэмбийн гол юм. Хөвсгөлийн Улаантайгын нурууны өвөр хажуугаас эх авах ба 439.7 км урт, 18670.6 ам км ус хурах талбайтай, 0.0035 хэвгий юм. Голдрилын дундаж өндөр 1335 м, ус хагалбарын шугамын урт 1362.9 км, түүний дундаж өндөр 2231.5 м, голуудын нийлбэр урт 8002.3 км, усан сүлжээний нягтшил 0.43 км/ам км, ус хурах талбайн дундаж өндөр 1921 м, хөндийн гүн дунджаар 896.5 м, түүний өргөн 42.5 км, сав газрын суналтын зэрэг 10.4, ус хагалбарын шугамын хөгжлийн зэрэг 2.8, хажуугийн хэрчигдэл 1.0, Хортоны хуулийн голын тоо, урт, ус хурах талбайн харьцаа 4.45, 2.81, 5.188 тус тус байна.

Сав газрын эх ихээхэн хэрчигдэлтэй, адагтаа тэгш намхавтар уулсын дундуур урсана. Голын эхээр ойт-хээр, адгаар хээрийн ургамал зонхилно. Голдрилын ёроолын хурдас голын эхэнд үхэр чулуу, хайрга адагт элсэрхэг юм. Дэлгэрмөрний сав газрын онцлог бол шохойн чулуулаг массив нилдээ тархсан учир урсацын алдагдал ихтэй, гачиг үеийн урсац бусад голуудынхаас ахиу байдагт оршино. Дэлгэрмөрөний хамгийн их үерийн өнгөрөлт 1986 оны 6 дугаар сарын 27-ны өдөр 1980 шоо м/с хүрчээ.

**Идэр гол нь:** бол 7 дугаар эрэмбийн гол юм. Энэ нь Хангай нурууны баруун хойт хажуу Отгонтэнгэр уулын араас эх авах ба 22419.9 ам км ус хурах талбайтай, 465 км урт урсахдаа Суман, Чулуут зэрэг том жижиг голыг нийлүүлнэ. 0.0047 дундаж хэвгийтэй юм. Голдрилын дундаж өндөр 1588 м, ус хагалбарын шугамын урт 1262.1 км, түүний дундаж өндөр 1588.0 м, голуудын нийлбэр урт 22230.3 км, усан сүлжээний нягтшил 0.99 км/ам км, ус хурах талбайн дундаж өндөр 1780 м, хөндийн гүн дунджаар 329.0 м, түүний өргөн 48.2 км, сав газрын суналтын зэрэг 9.7, ус хагалбарын шугамын хөгжлийн зэрэг 2.4, хажуугийн хэрчигдэл 6.0, Хортоны хуулийн голын тоо, урт, ус хурах талбайн харьцаа 3.86, 2.45, 4.34 тус тус байна.

**Шишхэд гол нь:** Хөвсгөлийн уулсын Улаан тайгын нуруу, Доод Тайгасын өмнөд хэсэг Ёлт уулын хажуугийн Гуна голоос эх авч Улаан-Уул, Ренчинлхүмбэ сумын хилийн зааг Хоёр гол, Багтахын голын уулзвараас эхлэн Шишхэдийн гол гэж нэрлэгдэх бөгөөд Ренчинлхүмбэ сумын баруун зах Дархадын хотгороор Дээд, Доод цагаан нуурын усыг дамжин Улаан Тайгын нурууны хойт хэсгээр Зүрх, Их-Уул, Овоот уулын бэлээр урсч Цагааннуур сумын хил даван баруун зүг Хойт, Урд Агаягийн уулсын дундуур урсаж Улаан-Уул, Цагааннуур сумдын хилийн заагийг даган урсаар улсын хил даван Енисей

мөрөнтэй нийлнэ. Шишхэд голын нийт урт 341 км, сав газрын голын сүлжээний нийт урт 11354.3 км, урсацын хэмжээгээр 7-р эрэмбэ буюу дунд эрэмбийн голд хамаарна.

Ус хурах талбай нь 19932.9 ам км, хэвгий 0.006, жилийн дундаж өнгөрөлт 16.0 шоо м/с болно. Гольдрилын дундаж өндөр 1539 м, ус хагалбарын шугамын урт 1009.0 км, түүний дундаж өндөр 2217.0 м, голуудын нийлбэр урт 11354.3 км, усан сүлжээний нягтшил 0.57 км/ам км, ус хурах талбайн дундаж өндөр 2200.0 м, хөндийн гүн дунджаар 678.0 м, түүний өргөн 58.4 км, сав газрын суналтын зэрэг 5.8, ус хагалбарын шугамын хөгжлийн зэрэг 2.0, хажуугийн хэрчигдэл 1.7, Хортоны хуулийн голын тоо, урт, ус хурах талбайн харьцаа 3.73, 2.40, 4.198 тус тус байна.

Шишхэдийн голд Монгол шарын давааны өврөөс эх авдаг Тэнгис, бусад уул нуруудаас эх авдаг Гуна, Бахта, Хөг, Бүс, Шарга, Ходон, Арсай зэрэг томоохон голуудын усан хагалбараас гадна Жаваш, Их жамс, Нуурт бяран, Гадар өөс, Их өл, Хагаргын, Жаргалант, Ар хорьдол, Баян, Шаварт татуур зэрэг уулсын амаас эх авах олон гол, горхиуд Шишхэд голыг усжуулна.

**Тэнгис гол нь:** Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын нутаг, Монгол орны нутгийн хамгийн хойд цэг болох Монгол Шарын давааны өврөөс эх авч уулс зэрэг тайга, өндөр уулсын дундуур урсаж нийтдээ 80 гаруй км үргэлжилсээр Ренчинлхүмбэ сумын хилийг даван Шишхэдийн голд цутгадаг. Голын уртыг газар зүйн мэдээллийн системийн аргаар 1:100000 масштабтай зураг дээр тооцоход ус хагалбарын нийт урт 8,5 км байна.

Хөлтөс тошимын гол, Тээртуурагийн гол нийлж Тэнгис гол бүрэлддэг бөгөөд Халбагтаг, Жараалал, Тулэгтаг, Хар ус, Онголгой, Орхашиг зэрэг бусад жижиг голууд цутгана. Хөлтөс тошимын голд Тошим, Хэлтэс, Хорхойт, Цагаан, Шарлаг ойн голууд, Тээртуурагийн голд Дээд сайлаг, Урд хэрхэй зэрэг жижиг голууд цутгана.

Тэнгис болон Шишхэд голын усан хагалбар бүхий ян сарьдаг, өндөр уулын тундр, нугат хээр, тайга хосолсон ландшафтыг хамгаалах, унаган төрхөөрөө байгаа үзэсгэлэнт байгаль, нутгийн уугуул иргэдийн амьдралын өвөрмөц хэв маяг, заншилд тулгуурласан байгалийн аялал, жуулчлалыг хөгжүүлж орон нутгийн хөгжлийг дэмжих, түүнчлэн нөөц, байршил нь ихээхэн хомсдож буй ан амьтдын амьдрах орчныг хамгаалах зорилгоор Тэнгис, Шишхэд болон Шаргын голын сав газар бүхий Цагааннуур, Ренчинлхүмбэ, Улаан Уул сумдын нутагт дэвсгэр хамаарах 875.7 мян.га газрыг 2011 оны УИХ-ын 18-р тогтоолоор байгалийн цогцолборт газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтанд авсан.

**Шаргын гол нь:** Цагааннуур сумын нутаг, Дорнод Саяаны нуруунаас эх авч урсах Доод Ухаа Хэм, Баргалтайн голууд нийлж Шаргын гол болох бөгөөд Урд гурван авандай, Зэрлэг уулын дундуур урсаж зүүн урагш чиглэн Цагааннуур, Ренчинлхүмбэ сумын хилийн цэс Шаргын Ганц уулын баруун талаар уруудаж Нарийн талыг дайран Дархадын хотгорт орон Талын нуур, Хайрхал нуур зэрэг олон жижиг нуурыг дамжин Доод Цагаан нуурт цутгана. Голын сүлжээний нийт урт 351 км, Шаргын голд Ухаа Хэм, Баргалтай, Утраг, Жарай голууд цутгана.

**Хөгийн гол нь:** Улаан-Уул сумын нутаг, Улаан тайгын нурууны зүүн хойд, Дунд тайгасын нурууны баруун урд хэсгийн уулсаас эх авч хойд зүг Хөгийн давааны зүүн бэл

хүрч баруун тийш Дунд тайгасын нурууны хойд талаар тайгын дундуур урссаар Шүүрэгтийн талын хөндийг дайрч Улаан-уул, Ренчинлхүмбэ сумын хилийн цэс Дээд цахир уулын баруун үзүүр хүрч, Ренчинлхүмбэ сумын баруун урдаас зүүн хойд зүг чиглэн Дархадын хотгор орж Шишхэд голд цутгах бөгөөд голын сүлжээний нийт урт 186 км орчим. Хөгийн голд Үхэрт, Тайгасын, Буурал зэрэг голуудын хагалбар болон бусад жижиг гол, горхи цутгана.

**Арсай гол нь:** Ренчинлхүмбэ сумын нутаг, Хорьдол сарьдагийн нуруу, Хорьдолын давааны өвөр бэлээс эх авч зүүн, зүүн хойд зүг рүү чиглэн Уран Дөш, Хар Ус, Хар Чулуут Нуурын баруун бэлээр уруудаж Жиглэгийн даваа хүрч баруун хойд урссаар Дархадын хотгор орж Бургаст, Цагаан Морьт нуурын усыг дамжин Шишхэд голд цутгана. Арсай голд Усан хужир, Их хар, Ар хачимын, Ар хар ус, Их цагаан, Баянцагаан, Монголын яст зэрэг голууд цутгах бөгөөд голын сүлжээний нийт урт 214,6 км.

**Нуур, тойром.** Дархадын хотгорын олон нуураас хамгийн том нь 50 га талбай бүхий Доод Цагаан нуур юм. Улаан тайгын нуруунд Тайж нуур, Барлин зэрэг том жижиг олон нуур байдаг. Аймгийн өмнөт, төв, баруун хэсгээр Сангийн далай, Эрхэл, Ачмаг, Цэнгэл, Гандан, Жугнай, Тунамал, Төх, зэрэг нууруудтай. Эдгээрээс хамгийн том нь Сангийн далай нуур нь 18800 га талбайтай, 12 м гүн юм. 2013 оны аймгийн гадаргын усны судалгаанд 578 нуур тойром бүртгэгдсэн ба үүнээс ширгэсэн үзүүлэлт байхгүй бүгд устай байна.

## Хүснэгт№8.7. Нууруудын судлагдсан байдал

Дугаар, индекс	Нууруудын нэр	Үнэмлэхүй өндөр /м	Галаргын талбай /км	Урт /км	Өргөн /км/		Гүн /м/		Усны эзэлхүүн /км <sup>3</sup>	Эргийн шугам		Ус хураах талбай /км <sup>2</sup> /	Морфометрийн үзүүлэлтүүд			Ерөнхий эрдэскилт г/л
					Дундаж	Их	Дундаж	Их		Урт /км	Хөгжлийн коэффициент /енг		Авсаарга зэрэг	Хэлбэр, суналын зэрэг	Харьлах талбай	
1	Арт нуур	1983	0.7	1.6	0.4	0.7				4.6	1.551	18.5	0.63	2.29	26.5	4.130
2	Жошмог нуур	1835	1.8	3.0	0.6	0.8	0.9	2.2	0.0016	4.2	1.000	135.0	0.75	3.75	75.0	0.380
3	Хурсын хар нуур	2013	1	1.3	0.7	1.2	1.6	4.0	0.0020	3.6	1.016	21.0	0.64	1.08	21.0	
4	Пүлхэрлэг нуур	2000	0.7	1.8	0.4	0.9				4.6	1.551	60.0	0.35	2.00	85.7	
5	Ганц өлөн хар нуур	1820	1.9	1.9	1.0	1.2				4.8	1.000	20.5	2.28	1.58	10.7	
6	Уушиг нуур	1780	1.2	2.0	0.6	0.9				4.4	1.133	13.0	0.67	2.22	10.8	
7	Бургаст нуур	1539	0.6	1.5	0.4	1.1	1.7	4.00	0.0006	4.0	1.457	15.0	0.36	1.36	25.0	
8	Модот нуур	1550	0.7	1.0	0.7	1.0	1.2	3.5	0.0008	3.2	1.079		0.70	1.00		
9	Тахир нуур	1550	0.7	1.1	0.6	1.0	2.1	4.5	0.0014	3.4	1.146	20.0	0.64	1.10	28.5	
10	Дарьхинт нуур	1550	1.1	1.7	0.6	1.1	2.2	5.0	0.0011	6.0	1.615	3.7	0.59	1.50	3.3	
11	Цойцон /цэйцэн/ нуур	1550	0.6	1.4	0.4	0.8	1.4	3.0	0.0019	3.8	1.384		0.54	1.75		
12	Шар нуур	2200	0.8	2.3	0.3	0.7	3.5	8.0	0.0028	5.2	1.670	45.0	0.50	3.29	56.0	
13	Онон нуур	1800	0.5	1.6	0.3	0.6	0.7	1.9	0.0006	3.6	1.437	8.5	0.52	2.67	17.0	
14	Хангайн хар нуур	1950	0.7	1.9	0.3	0.7				4.2	1.416	19.6	0.53	2.71	28.0	
15	Цагаан нуур	1540	1.3	1.7	0.7	1.3	1.0	2.2	0.0013	5.4	1.337		0.59	1.31		0.175
16	Цагаан морьт /хулст/ нуур	1540	4	3.9	1.0	1.9	1.4	3.6	0.0056	13.4	1.891	40.0	0.54	2.05	10.0	0.173
17	Дүүрэн жаргалант нуур	1543	3.8	3.5	1.0	1.6	1.6	4.0	0.0003	12.2	1.766	29.0	0.63	2.19	7.7	
18	Дээд цагаан нуур	1550	2.7	2.9	0.9	1.9	0.7	2.0	0.0019	9.4	1.631		0.49	1.53		0.265
19	Бургаст нуур	1540	2.3	2.9	0.8	1.4	2.0	4.5	0.0046	8.0	1.489		0.57	2.07		
20	Цойцон /цацын/ нуур	1539	7.5	4.3	1.7	4.1	1.4	3.0	0.0070	20.2	2.081	630.0	0.43	1.05	84.0	
21	Ногоон нуур	1540	1.2	1.8	0.7	1.2	1.2	2.8	0.0014	4.8	1.236		0.56	1.50		
22	Эмт нуур	1540	5	3.8	1.2	2.3	1.1	2.5	0.0060	14.4	1.894	18.0	0.53	1.65	3.6	
23	Мунгариг /мөнгөрөг/ нуур/	2260	0.9	2.8	0.3	0.7				5.8	1.725	95.0	0.46	4.00	105.6	
24	Шар гэрт нуур	2160	50.9	1.3	0.3	0.6	1.7	3.5	0.0008	3.0	1.197	110.0	0.64	2.17	55.0	
25	Тайж нуур	2330	7.5	5.8	1.3	2.9	6.0	12.0	0.0050	19.6	2.019	115.0	0.45	2.00	15.3	
26	Эрхэл нуур	1544	13.2	5.0	2.6	5.0	0.9	4.5	0.0320	14.4	1.118	390.0	0.53	1.00	29.5	22.500
27	Цэнгэл нуур	1488	4.1	3.3	1.2	1.8	3.5	7.7	0.0140	9.0	1.254	110.0	0.69	1.83	26.8	
28	Булган нуур	1998	2.3	2.6	0.9	1.4	0.6	1.5	0.0013	8.2	1.526	48.5	0.63	1.86	21.0	
29	Улаан нуур	1807	0.7	1.8	0.4	1.0	1.2	3.0	0.0021	4.4	1.483	350.0	0.39	1.80	500.0	
30	Цагаан нуур	1767	0.5	1.4	0.3	0.6	0.9	2.0	0.0005	3.2	1.277	19.0	0.60	2.33	9.5	
31	Хунт нуур	1767	0.5	1.1	0.4	0.6	2.7	5.0	0.0029	2.8	1.117		0.76	1.83		
32	Ачмаг нуур	1583	1.8	2.4	0.8	1.3	1.1	2.5	0.0019	5.6	1.178	85.0	0.58	1.85	47.2	39.880
33	Ногоон нуур	1808	1.4	2.2	0.6	0.7	0.7	1.9	0.0009	5.2	1.240	15.0	0.91	3.14	10.7	



34	Гандан нуур	1988	.6	4.0	2.4	4.0	4.8	9.5	0.0448	14.4	1.310	60.0	0.60	1.00	6.2	0.230
35	Зүүн нуур	2006	17.5	7.0	2.6	3.8	8.3	17.6	0.1460	26.5	1.780	190.0	0.66	1.84	10.9	3.202
36	Жугнай нуур	1997	27	11.5	2.3	6.5	5.4	9.5	0.1426	35.0	1.900	214.0	0.36	1.77	7.9	7.450
37	Тунамал нуур	1874	20.2	7.2	2.7	5.0	5.5	9.9	0.1120	36.6	2.280	302.3	0.56	1.44	15.1	1.060
38	Доод цагаан нуур	1538	31.3	17.5	2.4	5.6	4.7	17.0	0.2035	63.0	2.760	11593.0	0.42	3.12	661.4	0.146
39	Сангийн далай нуур	1858	165	32.0	5.0	13.0	12.0	30.0	1.9950	127.0	2.790	2710.0	0.39	2.46	16.4	3.76-3.99
40	Тарган шарга нуур	1538	19.5	7.5	2.6	4.6	2.8	5.5	0.0544	26.9	1.720	171.3	0.51	1.63	8.7	0.207
41	Уст нуур	1123	1	2.0	0.5	0.8	1.7	2.5	0.0014	4.2	1.185		0.63	2.56		
42	Хар нуур	2170	0.9	1.2	0.7	1.2				3.6	1.071	12.3	0.63	1.00	13.6	
43	Цармын нуур	2380	1	2.4	0.5	0.6	4.0	9.1	0.0004	5.8	1.637	35.0	0.69	4.00	35.0	
44	Гунайн эхний нуур	2500	1.8	2.2	0.8	0.9				6.4	1.346	20.0	0.91	2.44	11.1	
45	Дуут нуур	2180	0.6	1.5	0.4	0.5	1.8	5.1	0.0010	3.4	1.238	22.0	0.80	3.00	36.6	
46	Шашлиг нуур	2220	0.5	1.4	0.3	0.4				3.0	1.970	18.0	0.89	3.50	36.0	
47	Агуйт нуур	2260	1.4	3.0	0.4	0.5	4.0	7.6	0.0006	6.8	1.000	30.0	0.93	6.00	21.4	
48	Хуулагат /хөлөгт/ нуур	2002	0.7	2.3	0.3	0.7				5.2	1.752	55.0	0.41	3.29	78.5	0.045
49	Урд нуур	1550	0.6	1.7	0.3	0.5	2.5	4.6	0.0042	4.0	1.457		0.85	3.40		
50	Хармайн зүүн нуур	1660	1.1	2.6	0.4	0.6	1.2	3.0	0.0013	6.2	1.668	26.0	0.71	4.33	23.6	
51	Түрүүн нуур	1550	2.4	2.3	1.0	1.1	3.5	7.0	0.0084	5.0	1.000		0.95	2.09		
52	Бөөрөг нуур	1570	1.2	2.0	0.6	1.2	1.8	4.0	0.0021	5.0	1.288		0.50	1.67		
53	Холбоо цагаан нуур	1550	1.6	2.6	0.6	1.0	0.6	2.1	0.0009	6.2	1.383		0.62	2.60		
54	Цэцэгт нуур	1550	1.5	1.9	0.8	1.3	1.1	2.6	0.0016	6.0	1.382		0.61	1.46		
55	Зуун модот нуур	2050	0.5	1.1	0.4	1.0				3.2	1.277	21.0	0.91	1.10	42.0	
56	Лам тайгын нуур	2160	1.2	1.9	0.6	0.9				4.8	1.236	80.0	0.70	2.11	66.6	
57	Заяат /хурган/ нуур	1580	0.5	1.1	0.4	0.9	0.8	2.1	0.0004	2.8	1.117		0.51	1.22		
58	Урд цармын нуур	1920	0.5	1.0	0.5	0.8				2.8	1.117	25.0	0.60	1.25	50.0	
59	Салт нуур	2001	0.5	1.2	0.4	1.0	1.2	3.0	0.0006	3.2	1.277	8.0	0.42	1.20	4.0	
60	Гашуун нуур	2100	0.5	1.2	0.4	0.7				3.0	1.197	30.0	0.60	1.71	15.0	
61	Дээд нуур	1908	0.5	1.0	0.5	0.8	0.9	2.3	0.0005	3.4	1.357		0.63	1.25		
62	Дэлгэр нуур	2132	0.7	2.1	0.3	0.5				4.6	1.551	35.0	0.67	4.20	24.5	
63	Чулуут нуур	1540	0.5	1.3	0.4	0.7	2.0	4.5	0.0010	4.8	1.915		0.55	1.86		
64	Урд нуур	2160	0.5	1.3	0.3	0.4				2.8	1.117	10.0	0.96	3.25	5.0	
65	Их ханзарлагийн нуур	2250	0.5	1.5	0.3	0.4				3.0	1.197	15.0	0.71	3.75	30.0	
66	Агуйтын доод нуур	2260	0.5	1.4	0.3	0.4				3.0	1.197	16.0	0.89	3.50	32.0	
67	Зүүн тошдог нуур	2260	0.6	1.9	0.3	0.7	1.5	4.1	0.0009	4.4	1.602	18.0	0.45	2.71	30.0	
68	Бага сарьдагийн нуур	2030	0.5	1.0	0.5	0.7				3.4	1.357	45.0	0.71	1.43	90.0	
69	Баруун хуулагт нуур	2050	0.7	1.5	0.4	1.2				4.2	1.416	23.0	0.39	1.25	32.8	
70	Ар тайгын нуур	1987	0.5	1.1	0.4	0.7				2.8	1.117		0.65	1.57		
71	Бөөрөгт нуур	1542	0.7	1.0	0.7	0.7	1.6	3.0	0.0011	3.2	1.079	60.0	1.00	1.43	85.7	
72	Бага бөөрөгт нуур	1538	0.5	0.8	0.6	0.7	1.4	3.0	0.0007	2.2	1.000	75.0	0.89	1.14	150.0	

73	Онгой нуур	1550	0.5	1.7	0.3	0.5	1.0	2.0	0.0002	4.0	1.457		0.85	3.40		
74	Тайгасын зүүн нуур	2200	1.5	3.8	0.4	0.8	1.5	4.2	0.0023	8.4	1.935	85.0	0.49	4.75	56.6	
75	Гэрт нуур	2200	0.6	1.2	0.5	0.9				3.0	1.092	70.0	0.56	1.33	116.6	
76	Дээд нуур	2140	0.5	1.2	0.3	0.4				2.8	1.117	10.0	1.04	3.00	5.0	
77	Нэргүй нуур	2219	0.6	1.5	0.4	0.5	2.1	5.2	0.0002	3.4	1.238	30.0	0.80	3.00	50.0	
78	Ёлтын хар нуур	2460	0.5	1.3	0.4	0.5				3.2	1.277	15.0	0.77	2.60	7.5	
79	Сарьдагийн цуваа	2340	0.5	1.1	0.4	0.7				2.8	1.117	35.0	0.65	1.57	17.5	
80	Тагийн нуур	2339	0.5	1.4	0.3	0.8				3.4	1.357	55.0	0.45	1.57	27.5	
81	Тагийн хаг нуур	2226	0.5	1.0	0.5	0.8				2.8	1.117	18.0	0.63	1.25	9.0	
82	Ёлтын өмнөд хар нуур	2360	0.5	1.6	0.3	0.8				3.0	1.197	20.0	0.39	2.00	10.0	
83	Цагаан нуур	1700	0.9	1.3	0.6	1.0	1.2	2.7	0.0002	4.2	1.249		0.69	1.30		
84	Холбоо нуур	2036	0.6	1.2	0.5	1.0				3.8	1.384	19.0	0.50	1.20	31.6	
85	Хага нуур	1161	0.6	1.8	0.3	0.8	1.2	2.0	0.0007	3.2	1.165		0.42	2.25		
86	Тасархайн нуур	1550	0.5	1.3	0.3	0.6	1.9	4.0	0.0009	3.0	1.197		0.64	2.17		
87	Цэцэгт нуур	1550	0.6	1.3	0.4	0.8	1.6	3.5	0.0020	3.6	1.311		0.58	1.63		
88	Хашаат нуур	1540	0.7	1.5	0.5	0.8	2.0	4.1	0.0014	4.0	1.349		0.58	1.88		
89	Тагийн нуур	2420	0.5	1.3	0.4	0.8				3.0	1.197	17.0	0.48	1.63	8.52	
90	Тайгасын цуваа	2375	1.5	2.8	0.5	0.8				7.6	1.751	30.0	0.43	3.50	20.0	
91	Их нуур	2400	2.7	4.0	0.7	2.0				9.2	1.580	25.0	0.34	2.00	9.3	
92	Тэргүүн нуур	1785	0.8	1.5	0.5	0.9	0.6	1.7	0.0005	4.2	1.325	36.0	0.59	1.67	45.0	
93	Хөвсгөл нуур	1645	2760	136.0	20.3	36.5	138.0	262.4	380.7000	414.0	2.230	4920.0	0.56	3.73	1.8	

### **8.2.2. Хөвсгөл аймгийн 0.5 км<sup>2</sup>-аас дээш талбайтай нуур тусбүрийн товч тайлбар, тодорхойлолт**

**1. Арт нуур:** Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын нутагт Тэнгис голын савд 1883 м өндөрт байдаг мөстлийн гаралтай гадагш урсгатай цэнгэг нуур. 0.7 км<sup>2</sup> талбайтай, 1.6 км урт, 0.7 км өргөн, эргийн шугамын урт 4.6 км. Гадаргын ба гүний усаар сэлбэгддэг. Загас жараахай элбэг байдаг.

**2. Жошмог нуур:** Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын нутагт Тэнгис голын савд 1835 м өндөрт байдаг мөстлийн гаралтай гадагш урсгалтай цэнгэг нуур. 11.8 км<sup>2</sup> талбайтай, 3.0 км урт, эргийн шугамын урт 4.2 км. Усны температур 7 дугаар сард 17.1°C-18.6°C, ёроолдоо мөстөлийн хурдас, бул чулуутай.

**3. Хурсын хар нуур:** Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын нутагт Тэнгис голын савд 2013 м өндөрт байдаг мөсөн голын гаралтай цэнгэг нуур. 1.0 км<sup>2</sup> талбайтай, 1.3 км урт, 1.2 км өргөн, эргийн шугамын урт 3.6 км. Орчны байгаль нэн үзэсгэлэнтэй.

**4. Пүлхэрлэг нуур:** Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын нутаг Шишихид голын цутгал Их Сариг голын савд 2020 м өндөрт байдаг мөстлийн гаралтай цэнгэг нуур. 0.7 км<sup>2</sup> талбайтай, 1.8 км урт, эргийн шугамын урт 4.6 км. Орчинд нь эртний мөстөлийн хурдас тархдаг.

**5. Ганц өлөн хар нуур:** Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын нутагт Тэнгис, Дэрт-Уураг голын бэлчирт 1820 м өндөрт байдаг мөстлийн гаралтай цэнгэг нуур. 1.9 км<sup>2</sup> талбайтай, 1.9 км урт, эргийн шугамын урт 4.8 км. Хур бороо гадаргын усаар тэжээгддэг.

**6. Уушиг нуур:** Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын нутагт Тэнгис голын хөвөөнд 1780 м өндөрт байдаг морены гаралтай нуур. 1.2 км<sup>2</sup> талбайтай, 2.0 км урт, эргийн шугамын урт 4.4 км.

**7. Бургаст нуур:** Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын нутагт Дархадын хотгорт 1539 м өндөрт байдаг гадагш урсгалгүй термокарстын гаралтай цэнгэг нуур. 0.6 км<sup>2</sup> талбайтай, 1.5 км урт, эргийн шугамын урт 4.0 км. Эргэн тойронд намаг балчиг ихтэй. Төрөл бүрийн загас, нүүдлийн шувууд байршдаг.

**8. Модот нуур:** Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын нутагт Дархадын хотгорын Тарган нуурын өмнө 1500 м өндөрт байдаг термокарстын гаралтай нуур. 0.7 км<sup>2</sup> талбайтай, 1.0 км урт, эргийн шугамын урт 3.2 км орчим. Ёроолд нь мөстөлийн зузаан хурдастай усны температур 17°-18°C, 10,11 дүгээр сард хөлддөг. Загас элбэгтэй.

**9. Тахир нуур:** Хөвсгөл аймгийн Дархадын хотгорт Тарган нуурын ойролцоо 1550 м өндөрт байдаг термокарстын гаралтай цэнгэг нуур. 0.7 км<sup>2</sup> талбайтай, 1.0 км урт, эргийн шугамын урт 3.4 км.

**10. Дарьхинт нуур:** Хөвсгөл аймгийн Дархадын хотгорт 1550 м өндөрт байдаг термокарстын гаралтай цэнгэг нуур. 1.1 км<sup>2</sup> талбайтай, 1.7 км урт, 1.1 км өргөн, эргийн шугамын урт 6 км.

**11. Цойдон /Цэйцэн/ нуур:** Хөвсгөл аймгийн Дархадын хотгорт 1550 м өндөрт байдаг гадагш урсгалтай нуур. 0.6 км<sup>2</sup> талбайтай, 1.4 км урт, эргийн шугамын урт 3.8 км.

Гадаргын ба гүний усаар сэлбэгддэг. Төрөл бүрийн загастай, усны температур 7 дугаар сард 18.6°-аас хэтэрдэггүй.

**12. Шар нуур:** Хөвсгөл аймгийн Ханх, Хороо голын хооронд Хөвсгөл хуураас хойш 2200 м өндөрт байдаг мөстлийн гаралтай хэт цэнгэг үзэсгэлэнт нуур. 0.8 км<sup>2</sup> талбайтай, 2.3 км урт, 0.7 км өргөн, эргийн шугамын урт 5.2 км, гүн нь 8 м. Жаргалант голоор Хөвсгөл нууртай холбогдоно. Усны температур 7 дугаар сард 15.1°С-16.8°С, 10 дугаар сараас 5 дугаар сард хөлддөг. Ёроолдоо лаг наанги шавар, элс хайрга усны ургамалтай. Ерөнхий эрдэсжит 30.27 мг/л, гидрокарбонит /16,78мг/л/, сульфат /4.10 мг/л/ зонхилно. Умард мөсөн далайн загас жараахай элбэг байдаг. Байгалийн байдал нэн үзэсгэлэнтэй. Аялал – жуулчлал, ангуур – спортод нэн тохиромжтой.

**13. Онон нуур:** Хөвсгөл аймгийн Хөвсгөл нуурын хойд талд нуураас 3-4 км зайд 1800 м өндөрт байх хаягдал цэнгэг нуур. 0.6 км<sup>2</sup> талбайтай, 1.6 км урт, эргийн шугамын урт 3.6 км.

**14. Хангайн хар нуур:** Хөвсгөл аймгийн Хөвсгөл нуураас зүүн тийш Хивэн-залуу-үүрийн Сарьдагийн баруун сугад 1950 м өндөрт байдаг цэнгэг нуур. 0.7 км<sup>2</sup> талбайтай, 1.9 км урт, эргийн шугамын урт 4.2 км.

**15. Цагаан нуур:** Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын нутагт Дархадын хотгорын Шишихид голын далайн загас элбэг.

**16. Дүүрэн Жаргалант нуур:** Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ, Улаан уул сумдын заагт Хөөгийн голын адагт 1543 м өндөрт байдаг цэнгэг нуур. 3.8 км<sup>2</sup> талбайтай, 3.5 км урт, эрэг нь их хэрчигдсэн, эргийн шугамын урт 12.2 км, усны температур 7.8 дугаар сард 12.6°-13.4°С, ёроолд нь мөстөлийн эрэгт 1540 м өндөрт байдаг гадагш урсгалгүй хаягдал цэнгэг нуур. 3 км<sup>2</sup> талбайтай, 1.7 км урт, эргийн шугамын урт 5.4 км. Гадаргын ба гүний усаар сэлбэгддэг.

**15. Цагаан морьт /Хулст/ нуур:** Хөвсгөл аймгийн Дархадын хотгорт 1540 м өндөрт байдаг гадагш урсгалтай цэнгэг нуур. 4 км<sup>2</sup> талбайтай, 2 км урт, 1.2 км өргөн, эргийн шугамын урт 5 км. Нүүдлийн шувууд, умард мөсөн нарийн мөхлөгт зузаан тунамал хурдастай. Загас жараахай, нүүдлийн шувууд элбэг байдаг.

**17. Дээд Цагаан нуур:** Хөвсгөл аймгийн Улаан Уул, Ренчинлхүмбэ сумын нутгийн заагт Хөөг, Шишихид голын хөндийд 1550 м өндөрт байдаг урсгал нуур 2.7 км<sup>2</sup> талбайтай, 2.9 км урт, 1.9 км өргөн элдэв хэлбэртэй, эргийн шугамын урт 9.4 км, усны гүн 3.6 м. Нуурт хоёр түрүү гэдэг булаг нийлж цутгадаг. Усны температур 7 дугаар сард 12.8°С-13.6°С, ёроолд нь эртний мөстөлийн цайвар саарал лаг шавар элдэв ургамал ургадаг. Усан хоолой гэдэг өргөн хоолойгоор Шишихид голтой холбогддог, цэнгэг устай, ерөнхий эрдэсжилт 266.9 мг/л гидрокарбонат сульфатын төрлийн устай. Дархадын Цагаан зэрэг загастай. Нүүдлийн шувууд хуран цуглардаг.

**18. Бургаст нуур:** Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын нутаг Шишихид голын гольдролд 1540 м өндөрт байдаг үлдэгдэл нуур. 2.3 км<sup>2</sup> талбайтай, 2.9 км урт, 1.4 км өргөн, эргийн шугамын урт 8 км. Усны температур 7 дугаар сард 12.6-13.8°С, ёроолдоо

мөстөлийн лаг наанги зузаан хурдас, усны ургамалтай. Гадаргын ба гүний усаар сэлбэгддэг. Төрөл бүрийн загастай.

**19. Цойцон /цацын/ нуур:** Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын нутаг Шишихид голын хөндийд 1539 м өндөрт байдаг хаягдал нуур. 7.5 км<sup>2</sup> талбайтай, 4.3 км урт, өргөн, дугуй хэлбэртэй, эргийн шугамын урт 20.2 км, 3 м гүн. Хотон гол цутгаж гардаг. Ёроолдоо лаг, наанги шавар, усны ургамалтай. Загас элбэг байдаг.

**20. Ногоон нуур:** Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын нутаг Шишихид голын савд 1540 м өндөрт байдаг хаягдал нуур. 1.2 км<sup>2</sup> талбайтай, 1.8 км урт, 1.2 км өргөн, эргийн шугамын урт 4.8 км.

**21. Эмт нуур:** Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын нутагт Ногоон, Бургаст нуурын ойролцоо

1540 м өндөрт байдаг гольдролын нуур. 5.0 км<sup>2</sup> талбайтай, 3.8 км урт, 2.3 км өргөн, эргийн шугамын урт 14.4 км, гүн 2.5 м, эзлэхүүн 6 сая м<sup>3</sup>. Ёроолдоо лаг, наанги шавартай, гадагш урсгал цэнгэг устай. Загс жараахай, нүүдлийн шувууд элбэг байдаг.

**22. Мунгариг /мөнгөрөг/ нуур:** Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын нутаг Улаантайгын нуруунд 2260 м өндөрт байдаг мөстөлийн гаралтай цэнгэг нуур. 0.9 км<sup>2</sup> талбайтай, 2.8 км урт, 0.7 км өргөн, эргийн шугамын урт 5.8 км.

**23. Шар гэрт нуур:** Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын нутагт Улаан тайгын нуруунд 2160 м өндөрт байдаг гадагш урсгалтай мөстөлийн гаралтай цэнгэг нуур. 0.5 км<sup>2</sup> талбайтай, 1.3 км урт, эргийн шугамын урт 4.8 км.

**24. Тайж нуур:** Хөвсгөл аймгийн Улаан-Уул мутын нутаг Улаан тайгын нуруунд 2330 м өндөрт байдаг мөстөлийн гаралтай нуур. 7.5 км<sup>2</sup> талбайтай, 5.8 км урт, 2.9 км өргөн, эргийн шугамын урт 19.6 км. Олон гол горхи цутгаж Дэлгэр Мөрөн гол эндээс эх авдаг, нэн цэнгэг устай, загас жараахай элбэг.

**25. Эрхэл нуур:** Хөвсгөл аймгийн Арбулаг сумын нутаг Бүрэнхаан уулын арын тектоник хотост 1544 м өндөрт байдаг гадагш урсгалгүй шорвог нуур. 13.2 км<sup>2</sup> талбайтай, 5 км урт, өргөн, эргийн шугамын урт 14.4 км, усны гүн нь 4.5 м, эзлэхүүн 25.1 сая м<sup>3</sup>. 0-2 м гүн талбайн 44.4 хувь, эзлэхүүний 10.5 хувийг эзэлдэг, усны температур нь 7,8 дугаар сард өнгөндөө 18.3°C-20°C, 3 м гүнд 17.5°, 4 м гүнд 19.2°C, хүчилтөрөгчийн хангамж өнгөндөө 8.8, 2 м гүнд 8.2, ёроолдоо 6.4 мг/л, усны эрдэсжилт 22.5 г/л болж сульфатхлор ангийн натри магнийн төрөлд багтдаг. Ёроолд нь лаг, наанги шавар, элс хайрга, давсан хурдас хуримтлагддаг. Нуурын шүүг малын эрдэс тэжээлд орон нутгийн чанартай ашигладаг.

**26. Цэнгэл нуур:** Хөвсгөл аймгийн Түнэл сумын нутагт 1488 м өндөрт байдаг гадагш урсгалгүй тектоник гаралтай шорвог нуур. 4.1 км<sup>2</sup> талбайтай, 3.3 км урт, 1.8 км өргөн, эргийн шугамын урт 9 км.

**27. Булан нуур:** Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт Жуснай нуураас зүүн тийш 0.2 км зайд 1998 м өндөрт байдаг хаягдал нуур. 2.3 км<sup>2</sup> талбайтай, 2. км урт, 1.4 км өргөн, эргийн шугамын урт 8.2 км.

**28. Улаан нуур:** Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутаг Шаргын голын эхэнд 1807 м өндөрт байдаг цэвдгийн гаралтай урсгал нуур. 0.7 км<sup>2</sup> талбайтай, 1.8 км өргөн, эргийн шугамын урт 4.4 км.

**29. Цагаан нуур:** Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт Тэс голын цутгал Жаргалант голын хөндийд 1767 м өндөрт байдаг термокарстын гаралтай шорвог нуур. 0.5 км<sup>2</sup> талбайтай, 1.4 км урт, 0.6 км өргөн, эргийн шугамын урт 3.2 км.

**30. Хунт нуур:** Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт Тэсийн голын цутгал Жаргалант голын адагт 1767 м өндөрт байдаг термокарстын гаралтай урсгал нуур. 0.5 км<sup>2</sup> талбайтай, 1.1 км урт, 0.6 км өргөн, эргийн шугамын урт 2.8 км, 5 м гүн.

**31. Ачмаг нуур:** Хөвсгөл аймгийн Мөрөн хотоос зүүн хойш 30 км зайд Босгын Давааны баруун хотост 1583 м өндөрт байдаг шорвог нуур. 1.8 км<sup>2</sup> талбайтай, 2.4 км урт, 1.3 км өргөн, эргийн шугамын урт 5.6 км. Усны эрдэсжилт 39.88 г/кг, түүний ихэнхийг сульфат, хлорт натри зонхилж найрлагаараа сульфат натрийн төрөлд багтана. Давсыг орон нутгийн чанартай ашигладаг.

**32. Ногоон нуур:** Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт Жарантайн голын хөндийд 1808 м өндөрт байдаг цэвдгийн гаралтай нуур. 1.4 км<sup>2</sup> талбайтай, 2.2 км урт, 0.7 км өргөн, эргийн шугамын урт 5.2 км.

**33. Гандан нуур:** Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын нутаг Булнай нурууны ар хормойд Сангийн далай нуурын ойролцоо 1988 м өндөрт байдаг тектоник гаралтай цэнгэг нуур. 9.6 км<sup>2</sup> талбайтай, 4 км урт, өргөн, эргийн шугамын урт 14.4 км, гүн 9.5 м, эзэлхүүн 45 сая м<sup>3</sup>, усны температур 6 дугаар сард 11.5°C-12.5°C, 7,8 дугаар сард 17.2°C, тунгалагшилт 8 м, 10 дугаар сараас 5 дугаар сард хөлдөж мөсний зузаан 1.1-1.4 м хүрнэ. 59 км<sup>2</sup> талбайгаас усжих булаг шандны усаар сэлбэгддэг. Ёроолд нь цайвар бараан лаг, наанги шавар, элс хайрга тархана. Усны эрдэсжилт 227.8 мг/л, хүчилтөрөгчийн хангамж өнгөндөө 9.3 мг/л, гидрокарбонат, кальц, магнийн ион зонхилдог. Нуурын зүүн эргээс 50-60 м зайд битүү ой модон дотор хаягдал үзэсгэлэнт нууртай, түүнийг ХОРОЛМАА гэнэ. Байгалийн үзэсгэлэнт байдлыг түшиглэн амралт сувилалын чиглэлээр ашигладаг.

**34. Зүүн нуур:** Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын нутагт Сангийн далай нуураас зүүн тийш 2006 м өндөрт байдаг тектоник гаралтай нуур. 17.5 км<sup>2</sup> талбайтай, 7 км урт, 3.8 км өргөн, эргийн шугамын урт 26.5 км. 17,6 м гүн, 146 сая м<sup>3</sup> эзэлхүүнтэй. Усны температур 6 дугаар сард 10.6°C-13.5°C ёроолруугаа буурдаг. 10 дугаар сараас 4 дүгээр сард хөлдөж 1.2-1.5 м зузаан мөсөөр хучигддаг. Ёроолдоо лаг, наанги шавар, элс хайрга, усны ургамалтай. Усны эрдэсжилт 3202.7 мг/л, хлорын ангийн натрийн төрөлд багтдаг. Байгалийн байдал үзэсгэлэнтэй, эргийн дагуу ой модтой, дөрвөн өнцөгт нь усны мандлаас 20-40 м өндөр Зүүн сант, Номтын сант, Цагаан дошны сант, Дугуйн сант гэдэг тулгын тотго шиг толгодтой, рекреацийн боломж сайтай. Нүүдлийн шувууд цугладаг.

**35. Жугнай нуур:** Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт 1997 м өндөрт байдаг уулын үзэсгэлэнт нуур. Эргийн байдал уулархаг, хойноос нь ой модтой Рэнцэнжугнай гэдэг хушуу түрж нуурыг бараг хоёр хуваана. 2.7 км<sup>2</sup> талбайтай, 11.5 км урт, 6.5 км өргөн, эргийн шугамын урт 35 км, усны хамгийн гүн нь 9.5 м, дундаж гүн 5.4 м, эзэлхүүн

142.6 сая м<sup>3</sup>. Ёроолдоо лаг наанги хурдас элс хайрга тархдаг. Ерөнхий эрдэжилт 7.45 г/л, хлорт-сульфат натри зонхилж найрлагаараа сульфатын төрлийн сульфат натрийн доод төрөлд багтана. Усны температур 6 дугаар сард 11.°C-12.°C, 7-р сард 13.5°C-аас үл хэтэрнэ. 10 дугаар сараас 4 дугаар сард хөлддөг мөсний зузаан 1.0-1.3 м хүрч ан цав, хар цагаан хил үүсдэг. Спорт, амралт сувилалд нэн тохиромжтой.

**36. Тунамал нуур:** Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын төвөөс баруун тийш 1874 м өндөрт байдаг гадагш урсгалгүй тектоник хотост тогтсон эрдэст нуур. Эргийн байдал үзэсгэлэнтэй, булан тохой олонтой зүүнээс түрж орсон толгойг нуурын овоо гэх ба нутгийнхан тахиж шүтдэг, 20.2 км<sup>2</sup> талбайтай, 7.2 км урт, 5 км өргөн, эргийн шугамын урт 36.6 км. Усны хамгийн гүн нь 9.9 м, дундаж гүн 5.5 м, эзэлхүүн 112 сая м<sup>3</sup>. Нуурын ёроолд хүхэр устөрөгчийн үнэртэй лаг шавар, эрэг дагуу элс хайр тархдаг. Ерөнхий эрдэжилт 1.06 г/л, түүний дийлэнхийг хлорт, натри, биокарбонат магни эзэлж найрлагаараа сульфат натрийн доод төрөлд багтана. Усны температур 6 дугаар сард 9.5°C-10.5°C, 7-р сард 13-14°C, 11 дүгээр сараас 6 дугаар сард хөлддөг. Хур бороо гүний усаар сэлбэгддэг, бас 302.3 км<sup>2</sup> талбайгаас усжиж Угалзат, Урт зэрэг олон жижиг булаг цутгадаг. Усны шувууд хуран цуглардаг. Рекрайцийн боломж сайтай.

**37. Доод Цагаан нуур:** Хөвсгөл аймгийн Цагаан нуур сумын нутагт Дархатын хотгорт 1538 м өндөрт байдаг урсгал цэнгэг нуур. Хармай, Доод, Дунд нуурын хамт 41.3 км<sup>2</sup> талбайтай, 7.5 км урт, 5.6 км өргөн, эргийн шугамын урт 63 км. Усны гүн доод нуурт 5 м, Дунд нуурт 10 м гүн, Хармай нуурт 17 м орчим, 203.5 сая м<sup>3</sup> эзэлхүүнтэй. Нуурт Шарга, Шишихид Арсай, Хармайн гол цутгаж Шишихид гол урсаж гардаг. Усны температур 7,8 дугаар сард 19.5°C-23°C, 9 дүгээр сард 14.5°C орчим, 10 дугаар сараас 5 дугаар сард хөлддөг. Мөсний зузаан 1.2-1.5 м, Ан цав, хар Цагаан хил үүсдэг. Ёроолд нь эртний мөстөлийн хурдас болох лаг наанги шавар тархаж булан тохойд усны ургамал ургадаг хэд хэдэн жижиг аралтай. Ерөнхий эрдэжилт 129.5 г/л, РН 7.0, ерөнхий хатуулаг 2.2 мг/экв, уусмал хүчилтөрөгч 6.0-7.9 г/л гидрокарбонат, кальц, сульфат ион зонхилно. Умард мөсөн далайтай ай сав загасаар элбэг, тэр орчны нуур уснаас жилд 700-2000 ц загас агнах тооцоо бий. Одоо загас агнуурыг улирлын чанартай эрхлэж байна. Рекреацийн боломж сайтай. Эрэг дээр нь Цагаан нуур сум байрладаг. Усан тээвэр, эрчим хүчний нөөцтэй.

**38. Сангийн Далай нуур:** Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр, Бүрэнхаан, Бүрэнтогтох сумдын заагт Булнайн нурууны ар дагуух тектоник хотост 1889 м өндөрт байдаг гарал үүсэл, хөгжил, усны горим, нөөц, амьтны аймгийн хувьд өвөрмөц үзэсгэлэнт нуур. 165 км<sup>2</sup> талбайтай, 32 км урт, 13 км өргөн, эргийн шугамын урт 127 км. Хамгийн гүн баруун талдаа 30 м, зүүн хотгорт 12м, 13-30 м гүн талбайн 80 орчим хувь, эзэлхүүн 1995 сая м<sup>3</sup>. Эрэг нь их хэрчигдэж олон тооны булан тохойтой, томхон цутгал голын адагт намагждаг, өмнөт эрэг нь хадан хясаа, ой модтой. Нуурт 2710 км<sup>2</sup> талбайгаас усжих 20-иод гол горхи цутгахаас Чулуут, Сэвсүүл, Замын хоолой, Уртын голууд байнгын урсацтай. Усны температур 7,8 дугаар сард 18.0°C-20.0°C, ёроолдоо 13.0°C-15.0°C, өвөл өнгөндөө 0.5°C-1.0°C, ёроолдоо 4.0-6.0°C зун шууд, өвөл урвуу үелэл тогтворждог. 11 дүгээр сараас 5

дугаар сард хөлддөг. Мөсний зузаан 1.5-1.8 м, тунгалагшилт 3-4 м, усны өнгө зэгэл цайвар, ногоовтор туяатай, нуурын ёроолд лаг, наанги, чулуурхаг, элсэнцэр хурдас тархаж ёроолын 13 хувийг лаг, 26 хувийг наанги шавар эзэлдэг. 1905 оны газар хөдлөлтийн үед талбай, нөөц үлэмж нэмэгдээд татарсан боловч сүүлийн жилүүдэд түвшин дээшилж Далайн овоо, Хар нүдэн булаг, гэдэг арлууд живж далд оржээ. Усын эрдэжилт өнгөндөө 3.76 г/л, 20 м гүнд 3.99 г/л, хлорт карбонат, натри зонхилж найрлагаараа карбонатын төрөлд багтана. Төв азийн гадагш урсгалгүй ай савын загас элбэг, нүүдлийн шувууд их цуглардаг. Амралт сувьлал, усан зам, спорт агнуур, аялал жуулчдын бааз байгуулахад тохиромжтой.

**39. Тарган /Шарга/ нуур:** Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын нутагт Дархадын хотгорт 1538 м өндөрт байдаг нуур. 19.9 км<sup>2</sup> талбайтай, 7.5 км урт, 4.6 км өргөн, эргийн шугамын урт 26.9 км. Эрэг хөвөө нь мөстлийн эгц зузаан хурдас, олон тооны мөсөн цөм бүхий бөөргүүдтэй. Жижиг гол горхи цутгаж өргөн хоолойгоор Доод Цагаан нууртай холбогддог. Усны температур 7,8 дугаар сард өнгөндөө 13.6°C, 2 м гүнд 13.0°C, 5 м гүнд 12.8°C тунгалагшилт 1.8-2.0 м, ёроолд нь эртний мөстлийн үнсэн саарал, шаргал өнгийн лаг наанги хурдас тархдаг. Ерөнхий эрдэжилт 149.7 мг/л, гидрокарбонат, сульфатын төрлийн устай. Умард мөсөн далайн ай савын загас, нүүдлийн шувууд элбэгтэй.

**40. Уст нуур:** Хөвсгөл аймгийн Тариалан, Булган аймгийн Хутаг сумдын заагт 1123 м өндөрт байдаг термокарстын гаралтай нуур. Эргэн тойронд нь их намагтай, ойр орчинд нь Хаг /0.6 км<sup>2</sup>/, Цагаан /0.4 км<sup>2</sup>/ зэрэг бүлэг нуур байдаг. Нуур нь 1.0 км<sup>2</sup> талбайтай, 2 км урт, 0.8 км өргөн, эргийн шугамын урт 4.2 км. Жижиг горхи цутгаж Тээлийн голоор Сэлэнгэ мөрөнтэй холбогддог цэнгэг устай. Загас жараахай, нүүдлийн шувууд элбэг байдаг.

**41. Хар нуур:** Хөвсгөл аймгийн Ханх хорооны нутаг Их Хороо голын савд 2170 м өндөрт байдаг мастлийн гаралтай үзэсгэлэнт нуур. 0.9 км<sup>2</sup> талбайтай, 1.2 км урт, эргийн шугамын урт 3.6 км. Умард мөсөн далайн загас жараахатай гадагш урсгал цэнгэг нуур.

**42. Царам нуур:** Хөвсгөл аймгийн Улаан тайгын нуруунд 2380 м өндөрт байдаг мөстлийн гаралтай цэнгэг нуур. 1.01 км<sup>2</sup> талбайтай, 2.4 км урт, 6.0 км өргөн, эргийн шугамын урт 9.2 км.

**43. Гунайн эхний нуур:** Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын нутагт Гунайн голын эхэнд 2500 м өндөрт байдаг мөстлийн хүнхэд тогтсон нуур. 1.8 км<sup>2</sup> талбайтай, 2.2 км урт, 0.9 км өргөн, эргийн шугамын урт 6.4 км.

**44. Дуут нуур:** Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын ойролцоо 2180 м өндөрт байдаг мөстлийн гаралтай цэнгэг нуур. 0.6 км<sup>2</sup> талбайтай, 1.5 км урт, 0.5 км өргөн, эргийн шугамын урт 3.4 км.

**45. Шашлиг нуур:** Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын нутагт 2220 м өндөрт байдаг мөстлийн гаралтай нуур. 0.5 км<sup>2</sup> талбайтай, 1.4 км урт, 0.4 км өргөн, эргийн шугамын урт 3.0 км.



**46. Агуйт нуур:** Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын нутагт улсын хилийн ойролцоо 2260 м өндөрт байдаг мөстлийн гаралтай нуур. 1.4 км<sup>2</sup> талбайтай, 13.0 км урт, 0.5 км өргөн, эргийн шугамын урт 6.8 км.

**47. Хуулагат /Хөлөгт/ нуур:** Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын нутагт Шишихидийн Их Жамц голын эхэнд 2002 м өндөрт байдаг мөстлийн гаралтай цэнгэг нуур. 0.7 км<sup>2</sup> талбайтай, 2.3 км урт, 0.7 км өргөн, эргийн шугамын урт 5.2 км.

**48. Урд нуур:** Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сум, Дархадын хотгорт 1550 м өндөрт байдаг цэнгэг нуур. 0.6 км<sup>2</sup> талбайтай, 1.7 км урт, 0.5 км өргөн, эргийн шугамын урт 4.0 км.

**49. Хармайн Зүүн нуур:** Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сум, Дархадын хотгорт 1660 м өндөрт байдаг хаягдал нуур. 1.1 км<sup>2</sup> талбайтай, 2.6 км урт, 0.6 км өргөн, эргийн шугамын урт 6.2 км. Гадагш урсгал цэнгэг нуур.

**50. Түрүүн нуур:** Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сум, Дархадын хотгорт 1550 м өндөрт байдаг термокарстын гаралтай нуур. 2.4 км<sup>2</sup> талбайтай, 2.3 км урт, 1.1 км өргөн, эргийн шугамын урт 5.0 км. Жижиг гол горхи цутгаж гадагш урсгалтай.

**51. Бөөрөг нуур:** Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сум, Дархадын хотгорт Шишихид голын эрэг дээр 1570 м өндөрт байдаг хаягдал цэнгэг нуур. 1.2 км<sup>2</sup> талбайтай, 2.0 км урт, 1.2 км өргөн, эргийн шугамын урт 5.0 км, эргэн тойронд мөсөн цөмт бөөрөгтэй.

**52. Холбоо Цагаан нуур:** Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сум, Дархадын хотгорт Дээд цагаан нууртай холбоотой 1550 м өндөрт байдаг цэнгэг нуур. 1.6 км<sup>2</sup> талбайтай, 2.6 км урт, 1.0 км өргөн, эргийн шугамын урт 6.2 км.

**53. Цэцэгт нуур:** Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сум, Дархадын хотгорт 1550 м өндөрт байдаг нуур. 1.5 км<sup>2</sup> талбайтай, 1.9 км урт, 1.3 км өргөн, эргийн шугамын урт 6.0 км.

**54. Зуун модот нуур:** Хөвсгөл аймгийн Ханх сумын Хибин залуу Үүрийн Сарьдагийн баруун хажууд 2050 м өндөрт байдаг цэнгэг нуур. 0.5 км<sup>2</sup> талбайтай, 1.1 км урт, 1.0 км өргөн, эргийн шугамын урт 3.2 км. Орчны байгаль нэн үзэсгэлэнтэй.

**55. Лам тайгийн нуруу:** Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Улаан Тайгын нуруунд 2160 м өндөрт байдаг мөстлийн гаралтай нуур. 1.2 км<sup>2</sup> талбайтай, 1.9 км урт, 0.9 км өргөн, эргийн шугамын урт 4.8 км.

**56. Заяат /хурган/ нуур:** Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сум, Дархадын хотгорын Шишихид голын эрэг дээр 1580 м өндөрт байдаг хаягдал цэнгэг нуур. 0.5 км<sup>2</sup> талбайтай, 1.1 км урт, 0.9 км өргөн, эргийн шугамын урт 2.8 км.

**57. Урт цармын нуур:** Хөвсгөл аймгийн Цагаан-Уулын рашаанаас баруун тийш 1920 м өндөрт байдаг цэнгэг нуур. 0.5 км<sup>2</sup> талбайтай, 1.0 км урт, 0.8 км өргөн, эргийн шугамын урт 2.8 км.

**58. Салт нуур:** Хөвсгөл аймгийн Цагаан-Уулын сумын нутагт Тунамал нуураас хойш 2001 м өндөрт байдаг шорвог нуур. 0.5 км<sup>2</sup> талбайтай, 1.2 км урт, 1.0 км өргөн, эргийн шугамын урт 3.2 км.

**59. Гашуун нуур:** Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын нутагт 2100 м өндөрт байдаг шорвог нуур. 1.2 км урт, 0.7 км өргөн, эргийн шугамын урт 3.0 км.

**60. Дээд нуур:** Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох, Бүрэнхаан сумын нутгийн заагт 1908м байдаг урсгал нуур. 0.5 км<sup>2</sup> талбайтай, 1.0 км урт, 0.8 км өргөн, эргийн шугамын урт 3.4 км.

**61. Дэлгэр нуур:** Хөвсгөл аймгийн Улаан уул сумын нутаг Улаан Тайгын нуруунд 2131м өндөрт байдаг мөстлөгийн гаралтай цэнгэг нуур. 0.7км<sup>2</sup> талбайтай, 2.1 км урт, 0.5 км өргөн, эргийн шугамын урт 4.6 км. Дэлгэрмөрний эхний цутгал гол орж гардаг урсгал устай загас жараахай элбэгтэй.

**62. Чулуут нуур:** Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын нутгаар урсдаг Шишихид голын уудам хөндийд 1540м өндөрт байдаг дулааны хөндийлжийн нуур. 0.5 км<sup>2</sup> талбайтай, 1.3 км урт, 0.7 км өргөн, эргийн шугамын урт 4.8 км.

**63. Урд нуур:** Хөвсгөл аймгийн Улаан уул сумын нутагт Мунгарагийн Цагаан уулын өмнө 2160м өндөрт байдаг мөстөлийн нуур. 0.5 км<sup>2</sup> талбайтай, 1.3 км урт, 0.4 км өргөн, эргийн шугамын урт 2.8 км гадагш урсгал загас жараахайтай.

**64. Их Ханзарлагийн нуур:** Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын нутагт Хойт Асгат уулын ар оройд 2250м өндөрт байдаг мөстөлийн хунхад тогтсон цэнгэг нуур. 0.5 км<sup>2</sup> талбайтай, 1.5 км урт, 0.4 км өргөн, эргийн шугамын урт 3.0 км.

**65. Агуйтын доод нуур:** Хөвсгөл аймгий Цагааннуур сумын нутагт Хойт Асгат уулын тагд 2260м өндөрт байдаг мөстөлийн хүнхийн нуур. 0.5 км<sup>2</sup> талбайтай, 1.4 км урт, 0.4 км өргөн, эргийн шугамын урт 3.0 км.

**66. Зүүн тошдог нуур:** Хөвсгөл аймгий Цагааннуур сумын нутагт Хуулагт тайгын орой дахь мөстөлийн хунхад 2260м өндөрт байдаг цэнгэг нуур. 0.6 км<sup>2</sup> талбайтай, 1.9 км урт, 0.7 км өргөн, эргийн шугамын урт 4.4 км. Гол горхиор Шишихид голтой холбогддог. Загас жараахай элбэгтэй.

**67. Бага Сарьдагийн нуур:** Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын нутаг Хуулагт тайгын ар оройд 2030м өндөрт байдаг мөстөлийн гаралтай бүлэг нуурын нэг. 0.5 км<sup>2</sup> талбайтай, 1.0 км урт, 0.7 км өргөн, эргийн шугамын урт 3.4 км. Гол горхиор Шишихид голтой холбогддог цэнгэг устай, загас жараахай элбэгтэй.

**68. Баруун Хуулгат нуур:** Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын нутагт Хуулгат Сарьдагийн баруун хавцалд 2050м өндөрт байдаг тайгын нуур. 0.7 км<sup>2</sup> талбайтай, 1.5 км урт, 1.2 км өргөн, эргийн шугамын урт 4.2 км. Гол горхиор Шишихид голтой холбогддог. Загас жараахай элбэгтэй.

**69. Ар тайгын нуур:** Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын нутагт Тэнгис голын савд 1989 м өндөрт байдаг тайгын цэнгэг нуур. 0.5 км<sup>2</sup> талбайтай, 1.1 км урт, 0.7 км өргөн, эргийн шугамын урт 2.8 км гол горхи цутгаж гардаг, загас жараахай элбэг.

**70. Бөөрөгт нуур:** Хөвсгөл аймгийн Цагааннуур сум болон Ренчинлхүмбэ сумын заагт Тарган нуурын зүүн эрэгт дулааны хөндийлжийн хотгорт 1542м өндөрт байдаг цэнгэг нуур. 0.7 км<sup>2</sup> талбайтай, 1.0 км урт, 0.7 км өргөн, эргийн шугамын урт 3.2 км цутгал ба урсгал гол горхитой. Загас жараахайтай.

**71. Бага бөөрөгт нуур:** Хөвсгөл аймгийн Цагааннуур сум болон Ренчинлхүмбэ сумын заагт Тарган нуурын зүүн талд дулааны хөндийлжийн хотгорт 1538м өндөрт байдаг хаягдал нуур. 0.5 км<sup>2</sup> талбайтай, 0.8 км урт, өргөнтэй, эргийн шугамын урт 2.2 км.

**72. Онгойн нуур:** Хөвсгөл аймгийн Цагааннуур сум болон Ренчинлхүмбэ сумын нутаг Шаргийн голын хөндий 1550 м өндөрт байдаг гадагш хаягдал нуур. 0.5 км<sup>2</sup> талбайтай, 1.1 км урт, 0.5 км өргөн, эргийн шугамын урт 4.0 км, 2 м гүн.

**73. Тайгасын зүүн нуур:** Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын нутаг Доод тайгасын Мунгарагийн Цагаан ууланд 2200 м өндөрт байдаг мөстлийн бүлэг нуурын нэг. 1.5 км<sup>2</sup> талбайтай, 3.8 км урт, 0.8 км өргөн, эргийн шугамын урт 8.4 км. Гол горхиор Мунгарагийн голтой холбогддог. Цэнгэг устай загас жараахайтай.

**74. Гэрт нуур:** Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын нутаг Доод тайгасын сарьдагийн Мунгарагийн Цагаан уулын өвөрт 2200 м өндөрт байдаг мөстөлийн нуур. 0.6 км<sup>2</sup> талбайтай, 1.2 км урт, 0.9 км өргөн, эргийн шугамын урт 3.0 км орох, гарах гол горхитой. Загас жараахай элбэгтэй.

**75. Дээд нуур:** Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын нутагт Шар гэр голын эхэнд 2140 м өндөрт байдаг мөстөлийн нуур. 0.5 км<sup>2</sup> талбайтай, 1.2 км урт, 0.4 км өргөн, эргийн шугамын урт 2.8 км, орох гарах гол горхитой. Загас жараахай элбэгтэй.

**76. Нэргүй нуур:** Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын нутагт Шар гэр голын цутгалын эхэнд 2219 м өндөрт байдаг мөстөлийн нуур. 0.6 км<sup>2</sup> талбайтай, 1.5 км урт, 0.5 км өргөн, эргийн шугамын урт 3.4 км, цутгал ба урсгалтай. Загас жараахай элбэгтэй.

**77. Ёлтын хар нуур:** Хөвсгөл аймгийн Улаануул сумын нутаг Ёлт уулын Хунх 2460м өндөрт байдаг мөстөлийн нуур. 0.5км<sup>2</sup> талбайтай, 1.3 км урт, 0.5 км өргөн, эргийн шугамын урт 3.2 км. Гол горхиор Дэлгэрмөрөнтэй холбогддог. Загас элбэгтэй.

**78. Сарьдагийн цуваа нуур:** Хөвсгөл аймгийн Улаан уул сумын нутаг Гунайн голын эхэнд Ёлт уулын арын тагд 2340м өндөрт байдаг бүлэг нуурын нэг. 0.5км<sup>2</sup> талбайтай, 1.1 км урт, 0.7 км өргөн, эргийн шугамын урт 2.8 км. Эргэн тойрон уулын намагтай, цутгах, гарах урсгалтай. Загас жараахай элбэгтэй.

**79. Тагнийн нуур:** Хөвсгөл аймгийн Улаан уул сумын нутагт Ёлт уулын хойд тагд 2339м өндөрт байдаг мөстөлийн нуур. 0.5км<sup>2</sup> талбайтай, 1.4 км урт, 0.8 км өргөн, эргийн шугамын урт 3.4 км. Орох гарах урсгалтай цэнгэг нуур.

**80. Тагийн Хар нуур:** Хөвсгөл аймгийн Улаан уул сумын нутагт Дэлгэрмөрний эхэнд 2226м өндөрт байдаг бүлэг нуурын нэг. 0.5км<sup>2</sup> талбайтай, 1.0 км урт, 0.8 км өргөн, эргийн шугамын урт 2.8 км. Гол горхиор Дэлгэрмөрөнтэй холбогддог. Загас элбэгтэй.

**81. Ёлтын өмнөд Хар нуур:** Хөвсгөл аймгийн Улаануул сумын нутагт Ёлт уулын тагд 2360м өндөрт байдаг нуур. 0.5км<sup>2</sup> талбайтай, 1.6 км урт, 0.8 км өргөн, эргийн шугамын урт 3.0 км. Олон нуур дамжих гол горхиор Дэлгэрмөрөнтэй холбогддог.

**82. Цагаан нуур:** Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт Алтан хөл уулын арын хотост 1700м өндөрт байдаг эрдэст нуур. 0.9км<sup>2</sup> талбайтай, 1.3 км урт, 1.0 км өргөн, эргийн шугамын урт 4.2 км.

**83. Холбоо нуур:** Хөвсгөл аймгийн Цагаануул сумын нутагт Гандан, Тунамал нуурын хооронд 2036м өндөрт байдаг эрдэст нуур. 0.6км<sup>2</sup> талбайтай, 1.2 км урт, 1.0 км өргөн, эргийн шугамын урт 3.8 км.

**84. Хаг нуур:** Хөвсгөл аймгийн Тариалан, Булган аймгийн Хутаг сумын заагт 1161м өндөрт байдаг термокарстын нуур. 0.6км<sup>2</sup> талбайтай, 1.8 км урт, 0.8 км өргөн, эргийн шугамын урт 3.2 км, нүүдлийн шувууд, загас, жараахай элбэгтэй.

**85. Тасархайн нуур:** Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын нутагт Хотон голын савд 1550м өндөрт байдаг гольдролын хаягдал нуур. 0.5км<sup>2</sup> талбайтай, 1.3 км урт, 0.6 км өргөн, эргийн шугамын урт 3.0 км. Ус нь гүехэн, ёроолд нь лаг шавартай.

**86. Цэцэгт нуур:** Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын нутагт Хотон голын адагт 1550м өндөрт байдаг бүлэг хаягдал нуурын нэг. 0.6км<sup>2</sup> талбайтай, 1.3 км урт, 0.8 км өргөн, эргийн шугамын урт 3.8 км. Лаг шавар тунаж элдэв замаг ургаж цэцэглэдэг.

**87. Хаашаат нуур:** Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын нутагт Шишихид голын гольдролд 1540м өндөрт байдаг хаягдал нуур. 0.7км<sup>2</sup> талбайтай, 1.5 км урт, 0.8 км өргөн, эргийн шугамын урт 4.0 км, орох гарах урсгалтай, загас жараахайтай.

**88. Тагийн нуур:** Хөвсгөл аймгийн Улаануул сумын нутагт Улаан тайгын Доод тайгасын нурууны мөстөлийн тэвшин хөндийд 2420м өндөрт байдаг нуур. 0.5км<sup>2</sup> талбайтай, 1.3 км урт, 0.8 км өргөн, эргийн шугамын урт 3.0 км. Орох гарах урсгалтай, цэнгэг устай. Дэлгэрмөрөн голтой горхиор холбогддог.

**89. Тайгасын цуваа нуур:** Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын нутагт Мунгарагийн голын эхэнд 2375м өндөрт байдаг мөстөлийн гаралтай бүлэг нуурын нэг. 1.5км<sup>2</sup> талбайтай, 2.8 км урт, 0.8 км өргөн, эргийн шугамын урт 7.6 км. Гадагш урсгал, загас жараахай элбэгтэй уулын нуур.

**90. Их нуур:** Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын нутагт Мунгарагийн цагаан уулын тагт, 2400м өндөрт байдаг мөстөлийн гаралтай цэнгэг нуур. 2.7 талбайтай, 4.0 км урт, 2.0 км өргөн, эргийн шугамын урт 9.2 км. Олон цуваа нуур дамжин Мунгарагийн голтой холбогддог. Загас жараахай элбэгтэй.

**91. Тэргүүн нуур:** Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт сумын төвөөс зүүн тийш 1785м өндөрт байдаг мөстөлийн гаралтай нуур. 0.8км<sup>2</sup> талбайтай, 1.5 км урт, 0.9 км өргөн, эргийн шугамын урт 4.2 км.

**92. Хөвсгөл нуур:** Хөвсгөл аймгийн нутагт 1645м өндөрт байдаг тектоник гаралтай үзэсгэлэнт нуур. Эргэн тойрон сүрлэг өндөр уулсаар хүрээлэгдсэн энэ нуурын талбай 2760км<sup>2</sup>, 136км урт, 37км өргөн, эргийн шугамын урт 414 км бөгөөд гүн, усны нөөцөөр Монгол төдийгүй Төв Азид томд тооцогддог. Усны нөөц нь манай орны бүх гол мөрний жилийн нийлбэр урсацаас бараг 10 гаруй дахин их, олон тооны булан тохой, арал хойгтой. Далайн хүйс, Модон хүйс, Хадан хүйс зэрэг аралтайгаас усны мандалаас 126м өндөр Далайн хүйс том нь бөгөөд 3км урт, 2км өргөн, 5.8км<sup>2</sup> талбайтай, битүү ой модоор хучигдаж эргийн шугамын урт 8.5км хүрнэ. Нуурын ёроолын гадарга нь янз бүр, ёроолын том уул нуруудаас гадна гүн хонхор ховдолтой, ёроолын талбайн 69% нь 100м-ээс илүү гүнтэй бол 0-15м гүн зөвхөн 15 хувийг эзэлдэг. Цутгал голын адгаас бусад хэсэгт ёроолын

хажуу эгц, эргээс 1-2км холдоход 100-200м гүн болдог. Нуурын усны үндсэн тэжээл нь хур бороо, гадаргын урсац бөгөөд нийтдээ 96 гол горхи цутгахаас 40 гаруй нь байнгын урсацтай. Нуураас ганц Эгийн гол гарч Сэлэнгэ мөрнөөр дамжин Байгаль нууртай холбогдон улмаар умард мөсөн далайд хүрч төгсөнө. Усны төвшний жил, улирлын хэлбэлзэл тогтвортой, 0.6-1.0м орчим байна. Дулааны горим нь бусад том нуураас үлэмж ялгаатай. 5-р сараас эхлэн гэсэх боловч 6-р сард ч мөстэй байх нь цөөнгүй. Мөсний зузаан 1.0-1.5м зонхилж зарим булан тохойд 2.0 м хүрнэ. Хамгийн дулаан сард ч усны өнгөний температур 18°-аас тэгтлээ үл давна. 7-8 сарын усны температурын дундаж 12-13° зуны богино хугацаанд зөвхөн 50м хүртэлх өнгөн хэсэг бүлээсэн температурын үелэл шууд, өвөл нь урвуу үелэл тогтворжиж 200м-ээс цааших гүнд 3.5-4° байдаг. 8-р сард усны гадаргад 9.6°, 10м гүнд 8.9°, 25 м гүнд 7.2°, 50м гүнд 4.6°, 100м гүнд 3.9°, 200м гүнд 3.7° дулаан байх жишээтэй. Хэдийгээр олон тооны гол горхи цутгах авч усны тунгалагшилт 24-25м хүрч дэлхийд дээгүүр ордог цэнгэг нуур юм. Нуурын ёроол гүн хонхорт лаг, наанги шавар, гүехэн хэсэгт элс хайрга тархаж булан тохойд нь усны ургамал мэр сэр ургана. Нуурын ач холбогдол асар их, цэнгэг арвин уснаас гадна 10 орчим зүйлийн загас жараахай усны төрөл бүрийн шувуудтай. Жилд 7800 ц загас агнах нөөцтэйгээс гадна рекреацийн боломжоор дэлхийн бусад нуураас дутуугүй. Амралт сувилал, аялал жуулчлал, агнуур-спорт хөгжүүлэх боломж сайтай. Эрт дээр үеээс хөрш улс оронтой харилцах усан зам болж ирснээрээ түүний эдийн засгийн ач холбогдол бусад нуураас давуу юм. Нуурын эрэгт Ханх, Хатгал зэрэг дамжлага бааз, хот сууринтай. Нуурын усны эрдэжилт маш бага, ерөнхий эрдэжилт 190-210мг/л, гидрокорбанат ангийн кальцийн бүлэгт багтдаг. Нуурын эргэн тойронд хэд хэдэн газрыг Дархан буюу нөөц газарт хамруулдаг. Нуурыг 25 сая жилийн өмнө үүссэн гэдэг. Эртний эндемик /орогномол/ амьтадтай. Нуурын цахилгаан эрчим хүчний нөөц асар их. Нуурын байгаль нэн үзэсгэлэнтэй, ар биеэр нь соёоны гучин гурван мундрага бүхий хур цаст Бүрэнхаан, баруун биеэр нь Хорьдол сарьдаг, Уран Дөшийн уулс, зүүн этгээдэд Хиван-залуу үүрийн сарьдаг уулс хашиж нуурын уснаа тольдоно.

### **8.3. Гүний усны судалгаа, өнөөгийн байдал**

Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэр дэх газрын доорхи усны нөөц харьцангуй бага судлагдсан бөгөөд одоогийн байдлаар Алаг-Эрдэнэ, Бүрэнтогтох сумын нутгийн заагт орших “Дэлгэр мөрний орд” -6559,0 м<sup>3</sup>/ хоног, Ренчинлхүмбэ сумын Арсайн ам, Зөөлөн орчмын “Ренчинлхүмбийн орд”-488,0м<sup>3</sup>/ хоног, Арбулаг сумын Ямаат, Сүмбэр орчмын “Хүрэн булагийн орд”-259,2 м<sup>3</sup>/хоног, Цагаан-Уул сумын Өвгөд багийн “Хүйтэн хошууны орд”- 242,0 м<sup>3</sup>/ хоног, Ханх сумын “Хавцлын амны орд”-492,0 м<sup>3</sup>/ хоног, Цагаан-Уул сумын “Шар голын орд”-244,0 м<sup>3</sup>/хоног буюу аймгийн хэмжээгээр 8284,2 м<sup>3</sup>/ хоногийн нөөцтэй гэж тогтоогдсон байдаг. Хөвсгөл аймгийн хувьд урьдчилсан судалгаагаар газрын доорхи ус 2,49км<sup>3</sup> үүнээс ашиглах боломжтой нөөц 1,95 км<sup>3</sup>, гадаргын ус 6,59 км<sup>3</sup>, үүнээс ашиглах боломжтой нөөц 0,16 км<sup>3</sup> байгааг тогтоосон байна. Аймгийн хэмжээнд хоногт 3500 м<sup>3</sup>, хүн ам ихээр төвлөрсөн Мөрөн суманд хоногт 1500 м<sup>3</sup> ус хэргэлдэгээс 1000 орчим

м<sup>3</sup> усыг бохир хэлбэрээр хаягддаг байна. Одоогийн байдлаар аймгийн нийт хүн амын 80 гаруй хувь баталгаат ундны усны эх үүсвэрээс хэргэлж байна

**Хөвсгөл аймгийн Ханх сумын төвийн усан хангамжийн эх үүсвэрийн зориулалттай газрын доорхи усны орд:**

1994 онд Ч. Лувсандорж, Р. Оюунсүрэн, Г. Цэрэнжав нар гидрогеологийн эрлийн ажлаар газар доорхи усны ашиглалтын нөөц баялгийн үнэлгээ өгсөн. Тайлангийн дугаар 4703. Ашиглалтын нөөц баялгийг Хавулын амын хөндийд тархсан дөрөвдөгчийн сэвсгэр хурдас агуулсан газрын доорхи усны ордод тооцсон. Уг амын ус хуримтлагдах талбайн хэмжээнд даралтгүй уст үеийн илэрэх гүн нь 1,5-3,7 м-т хэлбэлзэнэ. Тус хурдсанд өрөмдсөн цооногын ундарга нь усны түвшинг 2,5 м бууруулахад 5,2 л/с байжээ. Газар доорхи ус нь гидрокарбонат- магни-кальцийн найрлагатай, эрдэсжилтээр 0,1-0,2 г/л, ерөнхий хатуулаг 1,9-2,8 мг-экв/л байна. Газрын доорхи усны ашиглалтын нөөц баялгийг гидродинамикийн аргаар 5,7 л/с буюу 492,0 м<sup>3</sup>/хон –оор, С<sub>1</sub> зэргээр үнэлэн баталгаажуулжээ.

Газрын доорхи усны гол эх үүсвэр нь агаарын хур тунадас, гипсометрийн хувьд өндөр орших уст бүрдлийн далд шүүрэлтээр тус тус явагдана.

Газрын доорхи усны “Далайн булаг” ордыг сумын төвийн усан хангамжийн эх үүсвэрийн зориулалтаар ашиглаж байна. Газрын доорх усны ордын ус татах байгууламжийн эрүүл ахуйн хамгаалалтын 3-р бүсийн талбай 1,4166 км<sup>2</sup> болно.

- 42.47-03. Хөвсгөл аймгийн Ханх сумын төвийн усан хангамжийн газар доорхи усны орд: /ДТМ s= 0,8879 км<sup>2</sup>, ГТМ s= 1,4166 км<sup>2</sup>/

*Хүснэгт № 8.8 Хөвсгөл аймгийн Ханх сумын төвийн усан хангамжийн газар доорх усны ордын байршил*

№	х	у
1	100° 37' 37.050" E	51° 33' 23.011" N
2	100° 37' 6.341" E	51° 34' 17.353" N
3	100° 38' 8.440" E	51° 34' 24.214" N
4	100° 38' 12.037" E	51° 33' 43.475" N

**Хөвсгөл аймгийн Мөрөн хотын усан хангамжийн эх үүсвэрийн зориулалттай газрын доорхи усны орд:**

2007 онд Р. Батгөмөр, Ш. Бат-Өлзий, Б. Энх-Өнөр нар гидрогеологийн ашиглалтын хайгуулын ажлаар газар доорхи усны ашиглалтын нөөц баялгийн үнэлгээ өгсөн. Тайлангийн дугаар 6476. Ашиглалтын нөөц баялгийг Дэлгэрмөрөн голын хөндийд хэрэглэгчээс 3,7-4,8 км зайд байрлах газрын доорхи усны ордоор тооцсон.

Дэлгэрмөрөн голын хөндийн газар доорхи усны ордын ус агуулагч чулуулаг нь голын татам, дэнжийн дээд дөрөвдөгч-орчин үеийн сайр-сайргархаг, элсэрхэг сэвсгэр хурдас болно. Ус агуулагч хурдас ордын хүрээнд даралтгүй устай. Газар доорхи ус 1,60-5,34 м—ээс илэрч тогтоно. Уст давхаргын зузаан нь 18,64-37,5 м. Цооногууд дахь усны түвшинг 0,50-7,50 м бууруулахад ундарга нь 7,0-20,0 л/с байжээ. Газар доорхи усны ордын ашиглалтын нөөцийг гидродинамик аргаар нийт 6662,74 м<sup>3</sup>/хон –оор буюу 77,09 л/с

–ээр өгч үүнээс А зэрэглэлээр 28,09 л/с, В зэргээр 49,0 л/с -ээр тус тус үнэлэн баталгаажуулсан байна.

Дэлгэрмөрөн голын хөндийн газрын доорхи ус нь химийн найрлагаараа гидрокарбонат, натри- магнийн, магни- кальцийн найрлагатай, эрдэсжилт 0,305-0,417 г/л, ерөнхий хатуулаг 3,8-4,5 мг-экв/л байна.

Газрын доорхи усны гол эх үүсвэр нь агаарын хур тунадас ба голын усны шүүрэлт болон гипсометрийн хувьд өндөр орших уст бүрдлийн далд шүүрэлтээр тус тус явагдана.

Газрын доорхи усны тухайн ордыг хотын төвийн усан хангамжийн эх үүсвэрийн зориулалтаар ашиглаж байна. Газрын доорхи усны ордын ус татах байгууламжийн эрүүл ахуйн хамгаалалтын 3-р бүсийн талбай  $m^2$  болно. Энэ мужийн солиболцлууд:

- 64- 76. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын төвийн усан хангамжийн газар доорхи усны орд, /ДТМ s= 57,0763 км<sup>2</sup> , ГТМ s= 140,1023 км<sup>2</sup>/

*Хүснэгт № 8.9 Хөвсгөл аймгийн Мөрөн сумын төвийн усан хангамжийн газар доорхи усны ордын байршил*

№	x	y
1	99° 59' 56.745" E	49° 37' 35.744" N
2	100° 4' 14.240" E	49° 40' 44.001" N
3	100° 11' 35.136" E	49° 38' 30.886" N
4	100° 9' 37.852" E	49° 35' 5.242" N

***Хөвсгөл аймгийн Цагаан уул сумын төвийн усан хангамжийн эх үүсвэрийн зориулалттай газрын доорхи усны орд:***

1995 онд Д. Намсрайжав, Р. Баттөмөр нар гидрогеологийн эрлийн ажлаар газар доорхи усны ашиглалтын нөөц баялгийн үнэлгээ өгсөн. Тайлангийн дугаар 4817. Ашиглалтын нөөц баялгийг сумын төв болон түүнээс баруун тийш 800-904 м зайд орших шинэхэн залуу тектоник хагаралын ан цав-судлын усны газрын доорхи усны ордод тооцсон.

Энэ хэсэгт газар доорхи усны ордын ус агуулагч чулуулаг нь венд-дээд кембрий, дээд рифейн үеийн тунамал, интрузив чулуулгийн дунд үүссэн тектоник нээлттэй хагрлууд болно. Ус агуулагч хурдас ордын хүрээнд цэвдэг чулуулагтай холбогдон даралтад устай. Уст давхаргын дундаж зузаан нь 40-50 м. Цооногууд дахь усны түвшинг 40-60 м бууруулахад ундарга нь 2,0-3,0 л/с байжээ.

Газар доорхи усны ордын ашиглалтын нөөцийг усжсан тектоник хагралд өрөмдөн ус илрүүлсэн цооног тус бүрээр тодорхойллож С<sub>1</sub> ба С<sub>2</sub> зэрэглэлээр өгсөн байна. Тухайлбал, сумын төв орчмоор байгаа цооног-1-ээр 1,0 л/с ашиглалтын нөөцийг С<sub>2</sub> зэргээр, Доод маньтийн 4473-р худгаар 2,8 л/с нөөцийг С<sub>1</sub>-ээр, сумын төвийн баруун жигүүрт 904 м зайд өрөмдсөн 4-р цооногоор 1,5 л/с ашиглалтын нөөцийг С<sub>2</sub> зэргээр тус тус өгч баталгаажуулсан байна.

Ордын газрын доорхи ус нь химийн найрлагаараа ба чанараараа ундааны усны улсын стандартын шаардлагыг 4-р цооногийн уснаас бусад нь бүрэн хангаж байна. Газрын

доорхи усны гол эх үүсвэр нь агаарын хур тунадас болон гипсометрийн хувьд өндөр орших уст бүрдлийн далд шүүрэлтээр тус тус явагдана.

Газрын доорхи усны тухайн ордыг сумын төвийн усан хангамжийн эх үүсвэрийн зориулалтаар ашиглаж байна. Газрын доорх усны ордын ус татах байгууламжийн эрүүл ахуйн хамгаалалтын 3-р бүсийн талбай 4,0333 км<sup>2</sup> болно. Энэ мужийн солиболцлууд:

- 48.48- 17. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын төвийн усан хангамжийн газар доорхи усны орд, /ДТМ s= 2,2523 км<sup>2</sup>, ГТМ s= 4,0333 км<sup>2</sup>/

*Хүснэгт № 8.10. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын төвийн усан хангамжийн газар доорх усны ордын байршил*

№	х	у
1	98° 40' 7.984" E	49° 35' 47.291" N
2	98° 42' 9.364" E	49° 35' 54.722" N
3	98° 41' 16.215" E	49° 35' 16.652" N
4	98° 39' 49.342" E	49° 35' 4.485" N

***Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын төвийн усан хангамжийн газрын доорхи усны орд:***

1998 онд Д. Намсрайжав гидрогеологийн эрлийн ажлаар газар доорхи усны ашиглалтын нөөцийн үнэлгээ өгсөн. Тайлангийн дугаар 5115.

Газрын доорхи усны орд сумын төвөөс баруун зүгт дунд-дээд дөрөвдөгчийн сэвсгэр хурдасны уст үе давхарга нь олон жилийн цэвдгийн зузаалгийн дээд хэсэгт бүрэлдэн бий болсон гэсгэлэн өрхийн хэлбэрээр зурвас маягийн талбайд тархсан байна.

Ордын ус агуулагч чулуулаг нь дунд-дээд дөрөвдөгчийн элсэнцэр, хайрга, бул чулуутай сэвсгэр хурдас болно. Газар доорхи ус 2,0 -3,0 м—с илэрэх ба түрэлтгүй. Уст давхаргын зузаан нь 32-37 м байна.

Газар доорхи усны ордын ашиглалтын нөөцийг гидродинамик аргаар нийт 488,16м<sup>3</sup>/хон—оор буюу 5,65 л/с—ээр С<sub>1</sub>-ээр тогтоон баталгаажуулсан байна.

Газрын доорхи ус нь химийн найрлагаараа ихэвчлэн гидрокарбонат, кальций, натри-магнийн төрөлд хамаарах бөгөөд 0,2-0,3 г/л эрдэсжилттэй, цэнгэг ерөнхий хатуулаг 3,45 -3,9 мг-экв/л юм.

Газрын доорхи усны гол эх үүсвэр нь агаарын хур тунадас ба хүрээлэгч гидрогеологийн массиваас шүүрч буй газрын доорхи урсац болно. Газрын доорхи усны тухайн ордыг сумын төвийн усан хангамжийн нэмэлт эх үүсвэрийн зориулалтаар ашиглаж байна. Газрын доорх усны ордын ус татах байгууламжийн эрүүл ахуйн хамгаалалтын 3-р бүсийн талбай 1,7459 км<sup>2</sup> болно. Энэ мужийн солиболцлууд:

- 63.51-15. Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын төвийн усан хангамжийн газар доорхи усны орд, /ДТМ s= 2,9611 км<sup>2</sup>, ГТМ s= 1,7459 км<sup>2</sup>/

*Хүснэгт № 8.11. Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын төвийн усан хангамжийн газар доорх усны ордын байршил*

№	х	у
1	99° 38' 27.827" E	51° 6' 22.203" N
2	99° 37' 47.492" E	51° 6' 59.745" N



3	99° 38' 59.253" E	51° 7' 19.777" N
4	99° 39' 35.764" E	51° 6' 56.934" N

**Рашаан:** 2013 оны гадаргын усны тооллогоор Хөвсгөл аймагт нийтдээ 61 рашаан тоологдсон ширгэсэн үзүүлэлт байхгүй бүгд устай байна.


*Хүснэгт №8.12. Хөвсгөл аймгийн рашаан, булгийн тооллого*

№	Рашааны нэр	Байршдаг сумын нэр	Хамгаалалтын байдал	Ямар зорилгоор хэрэглэдэг
1	Цагаан булангийн рашаан	Арбулаг /сумаас баруун урд 51 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	-
2	Их ямаатын рашаан	Цэцэрлэг /сумаас зүүн хойд 40 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	-
3	Гантигт /Хядаг/	Бүрэнтогтох /Мөрөнгөөс баруун 32 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Элэг, цөс, дотор
4	Асгатын рашаан	Бүрэнтогтох /сумаас урагш 38 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Ходоод, гэдэс, дотор
5	Улаан булагийн рашаан	Их-Уул /баруун хойш 12 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Гэдэс, дотор
6	Жаргалантын рашаан	Их-Уул /хойш 35 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Ходоод, гэдэс, дотор
7	Алтан улиасны рашаан	Мөрөн /баруун 7 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Ходоод
8	Цэгэрийн рашаан	Чандмань-Өндөр /баруун 35 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Элэг цөс
9	Цахирын рашаан	Цэцэрлэг /баруун 18 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Гэдэс, дотор, бөөр, үе мөч
10	Тошинтын рашаан	Цэцэрлэг /зүүн урагш 38 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Дотор, үе мөч, зүрх, бөөр, умай
11	Өвгөд булнайн рашаан	Цагаан-Уул /баруун урагш 65 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Ходоод
12	Бөөстөгийн рашаан	Улаан-Уул /зүүн 30 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Мэдрэл, зүрх
13	Дээд цагаан нуурын рашаан	Улаан-Уул /хойд 45 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Ходоод, элэг цөс, мэдрэл, нүд
14	Хар усны рашаан	Рэнчинлхүмбэ /хойш 65 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Хордлого, арьсны өвчин
15	Хоногцол /уртраг/ рашаан	Рэнчинлхүмбэ /хойш 82 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Бөөр, уушиг, дотор, хамар хоолой, үе мөч
16	Тэрхэн цагаан уулын рашаан	Түнэл /хойш 60 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Мэдрэл, ядаргаа
17	Онъ дэл	Түнэл /зүүн хойш 20 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Дотор, ханиад
18	Саравслага рашаан	Цагаан-Үүр /хойш 180 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Таван цул, эмэгтэйчүүд
19	Түрүүний рашаан	Рашаант /урагш 6 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Дотор, хүчил ихсэх, элэг цөс
20	Хушгын рашаан	Цагаан-Үүр /хойш 200 км Үүрийн эх/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Доторт
21	Парчингийн рашаан	Баянзүрх Цагаан уул сумын хил дээр / хойш 65 км /	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Доторт
22	Бурхантын рашаан	Рашаант /баруун 5 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Доторт
23	Булган уулын рашаан	Рашаант /хойш 2 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Нүд

24	Гунзгийн рашаан	Рашаант /хойш 38 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Элэг цөс, замаг үе мөчинд
25	Ушгатын рашаан	Улаан-Уул /зүүн 15 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Уушиг
26	Жоншын рашаан	Галт /сумаас 63 км Зүрх багаас 3 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Ходоодны хүчил ихсэх
27	Боомын рашаан	Рэнчинлхүмбэ /баруун 32 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Дотор, ходоод, мэдрэл, бөөр нуруу
28	Бийжийн рашаан	Түнэл /зүүн хойш 21 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Элэг цөс, дотор
29	Агарын рашаан	Цагаан-Уул /баруун хойш/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	-
30	Үүртийн рашаан	Арбулаг /баруун урагш 30 км/	Аймгийн ИТХ-ын 2002 оны №4 тогтоол	Ходоод гэдсэнд
31	Дулаан бүлээний рашаан	Бүрэнтогтох	Аймгийн ИТХ-ын 2000 оны №6 тогтоол	Элэг, цөс, дотор, бөөр, нуруу, хамар хоолой, мэдрэл
32	Халуун усны рашаан	Галт	Аймгийн ИТХ-ын 2000 оны №6 тогтоол	Мэдрэл, үе мөч, бэртэнгэ даралт, бөөр
33	Булнай рашаан	Чандмань-Өндөр	Аймгийн ИТХ-ын 2000 оны №6 тогтоол	Мэдрэл, үе мөч, дотоод шүүрлийн өвчин
34	Жаргалантын рашаан	Төмөрбулаг /хойш 5 км/	Аймгийн ИТХ-ын 2000 оны №6 тогтоол	Ходоод, элэг цөс, бөөр
35	Торцын рашаан	Төмөрбулаг /Мөрөнгөөс урагш 76 км/	Аймгийн ИТХ-ын 2000 оны №6 тогтоол	Ходоод, бруцеллөз, үе мөч
36	Даян дээрхийн рашаан	Цагаан-Үүр /Даян дээрхийн агуй дотор/	Аймгийн ИТХ-ын 2000 оны №6 тогтоол	Дотор
37	Хөнжлийн халуун рашаан	Жаргалант /сумаас 3 км/	-	Үе мөч, бөөр, нуруу, чийг бам
38	Наранбумбат	Түнэл /сумаас баруун/	-	Ходоод, бөөр, уушиг, тогой, нүд, чих
39	Наранбулаг	Шинэ-Идэр /зүүн 45 км/	-	Ходоод, дотор
40	Доод түрүүний рашаан	Тосонцэнгэл	-	Дотор
41	Долоон булаг	Эрдэнэбулган /сумаас хойш 72 км/	-	Бөөр нуруу, дотор эрхтэн
42	Отогт	Эрдэнэбулган /сумаас зүүн 18 км битүү ой дотор/	-	Дотор, ходоод, хүчил багасах
43	Армагийн рашаан	Цагаан –Үүр /Уйлганд/	-	Дотор
44	Цагаан туурагтын рашаан	Цагаан-Үүр /Хээгт/	-	Дотор
45	Харнуутын рашаан	Баянзүрх /хилийн зурваст/	-	Дотор
46	Хөнжлийн рашаан	Рашаант /сумаас баруун 12 км/	-	Элэг цөс
47	Цагаан мөсний рашаан	Шинэ-Идэр	-	Дотор
48	Түлэгтагийн рашаан	Цагааннуур	-	-
49	Саригийн рашаан	Цагааннуур	-	-

#### 8.4. Бэлчээрийн усан хангамж

Хөвсгөл аймгийн хэмжээнд 2012 онд иргэдийн ундны усаар хангах усгүйн улмаас ашиглагдахгүй байгаа бэлчээрийг усжуулах ашиглахаар нийтдээ 15 суманд 24 худгийг тендер зарлаж шинээр барьсан байна. Тус худгийн ажлыг Хөвсгөл аймгийн “Хөвсгөл геологи” ХХК, Идэр чандмань ХХК нар улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн байна.



Хүснэгт № 8.13. Шинээр баригдсан худаг уст цэгийн судалгаа

№	Сумын нэр	Байршил	Шинээр баригдсан худаг	
			Худгийн тоо /инженерийн хийцтэй/	Санхүүжилтийн эх үүсвэр
1	Арбулаг	2-р баг Баян үзүүрийн ар	1	Улсын төсвийн хөрөнгөөр
2	Алаг-эрдэнэ	2-р баг улаан толгой	1	Улсын төсвийн хөрөнгөөр
3	Бүрэнтогтох	Туяа баг дааган толгой, бүрэн хаан баг Хөх хөтөлийн өвөр	2	Улсын төсвийн хөрөнгөөр
4	Галт	Рашаант баг Хөшөөт, Зүрх баг хайлантай	1	Улсын төсвийн хөрөнгө гишүүдийн багцаас
5	Мөрөн сум	10-р баг талын хонхор	4	Улсын төсөв, гишүүдийн багц, чехийн төслөөр
6	Их-уул	Асгат баг, олон жалга	1	Улсын төсөв
7	Рашаант	5-р баг их—ац, сумын төв	2	Улсын төсөв гишүүдийн багц
8	Тариалан	Ар тархи баг Тасархайн ам	1	Улсын төсөв
9	Тосонцэнгэл	4-р баг Олон булаг	2	Улсын гишүүдийн багц
10	Төмөрбулаг	Жаргалант баг Хойт цагааны гол	1	Улсын төсөв гишүүдийн багц
11	Түнэл	2-р баг нарийн хөндий	1	Улсын төсвийн хөрөнгөөр
12	Цагаан-үүр	Сумын төвд Булган хороололд	1	Улсын төсөв гишүүдийн багц
13	Чандмань-Өндөр	2-р баг Цахиурт	1	Улсын төсвийн хөрөнгө

14	Эрдэнэбулган	4-р баг Нарангийн энгэр	1	Улсын төсвийн хөрөнгө
15	Шинэ-Идэр	3-р баг Хошой цэцэрлэг, Холбоогийн дөрөлж, 2-р баг Сүүлт, нум толгой	4	Улсын төсвийн хөрөнгөөр
<b>Нийт дүн</b>			<b>24</b>	

Хүснэгт №8.14. Гол горхины эргийн хамгаалалтын бүсийн хэмжээ

№	Сумдын нэр	Гол горхины нийт талбай /га/	Гол горхигны эх газрыг хамгаалах талбай	
			Хувиар /%/	/ га /
1	Алаг-Эрдэнэ	2145	6.4	3405.4
2	Арбулаг	686	2.1	1089.1
3	Баянзүрх	9141	27.5	14512.4
4	Бүрэнтогтох	2216	6.7	3518.2
5	Галт	1308	3.9	2076.6
6	Жаргалант	688	2.1	1092.3
7	Их-Уул	1127	3.4	1789.2
8	Рашаант	1024	3.1	1625.7
9	Ренчинлхүмбэ	300	0.9	476.3
10	Тариалан	811	2.4	1287.6
11	Тосонцэнгэл	350	1.1	555.7
12	Төмөрбулаг	288	0.9	457.2
13	Түнэл	957	2.9	1519.4
14	Улаан-Уул	1300	3.9	2063.9
15	Ханх	-	-	-
16	Цагаан-Уул	950	2.9	1508.2
17	Цагаан-Үүр	3983	12.0	6323.5
18	Цэцэрлэг	2600	7.8	4127.8
19	Чандмань-Өндөр	673.3	2.0	1068.9
20	Шинэ-Идэр	771	2.3	1224.1
21	Хатгал	-	-	-
22	Мөрөн	-	-	-
23	Эрдэнэбулган	1000	3.0	1587.6
24	Цагааннуур	980	2.9	1555.9
<b>ДҮН</b>		<b>33298.3</b>	<b>100.0</b>	<b>52865.0</b>

Хүснэгт №8.15. Нуур цөөрөм бүхий газрын хамгаалах зурвасын хэмжээ

№	Сумдын нэр	Нуур цөөрөм бүхий газрын нийт талбай /га-аар/	Нуур цөөрөм бүхий газрын хамгаалах талбай	
			Хувиар /%/	/ га-аар /
1	Алаг-Эрдэнэ	1189	2.3	923.3
2	Арбулаг	-	-	-
3	Баянзүрх	130	0.3	100.9
4	Бүрэнтогтох	15200	29.6	11803.3
5	Галт	10	0.0	7.8
6	Жаргалант	-	-	-
7	Их-Уул	-	-	-
8	Рашаант	-	-	-
9	Ренчинлхүмбэ	12437	24.2	9657.7
10	Тариалан	-	-	-
11	Тосонцэнгэл	-	-	-
12	Төмөрбулаг	-	-	-
13	Түнэл	560	1.1	434.9
14	Улаан-Уул	7076	13.8	5494.8
15	Ханх	-	-	-
16	Цагаан-Уул	3040	5.9	2360.7
17	Цагаан-Үүр	-	-	-

18	Цэцэрлэг	960	1.9	745.5
19	Чандмань-Өндөр	3.1	0.0	2.4
20	Шинэ-Идэр	-	-	-
21	Хатгал	-	-	-
22	Мөрөн	-	-	-
23	Эрдэнэбулган	-	-	-
24	Цагааннуур	10785	21.0	8374.9
<b>ДҮН</b>		<b>51390.1</b>	<b>100.0</b>	<b>39906.1</b>

## Хүснэгт №8.16. Булаг, рашаан бүхий газрын хамгаалах зурвасын хэмжээ

№	Сумдын нэр	Худаг, булаг, рашаан бүхий газрын нийт талбай /га-аар /	Худаг, булаг, рашаан бүхий газрыг хамгаалах талбай	
			Хувиар /%/	/ га-аар /
1	Алаг-Эрдэнэ	-	-	-
2	Арбулаг	-	-	-
3	Баянзүрх	-	-	-
4	Бүрэнтогтох	7	0.5	133.1
5	Галт	20.5	1.6	389.8
6	Жаргалант	-	-	-
7	Их-Уул	-	-	-
8	Рашаант	-	-	-
9	Ренчинлхүмбэ	-	-	-
10	Тариалан	-	-	-
11	Тосонцэнгэл	-	-	-
12	Төмөрбулаг	-	-	-
13	Түнэл	-	-	-
14	Улаан-Уул	-	-	-
15	Ханх	-	-	-
16	Цагаан-Уул	-	-	-
17	Цагаан-Үүр	-	-	-
18	Цэцэрлэг	406	30.9	7719.3
19	Чандмань-Өндөр	45.6	3.5	867.0
20	Шинэ-Идэр	-	-	-
21	Хатгал	-	-	-
22	Мөрөн	-	-	-
23	Эрдэнэбулган	835	63.5	15875.9
24	Цагааннуур	-	-	-
<b>ДҮН</b>		<b>1314.1</b>	<b>100.0</b>	<b>24985.0</b>

## ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗРЫН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН ОДООГИЙН БАЙДАЛ

### 9.1. Улсын тусгай хэрэгцээний газрын өнөөгийн байдал


Улсын тусгай хэрэгцээний газар тус аймгийн хэмжээнд 2195651.53га буюу нийт нутаг дэвсгэрийн 21,81%-г эзлэж байна. Үүнээс улсын тусгай хэрэгцээний газар 1134,7мян.га бөгөөд шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай 33,8га, Улсын хилийн зурвас газар 1060,4мян.га, улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгогдсон газар 418,23га газрын тус тус эзлэж байна.

### 9.2. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ашиглалтын өнөөгийн байдал

Газар нутгийг тусгай хамгаалалтад авч буй зорилго нь байгаль экологийн тэнцвэрт байдлыг хангах, судалгаа, шинжилгээний түшиц газар болгох, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгаль орчны доройтлыг хязгаарлан зогсоох түүнээс урьдчилан сэргийлэх, хүн төрөлхтөний байгаль, түүх соёл, шинжлэх ухааны давтагдашгүй их өвийг хойч үедээ өвлүүлэн үлдээх болон үнэ цэнэ бүхий газрыг зохисгүй ашиглалтаас хамгаалж, улмаар бүс нутгууд байгаль орчиндоо зохицон, тогтвортой хөгжих үзэл санааг баталгаажуулахад оршино. Аймгийн ИТХ-ын 2009-06-01 өдрийн 01 тоот тогтоолоор Арбулаг, Алаг-Эрдэнэ, Баянзүрх, Улаан-Уул, Цагааннуур, Ханх, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Түнэл, Рэнчинлхүмбэ, Эрдэнэбулган сумдын нутаг дэвсгэрийг бүхэлд нь буюу тодорхой хэсгийг хамруулан 50 дугаар өргөргөөс хойшхи улсын тусгай хамгаалалтанд орсноос бусад 4.5 сая га талбай газар нутгийг Шишхид-Эг-Үүрийн байгалийн иж бүрдлийн нөөц газар нэрээр аймгийн хамгаалалтанд авч аймгийн нийт нутаг дэвсгэрийн 45.8 хувь нь аймгийн тусгай хамгаалалтанд ороод байна.

*Хүснэгт № 9.1. Улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгууд /2003-2012 он/*

Хамгаалалтад авсан газрын нэр	Ангилал	Харьяалагдах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээ /мян.га-гаар/
<b>ДАРХАН ЦААЗАТ ГАЗРУУД</b>		
Хорьдол сарьдаг	ДЦГ-ын өргөтгөл	Хөвсгөл аймгийн Улаан-Уул, Ренчинлхүмбэ-36.9 /226.7/
Улаан тайга	БЦГ-ыг өргөтгөж ангилал дээшлүүлэн ДЦГ болгосон.	Хөвсгөл аймгийн Баянзүрх, Улаан-Уул-326.3 /431.7/
<b>БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРУУД</b>		
Хөвсгөл	БЦГ-ын өргөтгөл	Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Ханх-342.2 /1175.6/
Тэнгис-Шишгэдийн ай сав	БЦГ	Хөвсгөл аймгийн Цагааннуур, Ренчинлхүмбэ, Улаан-Уул-875.7
<b>БАЙГАЛИЙН НӨӨЦ ГАЗРУУД</b>		
Намнан уул	БНГ	Хөвсгөл аймгийн Тариалан, Булган аймгийн Хутаг-Өндөр-29.7
<b>ДУРСГАЛТ ГАЗРУУД</b>		
Даяндээрхийн агуй	ДГ	Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сум - 31.3



Зураг № 9.1 Хөвсгөл аймгийн тусгай хамгаалалттай газар нутгийн зураг /УГЗБЕТ-өөс/

Газрын нэгдмэл сангийн ангиллаар 2003 оныг 2013 онтой харьцуулж үзэхэд Аймгийн нийт тусгай хэрэгцээний газрын хэмжээ 727910.63га талбайгаар нэмэгдсэн байна. Тус ангиллын голлох дэд ангиллаар авч үзвэл дархан цаазат газраас бусад дэд ангилал тус бүр дээр өссөн дүнтэй байна. Үүнээс Улсын тусгай хамгаалттай газар 108000 га-аар, Байгалийн цогцолбор газар 108000, ШУ-н технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай 9.8га –аар нэмэгдсэн байна. Улсын хилийн зурвас газар болон Улсын батлан хамгаалах болон, аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар хамгийн ихээр нэмэгдсэн байна.

Хүснэгт № 9.2. Аймгийн тусгай хэрэгцээний газрын талбайн өөрчлөлт, өсөлтийн хувь

№	Дэд ангилал	2003 он	2013 он	өөрчлөлт	хувь%
1	Бүгд	1467740.9	2195651.53	+727910.63	49.6
2	Улсын тусгай хамгаалттай газар	1026704.0	1134704	+108000	10.5
3	Байгалийн цогцолбор газар	838070	946070	+108000	13.0
4	Улсын хилийн зурвас газар	441000	1060495	+619495	140.7
5	Улсын батлан хамгаалах болон, аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар	12.9	418.23	+405.33	3142
6	ШУ-н технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай	24.0	33.8	+9.8	40.8

## Хүснэгт №9.3. Отрын бүс нутгийн судалгаа

№	Отрын бүс нутгийн байрших			Сумаас аль зүгт, хэдэн км хэдэн -г	Талбайн хэмжээ /га/	Оторлох малын тоо	Одоо байгаа талбайн хэмжээ /га/	Энэ нутагт одоо байгаа			Ашиглагч-ын зориулалт	Тайлбар
	Сумын нэр	Газрын нэр	Багийн нэр					Малын тоо	Өрхийн тоо	Усан хангамж		
1	Түнэл	Хадрагч	Зуна гол баг	Зүүн 80	5700	8370	20488	7516	17	Хад/гол	бэлчээр	хавар 14 өвөл 3
2	Түнэл	Бэрхийн даваа	Зуна гол баг	Зүүн 70	3200			3416	10	Гол модны харз	бэлчээр	Хавар 2 өвөл 8
3	Түнэл	Хуурай Баян гол	Зуна гол баг	Зүүн 86	8300			4021	8	Гүн өрмийн худаг	бэлчээр	Өвөл 8
4	Чандмань-Өндөр	Аригийн эх	Ёлгос	Баруун урагш 68	5680	15000	6143	1102	2	Ариг гол	Бэлчээр хадлан	Өвөл 2
5	Чандмань-Өндөр	Улиад	Ёлгос	Зүүн урагш 70	12890	11780	12980	2091	9	Гол мөрөн	Бэлчээр хадлан	Өвөл 9
6	Эрдэнэ-Булган	Бөөрөлж	1 баг	баруун	10280	8800	7795	9439	59		Бэлчээр хадлан	
7	Эрдэнэ-Булган	Хутаг гол	1 баг	Баруун 56			3910	313	4	Гол мөрөн	Бэлчээр хадлан	
8	Эрдэнэ-Булган	Горьхон	Зэрлэг баг	Зүүн хойд 35			4076	280	1	Гол мөрөн	Бэлч хадлан	
9	Эрдэнэ-Булган	Буурлын гол	Зэрлэг баг	Зүүн 90	11200	12160	15213	560	4	Гол мөрөн	Бэлчээр хадлан	
10	Эрдэнэ-Булган	Унгиа	Зэрлэг баг	Зүүн урд 45			9710	290	2	Гол мөрөн	Бэлчээр хадлан	
11	Тариалан	Асайтын даваа	Давааны ар	Хойш	2560	7215	2861	300	3		Бэлчээр хадлан	
12	Тариалан	Бор толгойн Өвгөд	Сэлэнгэ	Сэлэнгийн урд	16270	33100	13587	-	-	Гол мөрөн	Бэлчээр хадлан	
13	Тариалан	Ар, Өвөр зорлого	Давааны ар	Хойш	32385	31870	30552	-	-		Бэлчээр хадлан	
14	Тосонцэнгэл	Цагаан сайр	3 баг	Баруун урд	1000	2500	1132	350	10	Гар худаг	Бэлчээр хадлан	Худаг гаргах
15	Их - Уул	Зуун мод, Хөх ан	Шивээ баг	Баруун хойш	5800	8000	5807	2000	2	Гол горхи	Бэлчээр	
16	Рэнчинлхүмбэ	Хорон тал	Ёлт		26870	29590					бэлчээр	
17	Рашаант	Залаат Халиун энгэрийн даваа	Энх тал баг	Баруун урагш 20	9600	15080	13577	14819	58	Г/өр худаг 1 Гар/ху 1	Бэлчээр	
18	Рашаант	Натгуй Бадгуй	3 баг	Зүүн урд 3	800			5505	18	Гар худаг	бэлчээр	Худаг гаргах
19	Төмөрбулаг	Гүенгийн эх, Улаан хад, Уртбулаг	Тээл		10950	16540	11028	11471	41	Худаг Гол	бэлчээр	
20	Алаг - Эрдэнэ	Алагцар, Адуун гол	Яргис	Зүүн хойш	36400	15000	35353	6641	36	Гол горхи	Бэлчээр хадлан	
21	Цэцэрлэг Цагаан - Уул	Хилийн 255 баганаас 278 багана хүртэл	Хар боом Агар	Улсын хил дагуу	45700	44900	57680			Гол мөрөн	Бэлчээр хадлан	
Нийт					245585	259905	251892	70114	282			2 худаг

## 9.2. Газар хадгалан хамгаалах талаар авсан арга хэмжээ:

Аймгийн засаг дарга, Бүрэнтогтох сумын засаг дарга болон ИТХ, ГХБХБГазраас санаачлан Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Бүрэнхаан уул болон түүний орчмын 50.000 га газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар судалгаа хийж шат шатны хурлын байгууллагад танилцуулж Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2012 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн №03 тоот тогтоолоор орон нутгийн тусгай хэрэгцээнд авлаа. Бүрэнтогтох сумын Бүрэнхаан уул болон түүний орчмын газар, Хядага, Алтан-Улиасны рашаан, Дэлгэрмөрөн голын ай сав, түүх соёлын дурсгалт газарт болох Буган чулуун хөшөө бүхий 50000 га газар нь “Бүрэнхаан”-ы салбар уулс нь Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох, Арбулаг, Алаг-Эрдэнэ, Түнэл сумдын нутаг Хангайн нурууны салбар уулс болох Эрчим, соёоны



нуруудын салбарт багтах улсын хүрээлэлд багтах бөгөөд газар зүйн байрлалын хувьд өмнөд өргөргийн 49°-50°, уртрагийн 99°-101° –ийн солбилцолд багтах өргөн уудам газар нутгийг эзлэн оршино. Бүрэнхааны фосфоритын орд газрын нутаг дэвсгэрт хамаарах Бүрэнтогтох сумын нутаг дэвсгэрт хүрэл зэвсгийн үеийн түүхийн дурсгалт зүйлсэд хамаарагдах булш, бунхан, хадны сүг зураг, бичээсүүд олноор байдаг ба үүнээс Хүрэл зэвсгийн дунд үе буюу манай эриний өмнөх II-I мянган жилд босгосон гэж үздэг дэлхий дээрх хамгийн уран тод дүрслэлтэй Уушгийн өврийн буган чулуун хөшөө ордог юм.

Сүүлийн жилүүдэд орон нутгийн тусгай хамгаалалтад Бүрэнтогтох сумын ИТХ – аар тус сумын нийт нутаг дэвсгэр буюу 376860 га газрыг, мөн Цэцэрлэг сумын ИТХ – ын Тэргүүлэгчдийн 2012.3.2 – ны өдрийн 14 дүгээр тогтоолоор сумын нийт нутаг дэвсгэр буюу 745162 га газрыг тус тус орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан бөгөөд бүгд 1122022 га талбайг эзлэж байна. Ийнхүү аймгийн нийт нутаг дэвсгэрийн 7692889,4 га газар буюу 76,4% улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээнд орсон.

## АРАВДУГААР БҮЛЭГ. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### 10.1. Аялал жуулчлалын нөөцүүд

Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын салбарын одоогийн хүчин чадлын хувьд нэг ээлжиндээ 3000 жуулчин хүлээн авах чадалтай болсон, аялал жуулчлалын салбарт нийтдээ 452 иргэн байнгын болон түр ажлын байраар хангагдаж жилдээ 30-40 мянга орчим гадаад, дотоодын аялагчид, жуулчдад үйлчилгээ үзүүлж байна.

Жуулчны бааз 58, Отог 22, Гэр буудал 38, Амралтын газар 6, Зочид буудал 5, 18 дэн буудал байна. Аяллын төрлийн хувьд: Байгалийн аялал 35%, Соёл 30%, Адал явдалт аялал 15%, Амьтан, ургамал ажиглах 10%, Спорт загасчлал 10% тус тус эзэлж байна.

*Хүснэгт №10.1. Жуулчдын судалгаа*

№	Он	Гадаадын жуулчид	Дотоодын жуулчид	Дүн
1	2004	3552	4167	7719
2	2005	2837	4349	7186
3	2006	4611	5110	9721
4	2007	4654	8300	12954
5	2008	4584	7283	11867
6	2009	8167	4021	12187
7	2010	8800	14500	23300
8	2011	4121	20036	24157
9	2012	4518	40828	45346
10	2013	3690	28760	32450
11	2014	5327	19147	-

#### 10.1.1. Байгалийн нөөц

##### 1. Хөвсгөл нуур



Хөвсгөл нуур нь Мөрөн хотоос 102 км-г оршдог.

Хөвсгөл нуур нь хойш, урагшаа 134 км, өргөөшөө 39 км бөгөөд энэ нуурт 46 гол горхи цутгаж, ганцхан Эгийн гол эх авч

урсана. Хөвсгөл нуур нь Төв-Азийн хамгийн гүн нуур бөгөөд түүний усны нөөц 380 шоо км. Усны нөөцөөрөө Азид хоёрт, дэлхийд арван дөрөвт орох бөгөөд цэнгэг усны 1%-ийг агуулж байдаг. Нуурын нутагшил 24 м хүрнэ, эргэн тойрон нуурын усандаа тольдсон

уулын их шинэсэн ой, орой нь нүцгэрсэн их ян сарьдагтай. Хөвсгөл нуур нь омоль, магт, зэвэг, хадрана, цэгаан нүдэн, цаамхай, алгана зэрэг загастай.

## 2.Сангийн далай нуур



Хөвсгөл, Завхан аймгийн нутгийн заагт д.т.д 1980м өндөрт орших 166 ам.дөр.км талбайтай гадагшаа урсгалгүй, давстай нуур. Сангийн далай, түүний дэргэд Гандан нуур нь хурган, тунгалагжин зэрэг олон зүйл ховор шувууд цуглардаг үзэсгэлэнтэй сайхан нуур юм.

## 3.Хөнжлийн халуун рашаан



Энэ рашаан нь Хөвсгөл аймгийн Жаргалант сумын нутагт х.ө 480,34, з.у 990,22 солбилцолд д.т.д 1590м өргөгдсөн. Рашаан орчим, Хөнжлийн голын хөндийгөөр хайр сайрын хад чулуу элбэгтэй, элсэрхэг хөрстэй, уулсдаа боржин зэрэг хад чулуу элбэгтэй.Хөнжлийн халуун

рашаан нь бага зэрэг хүхэрлэг үнэр амттай, өнгөгүй, тунгалаг, 6-7 ундрагаас ундрэн гардаг. Гадарга дээр гарч байгаа халууны хэм нь 500 байдаг бөгөөд гадаргынхаа гүн рүү нэмэгддэг.

## 4.Булнайн рашаан сувилал



Газрын гүнээс ундардаг энэ рашаан үе мөч, арьс өнгө, бруцельоз өвчнийг анагаадаг болохоор нутгийн ардууд эрт дээр үеэс биеэ эрүүлжүүлж ордог байсан. Тийм учраас амралт, аялал жуулчлал, эрүүл мэндийн гээд олон чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг.

### 5. Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газар

1995 оны УИХ-ын 26-р тогтоолоор ТХГН—ын хуульд нийцүүлэн Байгалийн цогцолборт



газрын ангилалд авсан. Хөвсгөл нуурын баруун талын уулс хурц шовх оргил, хэрчигдсэн хянга хяртай, эгц цавчим хажуутай ба ихэнх уулс нь 2500 метрээс дээш өргөгдсөн байдаг. Хамгийн өндөр цэг нь Мөнхсарьдаг

3493м. Монголын улаан номонд орсон 28 зүйл ургамалтай, Хөвсгөл нуурын усанд 69 зүйл планктон амьтан амьдардгаас сэлүүр хөлт хавч 10, салаа сахалт хавч 19, хүрд хорхой 30 зүйл, 15 овогт хамаарах 200 шахам зүйлийн ёроолын амьтан байдаг.

### 6. Хорьдоль сарьдагийн нуруу дархан цаазат газар

Хөвсгөл аймгийн Улаан-Уул, Ренчинлхүмбэ сумын нутаг дэвсгэрийг хамарсан 188634 га талбайтай. Тус нутгийг УИХ-ын 1997 оны 47-р тогтоолоор улсын тусгай хамгаалалтанд



авсан. Орчин зүй, байгаль, ландшафтын хувьд ихээхэн ялгаатай, бие биенээсээ төдийлөн алслагдаагүй тундр, таг, тайга, ойт хээр, уулын нугын хээр зэрэг босоо бүслүүрийг хэв шинжтэй бөгөөд энэ онцлогоос

хамааран тундрын хөрсний олон төрөл ховор, ховордсон олон зүйлийн ургамал-ван сэмбэрүү, алтайн сонгино зэрэг ургадаг. Мөн аргаль, сибирь хандгай, хойлог, булга зэрэг амьтадтай.

## 7. Улаан тайга байгалийн цогцолборт газар

Дархадын хотгороос баруун тийш Бүсийн гол дагуу улсын хил хүртэл газрыг бүхэлд нь хамардаг том уул. Хамгийн өндөр хэсэгтээ Бэлчир уул 33521м хүрнэ. Улаан тайга уулнаас Шишгэд, Дэлгэрмөрөн болон нилээд олон гол эх авч урсана. Оргил нь Ёрвон уул өндөр нь 2955м өндөр. Улаан тайга уулыг 2003 онд 1080 ам.км талбайгаар Байгалийн цогцолборт газрын зэрэглэлээр улсын тусгай хамгаалалтанд авсан. Улаан тайга уул нь эртний тэгширлийн гадарга үлдсэн учраас орой нь тэгш бөгөөд мөстлөгийн орд ихтэй, жинхэнэ уулын тайгын бүслүүр тархснаараа онцлог.

## 8. Даяндээрхийн агуй



Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумынтөвөөс зүүн хойш орших Монгол орны хамгийн том агуйн нэг бөгөөд 2006 оны УИХ-ын 26-р тогтоолоор тусгай хамгаалалтанд авсан. Даян дээрхийн агуй нь ховор тогтоцтой, байгалийн үнэт үзмэр юм. Дотроо 10 гаруй өрөөтэй, зүг бүртээ олон ам хаалгатай, олон янзын рашаантай, нарийн шороон будагтай.

### 10.1.2. Түүх, соёлын нөөц

Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэр дээр нэн эртний үеэс хүн оршин сууж, амьдарч байсныг илтгэсэн чулуун болон хүрэл зэвсгийн үеийн булш, хадны зураг, буган хөшөө олонтой.

## 1. Жаргалантын дуган



Хөвсгөл аймгийн Жаргалант сумын төв, Хөнжлийн голын эрэгт орших Дашпэлжэйлэн хэмээх энэ дуганыг нутгийн тахилт шүтээн Дамдинчойжоо бурхант их уулыг голлуулан барьсан ба дуганы гол шүтээн дээрх бурхан байв. 1890-ээд онд Хөнжлийн гол үерлэн усанд автахад дуганг нүүлгэн зөөж, одоогийн Жаргалант сумын төв

байгаа газар аваачин барьжээ. Дуганы багана дам нуруунуудыг хооронд нь углуургадан зангидах, шаантаглаж холбох, ханыг дан банзаар хөндлөн босгох зэрэг аргаар угсран барьсан нь буулгаж зөөхөд зориулагдсан. Дуган нь бөмбөгөр оройтой, дөрвөлжин хэлбэртэй, гадуураа эргэн тойрон 6-8 баганатай, гурван үе байсан ба 1930 онд сүм, хийдийг олноор нураах үед агуулах болгож, одоогийн хэлбэрт оруулжээ.

## 2. Мөнх хааны Эрчүү хотын туурь

Хөвсгөл аймгийн Арбулаг сумын нутаг Дэлгэр мөрний хойд хөвөө Алтан гадас уулын ар талд XIII зууны Монголын хаан Мөнх хааны хөшөө, орд харшийн үлдэгдэл эвдэрхий балгас бий. Нутгийн ард олон үеэс үед дамжсан домог яриандаа энэ хавьд эртний хот балгасын ор үлдэгдэл байдаг төдийгүй Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцлийн толгойлогч Чингүнжавын түшлэг чулуу, сангийн бойпор гэж нэрлэдэг хоёр чулуу байсан нь цөм энд өгүүлэх эртний хоттой холбоотой гэж үздэг. Энэ балгас нь хуучин Монгол сурвалжид нэр гардаг Юан улсын үеийн Эрчүүгийн балгас мөн гэж үздэг. Мөнх хааны хотын туурийг 1953 онд Шинжлэх ухааны хүрээлэнгийн О.Намнандорж ахлагчтай орон нутаг судлах аялалынхан анх илрүүлэн олж гүймэг судлан XIII зууны үед холбогдох ыг түүхэн эш баримтанд тулгуурлан тодорхойлсон.

## 3. Мөнх хааны гэрэлт хөшөө



Судлаачид Гэрэлт хөшөөний монгол бичээст “... Мөнх хаан түмэн түмэн насалтугай хэмээж...” гэсэн үг буйг уншаад уг хөшөөг Мөнх хааны амьд байх үест босгосон болохыг нотложээ. Улмаар Хятад бичээсийг уншнаар 1257 онд босгосныг лавтай тодруулжээ.

## 4. Уушиг уулан дахь буган чулуун хөшөө

Уушиг уул нь Хөвсгөл аймгийн Мөрөн хотын баруун талд оршино. Цэлгэрхэн уулсын хөндийн дунд орших сэлүүхэн өвөрт 14 ширхэг буган чулуун хөшөө байдаг. Нэг дор



олноороо ийм буган чулуун хөшөө тааралдах нь ховор. Ганц нэг л бий. Түүх соёлын дурсгалыг ач холбогдолоор нь хосгүй, үнэт, ердийн гэж зэрэглэдэг. Тэгвэл Уушиг уулын өвөрт орших буган чулуун хөшөөнүүд нь хосгүй зэрэглэлд багтдаг. Иймд соёлын өвийн тухай хуульд заасны дагуу хамгаалалтанд авсан.

## 5. Нэг голын гурван аваргын хөшөө



2008 оныг МҮБХ Бөхчүүдийн Манлайлалын жил болгон зарласан. Энэ хүрээнд Хөвсгөл аймгийн төв Мөрөн суманд Уйлган голоос төрөн гарсан 3 аваргын хөшөө цогцолбор буюу “Монгол түмний хойморийн их шүтээн” цогцолбор, Хөвсгөлийн бөхийн өргөө, “Хөвсгөл хүчтэн бөхийн дэвжээ”-г тус тус бүтээн

цогцлоосон нь хамгийн онцлох үйл явдал байсан. Энэхүү буянлаг үйлсийг Галт сумын харьяат “Хөвсгөлийн хүчтэн бөхийн дэвжээ”-ний тэргүүн, МУГТ улсын заан С.Хүрэлбаатар, Алаг-Эрдэнэ сумын харьяат “Хөвсгөлийн хүчтэн бөхийн дэвжээ”-ний е.н.б.д, Чөлөөт бөхийн ОУХМ аймгийн арслан Г.Батпүрэв нар санаачлан зохион байгуулсан.

*Хүснэгт №10.2. Хөвсгөл аймгийн түүх, соёлын дурсгалууд*

<b>Буган хөшөө</b>	
Арбулаг	Бадрахын өврийн буган хөшөө
Баянзүрх	Хушаатын амны буган хөшөө
Бүрэнтогтох	Зүүн голын буган хөшөө 9ш, Хяраагийн эхний бугаан хөшөө
Галт	Бартын буган хөшөө 6ш, Галтын 3-р бригадын буган хөшөө 4ш, хөшөөтийн буган хөшөө 11ш
Мөрөн	Уушгийн өврийн буган хөшөө 13ш, Дэлгэрмөрний хөндийн буган чулуу
Рэнчинлхүмбэ	Тайгад буган хөшөө, тогосын буган хөшөө, тэхийн үзүүрийн буган хөшөө
Төмөрбулаг	Бадрахын өврийн буган хөшөө, зуны голын буган хөшөө
Улаан уул	Хураачийн амны буган хөшөө 2ш
Цагаан уул	Агаарын бригадын буган хөшөө, Бор хужирын голын буган хөшөө, өвгөд бригадын буган хөшөө
Чандмань-Өндөр	Булжихын голын буган хөшөө, Бадрахын нурууны буган хөшөө
Шинэ-Идэр	Дөрвөлжин амны буган хөшөө 3ш, Нүхтийн амны амны буган хөшөө, Хөнгийн сугийн буган хөшөө, Цохиотын амны буган хөшөө, Төв дахь хөшөөнүүд
Баяннуур	Нарны буган хөшөө, Уушгийн улаан буган хөшөө
<b>Хотын туурь балгас</b>	
Ар булаг	Мөнх хааны Эрчүү хотын туурь
<b>Хадны сүг зураг</b>	
Баянзүрх	Хөшөөгийн хадны зураг
Түнэл	Бичигт булгийн хадны зураг
Улаан уул	Жаргалантын, Гожигийн боомтны хадны зураг
Цагааннуур	Хөгийн боомны газар Бурхан нуурын хадны бичээс, Бугат бэлийн хадны зураг, Буянт эргийн хадны зураг, Хүнх цахир бага харганатын хадны зураг
Цэцэрлэг	Морьгойн толгойн хадны зураг, Хүүхдийн овооны хадны зураг, Цагирын хадны зураг, Харганатын амны хадны зураг
<b>Хүн чулуун хөшөө</b>	
Тариалан	Дадгийн өвөлжөөний хүн чулуу, Шивээт улааны цогцолбор дурсгал хүн чулуу
Цагаан уул	Зүүлийн огторын хүн чулуу
<b>Булш</b>	
Галт	Аргайн голын түрэй, хөгийн өндөр модны булшнууд
Их уул	Уран амны монгол булш
Рэнчинлхүмбэ	Долоодойн хиргисүүр, даянгийн хиргисүүр
Жаргалант	Уран амны монгол булш
<b>Гэрэлт хөшөө</b>	
Арбулаг	Мөнх хааны гэрэлт хөшөө
Цагаан уул	Өвөр булгийн хөх толгойн Орхон-Енисейн бичигт гэрэлт хөшөө, Тэсийн гэрэлт хөшөө
<b>Руни бичгийн дурсгалууд</b>	
Цагаан уул	Тэсийн түрэг бичээс
Рэнчинлхүмбэ	Орос хадны бичээс
Цэцэрлэг	Цахиуртын түрэг бичээс, долоон нуурын түрэг бичээс
Ханх	Хирвэстэс толгойн бичээс

Хүснэгт №10.3. Хөвсгөл аймагт зохион байгуулагддаг аялал жуулчлалын уламжлалт эвент арга хэмжээнүүд



**Хаан их сарьдаг, Хатан далай ээждээ хүндэтгэл үзүүлэх “Мөсний баяр”**

**Зохион байгуулагч:** Аймгийн ЗДТГ, Соёл спорт аялал жуулчлалын газар  
Хатгал тосгон, Хөвсгөлийн улсын ТХГазар  
**Утас:** 70381699, 70388067

**Хаана:** Хөвсгөл нуур Доод Модот булан  
**Хэзээ:** Жил бүрийн 03 дугаар сарын 2,3 нд  
**Агуулга:** “Мөсний баяр”-ыг өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор 2000 оноос эхлэн Хөвсгөл нуурын мөсөн дээр зохион байгуулж байгаа. Мөсний баярын үеэр мөсөн хотхон баригдаж “Чаргатай морьдын уралдаан”, “Мөсөн дээрх шагайн харваа, тэшүүрийн тэмцээн, дууны тэмцээн, үндэсний хувцасны үзүүлбэр, орс таталт, галын наадам, бөөгийн ёслол зэрэг арга хэмжээнүүд зохион байгуулагддаг.



**Цаатан Фестиваль**

**Зохион байгуулагч:** Хөвсгөл аймгийн ЗДТГ Хөвсгөл Монтрейвэл ХХК Далай тур жуулчны бааз  
**Хаана:** Хатгал тосгон Жанхайн Цагаан эрэг

**Хэзээ:** Жил бүрийн 07-р сарын 5-8 нд  
**Агуулга:** “Цаатан фестиваль” наадмыг соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, цаатан иргэдийн өвөрмөц зан заншил, өв соёлыг таниулах зорилгоор Хөвсгөл Монтрейвэл ХХК-ний “Далай тур” жуулчны баазаас санаачлан 2004 оноос эхлэн жил бүр тэмдэглэж байна. Энэ наадмын хүрээнд Монгол үндэсний бэсрэг наадам, урлагийн тоглолт, “Цаан поло”, Цааны уралдаан, Галын наадам, бөөгийн дуудлага зэрэг олон сонирхолтой уралдаан тэмцээнүүд зохион байгуулагдаж, жуулчид үзэж сонирхохоос гадна өөрсдөө оролцдог.





 <p>Алунгоо эхийн сургаалийн баяр Эв модны наадам</p>	<p>Алунгоо эхийн сургаалийн баяр <b>Зохион байгуулагч:</b> Чандмань-Өндөр сумын Засаг даргын тамгын газар <b>Утас:</b> 98387099, 99993916 <b>Хаана:</b> Чандмань-Өндөр сум <b>Хэзээ:</b> 2014 оны 7 дугаар сарын 24-26 <b>Агуулга:</b> Чингис хааны язгуурын 11 дэх үеийн дээд өвөг, түүхт эх хатдын дээд өрлөг Алунгоо хатан эжийн алсын холч ухаан мэргэн сургаалийг хойч үедээ мөнхлөн үлдээх зорилгоор зохион байгуулна. Энэ үеэр өсвөр үеийн хүүхдийн барилдаан, “Добу мэргэн” сур харвааны наадам, 100 дааганы уралдаан, “Сургаалиар хүмүүжсэн Монголчууд” ЭШ-ний бага хурал, Хүүхдийн урлагийн наадам болно.</p>
<p style="text-align: center;">Эв модны наадам</p> <p><b>Зохион байгуулагч:</b> ОХУ-ын буриад улсын Ахан аймаг, Тункин аймаг, Хөвсгөл аймаг <b>Утас:</b> 88556080 <b>Вэб/и-мэйл:</b> azaa_tuul@yahoo.com <b>Хаана:</b> Ханх сум, с.п Кырен, с.п Орлик <b>Хэзээ:</b> жил бүрийн 6-7-р сард <b>Агуулга:</b> 2 орны уламжлалт сайхан ахан дүүсийн харилцааг бататгасан эв найрамдалаа билэгдсэн наадам. Улсын хил амгалан тайван байгаагийн билэг тэмдэг болгон гурван аймгаас авчирсан эв модоо эвлүүлэн нийлүүлж, хурсан олон эв мод эвээрээ эээрээ, эв найрамдал хэвээрээ хэмээн хурайлан байж модоо эвлүүлэн наадамладаг.</p>	
<p style="text-align: center;">Ази тивийн ультра марафон гүйлт “Наран ургахаас-наран шингэх</p> <p><b>Зохион байгуулагч:</b> Тойлогт жуулчны бааз <b>Утас:</b> 99112273 99092273 99115771 <b>Хаана:</b> Хатгал тосгон Тойлогт жуулчны бааз <b>Хэзээ:</b> 2014 оны 08 дугаар сарын 02-09 ний хооронд <b>Агуулга:</b> Хөвсгөл нуурыг хамгаалах, хог хаягдлыг бууруулах</p>	
	<p style="text-align: center;">Хөвсгөл аймгийн олон ястны урлаг соёлын наадам”Бошлойн хад 2015”</p> <p><b>Зохион байгуулагч:</b> ССАЖЯ, Аймгийн ЗДТГ, АНУ-ын Монтана мужийн “Эгч дүү орнууд” төсөл, дэлгэрмөрөн голын сав газрын хамгалаалалтын захиргаа <b>Утас:</b> 99140965 <b>Хаана:</b> Баянзүрх сумын “Бошлой хад” <b>Хэзээ:</b> Жил бүрийн 6 дугаар сарын эхний 7 хоногт <b>Агуулга:</b> Хөвсгөл аймгийн 6 ястны өв соёлыг үе дамжин хадгалан хамгаалах, хойч үедээ өвлүүлэх</p>

## АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УУЛ УУРХАЙН АШИГЛАЛТЫН ОДООГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА

### 11.1. Уул уурхайн ашиглалтын өнөөгийн байдал


#### 11.1.1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талаар

Хөвсгөл аймгийн хэмжээнд нийт ашиглалтын 16 тусгай зөвшөөрийг 12 аж ахуйн нэгж эзэмшиж байна. Үүнээс 8 ашиглалтын тусгай зөвшөөрөл “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуульд хамрагдсан байна. 2013 оны 5 дугаар сарын байдлаар 2 ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд олборлолтын үйл ажиллагаа явуулахаар 2014 оны уулын ажлын төлөвлөгөөг ирүүлээд байна.

*Хүснэгт № 11.1. Хөвсгөл аймгийн ашигт малтмалын төрөл*

№	Ашигт малтмалын төрөл	Тусгай зөвшөөрлийн тоо	Аж ахуйн нэгжийн тоо
1	Алт	1	1
2	Барилгын материал	7	5
3	Нүүрс	5	4
4	Фосфорит	2	2
5	Хүдэр	1	1
	<b>Нийт</b>	<b>16</b>	<b>12</b>

Дээрхи хүснэгтийн үзүүлэлтээс үзвэл Хөвсгөл аймагт одоогийн байдлаар нөөц нь тогтоогдсон 16 орд газар байгаагаас 5 нь нүүрсний орд газар, 1 нь алтны орд газар, 1 нь хүдэрийн орд, 2 нь фосфорит, 7 нь Барилгын материалын орд газар байна.



Зураг № 11.1. Хөвсгөл аймгийн ашигт малтмал хайгуул, ашиглалтын лиценз бүхий талбай

Хүснэгт №11.2. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хэмжээг аж ахуй нэгж тус бүрээр авч үзвэл

№	Аж ахуй нэгж	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо	Талбай, га
1	Могойн гол	2	174.9
2	Мон-Ажнай	1	23.3
3	Олонгол трейд	3	295.2
4	Өргөн цагаан нуур	1	47.5
5	Сухайхэн цо	1	33.9
6	Топруон хэнцэ	2	80.12
7	Төв азийн гантиг	1	75.9
8	Хорих 443-р анги	1	82.81
9	Хөвсгөл зам	1	26.4
10	Хургатай хайрхан	1	5758.7
11	Эрдэс мөрөн	1	25.87
12	Эрэл	1	35.7
	<b>НИЙТ</b>	<b>16</b>	<b>6660.3</b>

Хүснэгт № 11.3. Гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо, талбайн хэмжээг аймгаар

№	Аймаг	Тоо	Талбайн хэмжээ /га/
1	Хөвсгөл	6	5943.5

Хүснэгт № 11.4. Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуульд хамрагдсан тусгай зөвшөөрлийн жагсаалт

№	ТЗ дугаар	Талбайн нэр	Эзэмшигч	Ашигт малтмал	Давхцалтай бүс
1	1356	Нүүрстэй	Хорих 443-р анги	Нүүрс	ОС, УС
2	1361	Жилчиг булаг	Мон-Ажнай	Нүүрс	ОС, УС
3	5364	Бэлчир	Эрэл	Алт	ОС, УС
4	9919	Сүхийн ам	Эрдэс мөрөн	Бар/м	УС
5	12229	Тэнгэс гол	Өргөнцагаан нуур	Бар/м	УБЭ
6	17098	Овоот	Хургатайхайрхан	Нүүрс	УС
7	13218	Хүрэмт	Олонгол трейд	Бар/м	УС
8	17076	-	Атлантиктрейд	Бар/м	-

Хүснэгт № 11.5. Хөвсгөл аймгийн барилгын материалын эрдэс түүхий эдийн орд газрууд

№	Орд, ил уурхайн нэр байршил	Түүхий эдийн зориулалт	Холбогдох шийдвэр	Нөөцийн судалгаа			
				А	В	С1	С
1	Улаанхужирт Мөрөн сум	Тоосгоны шавар	ГУУЯ, ШУТЗ1981	245	158	793	290
2	Сүхийн ам Мөрөн сум	Шохойн чулуу	ГУУЯ, ШУТЗ1962	108	-	190	-
3	Нугын тохой Мөрөн сум	Элс, хайрга	ГУУЯ, ШУТЗ 1982	115	293	538	1121
4	Айзам Хатгал сум	Элс, хайрга	ГУУЯ, ШУТЗ 1969	140	368	367	260
5	Хөх толгой Мөрөн сум	Барилгын чулуу, базальт	ГУУЯ, ШУТЗ 1984	-	251	161	113
6	Эрхэмийн орд Арбулаг сум	Барилгын чулуу, боржин	ГУУЯ, ШУТЗ 1984	-	-	1486	-
7	Ширэвгэр уул Мөрөн хотоос 35 км	Барилгын чулуу, боржин	ГУУЯ, ШУТЗ 1986	Ашиглалт явагдаагүй илэрц хэлбэрээр байгаа			
8	Их дөш Цэцэрлэг сум	Хүрмэн чулуу	ГУУЯ, ШУТЗ 1983	-	222	505	887
9	Хүрмэт Арбулаг сум	Хүрмэн чулуу	ГУУЯ, ШУТЗ 1987	-	321	330	678
10	Хөшөөт Цагаан-Уулсум	Хүрмэн чулуу	ГУУЯ, ШУТЗ 1992	Ашиглалт явагдаагүй			
11	Цагаан чулуут Алаг-Эрдэнэ сум	Цагаанцайвар, цагаан саарал гантиг	ГУУЯ, ШУТЗ 1992	-	2300	-	-

Дээрх орд газрын судлагдсан байдлаас үзэхэд Хөвсгөл аймагт барилгын төрөл бүрийн төмөрбетон эдлэхүүн, зам талбайн өнгөт, хээтэй хавтан хашлага, тоосгоны үйлдвэрээс гадна шохой, шохойн түүхий эд бүхий сликат хөнгөн бетон, Хүрмэн бетон ханын төрөл бүрийн гулдмай, байгалийн өнгөт чулуу боловсруулах үйлдвэрлэл тухайлбал цагаан гантиг, саарал боржин өнгөлгөөний материал үйлдвэрлэх бүрэн боломжтой.

## Хүснэгт № 11.6. Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн судалгаа

№	Сум, дүүрэг	Тусгай зөвшөөрлийн н дугаар	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Талбайн нэр	Талбайн хэмжээ (га)	ААН-ийн төрөл	Барьц аалагч	Ашигт малтмал	Олгосон огноо	Дуусах огноо
1	Цэцэрлэг	MV-000384	Могойн гол	Могойн гол	89.73	Хамтарсан ХК		Нүүрс	1995.06.28	2025.06.28
2	Бүрэнтогтох	MV-001356	Хорих 443-р анги	Нүүрстэй	82.81	УҮГ		Нүүрс	1998.09.25	2028.09.25
3	Бүрэнтогтох	MV-001361	Мон-Ажнай	Жилчиг булаг	23.29	ХХК		Нүүрс	1998.09.29	2028.09.29
4	Ренчинлхүмбэ	MV-005364	Эрэл	Бэлчир	35.69	ХХК		Алт	2003.01.31	2033.01.31
5	Мөрөн	MV-009919	Эрдэс мөрөн	Сүхийн ам	25.87	ХХК		Бар/м	2005.06.03	2035.06.03
6	Түнэл	MV-011823	Топруон хэнцэ	Бүрэнхаан-9	26.68	ХХК		Фосфорит	2001.05.03	2031.05.03
7	Бүрэнтогтох	MV-011824	Топруон хэнцэ	Бүрэнхаан-хх	53.44	ХХК		Хүдэр	2001.09.24	2031.09.24
8	Цагааннуур	MV-012229	Өргөнцагаан нуур	Тэнгэс гол	47.5	Гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК		Бар/м	2006.11.22	2036.11.22
9	Бүрэнтогтох	MV-012909	Хөвсгөл зам	Нугын тохой	26.4	ХХК		Бар/м	2007.10.31	2037.10.31
10	Арбулаг	MV-013218	Олонгол трейд	Хүрэмт	30.65	ХХК		Бар/м	2008.01.30	2038.01.30
11	Түнэл	MV-013813	Олонгол трейд	Улаан хужирт	77.47	ХХК		Бар/м	2008.06.17	2038.06.17
12	Алаг-Эрдэнэ	MV-017076	Төв азийн гантиг	Цагаан чулуут	75.89	ХХК		Бар/м	2012.07.17	2042.07.17
13	Цэцэрлэг	MV-017098	Хургатайхайрхан	Овоот	5758.7	Гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК		Нүүрс	2012.08.10	2042.08.10
14	Цэцэрлэг	MV-017243	Могойн гол	Могойн гол	85.21	Хамтарсан ХК		Нүүрс	2013.01.15	2043.01.15
15	Бүрэнтогтох	MV-017398	Сутайхэн цо	Бүрэнхаан-8	33.98	ХХК		Фосфорит	2001.12.25	2031.12.25
16	Мөрөн, Түнэл	MV-017517	Олонгол трейд	Хужиртын булаг	187.13	ХХК		Бар/м	2014.04.18	2044.04.18
17	Улаан-Уул	XV-007557	Алтандорнод монгол	Үхэрт гол	10387.51	Гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК			2004.05.24	2013.05.24
18	Улаан-Уул	XV-007558	Алтандорнод монгол	Бэлчир уул	58499.08	Гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК			2004.05.24	2013.05.24
19	Алаг-Эрдэнэ, Ренчинлхүмбэ	XV-008628	Эхмөрөн	Дөшийн гол	170.81	ХХК			2004.10.25	2013.10.25
20	Улаан-Уул	XV-008629	Эхмөрөн	Бэлтэсийн гол	2039.96	ХХК			2004.10.25	2013.10.25
21	Алаг-Эрдэнэ	XV-008630	Эхмөрөн	Өвөр мараат гол	1027.17	ХХК			2004.10.25	2013.10.25
22	Арбулаг	XV-008822	Монголцамхаг	Замын толгой	278.56	ХХК	Анод банк		2004.11.25	2013.11.25
23	Алаг-Эрдэнэ,	XV-010529	Өнгөтшүр	Хатгал	2147.23	ХХК			2005.09.29	2014.09.29

	Ренчинлхүмбэ									
24	Алаг-Эрдэнэ	XV-011330	Топлаки	Бага тээг	2374.89	Гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК			2006.02.09	2015.02.09
25	Цагаан-Үүр	XV-012766	Миллениумдисковери	Армаг гол	3592.07	ХХК			2007.10.04	2016.10.04
26	Бүрэнтогтох	XV-012816	Чилчиггол	Чилчигийн гол	250.14	ХХК			2007.10.15	2016.10.15
27	Цэцэрлэг	XV-013055	Блюскай майнинг	Баянзүрх	37994.6	Гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК			2007.12.19	2010.12.19
28	Бүрэнтогтох	XV-013580	Блэкрок	Төмөртийн ам	1080.16	ХХК			2008.04.21	2017.04.21
29	Цэцэрлэг	XV-013636	Хургатайхайрхан	Овоот	880.03	Гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК			2008.05.01	2017.05.01
30	Цагаан-Үүр	XV-013715	И энд Жи Ар	Уйлан гол	27011.87	ХХК			2008.05.19	2015.05.19
31	Түнэл	XV-013827	Юнайтедминералс	Бумбат уул	6661.92	ХХК			2005.12.20	2014.12.20
32	Түнэл	XV-013928	Хаанталст	Улаан хужиртын бэл	136.35	ХХК			2008.07.25	2014.07.25
33	Галт	XV-013934	Дасмондрилл	Бумбатын өндөр уул	5796.93	ХХК			2008.07.28	2014.07.28
34	Бүрэнтогтох	XV-013958	Блэкрок	Мөрөн	1628.52	ХХК			2008.07.31	2014.07.31
35	Арбулаг	XV-014024	Эм Жи Ти Жи	Зүүн чулуут хүрэн	809.45	ХХК			2008.08.18	2014.08.18
36	Арбулаг, Бүрэнтогтох	XV-014026	Эм Жи Ти Жи	Буянт	2478.88	ХХК			2008.08.18	2014.08.18
37	Арбулаг	XV-014027	Эм Жи Ти Жи	Нуурын	2379.01	ХХК			2008.08.18	2014.08.18
38	Цэцэрлэг	XV-014194	Могойн гол глобал ресурс	Бүрхээр-2	2691.87	ХХК			2008.09.23	2014.09.23
39	Бүрэнтогтох	XV-014303	Мон-Ажнай	Сайр	99.43	ХХК			2008.10.17	2014.10.17
40	Алаг-Эрдэнэ	XV-014315	И Эй Эм тэшиг	Их уул	3031.05	Гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК			2008.10.17	2014.10.17
41	Алаг-Эрдэнэ	XV-014426	Звездаметрика	Нэргүй	4510.99	Гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК			2008.11.19	2014.11.19
42	Цагаан-Уул, Цэцэрлэг	XV-014510	Хургатайхайрхан	Хуримт-1	21750.25	Гадаадын 100% хөрөнгө оруулалттай ХХК			2008.12.04	2014.12.04
43	Цагаан-Уул	XV-014637	Хургатайхайрхан	Хуримт-1	12200.41	Гадаадын 100%			2009.03.16	2015.03.16

						хөрөнгө оруулалттай ХХК				
44	Арбулаг	XV-014639	Мегамайнз монголия	Сонгинот	666.51	ХХК	ХААН банк		2009.03.16	2015.03.16
45	Түнэл	XV-014972	Мон-Ажнай	Улаан толгой	423.43	ХХК			2009.07.01	2015.07.01
46	Бүрэнтогтох	XV-015006	Эй Эс Ти Эс	Хавчиг	1894.31	ХХК			2009.07.20	2015.07.20
47	Бүрэнтогтох	XV-015384	Эй Эс Ти Эс	Нурамт	1715.12	ХХК			2009.12.28	2015.12.28
48	Цагаан-Уул	XV-016751	Монгол корпораци	ресурс Цагаан уул	2360.11	ХХК			2005.11.24	2014.11.24
49	Цэцэрлэг	XV-017003	Овоот коал майнинг	Овоот	2703.86	ХХК			2008.05.01	2017.05.01
50	Түнэл	XV-017177	Шим-Аминаа	Чулуут	223	ХХК			2008.10.22	2016.08.03

